

Монгол Улс: Цогц Дүн Шинжилгээ

Албан бус орчуулга

Талархал

Энэхүү Монгол Улс: цогц дүн шинжилгээг боловсруулах ажлын хэсгийг Самуэл Фрейж Родригуз (тэргүүлэх эдийн засагч, GPV02) болон Түен Нгуен (Монгол дахь суурин төлөөлөгч, ОУСК) нар ахлан ажиллав. Түүнчлэн, Дэлхийн банкны дараах эдийн засагчид энэхүү дүн шинжилгээний баримт бичгийн холбогдох хэсэг, бүлгүүдийн хувьд мэдээлэл цуглуулах, товч дүн шинжилгээ хийх, баримт бичгийг хэд хэдэн удаа хянан тохиолдуулах, мөн дотоод болон гадаад хэд хэдэн удаагийн семинарт оролцох байдлаар хувь нэмрээ оруулсан болно: Рабиа Али (ахлах эдийн засагч, GED02), Анар Алиев (компаний засаглалын мэргэжилтэн, CESEA), Индра Баатархүү (мэдээлэл харилцааны мэргэжилтэн, EAPEC), Эрдэнэ Бадарч (үйл ажиллагааны ажилтан, GSU02), Жулие М.Бякинг (хөрөнгө оруулалтын ажилтан, CASPE), Даваадалай Батсуурь (эдийн засагч, GMT1), Батмөнх Батболд (санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн, GF1), Эйлийн Бурке (үсны нөөцийн удирдлагын ахлах мэргэжилтэн, GWA02), Бурмаа Чадраабал (хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, CM4P4), Янг Чен (хотын тээврийн мэргэжилтэн, GTD10), Тунгалаг Чулуун (нийгмийн хамгааллын ахлах мэргэжилтэн, GSP02), Бадамчимэг Дондог (төрийн салбарын мэргэжилтэн, GGOEA), Жигжидмаа Дүгэрээ (хувийн хэвшлийн ахлах мэргэжилтэн, GMT1), Болормаа Энхбат (Дэлхийн банкны группийн шинжээч, GCCSO), Николас вон дер Голц (орон хариуцсан ахлах мэргэжилтэн, EACCF), Петер Жохансен (эрчим хүчний ахлах мэргэжилтэн, GEE09), Жулиан Латимер (ахлах эдийн засагч, GMT1), Улле Ломус (санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн, GF1), Ситарамачандра Мачиражу (хөдөө аж ахуйн ахлах мэргэжилтэн, GFA02), Жон Мидлтон (хүрээлэн буй орчны тэргүүлэх мэргэжилтэн, CESI2), Жуан Жосе Миранда Монтеро (хүрээлэн буй орчны мэргэжилтэн, GEE09), Жеймс Морли (хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, CM4C1), Динеш Найр (эрүүл мэндийн ахлах мэргэжилтэн, GHN02), Жоо Нам (хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, CN4S4), Жеан Паскал Нгуесса Нганоу (ахлах эдийн засагч, GMT1), Нейл Пейрера (хөрөнгө оруулалтын тэргүүлэх мэргэжилтэн, CNGMI), Поонам Пиллай (гамшгийн удирдлагын ахлах мэргэжилтэн, GSU08), Жосефина Посадас (ахлах эдийн засагч, GSP02), Артесса Салдивар Сали (хот төлөвлөлтийн ахлах инженер, GSU08), Аутиф Мохаммед Саид (үйл ажиллагааны ахлах мэргэжилтэн,), Ашим Шмиллен (ахлах эдийн засагч, GSP02), Каролина Луиза Вайра (засаглалын ахлах мэргэжилтэн, GGOEA), Алексей Волков (стратегийн мэргэжилтэн, CCECE), болон Юн Ву (эрчим хүчний мэргэжилтэн, GEE09).

Берт Хофман (орон хариуцсан захирал, EACCF), Жеймс Андерсон (орон хариуцсан менежер, EACMF) болон Салман Зайди (практик менежер, GPV02) нар ерөнхийд нь удирдан хянав. Түүнчлэн, Судхир Шетти (эдийн засгийн асуудал хариуцсан дарга, EAPCE) болон Шаокинг Юү (стратеги ба үйл ажиллагаа хариуцсан захирал, EAPVP) нар зааварчилгаа өгсөн болно.

Энэхүү цогц дүн шинжилгээний үзэл баримтлал болон баримт бичгийн эцсийн хувилбарыг хянахад: Транг Ван Нгуен (ахлах эдийн засагч, GPV03), Мигуел Эдуардо Санчез Мартин

(ахлах эдийн засагч, GMF02), Картер Ж.Брендон (тэргүүлэх эдийн засагч, GENDR) болон Даниел Франсис Стрийт (үйл ажиллагааны ахлах эдийн засагч, CCECE) нар оролцов.

Милдред Гонзалвез (хөтөлбөрийн туслах ажилтан, GPV02), Ангар Энхтөр (багийн туслах ажилтан, EACMF), Болороо Баясгалан (хөтөлбөрийн туслах ажилтан, EACMF), болон судалгааны туслах ажилтан Рено Девина (зөвлөх, GPV02) нар захиргаа, техникийн туслалцаа үзүүлэв.

Агуулга

МОНГОЛ УЛС: ЦОГЦ ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	1
ХУРААНГУЙ.....	1
<i>Монгол Улсын тухай.....</i>	<i>1</i>
<i>Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалт</i>	<i>4</i>
<i>Дүгнэлт.....</i>	<i>7</i>
I ОРШИЛ.....	10
<i>Дүн шинжилгээний хамрах хүрээ.....</i>	<i>12</i>
<i>Дүн шинжилгээний бүтэц.....</i>	<i>17</i>
II. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БӨГӨӨД ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ	18
<i>Эдийн засгийн өсөлт: Эдийн засаг хурдтай тэлж, бүтээмж нэмэгдсэн ч тогтворгүй байдал олширсоор байна.</i>	<i>19</i>
<i>Тогтвортой өсөлтөд хүрэх сорилтууд: Төсвийн зохистой бодлого ба хөрөнгийн хуримтлалыг төрөлжүүлэх нь</i>	<i>26</i>
III ХҮН АМЫН САЙН САЙХАН БАЙДЛЫГ ХАНГАХ.....	46
<i>Тэгш байдлын үзүүлэлт: Ядуурлыг бууруулахад эрсдэлтэй байна</i>	<i>47</i>
<i>Тэгш байдлын сорилтууд: сайн сайхан байдлыг хангах үндэс нь болсон эрүүл мэнд, боловсрол, орон сууцны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.</i>	<i>54</i>
IV ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ СТРЕССИЙГ БУУРУУЛАХ	72
<i>Тогтвортой байдлын тулгамдсан асуудлууд: Монгол улс байгалийн баялгийн капиталаа хуримтлуулж байна уу?</i>	<i>74</i>
V. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ.....	92
<i>Дүн шинжилгээний хураангуй.....</i>	<i>92</i>
<i>Эрэмбэлэх дасгал</i>	<i>95</i>
<i>Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалт:</i>	<i>96</i>
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	107
ЗУРАГНУУД	119
ХАВСРАЛТУУД	140
<i>Хавсралт 1: Монголын жишиг тогтоох дасгал</i>	<i>140</i>
<i>Хавсралт 2: Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт.....</i>	<i>209</i>
<i>Хавсралт 3: Монголын мэдээлэл, судалгааны ялгаа</i>	<i>240</i>

Хайрцгуудын жагсаалт

Хайрцаг 1: Монгол дахь засаглал: <i>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн цоорхой</i>	15
Хайрцаг 2: Монгол дахь засаглал: <i>“заалтуудын” байдал?</i>	41
Хайрцаг 3: Монгол дахь засаглал: <i>Клиентилизмын хямрал ба авилгын талаарх ойлголт</i>	69
Хайрцаг 4: Монгол дахь засаглал: <i>Одоогийн бодлого урт хугацаанд нөлөөлөх нь</i>	90
Хайрцаг 5: Монгол дахь засаглал: <i>Шийдвэрлэх мөч</i>	99

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: ТТС ба ИБСийн журам.....	114
Хүснэгт 2: Нэгдсэн төсөв ба улсын төсвийн нэгдсэн зарлагын гүйцэтгэл: Батлагдсан төсөвтэй харьцуулалт.....	115
Хүснэгт 3: Монгол Улсын худалдааны зардал өндөр байна	116
Хүснэгт 4: Мал аж ахуйн тэгш бус үйлдвэрлэл	116
Хүснэгт 5: Ядуурлын байдал айл өрх ба амьдралын төлөв байдлаар 2016.....	116
Хүснэгт 6: Монголд ган, зудын давтамж нэмэгдэж байна.....	118
Хүснэгт 7: Сонгосон орнуудын нэг хүнд ногдох баялгийн өөрчлөлт: 1995-2014.....	118
Хүснэгт А.1. 1: Харьцуулсан судалгааны үзүүлэлтүүдийн тайлбар толь.....	157

Зургийн жагсаалт

Зураг 1: Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтийн задаргаа, Монгол Улс 2000-2016.....	119
Зураг 2: Монгол дахь хөрөнгө оруулалт болон капиталын хуримтлал	120
Зураг 3: Хүчтэй худалдаа, экспортын сагс төрөлжөөгүй	121
Зураг 4: Бүтээмжийн чадавх, салбараар Монгол 2000 - 2016	122
Зураг 5: Монгол дахь валютын ханш	123
Зураг 6: Хос алдагдал, Монгол.....	124
Зураг 7: Монголын өрийн тогтвортой байдлын дүн шинжилгээ (2017 оны 12 сар)	124
Зураг 8: Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт.....	125
Зураг 9: Монгол дахь банкны салбарын нөхцөл байдал.....	125
Зураг 10: Монгол дахь дэд бүтэц болон ложистик	126
Зураг 11: Doing Business Distance to Frontier, 2018.....	126
Зураг 12: Монголын засаглалын үзүүлэлт.....	127

Зураг 13: Монгол дахь ядуурал, хөгжил цэцэглэлтийн хувь хэмжээ ба тэгш бус байдал 2010-2016	128
Зураг 14: Бодит цалин ба ажил эрхлэлтийг бий болгох үйл ажиллагаагаар, 2016-2000	129
Зураг 15: Хөдөлмөрийн зах зээлийн хүйсийн хуваагдалт, Монгол 2010-2016	130
Зураг 16: Эмэгтэйчүүдийн цаг ашиглалт, зээлийн өргөдлийн үйл явц.....	130
Зураг 17: Төсвийн хуваарилалтыг үндсэн шилжүүлэгт аравтаар хуваарилах	131
Зураг 18: Монгол дахь ногоон хөгжил.....	132
Зураг 19: Монгол дахь хүрээлэн буй орчны стресс	133
Зураг 20: Монгол дахь хүрээлэн буй орчны стресс	134
Зураг 21: Монголын нэг хүнд ногдох баялаг, 1995-2015	135
Зураг 22: Монголын хүрээлэн буй орчны эрүүл мэндийн зардал, 1990-2016.....	136
Зураг 23: Оролцогч талуудын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн зэрэглэл, ДБГ-ын шинжээчид болон харьцуулах судалгаа.....	138
Зураг 24: Оролцогч талуудын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн зэрэглэл, бүлэглэсний дараах ДБГ-ын шинжээчид болон харьцуулах судалгаа	139
Зураг А1 1: Монгол Улс илүү ардчилсан, ашигт малтмалын экспортоос ихээхэн хамааралтай болж байна.....	144
Зураг А1 2: Улс орнуудын ангилан хуваарилалт, жишиг улс орнуудын сонголт Монголд.	145
Зураг А1 3: Монгол болон дэлхийн шилдэг улсын ялгаа ба зай (с. 2013-2015).....	148
Зураг А1 4: Монгол болон дэлхийн шилдэг улсын ялгаа ба зай (с. 2013-2015).....	150
Зураг А1 5: Ангиллын зэрэглэл (с. 2013-2015).....	152
Зураг А2 1: Уулзалт, санал асуулга, цахим судалгаанаас түүвэрлэсэн гол хариултууд	227
Зураг А2 2: Цахим судалгааны гол хариултууд.....	229
Зураг А2 3: Уулзалтын байршлаас гол хариултууд	231
Зураг А2 4: Цахим судалгаанд хамрагдагсдын гол хариултыг насны ангиллаар	231
Зураг А2 5: Цахим судалгаанд хамрагдагсдын гол хариултыг хүйсийн ангиллаар	233

МОНГОЛ УЛС: ЦОГЦ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХУРААНГУЙ

Монгол Улсын тухай

- 1. Монгол Улс нь маш өвөрмөц онцлогтой орон юм:** Газар нутгийн хэмжээгээрээ Франц улсаас гурав дахин их, гурван сая гаруй хүн амтай (дэлхийд хүн амын суурьшлаар хамгийн сийрэг улсад ордог), ардчилал эрчимтэй хөгжиж буй, ОХУ ба БНХАУ-ын дунд орших далайд гарцгүй орон билээ. Уул уурхайн салбараас өндөр хамааралтай (нийт экспортын 90 орчим хувь), гадаад худалдааны хувьд нэг хөрштэй хийх худалдаа хэт давамгайлсан (нийт экспортын 90 орчим хувь нь БНХАУ-уруу гардаг), нийт хүн амын ойролцоогоор тэн хагас нь нийслэл хот болох Улаанбаатарт оршин суудаг юм. Эдийн засгийн өсөлт нь маш өндөр байсан (2011 онд дэлхийд хамгийн өндөр буюу эдийн засаг нь 17 гаруй хувиар өссөн) боловч өсөлтийн динамик нь маш тогтворгүй (2017 онд эхэлсэн 5.5 тэрбум долларын олон талт дэмжлэгийн үр дүнд 2016 оноос эдийн засгийн өсөлт нь тогтворжиж байгаа) байгаа юм.
- 2. Тус улс нь хэд хэдэн давуу талуудтай. Үүнд:** Дэлхийн хэмжээний ашигт малтмалын орд газруудтай (кокежих нүүрс, зэс, алт гэх мэт), бэлчээрийн талбай болон онгон байгальтай, дэлхийн хоёр дахь том эдийн засаг (БНХАУ)-тай хиллэдэг бөгөөд хүн амын дийлэнх нь боловсролтой юм. 1990-ээд оны эхэн үед зах зээлийн баримжаатай ардчилсан нийгэмд тайван замаар шилжин орсноос хойш ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх чиглэлээр ихээхэн амжилт гаргасан. Дотоодын хувийн хэвшил нь бүхий л салбарт (банк, үл хөдлөх хөрөнгө, харилцаа холбоо, хоол хүнс, ундаа гэх мэт) ихээхэн өргөжин тэлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт урсгал хэдий тогтмол бус ч орж ирэх хүлээлттэй байна.
- 3. Монгол Улс нь 1990-ээд оны эхэн үеэс эхлэн эрчимтэй хөгжиж, зах зээлийн баримжаа бүхий ардчилалд амжилттай шилжсэн.** Тус улс 1992, 1993 оноос хойш парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн жил тутам тасралтгүй явуулж ирсэн бөгөөд бүх тохиолдолд тайван замаар эрх мэдлийг шилжүүлж ирсэн байна (2008 онд болсон сонгуулийн дараа хүч хэрэглэсэн явдлаас бусад тохиолдолд). Энэ хугацаанд хүн амын дундаж наслалт 60-аас 69 болж, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмж 46-аас 60 хувь, цахилгаан эрчим хүчний хэрэглээ 64-өөс 85 хувь болж өссөн бөгөөд бага сургуулийн хүүхдүүдийн сургууль завсардалт 20-иос 3 хувь, хөдөөгийн хүн амын тоо 42-оос 27 хувь болж буурчээ. Эхийн эндэгдэл сүүлийн 10 жилд 50 хувиар буурч (100,000 амьд төрөлт тутамд 100-аас 50 хүртэл), гар утасны сүлжээ хүн амын 99 хувийг хамран, үүнээс 70 хувийг нь ухаалаг гар утасны хэрэглээ эзэлж байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2015 онд 1990 оны түвшнөөс хоёр дахин өссөн байна. Хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж 1990 онд ДНБ-д эзлэх хувийн жин нь 12 хувьтай тэнцэж байсан бол 2005 онд 25 хувь, 2012 онд бүр 40 хувьд хүрч өсөн эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэв. Банкны үйлчилгээний хүртээмжийн хувьд Монгол Улс дэлхийд хамгийн өндөр үзүүлэлттэй улсуудын нэг бөгөөд санхүүжилт нь үргэлжлэн өсч байна.
- 4. Урт хугацаандаа Монгол Улс ийнхүү ололт амжилт гаргасан хэдий ч өдгөө дараах гурван үндсэн бэрхшээлтэй тулгараад байна. Үүнд: эдийн засгийн өсөлт тогтворгүй, хүн амын аж байдлын түвшин эрсдэлтэй, байгаль орчны хямрал орно.** Өнгөрсөн хорин таван жилийн хугацаанд Монгол Улс эдийн засгийн гурван хямралыг даван туулж, ОУВС-ийн зургаан хөтөлбөрт хамрагдсан байдаг (одоо хэрэгжиж буй Өргөтгөсөн Санхүүжилтийн хөтөлбөрийг оруулаад). 2016 оны хос алдагдлын хямрал нь бүтцийн үндсэн хоёр асуудлыг үүсгэсэн. Нэг талаас төсвийн алдагдал огцом өсч, ЗГ-ын өр нэмэгдэж байсан нь төсвийн зохисгүй удирдлагаас голлон шалтгаалж байв. Нөгөө талаас, төлбөрийн тэнцлийн алдагдлын тогтворгүй байдал нь гадаад валютын цөөн эх үүсвэр (экспортын цөөн бүтээгдэхүүн/нэг зах зээл, уул уурхайн бүтээгдэхүүнд голлон чиглэсэн ГШХО, өрийн өсөлт)-тэй байсантай холбоотой байв. Өсөлт,

уналтын эдгээр мөчлөг нь амьжиргааны түвшнийг сайжруулахад эрсдэл учруулсан. Эдийн засгийн өсөлт 2014-16 онуудад огцом удааширсан нь бодит цалин хөлс болон хөдөлмөр эрхлэлтийг ихээхэн бууруулахад нөлөөлсөн. Ингэснээр хурдтай буурч байсан ядуурлын түвшний үзүүлэлтүүд эргээд өссөн. Ядуурлын түвшний албан ёсны тооцоогоор Монгол Улс дахь ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувь байсан бол 2014 онд 21.6 хувь болж буурч, харин 2016 онд 29.6 хувь болж өсөөд байна.

- 5. Нөгөө талаар, уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн нөөцийн доройтлын үр нөлөө илүү урт хугацааны туршид үргэлжилсээр байна.** Уур амьсгалын өөрчлөлт ба хүний үйл ажиллагааны улмаас гамшгийн эрсдэл, хүрээлэн буй орчны доройтол ихээхэн нэмэгдсэн. Өнгөрсөн жаран жилийн хугацаанд байгалийн гамшиг (зуд, ган, үер)-ийн давтамж, эрч нэмэгдэхийн зэрэгцээ Монгол Улсын агаарын дундаж хэм өсөх хандлагатай байгаа нь тодорхой байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эдгээр хүчин зүйлс нь хурдацтай явагдаж буй хотжилт, уул уурхайн үйлдвэржилт, бүтээмж багатай хөдөө аж ахуй зэрэгцэн агаарын бохирдлыг нэмэгдүүлж (Улаанбаатар хот агаарын чанарын үзүүлэлтээр, ялангуяа өвлийн улиралд дэлхийд хамгийн муу хотуудын нэгд орж байна), ус (нөхөн сэргээгдэх усан хангамжийн нийт зарцуулалт, зарим газарт жил бүр наад зах нь 50%-иар), бэлчээр (бэлчээрийн талбайн 90 хувь нь тодорхой хэмжээнд цөлжилтөд нэрвэгдсэн)-ийг доройтуулж байна. Эдгээр бүх асуудал, хүчин зүйлийг арилгах эсвэл тогтоон барихгүй бол дунд болон урт хугацаандаа эдийн засгийн өсөлт, хүн амын аж байдлын түвшинд саад учруулж болзошгүй юм.

Тулгамдаж буй сорилтууд ба хөгжлийн стратеги

- 6. Монгол Улс хөгжлийн гурван үндсэн бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд тэдгээрийг даван туулах хоёр үндсэн стратеги байна.** Гурван сорилтын хувьд: эхнийх нь илүү тогтвортой, олон талт эдийн засгийн өсөлтийн бодлогыг баримтлах; хоёрдугаарт, хүн амын амьжиргааны түвшнийг цаашид сайжруулахдаа ядуурлыг бууруулах чиг хандлагыг сэргээх, гуравдугаарт, байгаль орчны доройтлоос сэргийлэх, эсвэл арилгах замаар тогтвортой байдлыг бэхжүүлэх. Энэхүү Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ нь эдгээр зорилгод хүрэх хоёр үндсэн стратегийг санал болгож байна. Нэг талаас, Засгийн газрын төлөвлөгөө, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үр ашигтай зохицуулалтууд болон чадварлаг институциудыг бий болгох. Энэхүү "биет бус капитал" нь түүхий эдээс ихээхэн хамааралтай, тэдгээрээс үүдсэн өсөлт, уналтын мөчлөгөөс шалтгаалан мэргэжлийн болон улс төрийн зохицуулалт хийхэд нэн хүндрэлтэй байдаг баялгийн нөөцийн орлогыг илүү сайн удирдах, бизнесийн өрсөлдөхүйц орчныг дэмжих, чанартай нийгмийн үйлчилгээг хүргэх, байгалийн нөөцийг хамгаалахад шаардлагатай юм. Нөгөө талаас илүү төрөлжсөн санхүүгийн, биет болон хүний капиталыг хуримтлуулах шаардлагатай. Эдгээр "бодит хуримтлал" нь түүхий эдийн экспортоос эдийн засгийн үр өгөөж бүхий капитал бий болгоход чиглэгдэж, улмаар улс орны хөрөнгө, өрсөлдөх чадвар нь байгалийн баялгаас илүүтэй хүний болон бусад капиталд тулгуурласнаар эдийн засаг аяндаа өөрийн эрчимээр төрөлжих юм.
- 7. "Биет бус капитал"-ийн хувьд "хэрэгжилт сул" байна.** Өөрөөр хэлбэл, Монгол улсын хууль тогтоомжууд нь олон салбарт хатуу чанд, орчин үетэй нийцсэн хэдий ч хүчин төгөлдөр хууль тогтоомжуудын хэрэгжилтийг сайн хангах, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, тус улс түүхий эдийн үнийн хэлбэлзэл, түүний төсөвт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг гаргасан. Үүний зэрэгцээ, санхүүгийн салбарыг бэхжүүлэхийн тулд олон тооны дүрэм журмыг боловсруулж нэвтрүүлсэн боловч, Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтуудыг дагаж мөрдөөгүй бөгөөд 2012 оноос хойш олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, санхүүгийн салбарын зохицуулалтыг сулруулж байна. Хууль, тогтоомжийн хэрэгжилтэд учирч буй энэхүү хүндрэл нь төрийн байгууллагууд болон төрийн албаны тогтворгүй байдалтай холбоотой.

8. **Эрүүл мэнд, хотжилт, байгалийн нөөцийн удирдлагын хэрэгжилтийн тулгамдсан асуудал мөн түгээмэл байна.** Эдгээр салбар дахь олон тооны сайн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд нэгдмэл бус санхүүжилт болон байгууллага хоорондын бодлогын зохицуулалт сул байгаа нь сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Монгол улсын эрүүл мэндийн салбар дахь нийт зарцуулалт ижил төстэй бусад улс орнуудтай харьцуулахад ижил түвшинд байгаа боловч тус улсад халдварт бус өвчний тохиолдол өндөр байдаг тул үүнд чиглэсэн санхүүжилт бодит хэрэгцээнээс бага байна. Улаанбаатар хотод ус, цахилгаан, тээврийн компаниуд алдагдалтай ажиллаж, зардлаа нөхөж чадахгүй байгаагаас гадна шинэ хөрөнгө оруулалт, шинэчлэл хийх боломжуудыг хязгаарласан зохицуулалттай тулгарч байна. Усны эх үүсвэрийн хомсдол, агаарын бохирдлын өсөлт, бэлчээрийн доройтол, гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа нь олон тооны төлөвлөгөөнүүдийн үр нөлөө болон одоогийн байгаа хууль тогтоомжуудын хэрэгжилтэд эргэлзэхэд хүргэж байна. Зарим тохиолдолд асуудлын цар хүрээ, шаардлагатай нийт зардлын хэмжээ (жишээ нь, УБ хотын агаарын бохирдлын асуудлын хувьд) богино хугацаанд ахиц дэвшил гаргахад тушаа болох нь байгаа бол бусад тохиолдолд ялгаатай ашиг сонирхол бүхий нийгмийн олон бүлгүүдийн хооронд үүсэж буй улс төр эдийн засгийн сөргөлдөөн, тэдгээрийн зохицуулалт сул байгаа зэрэг нь улс орны бодит баялгийн үнэ цэнийг хадгалах хөгжил дэвшилд саад учруулж байна.
9. **"Бодит хуримтлал"-ын хувьд холимог байдалтай: уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хүчтэй байгаа хэдий ч дэд бүтэц болон бусад хөрөнгийн хувьд хуримтлал дутагдаж байна.** Нийт ДНБ-д эзлэх хөрөнгийн хуримтлал (голдуу ГШХО-аас бөгөөд ихэвчлэн олборлох салбараас 80 гаруй хувь, ялангуяа Оюу Толгой) 1994 онд 18 хувь байсан бол 2012 онд 50 хувь болж өссөн боловч ГШХО-ын зохицуулалт тогтвортой бус байсан болон урьдчилан таамаглах боломжгүй байсан хөрөнгө оруулалтын орчин үүссэнээс 2016 онд 21 хувь болж буурсан. Энэхүү үйл явц нь эдийн засгийг илүү хөрөнгө давамгайлсан, үр ашигтай болгосон. Энэ хөрөнгө хуримтлуулах үйл явц нь голдуу гадаадын шууд хөрөнгө оруулалт ба улсын өрөөр дамжин гадаад хадгаламжаар санхүүжигдсэн байна. Монголын эдийн засгийн хувьд дотоодын хуримтлалыг бүтээмжтэй үйл ажиллагаанд чиглүүлэн дайчлах асуудал ихээхэн чухал хэвээр байна. Монгол Улсад хувь хүний санхүүгийн хүртээмж дундаж орлоготой улсуудтай ижил түвшинд хүрч нэмэгдсэн. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарт өндөр эрсдэл бүхий банкны тогтолцоо давамгайлж, энэхүү тогтолцоо нь улсын нийт санхүүгийн хөрөнгийн 95 хувийг эзэлж байгаагийн зэрэгцээ аж ахуйн нэгж болон ЖДҮ-дэд санхүүжилт авах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Тээврийн дэд бүтэц хангалтгүй хэвээр байгаа бөгөөд 2016 оны байдлаар нийт замын сүлжээний зөвхөн тавны нэг нь хатуу хучилттай, хайрган эсвэл сайжруулсан зам байна. 2015 онд Монгол Улс замын чанараараа 118 дугаарт жагссан нь ижил төстэй орлоготой орнуудын түвшнээс ихээхэн доогуур үзүүлэлт юм. Тээврийн дэд бүтцийн сүлжээ муу байгаа нь Монгол Улсын бизнесийн орчны нэг томоохон саад тотгор болж байгааг Бизнес эрхлэхүй, Аж ахуйн нэгжийн судалгаа, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Логистикийн гүйцэтгэлийн индекс (LPI) зэрэг судалгаанууд харуулж байна. Жишээлбэл, Монгол Улс дэлхийн өрсөлдөх чадварын индексээр 2016 онд 102-т жагсаж, Логистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)-ээр 108-р байр эзэлжээ. Худалдаа, тээвэртэй холбоотой дэд бүтцийн чанарын хувьд 160 улсаас 140-т орсон байна.
10. **Хүний капиталын хуримтлал, байгалийн нөөцийн хамгаалал чиглэлээр мөн ижил төрлийн асуудлууд тулгарч байна.** Жишиж болохуйц улс орнуудтай харьцуулахад хүн амын дундаж наслалт доогуур, халдварт бус өвчний тохиолдол нэмэгдэж байгаа нь хүн амын аж байдлын түвшинд ноцтой эрсдэл учруулж байна. Нийт хүн амын бараг тэн хагас нь гэрт амьдарч (2015 оны хүн амын тооллогоор 45 хувьтай байсан) байгаа бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, төвлөрсөйн хүртээмж хязгаарлагдмал байгаатай холбоотой хүн амын эмзэг аж байдн халаалт, тээвриалд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Улаанбаатар хотын агаарын бохирдол дэлхийн бүх нийслэл хотуудын дунд хамгийн муу байна. Нийслэлийн хурдацтай хотжилт болон орон нутаг дахь уул уурхай, мал аж ахуйн салбарын

хөгжил нь зарим орон нутагт усны ноцтой хомсдлыг бий болгосон. Хөдөө орон нутагт амьжиргааны гол эх үүсвэр нь хөдөө аж ахуйд суурилсан бөгөөд ойгүйжилт, малын тоо толгой өссөнөөс үүдсэн бэлчээрийн доройтол бий болж, бэлчээрийн дор хаяж 90 хувьд нь ямар нэг хэмжээгээр цөлжилт явагдаж байна. 2016 оны байдлаар эрүүл мэндийн эрсдэлийн эдийн засгийн нийт зардал (2011 оны тогтмол ам.доллараар) 1995 онтой харьцуулахад даруй гурав дахин их болсон байна. Хүлэмжийн хийн ялгарал ихээхэн хэмжээгээр нэмэгдсний дотор хүлэмжийн хийн түлшнээс (1995 оноос 2015 он хүртэлх хугацаанд 10 дахин нэмэгдсэн) болон хөдөө аж ахуйн салбараас (ижил хугацаанд хоёр дахин) их хэмжээгээр нэмэгдсэн. Ингэснээр хүрээлэн буй орчны болон эрүүл мэндийн нийт зардал 1995 оноос хойш өсч, өдгөө 1990 оны үзүүлэлтээс ч өндөр түвшинд хүрчээ.

Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалт

11. Монгол Улс: цогц дүн шинжилгээ нь эдийн засгийн гол асуудлууд болон эдгээрийн ерөнхий шалтгааныг тодорхойлохын зэрэгцээ хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалтыг санал болгож байна. Энэхүү жагсаалтыг дараах зүйлүүдийг нэгтгэн авч үзэсний үндсэн дээр гаргасан болно. Үүнд: (i) тоон харьцуулсан үзүүлэлтүүд, (ii) оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтууд ба (iii) Дэлхийн Банкны Группын мэргэжилтнүүдийн шинжилгээ судалгаа. Харьцуулалтыг хийх явцад Монгол улсын гүйцэтгэлийг дэлхийн бүх орнуудтай болон сонгосон "ижил төстэй нөхцөл байдал бүхий" цөөхөн орнуудтай хөгжлийн тодорхой үзүүлэлтүүдийн дагуу харьцуулан (110 орчим индексүүд, голчлон Дэлхийн хөгжлийн индексээс) хэмжсэн. Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтаар Улаанбаатар хот болон 5 аймгийн 400 орчим хүнээс саналыг нь авснаас гадна 600 орчим хүн цахим судалгаанд (судалгаанд оролцогчдын 91 хувь нь монгол хэл дээр судалгааг бөглөсөн) оролцсон байна. Эцэст нь, энэхүү Монгол Улс: цогц дүн шинжилгээг боловсруулахад хувь нэмрээ оруулсан Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, энэхүү тойм судалгаа, харьцуулсан үзүүлэлтүүд болон оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтуудаас гарсан мэдээллүүд дээр үндэслэн Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн дарааллыг тодорхойлох семинарт оролцсон. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд хөгжлийн хоёр төрлийн сорилтыг тодорхойлоод байна. Нэгдүгээрт, харьцуулсан үзүүлэлтүүд, оролцогч талууд болон банкны мэргэжилтнүүдийн өгсөн бүх төрлийн мэдээлэлд хөгжлийн тулгарч буй гол сорилт нь засаглал гэж дурьдсан байна. Хоёрдугаарт, нэг хэсэг сорилтуудын хамрах хүрээ нь давхцаж байгаа нь хөгжлийн гол сорилт болж байна. Дээрх зүйлүүд дээр үндэслэн дараах тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг гаргасан болно.

Засаглал: бүх гол сорилтуудын суурь шалтгаан

12. Төсвийн тогтвортой байдлыг хангах болон нийгмийн бодлогоос эхлээд хотжилт, хүрээлэн буй орчны хамгааллын хүрээнд сүүлийн жилүүдэд гарч буй үр дүнгүүд тогтворгүй байгаагийн гол суурь шалтгаан нь засаглал сул байгаатай холбоотой байна. Тиймээс засаглалыг сайжруулах нь хөгжлийн өнөөдрийн гол саад тотгоруудыг арилгах, урт хугацаанд үр нөлөө үзүүлэх гол түлхүүр юм. Засаглалын ерөнхий гурван асуудлыг онцлон тэмдэглэвэл: мөчлөг дагасан сонгуулийн бодлого (өсөлт-уналт-тусламж мөчлөгийг улам хүндрүүлэх), хууль тогтоомжийг даган мөрдөх, хэрэгжүүлэх явдал хангалтгүй (“хэрэгжилтийн сул байдал”), улс төрчдийн ашиг хонжоо харсан түншлэлд суурилсан /клиентилистик/ улс төрийн өрсөлдөөн, парламент солигдсоны дараах байнгын өөрчлөлтүүд (төрийн албан хаагчид байнга бүтцийн өөрчлөлтөд орох, солигдох). Эдгээрийг үйл ажиллагааны талаас нь илүүтэй авч үзвэл, төсвийн тогтвортой байдал, төсвийн хөрөнгө оруулалтын чанар ба түүнийг урьдчилан хэлэх боломж, төрийн албаны чадавх ба тууштай залгамж чанар зэрэгтэй холбоотой асуудлуудыг бий болгож байна.

13. Төрийн албаны үйлчилгээ, төрийн албаны удирдлагыг сайжруулснаар “хэрэгжилтийн цоорхой”-н асуудал тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэх боломжтой. Ажил албаа гүйцэтгэх

урам зориг, ур чадвар бүхий төрийн албан хаагчид олон тооны дүрэм журмыг гүйцэтгэх үүрэг хүлээдэг. Гэтэл төрийн албан хаагчдыг эрх мэдэл, танил талаараа зуучлан томилсноор хамгийн авьяас чадвартай хүмүүс дэвшин ажиллах тогтолцоог алдагдуулж байна. Ингэснээр үнэ цэнэтэй мэргэжлийн ур чадвар бүхий авьяаслаг боловсон хүчнээ алдаж, одоогийн мэргэжилтнүүдийн ур чадварын зааг ялгаа улам нэмэгдэх, төрийн албаны чадал, чадавхи буурч, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд эрсдэл гарахад хүргэж болзошгүй. Түүнээс гадна төсвийн зардлыг илүү үр ашигтай болгохын тулд төсвийн мэдээлэл, санхүүгийн болон төрийн худалдан авах ажиллагааны удирдлагад байгаа дутагдалтай сул талуудыг арилгах хэрэгтэй байна. Эдгээр нь улс төрчдийн ашиг хонжоо эрэлхийлсэн ивээн тэтгэлэгт байдал ба авилгын талаарх нийгмийн урьдчилсан төсөөллийг нэмэгдүүлэхэд хүргэдэг улс төрийн өрсөлдөөнөөс үүссэн засаглалын гүнзгий асуудлын илрэл юм.

14. **Макро эдийн засгийн оновчтой удирдлага нь засаглалын хамгийн тулгамдсан асуудал байж болзошгүй юм.** Тогтвортой бус урсгал данс болон төсвийн алдагдлаас үүдэлтэй 2016 оны эдийн засгийн огцом хүндрэл нь “Өсөлт-Уналт (Boom-Bust Cycle)” мөчлөгийн эрсдлийг харуулсан. Макро эдийн засгийн оновчтой удирдлагыг бэхжүүлэхэд чиглэгдсэн одоог хүртэл хүлээгдэж буй ажлыг гүйцэтгэхэд тууштай үргэлжлүүлэх шаардлагатай. Эрх баригчид төсвийн тогтмол алдагдлыг зохистой түвшинд хүртэл бууруулах, улсын өрийн өсөлтийг хязгаарлах хэрэгтэй. Түүхий эдийн үнийн өсөлт, уналтын мөчлөгт өртөмтгий, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийн эмзэг хэвээр байгаа энэ нөхцөлд төсвийн мөчлөг-сөрсөн бодлогыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн тогтворгүй байдлыг зөөлрүүлэхэд чухал юм. Харин мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлын зорилтдоо тууштай байж, мөнгөний уламжлалт бодлогын хэрэгслүүдээр дамжуулан хөрвөх чадварыг хангах, төсвийн үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийхэд чиглэгдэх нь зүйтэй.

Ажлын байр, хувийн хэвшлийн хөгжил: ихэнх Монголчуудын хувьд суурь асуудал байсаар байна

15. **Ажил, хөдөлмөр эрхлэлт ба цалин хөлс нь ядуурлыг бууруулах хамгийн чухал үндсэн хүчин зүйл мөн боловч ирээдүйн илүү өндөр чанартай ажилд нийцүүлэн ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх хэрэгтэй байна.** Сүүлийн жилүүдэд хот суурин газруудад хувийн хэвшлээр дамжин, харин хөдөө орон нутагт фермийн аж ахуйгаар дамжин илүү өндөр орлого бүхий ажлын байрууд бий болсон нь ядуурлыг бууруулах гол хүчин зүйл болж байна. Хөдөлмөр эрхлэлтийн энэхүү өсөлтийн зэрэгцээ хөдөө аж ахуйгаас үйлчилгээний салбарт шилжих бүтцийн болон ур чадварын өөрчлөлт явагдаж байгаа нь сайшаалтай бөгөөд үүнд Монгол Улсын суурь боловсролын тогтолцоо мөн дэмжлэг болж байна. Гэсэн хэдий ч ажилгүйдлийн түвшин өндөр, ялангуяа хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа нь цаашид ажлын байр бий болгох чиглэлд илүү ихийг хийх хэрэгтэйг харуулж байна. Эдийн засаг өсч, улам бүр нарийн төвөгтэй болсноор сүүлийн үеийн төгсөгчдийн ур чадвар (ялангуяа дээд боловсролын түвшинд) нь ажлын байрны шаардлага хангахгүй, улмаар хөдөлмөр эрхлэлт, бүтээмж зогсонги байдалд ороход сөргөөр нөлөөлөх гол шалтгаан болж байгааг орон нутгийн оролцогч талууд онцолж байв.
16. **Хувийн хэвшлийн хөгжил: Хувийн хэвшил нь улс орны хөгжил болон ажлын байрны хөдөлгөгч хүч боловч төсвийн шахалт болон урьдчилан тааварлах боломжгүй хөрөнгө оруулалтын орчноор хязгаарлагдаж байдаг.** Бизнес эрхлэхүй судалгааны индикаторууд сайжирч, тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үздэг дэд бүтэц хязгаарлагдмал байгаа ч тусгай зөвшөөрөл, санхүүжилтийн талаарх мэдээллийн хүртээмж тэнцвэргүй, зохицуулалтууд байнга өөрчлөгдөж байдгаас хувийн хөрөнгө оруулагчид Монгол улсыг хөрөнгө оруулахад өндөр эрсдэлтэй гэж үзсэн хэвээр байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг бэхжүүлэх, санхүүгийн салбар, ялангуяа жижиг дунд үйлдвэрийн чанарыг сайжруулах, мөн хяналт шалгалтын шинэчлэл, хүнсний аюулгүй байдал, худалдааны логистик зэрэгт тусгайлан чиглэсэн

худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийг улам гүйнзгийрүүлснээр энэхүү асуудлыг буцаан хэвэнд нь оруулж болох юм.

Хүний капиталын хуримтлал ба хамгаалал: ашигт малтмалын баялгийг хүн амын аж байдлыг сайжруулахад чиглүүлэх

17. **Сүүлийн хорин жилийн хугацаанд эрүүл мэндийн үйлчилгээнд ахиц дэвшлүүд гарч байгаа боловч цаашид чанарыг сайжруулахад илүү их хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.** Дундаж наслалт, эх ба нярайн эндэгдэл, халдварт өвчин зэрэг хүн амын аж байдлын түвшний гол үзүүлэлтүүд сүүлийн 20 жилийн хугацаанд эерэг чиглэлд өөрчлөгдөж байна. Гэвч хөрш орнуудтай харьцуулахад дундаж наслалт (2015 онд 69 байсан) харьцангуй доогуур байна. Халдварт бус өвчний тархалт нэмэгдэж, 2015 оны байдлаар нийт нас баралтын шалтгааны 78 хувийг эзэлснээр ижил түвшний орнуудын жагсаалтын сүүлийн хагаст эрэмбэлэгдэж байна. Үүний дээр гэр бүлийн хүчирхийлэл, хот хөдөөд үйлчилгээний хүртээмж ялгаатай зэрэг бусад асуудлууд байсаар байна. Эдгээр хүндрэл, бэрхшээлүүд нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэн, чанарыг сайжруулахын зэрэгцээ халдварт бус өвчинтэй тэмцэхийн тулд эмнэлгийн тогтолцоон дахь урамшууллын системийг илүү оновчтой болгох хэрэгтэйг харуулж байна.
18. **Боловсрол: Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш боловсролын салбарт гайхалтай хөгжил дэвшил гарсан хэдий ч Монгол улсын хөгжлийн хэрэгцээг хангахын тулд боловсролын салбарт байнга хөрөнгө оруулалт хийж, шинэчилж байх шаардлагатай.** Монгол Улсын суурь боловсролын хүчтэй тогтолцоо болон бараг бүх нийтээр бичиг үсэг тайлагдсан байдал нь сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлсөн байна. Өнөөгийн байдлаар тус улсын боловсролын салбар дахь төсвийн хөрөнгийн зарцуулалт дунд түвшинд (ижил түвшний улс орнуудтай харьцуулахад) байгаа бөгөөд хүн ам нь бүтцийн хувьд залуу, хотжилт хурдацтай явагдаж байгаагаас шалтгаалан боловсролын салбарын үйлчилгээ, ялангуяа сургуулийн өмнөх боловсролын эрэлт-нийлүүлэлтийн зөрүү ихэссээр байна. Түүнчлэн улс орны эдийн засаг цаашид хөгжин, дэлхийн зах зээлтэй холбогдохын хэрээр илүү өндөр үнэлэмж бүхий ажлын байранд ирээдүйн ажиллах хүчнийг бэлтгэхийн тулд дээд боловсрол, мэргэжлийн боловсролын чанарыг дээшлүүлэх хэрэгтэй байна. Боловсрол, эрүүл мэнд, суурь дэд бүтцэд хөрөнгө оруулах нь Монгол улсад бүтээмжийн өгөөжийг (илүү сайн ажил, орлого г.м) ирээдүйд бий болгоход шаардлагатай нийгмийн капитал/хөрөнгө/-ыг (жишээ нь, бүтээмжтэй хөрөнгө) бий болгодог.
19. **Нийгмийн хамгаалал: Хамгийн ядуу иргэдийг хамгаалах, тэдэнд хүртээмжтэй суурь үйлчилгээ үзүүлэх нь чухал бөгөөд нийгмийн хамгаалал нь зорилтот бүлэгт илүүтэй чиглэсэн, төсвийн хувьд тогтвортой байх шаардлагатай.** Нийгмийн хамгааллын тогтолцоо нь хамрах хүрээний хувьд хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч макро эдийн засгийн цочрол болон ядуурлыг бууруулахад үзүүлэх үр нөлөө нь хязгаарлагдмал байсаар байна. Хэдийгээр нийгмийн халамжийн олон хөтөлбөрүүд ядуу, эмзэг бүлэгт илүүтэй хүрдэг хэдий ч зорилтот бүлгээ хүн амын бүлгээр тодорхойлдог эсвэл нийтийг хамарсан байдлаар олгодог хэвээрт байна. Цаашид дараах өөрчлөлтийг хийх шаардлагатай байна. Үүнд: (i) хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүртээмжийг сайжруулах; (ii) эдийн засгийн цочрол хүндрэлийг даван туулах илүү үр нөлөөтэй арг хэрэгсэл болгох, ингэхдээ иргэдийн амьжиргааны түвшнээс хамааруулж, зорилтот бүлэгт илүү чиглэсэн байх; ба (iii) санхүүгийн хувьд илүү тогтвортой үргэлжлэх боломжтой байх. Тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийхгүй бол өдгөө тэтгэвэрт зориулсан төсвийн татаасын хэмжээ 2030 онд 6 хувь, 2050 онд 11 хувьд хүрэхээр байгаа тул тэтгэврийн тогтолцооны асуудалд тусгайлан анхаарах шаардлагатай байна.

Дэд бүтэц: эдийн засгаа цаашид төрөлжүүлэхэд голлох үүрэгтэй

20. **Олон тооны үзүүлэлтээс харахад Монгол Улс дэд бүтцийн хувьд дэлхийд хамгийн доогуур түвшинд байна.** Энэ нь улс орны өрсөлдөх чадварт илэрхий хязгаарлалт болж байна. Дэлхийн эдийн засгийн форумын 2016 оны үзүүлэлтээр Монгол Улсын дэд бүтцийн салбар 138 орноос 110 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Томоохон дэд бүтцийн төслүүд нь улс орны хөгжлийг хурдасгах болон улсын орлого бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч улс төрийн шалтгаанаар гацаанд орох эрсдэлтэй (мөн л засаглалын асуудал) төдийгүй голлох дэд бүтцэд (эрчим хүч, дулаан, ус, тээвэр) төр давамгайлсан байдалтай, хувийн хэвшлийн оролцоо, тэр дундаа төр, хувийн хэвшлийн түншлэл хүртэл хязгаарлагдмал байна. Газар зүйн байршлын хувьд далайд гарцгүй тул тээвэр, логистикийн асуудал нь худалдаанд (ялангуяа аялал жуулчлал, хөдөө аж ахуй) саад тотгор болж, бүс нутгийн төв болох боломжид сөргөөр нөлөөлж байна. Цахилгаан эрчим хүч, ус, тээвэр зэрэг үндсэн дэд бүтэц дэх төрийн оролцоо маш их бөгөөд цаашид ч эдгээр салбарт чухал үүрэгтэй хэвээр байх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хувилбаруудаас сонгох нь төсвийн дарамт, улсын өрийн өсөлтийг бууруулж, эцсийн хэрэглэгчдэд технологийн дэвшил, сайн засаглал, илүү үр ашигтай үйлчилгээг хүргэх болно.

Байгалийн баялгийг хамгаалах: Уг асуудалд алсын хараагүй хандах нь маш том алдаа болно.

21. **Байгалийн баялгийн доройтолд уур амьсгалын өөрчлөлт болон эдийн засгийн хөгжлийн үзүүлэх үр нөлөө.** Зарим бүс нутаг дахь усны нөөцийн хомсдол, Улаанбаатар хотын агаарын их хэмжээний бохирдол, бэлчээрийн доройтолт, гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа зэрэг нь байгалийн нөөцийн тухай хуулиудыг чанд хэрэгжүүлэхийг шаардаж байна. Байгаль орчны доройтлыг зогсоох чиглэлд олон чухал ажил хийх оролдлого гарч байгаа боловч эрх баригчид цаашид илүү алсын хараатай бодлого хэрэгжүүлэх, мөн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Нэг талаас байгалийн баялгийг ашиглахтай холбоотой хууль ёсны ашиг сонирхлын зөрчлүүд үүсч байгааг ил тодоор хэлэлцэж, сул давуу талуудыг ярилцах нь зүйтэй. Нөгөө талаас олон нийт болон бодлого боловсруулагчдын ойлголт, мэдлэг энэ салбарт хязгаарлагдмал байгаа нь эдгээр хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхгүй байх, нөөцийг улам хомсдохоос урьдчилан сэргийлэх зохистой бодлого хэрэгжүүлэхгүй байх харалган байдалд хүргэж байна. Цаашид Улаанбаатар хотын халаалт, дулааны асуудлыг шийдэх хувилбарууд, бэлчээрийн удирдлагыг сайжруулахын тулд малчдын дунд чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, усны шинэ эх үүсвэрүүдийн зохистой ашиглалт ба хамгаалалт, усны засаглалыг илүү үр дүнтэй удирдан зохион байгуулах зэрэг чухал санаачилгуудыг эхлүүлэх шаардлагатай юм

Дүгнэлт

22. **Дүгнэж үзэхэд, Монгол Улс чамгүй ахиц дэвшил гаргаж чадсан боловч тогтворгүй байдал улам бүр нэмэгдэж, энэ нь ирээдүйн эдийн засгийг төрөлжүүлэх биет ба хүний капитал буюу "бодит хуримтлал" маш багыг бий болгосон ба ашигт малтмалын түүхий эдээс хамааралтай тогтворгүй эдийн засгийг удирдан зохицуулах "биет бус капитал"-ыг үүсгэж хараахан амжаагүй байгааг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн энэхүү дүн шинжилгээ харуулж байна.** Энэхүү товч хураангуйд дурьдсан хөгжлийн ерөнхий тулгамдсан асуудлуудаас харахад хөгжлийн зорилтууд нь Монгол Улсын өсөлтийг тууштай байлгах, хүн амын аж байдлыг цаашид улам сайжруулах, тогтвортой байдлыг бэхжүүлэх ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, эсвэл учирсан сөрөг нөлөөг эргүүлэхэд чиглэгдэх ёстой. Энэхүү дүн шинжилгээ, оношилгоон дээрээс үзэхэд, үүнийг тулд тогтворгүй байдлыг удирдан зохицуулах, олон төрлийн хөрөнгийг хуримтлуулах шаардлагатай. Дээр дурдсан

тэргүүлэх чиглэлийн нарийвчилсан үйл ажиллагаануудыг стратегийн хоёр агуулгын хувьд хураангуйлан ангилж дараах хүснэгтэд оруулав.

	Бүтээмжит хөрөнгийг төрөлжүүлэхийн тулд "бодит хуримтлал"-ыг нэгтгэн цуглуулах	Түүхий эдэд суурилсан экспортын тогтворгүй байдлыг удирдан зохицуулах "биет бус капитал"-ыг үүсгэх
Засаглал	<ul style="list-style-type: none"> i. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын оновчтой удирдлага; ii. Дунд хугацааны өрийн удирдлагыг бэхжүүлэх; 	<ul style="list-style-type: none"> iii. Мэдлэг, ур чадварыг үндэслэн албан тушаалд томилдог тогтолцоог сэргээж, мэргэжлийн ажилтнуудын гадагш чиглэсэн урсгалыг багасгах; iv. Улсын төсвийн нэгдсэн, ил тод байдлыг нэмэгдүүлэх; v. Макро эдийн засгийн оновчтой бөгөөд тогтвортой удирдлагын тогтолцоог сэргээх.
Ажил хувийн хэвшлийн хөгжил ба	<ul style="list-style-type: none"> i. Орчин үеийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөрүүд; ii. Бизнес эрхлэх сургалт ба санхүүжилтийг дэмжих; iii. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх; 	<ul style="list-style-type: none"> iv. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах хууль тогтоомж ба хөдөө аж ахуй, аялал жуулчлал, эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих. v. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мах ба сүүн бүтээгдэхүүний гарал үүслийг бүртгэх тогтолцоог хөгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ ба хил дамнасан өвчнийг хянахад зориулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх
Хүний капитал	<ul style="list-style-type: none"> i. Чанартай сургуулийн өмнөх ба бага, дунд боловсролын хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах; ii. Орон нутгийн сургуулиудыг сэргээн засварлаж, хот суурин газрын сургуулиудыг өргөтгөх; iii. Дээд боловсролын дэд салбар дахь шинэчлэлийг үргэлжлүүлэх 	<ul style="list-style-type: none"> i. Эрүүл мэндийн үйлчилгээг өөрчлөн зохион байгуулах (анхан шатны болон эмнэлгийн үйлчилгээний уялдааг илүү хангах) халдварт бус өвчнөөс үүсэх ачаалал нэмэгдэж байгааг анхаарах; ii. Эрүүл мэндийн санхүүжилтийн хэсэгчилсэн байдлыг багасгаж,

	<ul style="list-style-type: none"> iv. Хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүрэлцээт байдлыг сайжруулах; v. Хүн амд эдийн засгийн цочролын үзүүлэх нөлөөг багасгахад чиглэсэн хөтөлбөрүүдийг сайжруулах, ингэхдээ хүн амын амьжиргааны түвшнээс хамааруулж, зорилтот бүлэгт чиглүүсэн байдлаар болгох; vi. Тэтгэвэр, Хүүхдийн мөнгөний хөтөлбөр, нийгмийн хамгааллын санхүүгийн хувьд тогтвортой үргэлжлэх байдлыг хангах. 	эрүүл мэндийн чанарыг сайжруулах
Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> i. Оновчтой санхүүжилт бүхий зам тээврийн салбарын төлөвлөгөө хэрэгжүүлэх; ii. Гэр хорооллын замыг сайжруулж, явган хүний зам гаргах, ариун цэврийн байгууламж, эрчим хүчний дэд бүтцийг бий болгох; iii. Хөдөө орон нутагт МХХТ-ийн сүлжээг бий болгоход хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хот суурин газарт оролцох оролцоог дэмжих. iv. Дулаан, цахилгаан дамжуулах, түгээх дэд бүтцийг сайжруулах (ихэвчлэн тухайн салбарыг хувийн хөрөнгө оруулалтад нээх замаар). 	<ul style="list-style-type: none"> v. МХХТ-ийн салбарын бодлого, зохицуулалтын орчныг сайжруулах, ... vi. Эрчим хүчний зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх (голчлон тарифын шинэчлэл хийх) ба ...
Байгалийн нөөц баялаг	<ul style="list-style-type: none"> i. УБ хотын гэр хорооллын цэвэр, хямд төсөр халаалтын шийдлийг дэмжих. ii. Хямд өртөгтэй ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийг газар дээр нь хийхийг дэмжиж, бохир усыг хуримтлуулах ба цэвэрлэх зохистой бөгөөд оновчтой аргачлалыг нэвтрүүлэх. iii. Бэлчээрийн болон усны тогтвортой менежментийг нэвтрүүлэх механизмыг бий болгох замаар хөнгөн хүнд үйлдвэрлэлийн холбоод, гэрээт фермүүдийг дэмжих. 	<ul style="list-style-type: none"> i. Халаалт ба ариун цэврийн байгууламжийн эдгээр шийдлүүдийг дэмжих хууль журам болон байгууллагын бүтцийг шинэчлэх ii. Бага үет уст давхрагаас гаргасан мадчдын гар худгийн хэрэглээг харгалзан үзэж эдийн засгийн салбаруудын эрэлтийг хангахад усны зохистой хэрэглээ ба хуваарилалтыг төлөвлөхдөө газрын доорх усны үнэлгээг хийх

I ОРШИЛ

- 1. Монгол Улс нь онцгой шинж чанартай орон юм:** газар нутгийн хэмжээгээрээ Франц Улсаас (дэлхийн хамгийн их сийрэг суурьшилтай хүн амтай) гурав дахин их бөгөөд гурван сая гаруй хүн амтай, ардчилал эрчимтэй хөгжиж буй, ОХУ ба БНХАУ-ын дунд орших далайд гарцгүй, уул уурхайгаас хамаарал бүхий (нийт экспортын 90 орчим хувийг эзэлнэ), гадаад худалдааны хувьд нэг хөрштэйгээ хийх худалдаа нь нилээн давамгайлсан (улсын нийт экспортын 90 гаруй хувь БНХАУ-д гарч байна), нийт хүн амын ойролцоогоор тэн хагас нь нийслэл хот Улаанбаатарт оршин суух бөгөөд *эдийн* засгийн өсөлт, хөгжил нь гайхалтай (ДНБ нь дэлхийн хамгийн өндөр өсөлтөд хүрсэн үзүүлэлт буюу 2011 онд 17 гаруй хувьтай байсан) боловч маш тогтворгүй (2017 онд олгосон 5.5 тэрбум долларын олон талт дэмжлэгийн багцын дүнд 2016 оноос эдийн засгийн өсөлт нь тогтвортой байгаа) эдийн засагтай орон юм.
- 2. Монгол Улс хэд хэдэн давуу талтай:** Дэлхийн хэмжээний ашигт малтмалын орд газруудтай (коксжих нүүрс, зэс, алт гэх мэт), бэлчээрийн талбай болон онгон байгальтай, дэлхийн хоёр дахь том эдийн засаг (БНХАУ)-д ойрхон бөгөөд хүн амын боловсрол өндөр байна. 1990-ээд оны эхэн үед зах зээлийн баримжаатай ардчилсан нийгэмд тайвнаар шилжин орсноос хойш Монгол Улс ядуурлыг бууруулах, амьдралын сайн сайхан байдлаа дээшлүүлэх чиглэлээр ихээхэн амжилтанд хүрсэн. Хувийн хэвшил бүхий л салбарт (банк, үл хөдлөх хөрөнгийн зах зээл, харилцаа холбоо, хоол хүнс, ундаа гэх мэт) ихээхэн өргөжин тэлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь тодорхой боловч тогтмол бус шинж чанартай байна.
- 3. Монгол Улс 1990 оны эхэн үеэс нээлтэй ардчилал, зах зээлийн баримжаа бүхий эдийн засагт тайвнаар, амжилттай шилжсэн.** Тус улс 1992 (Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд 1993) оноос хойш дөрвөн жил тутам парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийг тасралтгүй явуулж ирсэн бөгөөд бүх тохиолдолд тайван замаар эрх мэдлийг шилжүүлж ирсэн байна. (2008 онд явуулсан сонгуулийн дараах хүчирхийллийн хэрэг явдлаас бусад тохиолдолд). Энэ хугацаанд тус улс нь анхаарал татахуйц шилжилт хийсэн. Хүн амын дундаж наслалт 60-аас 69 болж, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмж 46-аас 60 хувь, цахилгаан эрчим хүчний хэрэглээ 64-өөс 85 хувь болж өссөн бөгөөд бага сургуулийн хүүхдүүдийн сургууль завсардалт 20-иос 3 хувь, хөдөөгийн хүн амын тоо 42-оос 27 хувь болж буурчээ. Эхийн эндэгдэл нь сүүлийн 10 жилд тавин хувиар буурч (100,000 төрөлт тутамд 100-аас 50 хүртэл), гар утасны сүлжээ нь хүн амын 99 хувийг хамарч, үүнээс 70 хувийг нь ухаалаг гар утасны хэрэглээ эзэлж байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нь 1990 онтой харьцуулахад 2015 оны байдлаар хоёр дахин өссөн байна. Эдийн засгийн оролцоо, хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж 1990 онд ДНБ-д эзлэх хувийн жин 12 хувьтай тэнцэж байсан бол 2005 онд 25 хувь (2011, 2012 онд 40 хувиас дээш) хувиар өсөж, банк санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломж, ялангуяа ЖДҮ ийн боломж жил ирэх тусам өссөн байна.
- 4. Гэвч уул уурхайгаас хамааралтай улс орон гадаад хүчин зүйл (экспортын ганц бүтээгдэхүүн ба худалдааны ганц түншээс хэт хамааралтай) болон дотоод хүчин зүйлүүдээс (макро эдийн засгийн тогтворгүй бодлого, “implementation gap” буюу хууль**

тогтоомжийн хэрэгжилт тааруу, клиентелизм гэх мэт засаглалын асуудлуудаас шалтгаалан) шалтгаалан эдийн засаг нь өндөр хэлбэлзэлтэй байх сорилттой тулгардаг. Байгууллагын чадавх сайжирч байгаа боловч бодит хэрэгжилт түүштай бус байна. Өсөлт уналтын мөчлөг дагасан төсвийн бодлого нь макро эдийн засгийн хямралыг улам гүнзгийрүүлж байна. Хөрөнгө оруулалтын орчин нь сайжирч байгаа, цаашид ч сайжрах боломж байгаа хэдий ч саяхнаас муудаж, ялангуяа дэд бүтцэд (эрчим хүч, халаалт, ус, тээвэр) шаардлагатай гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан. Товчхондоо, сүүлийн жилүүдэд эдийн засагт гарсан холбогдох өсөлтөөс гадна Монгол Улсын засаглалын сул тал, макро эдийн засгийн тогтворгүй байдал нь хөрөнгөө оновчтой ашиглах, өсгөх чадварыг нь хязгаарлаж байна. Тиймээс нийгмийн болон хүрээлэн буй орчны стресс илүү хурцаар дордохын хирээр амьдралын сайн сайхан байдал нь зогсонги байдалд (мөн ч гэсэн эргэлт буцалтгүй) ордог.

5. **Энэхүү тогтворгүй байдал нь цаг хугацааны туршид нэмэгдэж ирсэн.** Өнгөрсөн хорин таван жилийн хугацаанд Монгол Улс орон гурван хямралыг даван түүлж, ОУВС-ийн зургаан хөтөлбөрт багтсан (үүнд одоогийн ӨСХ-г оруулав).¹ Саяхан болсон хос алдагдлын хямрал нь эдийн засгийг зогсонги байдалд оруулж, бүтцийн үндсэн хоёр асуудлыг үүсгэсэн. Нэг талаас төсвийн алдагдал нэмэгдэж байгаа нь голчлон засаглалын чадвар сул байгаатай холбоотой. Нөгөө талаас, төлбөрийн тэнцлийн үрсгал дансны алдагдал, тогтворгүй байдал нь гадаад валютын эх үүсвэр цөөн (экспортын нэг бүтээгдэхүүн / ганц үйлчлүүлэгч, уул уурхайн голлох ГШХО, өрийн өсөлттэй холбоотой) байгаатай холбоотой байна. Эдгээр өсөлт ба уналтын мөчлөг нь амьжиргааны түвшинг сайжруулахад эрсдэл дагуулж байдаг. 2014-2016 оны хооронд эдийн засгийн өсөлт гэнэт буурсан нь хөдөлмөр эрхлэлтийн өсөлт, бодит цалин хөлс буурахад нөлөөлсөн. Иймээс өмнө нь хурдацтай буурч байсан ядуурлын түвшингийн үзүүлэлтэд сөргөөг нөлөөлж, хүний хөгжлийн өсөлт буурчээ.

6. **Мөн удаан хугацааны туршид үргэлжилж буй асуудлууд нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар ба байгалийн нөөцийн доройтол юм.** Уур амьсгалын өөрчлөлт ба хүний үйл ажиллагааны улмаас гамшгийн эрсдэл нэмэгдэж, хүрээлэн буй орчны доройтол бий болсон. Өнгөрсөн жаран жилийн хугацаанд байгалийн гамшиг (зуд, ган, үер) -ийн давтамж, хор хөнөөлийн ноцтой байдлын түвшин нэмэгдэж, Монгол Улсын агаарын дундаж температур өсөх хандлага тодорхой ажиглагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эдгээр хүчин зүйлс нь хурдацтай хөгжиж буй хотжилт хөдөлгөөн, уул уурхайн үйлдвэржилт, бүтээмж багатай хөдөө аж ахуйн салбарын өсөлттэй зэрэгцэн агаарын бохирдлыг нэмэгдүүлж, ус, бэлчээрийн талбайг доройтуулж байна. Энэ бүх асуудлуудаа шийдвэрлэхгүй тохиолдолд дунд болон урт хугацаандаа эдийн засгийн өсөлт, хүн амын сайн сайхан байдалд саад учруулах юм.

7. **Урт хугацаандаа олсон ахиц дэвшлийг үл харгалзан Монгол Улс өнөөгийн байдлаар өргөн хүрээний гурван асуудалтай тулгарч байна. Үүнд: эдийн засгийн тогтворгүй өсөлт, хүн амын сайн сайхан байдалд эрсдэл учрах, хүрээлэн буй орчны стресс зэрэг болно.** Эдгээр сорилтууд нь Монгол Улсын хөгжлийн үндсэн гурван сорилт юм:

¹ □ ОУВС-ийн хөтөлбөрүүд: 1991 оны Стенд бай хөтөлбөр, 1993 ба 1997 оны Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөр, 2001 оны 9 дүгээр сард Ядуурлыг бууруулах хөтөлбөр, 2009 оны 4 дүгээр сард Стенд бай хөтөлбөр. Одоогийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 2017 оны 5 дугаар сард баталсан.

Монгол Улсыг тогтвортой хөгжүүлэх, ядуурлыг бууруулах хуучин хандлагаа сэргээх, хүн амын ирээдүйн сайн сайхан байдлыг сайжруулах, Монголын тогтвортой байдлыг бэхжүүлэх, хүрээлэн буй орчны стрессээс зайлсхийж, сөрөг арга хэмжээ авах зэрэг болно. Энэхүү Монгол Улс: цогц дүн шинжилгээ нь эдгээр зорилгод хүрэхийн тулд улс орны давж гарах ёстой бэрхшээлүүдийг тодорхойлоход оршино.

Дүн шинжилгээний хамрах хүрээ

9. **Улс орны цогц дүн шинжилгээ нь Дэлхийн Банк группын оролцооны тэргүүлэх чиглэлүүдийн талаарх Дэлхийн Банк болон Монгол Улс хооронд хийсэн стратеги яриа хэлэлцүүлгийн үр дүнг мэдээлэх юм.** Энэ нь Засгийн газрын эрх бүхий байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр Дэлхийн Банкны ажилтнуудын хийсэн дүн шинжилгээ юм. Үүнд Монгол Улсын зүгээс тулгамдаж буй сорилтуудаа шийдвэрлэхэд тулгарч буй асуудлууд болон ядуурлыг төгсгөл болгох, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжуудыг нь тодорхойлох системчилсэн үнэлгээ багтана. Энэхүү үнэлгээ нь Дэлхийн Банкны зүгээс тус улсад идэвхитэй хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, Дэлхийн банкнаас тодорхойлсон тухайн улсын хэрэгцээгээр хязгаарлагдахгүй. Дүн шинжилгээ нь ядуурлыг бууруулах, хамтын хөгжил цэцэглэлтийг хөгжүүлэх зорилтоо хамгийн үр дүнтэй, тогтвортой байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдийг тодорхойлно.²

10. **Энэхүү цогц дүн шинжилгээ нь хөгжлийн гол сорилтуудыг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг тодорхойлох зорилгоор Дэлхийн Банкнаас саяхан гаргасан *Евразийн бүс нутагт эдийн засгийн хөгжлийг төрөлжүүлэх* сэдэвт дүн шинжилгээний тайланг ашиглана.** Төрөлжүүлсэн хөгжлийн гол санаа нь цөөн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспортоос хамаарал бүхий эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлт хэлбэлзэл ихтэй байдаг тул (жишээ нь тэд "өндөр Бета" улс орнууд) эдийн засгаа төрөлжүүлэх замаар өсөлтийг ханагахыг зөвөлнө. Энэхүү хэлбэлзэл нь ялангуяа эрдэс баялаг, газрын тос байгалийн хийн үндсэн орц болох нүүрстөрөгчийн дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлтөөс шалтгаалан дотоодын зах зээлд өсөлт, уналтын мөчлөг үүсэх, мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлэх, нөөцийн түрээс (mineral rents) -ийн бодлого хэрэгжүүлэхэд тулгарч буй менежментийн хүндрэлтэй асуудал зэргээс улбаалан улам бүр дордож байдаг. Түүнчлэн экспортын сагсны хэт төвлөрлийг богино хугацаанд өөрчлөхөд хэцүү байдаг. Учир нь худалдааны төлөв байдал нь тухайн улсын хувьд бүтээмжийн холбогдох факторуудаас (байгалийн баялаг, хүний нөөц, эрчим хүч болон санхүүгийн хөрөнгө гэх мэт) шалтгаалж байдаг бөгөөд өөр бусад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хуримтлал үүсгэх, экспортлох өрсөлдөх чадварыг бий болгоход тодорхой хугацаа шаардагдана. Дээрх шалтгааны улмаас эдгээр улсуудын эдийн засаг эмзэг байхаас гадна нь түүхий эдийн үнэ дэлхийн зах зээлд өссөн үед хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, ялангуяа нийгмийн хөрөнгө (эрүүл мэнд ба боловсрол) оруулалтаар дамжуулан орчин үеийн үр чадвар, технологи дамжуулах замаар илүү үр өгөөжтэй байх боломжтой байдаг. ГШХО.

² Дэлхийн Банк Группын удирдамж. Улс орны оролцоо. III Бүлэг, нийтлэл 4 and 5. (Catalogue OPCS 5.01-Dir.01)

11. **Эдийн засгийн төрөлжүүлэх хөгжил - энэ төрлийн эдийн засагтай улс орнууд экспортыг төрөлжүүлэх бодлогод анхаарлаа бага хандуулж (зорилтод аж үйлдвэржилтийн бодлого гэх мэт), харин эдийн засгийн хэлбэлзлийг зөв удирдан зохицуулах бодлого хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарлаа чиглүүлэхийн чухлыг зөвлөдөг.** Нэг талаас хөрөнгийг төрөлжүүлэхийг (үр дүн эсвэл экспортоос гадна) зөвлөдөг ба нөгөө талаас нөөцийн орлогын хэлбэлзлийг зөв удирдан зохицуулах үр дүнтэй институт байгуулж, нийгмийн чанартай үйлчилгээ үзүүлж (ялангуяа эрүүл мэнд ба боловсролын салбар), шударга, тогтвортой, өрсөлдөөн бүхий бизнесийн орчныг дэмжиж өгөх хэрэгтэй. Энэ хоёр хандлага нь энэхүү тайланд дурьдсанчлан, “бодит хуримтлал” буюу “*genuine savings*” хуримтлал үүсгэх болон “биет бус капитал” бий болгоход чиглэгдэх ёстой. Эхний хуримтлал нь уул уурхайн бүтээгдэхүүний баялгийн нөөцийн рентээс өндөр бүтээмжтэй шинэ капиталын нэгдлийг бий болгоход чиглэгдэх ёстой. Ингэснээр баялгийн нөөцийн хөрөнгөөс өндөр бүтээмж бүхий хүний капиталын хуримтлал бий болгоход шилжиж эдийн засгийн төрөлжилт жам ёсоороо явагдах юм. Хоёр дахь асуудал нь түүхий эдээс хэт хамааралтай, өсөлт, бууралтын мөчлөгтэй холбоотойгоор хэлбэлзэж байдаг эдийн засгийг зөв оновчтой удирдан зохицуулах шаардлагатай байдаг.

12. **Монгол Улсын хөгжлийн сорилтуудад Евразид хийсэн Хөгжлийн төрөлжүүлэлт судалгаатай ижил төрлийн асуултууд тавих зарчмаар дүн шинжилгээ хийж болно: Тус улсын эдийн засгийн гүйцэтгэл үр ашигтай байсан уу? "Бодит хуримтлал" үүсгэж чадсан уу? Мөн "биет бус капитал" -ын үйл ажиллагааг зохицуулах институт, хууль тогтоомжийг бий болгосон уу?** Эдгээр асуултанд хариулах байдлаар дүн шинжилгээ өрнөх бөгөөд эдийн засгийг тогтвортой түвшинд өсгөж, хүн амын сайн сайхан байдлыг сайжруулах, хүрээлэн буй орчны стрессийг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг тодорхойлно.

13. **Монгол Улсын эдийн засгийн үр ашигтай гүйцэтгэл, бодит хуримтлал, биет бус хөрөнгийн хувьд холимог байдалтай байна.** Монгол Улс хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөр эрхлэлтийн хувьд чухал ахиц хуримтлуулсан боловч эдгээр ахиц нь салбар бүрт ялгаатай байгаа бөгөөд эдийн засаг нь олон жилийн турш тогтворгүй байна. Төсвийн оновчгүй бодлого нь улс оронд макро эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгоход хүргэж, зөвхөн амьжиргааны түвшинд нөлөөлөхөөс гадна хувийн хэвшлийн өсөлтийг сааруулсан байна. Монгол Улсын төсвийн удирдлага, зохицуулалтын чиглэлээр баталсан хууль тогтоомжууд нь сайн боловч хуулийн хэрэгжүүлэлт маш сул байна. Үүний зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээл, хувийн хэвшилтэй холбоотой дүрэм журмыг хурдан өөрчилж, тууштай хэрэгжүүлдэггүй тул гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулсаар байна. Үүнтэй ижил төстэй асуудлууд нь хотын хөгжил, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэгт нөлөөлж байна. Эдгээр асуудлууд нь ихэвчлэн тарифын код, орлого татвар хураах тогтолцоо, нийтийн аж ахуйн үйлчилгээний хөрөнгө оруулалтын урамшуулал, хот суурин газрын эзэмшил, бүртгэл, маркетингийн механизмтай холбоотой асуудлуудыг зохицуулж буй хууль журмуудын хэрэгжилт үр дүнгүй байгаагаас үүдэлтэй байдаг.

14. **Монгол Улсад засаглалын өргөн хүрээтэй гурван асуудал байна.** Нэгдүгээрт, сонгуулийн кампанит ажлаар төсвийн тодорхой санхүүжилтгүйгээр тодорхой нийгмийн бүлэгт чиглэсэн нийгмийн болон бусад давуу тал олгох амлалтыг өгдөг. Хоёрдугаарт, улс орны нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ шинжилгээ хийхгүйгээр, мөн олон нийтийн дунд

хэлэлцүүлэг зохион байгуулахгүйгээр (энэ нь зарим улс оронд тохирдог) хууль тогтоомжийг боловсруулж улмаар баталдаг. Гуравдугаарт, хууль тогтоох байгууллагын өөрчлөлттэй холбоотойгоор байнга солигддог улс төрчид, бизнесийнхэн төрийн эрх барих асуудал. Эдгээр нь дэлхийн бусад орнууд болон зарим судалгааны үзүүлэлттэй харьцуулж үзвэл Монголд авилга, хараат бус шүүх засаглал, засгийн газрын үр ашгийн тухай ойлголт бага байгаатай холбоотой. Бусад ижил түвшний улсуудтай харьцуулахад тогтвортой байдал, улс төрийн хүчирхийлэл, эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүрэг хариуцлага зэрэг асуудлын гүйцэтгэл ижил түвшинд эсвэл зарим тохиолдолд сайн үзүүлэлттэй байна. Энэ нь 1990 оод оноос эхтэй ардчилал³ тай холбоотой бөгөөд ардчилалын бусад үнэлгээгээр тухайлбал, Freedom House-ын үзүүлэлтийн хувьд сайн байна.

15. **Үйл ажиллагааны талаас нь авч үзвэл, эдгээр засаглалын асуудлууд нь төсвийн төслийн найдвартай байдал, хууль тогтоомжийн чанар, төрийн албаны чадавх, хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшил зэрэгт нөлөөлж байна.** Сүүлийн үеийн эдийн засгийн ахиц дэвшлээс гадна Төрийн санхүүгийн удирдлагын үр ашгийг сайжруулах, үр дүнтэй болгох, ил тод байдлыг хангахад сорилтууд тулгарч байна. Ялангуяа, төсвийн орлого зарлагыг тэнцвэржүүлээгүй, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн стандартын хэрэгжилт сул байгаагаас нь төсвийн төсөлд итгэх итгэл хангалтгүй байна. Үүний нэгэн адилаар Монгол Улсын Засгийн газар нь сүүлийн жилүүдэд хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохын тулд хэд хэдэн шинэчлэлийн алхмуудыг хэрэгжүүлж ирсэн боловч эдгээр шинэчлэлтүүд нь хууль тогтоомжийн боловсруулалт, зохицуулалт, ил тод байдал, хэрэгжилтийг хангахад илүү системтэйгээр хандах шаардлагатай байгааг харуулж байна. Хууль тогтоомжийн зохицуулалт, дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ хийх болон үр дүнтэй хэлэлцүүлгийн механизмуудыг сайжруулах хэрэгцээ байна. Эцэст нь хэлэхэд, Монгол Улсын төрийн алба нь олон төрлийн сорилтуудтай тулгараад байгаа бөгөөд хэрвээ шийдэгдэхгүй бол төрийн албанд итгэх итгэл үнэмшил, техникийн үр чадвар, үр дүнтэй байдал алдагдах болно. Төрийн албан хаагчдын тоо зарим газар нэмэгдэж байгаа нь хууль ёсны байж болох ч зарим тохиолдолд танил тал, улс төрийн томилгооны үр дүнд нэмэгдсэн байна. Халаа сэлгээ жилээс жилд нэмэгдэж (5 -аас 14 хувь хүртэл, 2007 -2014 онуудын хоронд), ёс суртахууныг доройтуулж, хүримтлүүлсэн туршлагыг бууруулж, улмаар төрийн албаны үр нөлөө, чадавхыг бууруулж байна.

16. **2017 онд гаргасан “Дэлхийн хөгжлийн тайлан: Засаглал ба хууль тогтоомж” баримт бичиг нь засаглалын төлөв байдал, сорилтууд, түүний төрийн бодлого, хэрэгжилтэд үзүүлэх үр нөлөөний талаарх суурь ойлголт, мэдээллийг олж авахад чухал эх сурвалж болсон.** Монгол Улс: цогц дүн шинжилгээний хүрээнд хөгжлийн сорилтууд, ялангуяа “хэрэгжилтийн цоорхой” буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн сул байдалд анализ хийхэд энэхүү Дэлхийн хөгжлийн тайлангийн үр дүнг түшиглэх юм. Тухайлбал, холбогдох хууль журмууд нь сайн байгаа хэдий ч хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй засаглалтай холбоотой түвэгтэй асуудлууд болох төсвийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэгтэй холбоотой асуудлуудад дүн шинжилгээ хийх юм. (Хайрцаг 1 харна уу).

³ Засаглалын шалгуур үзүүлэлтүүдийн нэгтгэлийг эндээс харна уу <https://govdata360.worldbank.org/>

Хайрцаг 1: Монгол дахь засаглал: Хууль тогтоомжийн хэрэгжилтийн цоорхой

Түүхээс

Монгол Улсын эдийн засаг, улс төрийн хэтийн төлөв 1990 оны байдлаар таатай бус байсан. Монголд сөрөг хүчин анх 1989 онд гарч ирж, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц өрнөж, дэглэм өөрчлөгдөх тэр үед Монгол Улс байгалийн баялгийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаагүй бөгөөд Төв Азийн бусад орнуудтай харьцуулахад тэргүүлэн манлайлах удирдагчгүй байсан. Монгол Улсын амьжиргааны түвшин 1990-ээд оны шилжилтийн үедээ бусад коммунист дэглэмээ өөрчилж буй улсуудын хамгийн доод түвшинд байсан бөгөөд зөвхөн Албани улстай ижил түвшинд байсан.

Гэсэн хэдий ч Монгол Улс нь 'oasis of democracy' буюу "ардчиллын хүрхрээ", "гайхамшиг" гэж нэрлэгддэг бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хэлснээр "хөгжиж буй олон орны хувьд үлгэр дүүриалал болно" гэж үздэг. Тус улс харьцангуй цөөн хүн амтай бөгөөд хүн ам нь бүрэн бичиг үсэгт тайлагдсан (ЗХУ-ын үеэс залгамжилж ирсэн), мөн гарал угсааны хувьд харьцангуй цөөн үндэстэнтэй зэрэг байдлаас шалтгаалан пост коммунизмын ардчиллын үйл явц амжилттай өрнөсөн болно. Энэ бүх амжилтыг хамтралыг тараах гэх мэт нь эрх баригч нам болон хөдөөгийн орон нутгийнхний хооронд үүссэн үймээн маргаан зэрэг радикал 'shock therapy' -г даван туулах замаар олж авсан байна. Эдийн засгийн агшилт нь (1992-1993 онд хамгийн их уналтын үе байсан) 1930-аад оны үед АНУ-д нүүрлэсэн хямралын үеэс дор байсан бөгөөд хэрэглээний түвшин нь 1940-өөд оны үеийн түвшинд хүрч, 1990-1995 оны хооронд нэг хүнд ногдох ДНБ 33% хувиар буурсан байна. Гэсэн хэдий ч үүний хажуугаар, Ардын Их Хурал 1992 оны 1 дүгээр сард Францын тогтолцоонд тулгуурласан парламентын засаглалыг баталж, хүчирхэг хууль тогтоох байгууллагыг бий болгон Ерөнхийлөгчийн зарим эрх мэдлийг тогтоож улс төрийн олон намын эхлэл тавигдсан. Ийнхүү парламентын тогтолцоог дэмжигчид ялалт байгуулсан боловч ерөнхийлөгчийн хувьд парламентын шийдвэрт хориг тавих эрх мэдлийг олгосон (сонгуулиар). Монгол Улсын ардчиллын орчин үеийн хязгаарлалтуудын талаар - сонгуулийн хуулиудын уян хатан байдал, намуудын хуваагдал, үндсэн хуулийн шинэчлэлийн үндсэн гол өөрчлөлтүүдийг хойшлуулах тухай асуудлуудыг дурьдаж болох юм. Гэхдээ 1990-ээд оны дундуур тогтсон ардчиллын бүтэц хэвээр үлдсэн байна.

Ардчиллын уламжлалт хэмжүүр болон эдийн засгийн гүйцэтгэлээр Монгол Улс Евразийн пост коммунист улс орнуудаас дээгүүр үзүүлэлттэй байна. Хуучин ЗХУ-ын системийн Ази бүсийн зарим ерөнхийлөгчийн супер засаглалтай улс орнуудаас зарим нь нам төвтэй дэглэмээс хувийн дэглэм шилжсэн. Монголд ардчиллын эсрэг намууд аливаа хүчирхийлэл, хүчинд автаагүй бөгөөд эдийн засгийн өсөлт, уналтын хүнд хэцүү мөчлөгийн үеэр багахан хэмжээний хохирол амсжээ. Гэхдээ 2008 онд болсон үйл явдлыг тооцохгүйгээр. Санал хураалтын тоо баримтаас харахад ардчилал тууштай хэрэгжиж байна. 1990 оноос хойшхи ерөнхийлөгчийн болон парламентын долоон сонгуулийн үйл ажиллагааны 5-д нь зөрчил илэрсэн байна. Сонгуулийн хууль тогтоомжийн өөрчлөлт нь сонгуулийн мөчлөгт нөлөөлж байсан боловч сүүлд явуулсан буюу 2016, 2017 оны сонгуулийн үйл ажиллагаа "олон улсын стандартыг" дагуу хэрэгжсэн байна. Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулиар санал хураалтын үеэр нууцлал зарим үед алдагдах

гэх мэт мэр сэр алдаанаас бусдаар сонгуулийн хорооны мэдэгдсэнээр сонгууль "өрсөлдөөнтэй, сайн зохион байгуулалттай" чвагдсан гэж үзсэн байна. Энэ бүх үйл явц харьцангуй хүчтэй иргэний нийгмийн оролцоо нөлөөлсөн байна. 2000 оны дундуур 4000 гаруй ТББ бүртгэгдсэн байна. (Дэлхийн Банк 2005).

Монголын ардчиллын үйл явц, түршлагыг үнэлэх юм бол ардчилал ба эдийн засгийн өсөлт, улс орны хөгжлийн явц, улс төрийн эрх мэдлийн харилцаа хамаарал, нөлөөллийг үнэлэхэд төвөгтэй юм. Асуудлын гол нь учир шалтгаан нь улс төрийн тогтолцоонд клиентелизм ба танил тал, нөөцийн рентийг захиран зарцуулах, хуваарилах улс төрийн хүндрэлтэй асуудал бат бөх оршиж байгаатай холбоотой. (...) Ардчилал нь клиентелистик хэв шинжийг агуулсан байх нөхцөлд эдийн засгийн өсөлтийн хурд, шинж чанар нь өрсөлдөгч фракцуудын зөрчилдөөнийг үүсгэж, зах зээлийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, үүрэг функцүүдэд нөлөөлж байдаг.

Засаглал ба “хэрэгжилтийн цоорхой” буюу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх

Засаглал гэдэг нь төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллүүд тогтоосон журам, эрх мэдлийн хүрээнд бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох үйл явц, тэдгээрийн хоорондын харилцааг хэлнэ. (...) Хөгжлийн зорилтуудаа хангах бодлого нь хэр үр дүнтэй байх нь хэрэгжүүлэгч байгууллагууд, тэдгээрийн гурван цөм үүрэг функцээс шалтгаална. Үүнд: амлалт найдвартай байх, үүнд хамтран зохицуулалт хийх, хамтын ажиллагааг өргөжүүлэх хамаарна. Эдгээр үүрэг функцүүдийн нь магадгүй улс төрийн намуудын зан төлөв, ашиг сонирхол, сонгуулийн дүрэм журам, эрх баригч нам, эвсэл бүрдүүлж зохицуулна. (цэрэг, талууд, гүйцэтгэх, бизнесийн лобби, шүүхийн байгууллага, гадаадын засгийн газар, хөгжлийн агентлагууд, хөдөлмөр эрхлэлт, иргэний нийгмийн бүлгүүд гэх мэт).

Хөгжлийн зорилтуудаа хангах явцад гарч буй алдаа, хүндрэлүүд нь ихэнх хөгжиж буй улс орнуудын хувьд хууль тогтоомж, дүрэм журмын алдаа дутагдлаас шалтгаалдаггүй. Харин батлагдсан хуулиа хэрэгжүүлж, хяналт тавьж “хэрэгжилтийн цоорхой”-д анхаарах хэрэгтэй. Төсвийн аалдагдал нь шинэчлэлийн хөтөлбөрүүдийн бодит хэрэгжилт сул байгаатай - isomorphic mimicry гэдэг нь өөр газар хийсэн шинэчлэлийн ажлуудтай ижил харагдах боловч хэрэгжилт нь ялгаатай - болон "төрийн чадавх доройтсон" байдалтай холбоотой байдаг. Төсвийн алдагдал нь улс төрийн хүсэл зориг, төрийн чадавхтай холбоотой гэж ойлгохоос илүүтэйгээр улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй албан болон албан бус байгууллага, бүлгүүд тоглоомын дүрмийг хэрхэн зохицуулж буйг ойлгох нь сорилт болж байна. (Дэлхийн Банк 2017). Бодлогууд нь вакуум орчинд хийгддэггүй бөгөөд "тэгш бус хэлэлцээр" гэж тэмдэглэгдсэн улс төр, нийгмийн нарийн төвөгтэй орчинд явагддаг. [бүлэг] зөрчилдсөн ашиг сонирхолыг дагаж өөрчлөгдсөн дүрмүүдтэй харилцах "(ibid, 29). Дээрхтэй адил дүрмүүд нь өөр өөр үр дүнд хүргэж чадна. Бодлогын үр дүнг зөвхөн бодлого хэрхэн боловсруулагдсанаас гадна бодлогын хувилбарыг хэрхэн сонгож яаж хэрэгжүүлдгээс шалтгаална. (ibid, 7).

Хэрэгжилтийн цоорхой буюу ‘implementation gap’ арилгахын тулд бодлогын гол гурван үе шатыг хэрэгжүүлэх хэрэгтэй: дүн шинжилгээ хийх (үйл ажиллагааны проблемыг тодорхойлох), үнэлгээ хийх (эрх мэдлийн тэгш бус байдал ба хэлэлцээ хийх үйл явц), ба

зорилт тавих (Бодлого боловсронгуй болгох урам зориг, давуу талыг хэрхэн сэргээж болох вэ?) Дэлхийн банк 2017. Цаашдын дүн шинжилгээндээ бид эдгээр гурван гол үе шатыг эдийн засгийн тогтвортой өсөлт, хүн амын сайн сайхан байдлыг дээшлүүлэх болон хүрээлэн буй орчны стрессийг бууруулахад чиглүүлэн хянахыг санал болгоно. (see Хайрцаг 2, 3 болон 4, зэргийг харна уу).

Эх үүсвэр: Эшлэл (M. J. Watts 2017)

Дүн шинжилгээний бүтэц

17. **Энэхүү Монгол Улс: цогц дүн шинжилгээ нь хөгжлийн сорилтын дүн шинжилгээний гурван үндсэн хэсэг болон ирээдүйн бодлого шинэчлэлийн гол тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон дүгнэлт хэсгээс бүрдэнэ.** Бүлэг Error! Reference source not found., Error! Reference source not found. болон Error! Reference source not found.-т эдийн засгийн тогтворгүй өсөлт, хүн амын сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлс, буй хүрээлэн буй орчны өсөн нэмэгдэж тулгамдсан асуудлуудтай холбоотой сорилтуудыг авч үзлээ. Бүлэг тус бүрийг Монгол Улсын нөхцөл байдалд хөрвүүлэн Төрөлжүүлсэн хөгжлийн зарчим дээр тулгуурлан боловсруулав. Бүлэг тус бүр нэгдүгээрт, тухайн улсын гүйцэтгэлийн дүн шинжилгээнд зориулсан дэд хэсэг, хоёрдугаарт, биет болон хүмүүнүн хуримтлал болох "бодит хуримтлал" болон "биет бус капитал"-ыг хуримтлуулж чадсан эсэх талаар хэлэлцэх дэд хэсгээс бүрдэнэ. Эдийн засгийн өсөлт, сайн сайхан байдал болон тогтвортой байдал хэрхэн засаглалтай холбогддог талаар дүн шинжилгээ хийж, улс төрийн эдийн засгийн хүчин зүйлсийг бүлэг тус бүрд судлах болно (Хайрцаг 2, 3, 4). V бүлэгт Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн санал, зөвлөмж болон Монгол дахь оролцогч талуудын хэлэлцүүлгийн үндсэн дээр өмнөх бүлгүүдэд олж авсан баримтуудыг нэгтгэн хураангуйлж богино болон дунд хугацааны хөгжлийн бодлогыг бүрдүүлэх хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг жагсаасан болно.

18. **Энэхүү Монгол Улсын системчилсэн дүн шинжилгээ нь мөн үндсэн тайлангийн баримтуудыг бататгах хоёр хавсралтаас бүрдэнэ.** Нэгдүгээрт, Монгол Улсын гүйцэтгэлийг голчлон Дэлхийн хөгжлийн индексээс бүрдсэн 100 гаруй шалгуур үзүүлэлтээр дэлхийн бүх улс орнууд болон сонгосон цөөн тооны орнуудтай харьцуулалт хийж жишиг тогтоосон (Хавсралт 1-ээс Монгол Улсын жишиг тогтоох үйл явцыг харна уу). Хоёрдугаарт, 2017 оны 9, 10-р саруудад зохион байгуулсан оролцогч талуудтай хийсэн уулзалтуудын хураангуй болно. Эдгээр уулзалтууд нь төрийн алба, эрдэм шинжилгээний ажилчид, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд болон олон талт байгууллагуудын төлөөллийг хамруулан хот, хөдөөгийн хэд хэдэн газруудад зохион байгуулагдсан (тухайлбал: Улаанбаатар, Дархан, Орхон). Уулзалтууд "Chatham house"-ийн дүрмээр явагдсан бөгөөд чанарын болон тоон мэдээлэл цуглуулах үүднээс албан бус тойм саналуудыг мөн багтаасан болно. Үүнээс гадна олон нийтийн оролцоог идэвхжүүлэх үүднээс цахим/вэб-сайт дээр суурилсан платформоор мэдээлэл нээлттэй хүлээж авсан бөгөөд цугларсан мэдээллүүдийг мөн хавсралтад хураангуйлан оруулав (Хавсралт 2: Оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлэг).

Эдийн засгийн өсөлт: Эдийн засаг хурдтай тэлж, бүтээмж нэмэгдсэн ч тогтворгүй байдал олширсоор байна.

22. **Монгол Улс нь эдийн засгийн өндөр өсөлтийн боломжоо хэсэгчлэн ашиглаж байна.** 1990-ээд онд Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих хүндхэн шилжилтийг хийсэн бөгөөд тухайн үед нэг хүнд ногдох ДНБ жилийн 1.2 хувиар буурсан. Гэвч 2000 оны эхний арван жилд шилжилтийн үр дүнд нэг хүнд ногдох ДНБ 5.2 хувиар өсчээ. 2010-17 онуудад эдийн засаг эрчтэй өссөн ба нэг хүнд ногдох ДНБ жилд дундажаар 7.3 хувьд хүрсэн байдаг.

23. **Сүүлийн 15 жилд нэг хүнд ногдох ДНБ хэмжээ дорвитой өссөн нь нэг ажилтны бүтээмж эрчимтэй өссөнтэй холбоотой байв.** Хүн амын өсөлт тийм ч өндөр биш буй улсын хувьд үйдвэрлэлийн нэг хүчин зүйл болох хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн нь нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ буурахад нөлөөлсөн байна. 2000-10 онуудад хөдөлмөрийн насны хүн амын өсөлт нь нэг хүнд ногдох ДНБ -ний бараг тэн хагасыг (2.0 нэгж хувиар) эзэлж байсан бол 2010-16 онд нэг хүнд ногдох ДНБ бараг өсөлтгүй (0.2 нэгж хувиар)⁵ байв. Үүнээс гадна хөдөлмөр эрхлэлтийн түвшин дээрх хугацаанд буурсан нь нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлжээ (тус тус 0.8 ба 0.3 нэгж хувиар). Харин энэ хугацаанд нэгж ажиллах хүчинд ноогдох үйлдвэрлэлийн хэмжээ нэг хүнд ногдох ДНБ-ий 50 хувиас 95 гаруй хувьд хүрч өсчээ (Зураг 1, баруун дээд болон зүүн хэсэг).⁶

24. **Нэгж ажиллах хүчинд ногдох үйлдвэрлэлийн хурдацтай өсөлт нь бүтцийн өөрчлөлт болон хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс шалтгаалжээ.** 1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн дараа бүтээмж багатай салбараас бүтээмж өндөртэй салбар уруу ажиллах хүчин шилжих байдлаар 2000 оны эхээр эдийн засагт бүтцийн өөрчлөлт явагдсан. Ийнхүү салбар хоорондын шилжих хөдөлгөөн нь голчлон хөдөө аж ахуйн салбараас бусад салбар руу чиглэсэн бөгөөд энэ нь нэгж ажиллах хүчинд ногдох бүтээгдэхүүний гарцын өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн. 2000-10 оны хооронд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн талаас илүү хувь нь салбар дундын шилжилт хөдөлгөөнөөр тайлбарлагдана. (2.8 хувийн хөдөлмөрийн бүтээмийн 1.5 нэгж хувийг шилжилт хөдөлгөөн эзэлж байна). Харин 2010-16 оны хооронд болсон "салбар хоорондын" шилжилт хөдөлгөөнд хөдөлмөрийн бүтээмж багахан хувийг эзэлж байна. (хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өсөлтийн 7.1 хувиас зөвхөн 1.6 нэгж хувийг эзэлж байна). Энэ нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ихэнхдээ нийт салбаруудын үйлдвэрлэлийн бүтээмжээр тайлбарлагдана. Хөдөө аж ахуй ба уул уурхайн салбаруудын хөдөлмөрийн бүтээмжүүд нь нийт хөдөлмөрийн бүтээмийн талаас илүү хувийг

⁵ <http://www.1212.mn/>

⁶ $\frac{GDP}{P} = \frac{GDP}{E} \cdot \frac{E}{A} \cdot \frac{A}{F}$

бүрдүүлж байна. (салбар хоорондын шилжилтийг хассан хөдөлмөрийн бүтээмжийн нийт өсөлт 6.5 хувь бөгөөд 1.6 ба 2.3 нэгж хувь дээрх 2 салбарын бүтээмжээр тайлбарлагдаж байна). Үлдсэн бүх салбар хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нийт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн 1 ба түүнээс хүрэхгүй бага хувийг бүрдүүлсэн байдаг. Судалгаанд хамрагдсан хугацаанд үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмж сөрөг байсан бол боловсруулах үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмж хамгийн удаан өсөлттэй салбаруудын нэг байсан нь ажиглагдсан. (Зураг 1, дунд болон зүүн хэсэг).

25. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн гол нэг эх үүсвэр нь хөрөнгийн хуримтлал ба ялангуяа нийт хүчин зүйлийн бүтээмж өсөж байсантай холбоотой байхаар байна. Монгол Улсын эдийн засгийн шинэчлэл болон 2000-аад оноос глобал зах зээл үрүү нэвтрэх үйл явц нь нийт хүчин зүйлийн бүтээмж өсөхөд нөлөөлсөн бөгөөд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлийн 2/3-ийг тайлбарлаж байна. (хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өсөлт 1.4 хувь байгаагаас 0.9 нэгж хувийн нийт хүчин зүйлийн бүтээмж бүрдүүлж байна, салбар дундын хөдөлмөр шилжилтийг хассан). 2010-16 онуудад тус уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн нь нэгж ажиллах хүчний хөрөнгийн хуримтлалыг өсгөхөд нөлөөлсөнөөс гадна нийт хүчин зүйлийн бүтээмж өсөхөд мөн нөлөөлжээ. Үүний үр дүнд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт маш хурдацтай явагдсан байх талтай. (Зураг 1, баруун доод ба зүүн хэсэг).⁷

26. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд хөрөнгийн хуримтлал хэлбэлзэл өндөр байв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хөрөнгө оруулалт жил тутам бүүрч байсан бөгөөд 1990 оны дунд үе хүртэл нөхцөл хандлага хэвээр байсан. ДНБ-д эзлэх хувь нь 1994 он гэхэд хамгийн бага буюу 17.8 хувь хүрсэн бол 2012 он гэхэд хамгийн их буюу 50 хувьд хүрсэн, харин 2016 онд огцом бүүрч 21 хувьд хүрсэн байдаг. Энэ үйл явц нь Монголын эдийн засагт эрс өөрчлөлтийг авчирч, хөрөнгийн хуримтлал гарцын хэмжээ 1990-ээд онд ойролцоогоор 4.5 байсан бол зах зээлд шилжсэнээр 2000 оны дунд үе гэхэд гэхэд уг харьцаа 2.7 болсон байдаг. (Зураг 2). Энэ үйл явц Монголын эдийн засгийг үр ашигтай (жилийн нийт гарцын хэмжээ 22 хувиас 37 хувь хүртэл) болгож, хөрөнгийн хуримтлалыг эрчимжүүлсэн. (2000-16 онуудад нэг хүнд ногдох хөрөнгийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн).⁸

⁷ $\frac{GDP}{E} = \phi \left(\frac{K}{E} \right)^{1-\alpha}$ **Erro**
r! Bookmark not defined.

⁸ (Nehru and Dhareshwar 1993)

30. **Харин өнгөрсөн хугацаанд эдийн засгийн уламжлалт эх үүсвэр болж байсан хөдөө аж ахуйн салбар нь одоо ч гэсэн хөдөлмөр эрхлэлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.** 1990 оод онд хөдөө аж ахуйн салбар нь бодит ДНБ-ний 1/3-ийг бүрдүүлдэг байсан бөгөөд сүүлийн 25 жилийн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд энэ хэмжээ буурч, 2015 онд ДНБ-ний 13 хувийг бүрдүүлж, эдийн засгийн идэвхитэй нийт хүн амын 1/3-ийг ажлын байраар хангаж байсан. Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуйн салбар дийлэнх хувийг эзэлдэг. (84.2 хувь). Мах болон сүүн бүтээгдэхүүн нь мал аж ахуйн салбарын үндсэн бүтээгдэхүүн бөгөөд уг салбарын гарцын 61 хувийг бүрдүүлдэг ба энэ нь ДНБ-ний 7 хувьтай тэнцүү юм. 2016 оны мал тооллогын дүнгээр нийт малын тоо толгой 61.5 саяд хүрч, ойролцоогоор 160'650 малчин өрх байна.

31. **Шилжилтийн үед Хөдөө аж ахуйн салбар бараг бүрэн уналтанд ороод байсан бол эргээд сэргээд байна.** 1990-ээд оноос 2000 оны эхэн үеийн аж үйлдвэржилтийн зогсонги байдал нь олон өрхийг эргээд мал маллахад хүргэсэн. Гэвч мал сүргийн тоог өсгөж, бэлчээрийн сэлгэлт хийхгүй, өвлийн нэмэлт тэжээл хангалтгүй зэргээс олон тооны малчдын амьжиргааг эрсдэлд оруулсан. Хэдий тийм боловч 2000 оны дунд үеэс хойш мах, хүнсний ногоо, үр тариа, төмс зэргийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхээр хэд хэдэн санаачлага нэвтрүүлсэн нь уг салбарын нөхцөл байдлыг өөрчилсөн.

32. **Монгол Улс мах, улаан бүүдай, төмс тариалж дотоодын хэрэгцээгээ хангах боломжтой ч олон улсын түвшинтэй харьцуулахад бүтээмж бага байгаа нь малын тоо толгой, газар тариалангийн бүтээмжийн бууралттай холбоотой.** Нэг хүнд ногдох мах, үр тариа, төмсний хангамж эрс нэмэгдэж, эрэлт хэрэгцээгээ дотооддоо бүрэн хангаж байна. Гэтэл үхэр, хонь, ямааны махны гарц нь дэлхийн түвшинтэй харьцуулахад доогуур байна. Дэлхийн банкны мал аж ахуйн салбарын судалгаагаар Монголын үхрийн махны гарц олон улсын түвшингийн 50 хувиас бага, Монголын хонины махны гарц 60 хувьтай тэнцэж байна.⁹ Улаан бүүдай, төмс үйлдвэрлэгчдийн бүтээмж өссөн хэдий ч дундаж гарц нь бусад орнуудын дэвшилтэт үйлдвэрлэгчдийн өгөөжөөс харьцангуй доогуур байна. Газар тариалангийн бүтээмжийг шинэ технологи (хамгийн бага усалгаа), тоног төхөөрөмж, гербицид болон сайжруулсан үрийн сортуудыг ашиглах замаар нэмэгдүүлж чадсан. Эдгээр үр өгөөж нь нэмэлт бордоо, газар тариалангийн талбайн сэлгэлт, хөрс сайжруулах газар тариалангийн үлдэгдлийн менежментийг сайжруулахгүй бол дахин буурах аюултай. Хөрсний үржил шимийг сайжруулах, хөрсний элэгдэл, усны үр ашигтай хэрэглээ (газар доорх усыг хамтад нь ашиглах гэх мэт) болон менежментийн ба техникийн хувьд илүү үр дүнтэй байх нь ургацын салбарын урт хугацааны бүтээмжийг дээшлүүлэх гол түлхүүр болох юм.

33. **Өнгөрсөн хугацаанд уул уурхайн экспортын өсөлт нь бүтээмжийг өсгөөд зогсохгүй амьжиргааны түвшинг сайжруулсан ч эдийн засгийн төрөлжид төдийлөн нөлөөлсөнгүй.** 2000 оны эхэн үеэс экспортын хэмжээ бараг арав дахин өссөн нь голчлон нүүрс болон зэсийн экспортоос шалтгаалав (Зураг 3, дээд зүүн хэсэг). Уул уурхайн салбарын үйл ажиллагаа амжилттай өргөжиж, олон жилийн түрш алдагдалтай байсан гадаад худалдааны тэнцэл, урсгал дансыг ялангуяа сүүлийн жилүүдэд сайжруулахад хангахад ихээхэн түлхэц болсон. (Зураг 3, баруун талын хэсэг). Үүний зэрэгцээ мах, малын утас (ноос, ноолуур гэх

⁹ (Дэлхийн банк, 2009)

мэт) зэрэг уламжлалт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон хувцасны экспорт харьцангуй бага буюу зарим тохиолдолд их хэмжээгээр буурчээ (Зураг 3, дунд ба доод хэсэг).¹⁰ Эдийн засгийг төрөлжүүлэх энэхүү зайлшгүй шаардлага байгааг бусад жишиг болсон жишээнүүдийн хэсэг дээр дурдсан байгаа. Монгол Улсыг бусад ижил төстэй улсууд болон бусад бүх улс орнуудтай харьцуулахад жагсаалтын сүүл үрүү эрэмблэгдэж байгаа нь төрөлжилт муу экспорттой улсын тоонд орж байна. (Зураг А1 5-г үз) Түүнчлэн эдийн засгийг төрөлжүүлэх асуудал нь засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн хэлэлцүүлгийн үеэр хамгийн чухал асуудлуудын нэг болох харагдсан. Хэдийгээр худалдаа, экспортын хувьд санал асуулгаар эзлэх хувь өндөр байдаггүй, 5 хүрэхгүй хувийг бүрдүүлсэн. (Зураг А2 1, А2-р зураг, А2-р зураг 2-р зургийг үзнэ үү).

34. Экспорт нь зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй нэг зах зээл дээр төвлөрсөн байна. 2000 оны эхэн үед Хятад руу гаргасан экспортын хэмжээ нийт экспортын 20 орчим хувийг эзэлж байсан бол 2012 оноос хойш 90 гаруй хувийг эзлэх болжээ. Харин импортод хөрөнгийн бараа, завсрын хэрэглээний бараа, шатахуун давамгайлж байна (2015 онд импортын 71 хувийг эзэлж байсан); гэхдээ олон орноос дээрх бүтээгдэхүүнүүдийг импортолж байна. (Хятад, Орос, Япон улс 2016 оны байдлаар импортын барааны 36, 14, 12% -ийг тус тус бүрдүүлжээ).

35. Гэвч Монгол Улс дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвар сайтай, цаашид сайжруулах боломжтой экспортоо нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, тоо хэмжээг нь өсгөх боломж байсаар байна. ОУСК-ийн сүүлд хийсэн судалгаагаар Монгол Улс нь уул уурхай, малын гаралтай бүтээгдэхүүний (өмнөх хэсгүүдэд дурдсанчлан) өрсөлдөх чадвараа нэмэгдүүлсэн болохыг харуулж байна. Гэвч өрсөлдөх чадвартай байсан хувцас үйлдвэрлэл өрсөлдөх чадвараа алдаж, нэхмэл бүтээгдэхүүнээс багахан ашиг олжээ.¹¹ Зураг 4-ийн нэгдүгээр хэсэгт, Монгол Улс цөөн төрлийн үйл ажиллагаанаас хамааралтайг харуулж байна, хоёрдугаарт, 2000-16 оны хооронд тус улс малын гаралтай бүтээгдэхүүн, уул уурхайн салбарын гүйцэтгэлээрээ дэлхийн тэргүүлэх 25 улсын тоонд багтсан байна. Нэг талаас хувцас үйлдвэрлэлээр жагсаалтын эхний хагаст багтаж байсан эрэмбээ алдаж, нэхмэл бүтээгдэхүүн үйлвэрлэлийн өрсөлдөх чадварт ахиц гараагүй бөгөөд үр тариа, цаас, металл бүтээгдэхүүн, машин механизмд бага зэрэг дэвшил гаргасан байсан. ОУСК-ийн дүн шинжилгээ нь Монголын эдийн засгийг төрөлжүүлэх, бэхжүүлэхэд чиглэгдсэн хэд хэдэн үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын боломжуудыг тодорхойлсон. Үүнээс гадна ОУСК нь аялал жуулчлал, тээврийн үйлчилгээнд хамаарах үйлчилгээний экспортын сүүлийн үед гарсан ахиц, цаашид өргөжих боломж байгааг мөн дурьдсан.¹² Саяхан гаргасан Дэлхийн Банкны тайланд ноос, ноолуур, мах, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын чадавхыг тодорхойлсон

¹⁰ <https://atlas.media.mit.edu/en/>

¹¹ (Хаусман, et al. 2014)

¹² (Латимер and Пиатковский (бэлтгэж байна))

боловч эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх гол асуудал болох ложистик, санхүүгийн болон зохион байгуулалтын асуудлуудыг шийдвэрлэн зохицуулалт хийх шаардлага байсаар байна.¹³

36. Монголын эдийн засаг түүхий эдийн экспортоос хамаарах хамаарал өндөр байгаа нь эдийн засгийг түүхий эдийн дэлхийн зах зээлийн мөчлөг, үнийн хэлбэлзэлд хэт өртөмтгий болгож байна. Үүн дээр уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэт "төвлөрөл" нэмэгдэх бөгөөд завшаантай нь зөвхөн Оюу Толгой төслийн гүйцэтгэл нь улсын макро эдийн засгийн гүйцэтгэлд томоохон нөлөө үзүүлсэн хэвээр байна. Энэхүү хэлбэлзэл нь мөчлөг дагасан төсвийн бодлого, уул, уурхайн орлогыг зохицуулах улс төрийн эдийн засгийн удирдлага нэлээд хүндрэл үзүүлж байна. Түүчлэн экспортын хэт төвлөрлийг богино хугацаанд өөрчлөхөд хэцүү. Учир нь худалдааны төлөв байдал нь тухайн улсын хувьд бүтээмжийн олон төрлийн хүчин зүйлүүдээс (байгалийн баялаг, хүний нөөц, эрчим хүч болон санхүүгийн хөрөнгө гэх мэт) шалтгаалах ба экспортын өөр бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бий болгох, энэ чиглэлд шилжихэд тодорхой хугацаа шаардагддаг.

37. Түүхий эдийн үнэ ханш, валютын ханшийн тогтворгүй байдал нь Монголын гадаад худалдааны салбарт 2008-09 онуудад маш ихээр нөлөөлсөн. Түүхий эдийн үнийн өсөлтийн үед экспортын үнийн индекс өсөх хандлагатай байсан бол импортын үнийн индексийн өсөлт харьцангуй алгуур өсөлттэй байснаас 2009-12 онд худалдааны нөхцөл сайжирсан байдаг. Түүхий эдийн үнийн өсөлтөд экспортын үнийн индекс өсч, худалдааны нөхцөл сайжирснаар ГШХО нэмэгдэж, энэ нь төсвийн тэлэх бодлоготой давхцаж эцэстээ эдийн засаг огцом сайжирахад нөлөөлсөн. (Зураг 5, доод хэсэг). Энэ хугацаанд нэрлэсэн ханшны чангаралт нь инфляцитай хавсарснаар бодит ханшийн чангаралт авчирсан. Харин түүхий эдийн үнэ буурч эхлэхэд уул уурхайн салбарын огцом өсөлт саарч, мөн Хятадын өсөлт саарсан нь Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл байдлыг муутгасан. Төлбөрийн тэнцлийн дарамт нь 2012 оны сүүлээс валютын ханшийн огцом сулруулж, валютын нөөцийг үлэмж хэмжээгээр бууруулсан. 2012-16 онуудад нэрлэсэн ханш 78 хувиар суларсан нь нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER)-ийг 38 хувиар сулруулахад нөлөөлж, улмаар инфляци 2014 оны дунд үеэс буурснаас, бодит үйлчилж буй ханш (REER, Зураг 5, дээд хэсэг) тогтвортой байжээ.

38. Өсөлт, уналтын энэхүү эрсдэлтэй мөчлөг нь дотоодын эдийн засгийн төдийлөн зохистой бус бодлоготой давхцсан. 2011 оноос хойши түүхий эдийн үнийн огцом уналт нь төсвийн болон гадаад секторт хүчтэй нөлөөлсөн. 2011-13 онуудад гадаадын хөрөнгө оруулагчид байгалийн нөөц боломжийг хүртэхээр ихээр хөрөнгө оруулснаар Монгол Улсын эдийн засаг хоёр оронтой тоогоор өссөн. Гэвч, 2014-16 оны үед энэхүү өндөр өсөлт нь түүхий эдийн (зэс, нүүрсний) үнийн огцом бууралт, экспортын бууралтаас шалтгаалан огцом буурсан. ГШХОн 2011 онд ДНБ-ий 40 хувьтай тэнцэж байсан бол 2014-16 онуудад ДНБ-ний 2 хувиас бага хэмжээнд хүрч агшсан. Энэ нь ашигт малтмалын салбар дахь гадаадын хөрөнгө оруулалттай шинэ төслүүд хойшлогдсоноор тайлбарлагдаж байв. Бодлого боловсруулагчид эдийн засгийн өсөлтийг түр зуур дэмжсэн макро эдийн засгийн тэлэх бодлогыг хэрэгжүүлж, үүний улмаас гадаад өрийн хэмжээ нэмэгдэж, төлбөрийн тэнцэл муудаж, банкуудын хөрөнгийн чанар муудаж, дотоод болон гадаад зээлийн зардал өсч,

¹³ (Латимер and Пиатковский (бэлтгэж байна))

ядуурал нэмэгдсэн. 2016 оны эцсээр төсвийн алдагдал өсч болон төгрөгийн ханш суларснаар Засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-ий бараг 90 хувьд хүртэл өссөн.

39. Монгол Улсын эдийн засагт уул уурхайн экспорт давамгайлсан нь төсөвт нөлөөлсөн. 2010 онд төсвийн тогтвортой байдлын тухай хууль тогтоомжийг баталсан боловч сүүлийн жилүүдэд төсвийн бодлого нь мөчлөг дагасан хэвээр байсан нь бөгөөд төсвийн зарцуулалт нь нь Голланд өвчин эдийн засагт нүүрлэх гол суваг болсон (Кан ба Готтшолк 2017). Төсвийн зарцуулалт эрчимтэй өсч, - Монгол Улс магадгүй шууд нөөцөө бэлэн мөнгө болгон тараах схем ашигласан - 2010-12 оны хооронд иргэдэд бэлэн мөнгө тараасан нь дэлхий дээрх цорын ганц улс байж болох юм. (Инг ба Ховес, 2015). Эдгээр бодлого нь дотоод эдийн засгийн шингээх чадварын асуудлыг үүсгэсэн. Энэ нь хөгжиж буй орнуудад байгалийн баялагтай холбоотой үүсдэг асуудлуудыг нэг юм. (Коллиер, бусад, 2010). Эдийн засгийн дотоод шингээх чадварын асуудал нь өндөр инфляци болон (уул уурхайн бус) худалдааны өндөр алдагдлаар илэрдэг.

40. Улс орны хөдөлмөрийн бүтээмж, амьжиргааны түвшинд дорвитой өөрчлөлтийг бий болгосон уул, уурхайн экспорт нь гол хүндрэл биш юм. Гол хүндрэл бол бодлого боловсруулагчдаас уул, уурхайд түшиглэсэн эдийн засгийн зөв менежмент хийж чадаагүй явдал юм. Сүүлийн үеийн макро эдийн засгийн гол алдаатай бодлогуудаас дурьдвал, нэгдүгээрт, төсвийн бодлого. Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан их хэмжээний төсвийн шинжтэй зарцуулалтыг 2012-16 онуудад хийж, нэгдсэн төсвийн алдагдлыг ДНБ-ий 10 хувиас дээш түвшинд хүргэсэн. Хоёрдугаарт, мөнгөний болон валютын ханшны бодлогын хүрээнд 2012-14 онд Монголбанк бодлогын хүүг бууруулах, шинэ төрлийн төсвийн шинтэй зээлүүдийг хэрэгжүүлэх зэргээр ДНБ-ий 25 орчим хувьтай тэнцэх хэмжээний тэлэх бодлого хэрэгжүүлсэн. Мөн Монголбанк төгрөгийн ханшийг хамгаалах зорилгоор их хэмжээгээр валютын нөөцөө (ойролцоогоор 3 тэрбум ам.доллар) бууруулсан. Гуравдугаарт, санхүүгийн салбарын хяналт, шалгалтын тогтолцоо хангалтгүй, хязгаарлагдмал нөөцтэй, бодлого зээлүүд дээр удаа дараа хөнгөлөлт үзүүлсэн, хуулийн хэрэгжилт сул байсан гэх мэт. Тус улс хос алдагдал буюу төсөв болон гадаад тэнцлийн их хэмжээний алдагдалд орсны улмаас гадаад валютын нөөц хурдацтай бууруулж, гадаад өр огцом нэмэгдсэн асуудалтай тулгарсан. Макро эдийн засгийн тогтворгүй байдал нь эцэстээ хөгжлийн түншүүдийн тусламжтайгаар 2016-17 онуудад хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүргэсэн. (Зураг 6)

41. Гадны шокын эсрэг макро эдийн засгийн тэлэх бодлого нь өсөлтийг дэмжсэн боловч зардал өндөр байсан. Төсвийн хувьд алдагдал 2016 он хүртэл ерөнхийдөө хяналтанд байсан боловч төсвөөс гадуурхи зардал (дэд бүтцийн төслүүд болон хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд) -ийг Хөгжлийн банк (МУХБ), Монголбанк (МБ)-ны сувгуудаар 2012 оноос эхлэн олгосон. Төсвийн ерөнхий нөхцөл байдал тэлэлттэй байсан ба Монгол Улс эдийн засгийн өсөлттэй үедээ бүрдүүлсэн хуримтлалаа (хангалтгүй) шавхсан. 2011 оноос хойш Засгийн газрын өрийн хэмжээ бараг дөрөв дахин өсч, төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ий 17 хувьтай тэнцсэн. Мөнгөний тэлэх бодлого нь зээлийн өсөлтийг өдөөж, импортыг нэмэгдүүлж, валютын нөөцөө бууруулснаас гадна төгрөгийн ханш огцом суларч инфляцид нөлөөлсөн. Бодлогын зээлүүд дээр Төвбанкнаас зохистой харьцааны хөнгөлөлт үзүүлсэн нь банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлсэн. Түүнчлэн, Монголбанк болон

Хөгжлийн банкаар дамжуулан хийсэн санхүүжилттэй холбоотой засаглал сул байсан, зээлд хийх үнэлгээ сул байснаас үр өгөөж багатай, үр ашиггүй зардлыг санхүүжүүлж үндэсний баялагийг үргүй зарцуулсан.

42. 2012 оноос хойш өсөн нэмэгдэж буй төсвийн алдагдал, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад санхүүжилтийн тодорхойгүй байдал, өндөр өр нь эцэстээ хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр эдийн засагт тохиргоо хийх нөхцөлд байдлыг бий болгосон. 2017 оны 12 дугаар сард ОУВС-аас хийсэн Өрийн тогтвортой байдлын дүн шинжилгээ (DSA) -ийн урьдчилсан үр дүнгээс харахад төсөвт дорвитой тохиргоо хийх нь Засгийн газрын өрийг тогтворжуулна гэж дүгнэсэн: (i) томоохон уурхайн олборлолт, үйлдвэрлэлээс хамаарч 2019 онд эдийн засаг ихээхэн өсч, цаашид тогтвортой байх болно; (ii) доноруудаас олгох хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилт нь нийт санхүүжилтийн хэрэгцээг бууруулж, өрийн өнөөгийн үнэ цэнийг (PV) бууруулна. (iii) хөнгөлөлттэй бус нөхцлөөр авсан гадаад санхүүжилтийг дахин санхүүжүүлж, Засгийн газар дотоодын зээлдэгчдээс өнөөгийн нөхцлөөс илүү таатай нөхцлөөр санхүүжилт босгоно. Монгол Улсын нийт гадаад өр 2016 оны эцсээр ДНБ-ий 220 хувьтай тэнцсэн бөгөөд хэрэв 7.4 тэрбум ам.долларын компани хоорондын зээллэгийг хасч тооцвол дээрх үзүүлэлт 155.6 хувьтай тэнцэх юм. Эдгээр төсөөллийн дагуу, өрийн тогтвортой байдлын гол үзүүлэлт буюу ДНБ-д эзлэх өрийн өнөөгийн үнэ цэнэ нь 2018 онд 89 орчим хувь хүрэх магадлалтай байсан бөгөөд 2019 оноос буурч 2021 он гэхэд 81 хувьд хүрэхээр төсөөлөгдөж байна (Зураг 7). 2017 оны эдийн засгийн гүйцэтгэлийн үр дүнг харахад нэрлэсэн ДНБ ба төсвийн тэнцэл нилээд сайжирч, улсын өрийн хандлагыг сайжруулсан байгаа боловч өрийн тогтвортой байдал хэврэг бөгөөд гадаад цочролд мэдрэмтгий хэвээр байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр дотогш урсгал 2017 онд 1.5 тэрбум ам.долларт хүрээд байна.

Тогтвортой өсөлтөд хүрэх сорилтууд: Төсвийн зохистой бодлого ба хөрөнгийн хуримтлалыг төрөлжүүлэх нь

43. Эдийн засаг тогтворгүй байгаа нь нь Монголын эдийн засгийн үндсэн гурван сорилтын нэг юм. Өмнөх хэсэгт Монгол Улсын эдийн засгийн нээлттэй байдал болон уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр дүнд эдийн засаг, бүтээмж дорвитой өсч чадсан хэдий ч энэхүү өсөлтийн тогтворгүй байдал нэмэгдэж байгааг дурдсан билээ. Цаашид өсөлтийг үргэлжлүүлэн хадгалж тогтворгүй байдлыг бууруулахын тулд “Эдийн засгийн төрөлжилтийн дүн шинжилгээн”-д санал болгосны дагуу түүхий эдийн үнийн тогтворгүй байдлын эсрэг чадвартай мэргэшсэн институцийг бэхжүүлэх хмагийн чухал болоод байна. Мөн түүнчлэн цаашид илүү төрөлжсөн үйлдвэрлэл болон экспорттой болох шаардлагатай. Энэ хоёр хүчин зүйл нь эдийн засагт тогтвортой байдлыг бий болгоод зогсохгүй сүүлийн жилүүдэд эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн төсвийн болон төлбөрийн тэнцлийн алдагдлаас зайлсхийх орон зайг бүрдүүлнэ.

44. Эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрэхийн тулд макро эдийн засгийн зохистой бодлого, санхүүгийн салбарын эрүүл байдал болон бизнесийн таатай орчин зэрэг нь хамгаас чухал юм. Энэхүү цогц дүн шинжилгээгээр дээрх асуудлын хүрээнд Монгол Улсын эдийн засагт тулгараад буй сорилтуудыг авч үзлээ. Макро эдийн засгийн зохистой бус бодлого нь өрийн тогтворгүй байдлыг бий болгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татах

боломжгүй юм. Санхүүгийн салбараа бэхжүүлж, бизнесийн таатай орчингүйгээр бизнесийн шинэ боломжууд цэцэглэн хөгжих, цаашлаад эдийн засаг төрөлжих боломж хомс юм. Худалдааны зохистой дэд бүтэц, ложистикгүйгээрбол экспорт төрөлжих боломжгүй юм.

Хариуцлагатай, үр дүнтэй төсвийн бодлого

45. **Монгол Улс ирээдүйн эдийн засаг, хүний хөгжилд зориулж уул уурхайн салбараас орж ирэх орлогыг хуримтлуулах зорилгоор Баялгийн Сантай (БС) төстэй тогтолцоог бий болгох зорилгоор Монгол Улсыг Хөгжүүлэх Санг (МУХС) 2007 онд байгуулсан байдаг.** МУХС-г 2009 онд Хүний хөгжил санг (ХХС)-аар солигдсон байдаг. Эдгээр сангуудын зорилго нь зөв зүйтэй байсан хэдий ч харамсалтай нь 2004 болон 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр иргэдэд бэлэн мөнгөөр тараах, хавтгайрсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зэрэг улс төрийн амлалтуудыг биелүүлэхэд дээрх сангуудийн хөрөнгийг ашигласан ба энэ нь 2008-09 оны эдийн засгийн хямрал бий болоход дотоодоос нөлөөлсөн гол хүчин зүйлс байв. Харин 2011 онд улс төрийн намууд тохиролцоонд хүрч иргэдэд бэлэн мөнгө тараах байдлаар өрсөлдөхгүй байхаар тогтсон. Гэсэн хэдий ч илүү тогтвортой төсөв, ашигт малтмалын орлогын бодлогыг сайжруулах нь эдийн засгийн гол сорилт хэвээр байгаа бөгөөд цаашид ч тогтвортой байдлыг хангахад ихээхэн дорвитой өөрчлөлт шаардлагатай байна.

46. **2009 оны хямралын дараа түүхий эдийн үнэ өндөр, эдийн засгийн өсөлт сайн байх үе буюу 2010 онд Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан байдаг.** Энэ хууль нь 2013 оноос хэрэгжиж эхэлсэн ба төсвийн тогтворжуулалтын санг (ТТС) бий болгон түүхий эдийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамгаалах, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох, гарах үрсгалын өөрчлөлтөөс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой байв. Харамсалтай нь эдийн засгийн таатай цаг үе удаан үргэлжлээгүй ба 2012 оноос хойш түүхий эдийн үнэ, ГШХО бүүрч эхэлсэн. Үүний үр дүнд Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг ягштал дагаж мөрдөөгүй ба зарим заалтуудын хэрэгжилтийг хэд хэдэн удаа хойшлуулж, өөрчлөлт оруулсан байдаг. Мөн Төсвийн тогтворжуулалтын санд хангалттай хуримтлал үүсгэж чадаагүй юм. Орлого саарч, зарцуулалтад тавих хяналт ихээр суларсан. Мөн ЗГ-ын өр огцом өсөж, 2016 онд ДНБ-ний бараг 90 хувьд хүрсэн байна. Орлогыхоо бараг 20 хувийг зөвхөн хүүгийн төлбөрт шилжүүлж байгаа нь тогтворгүй байдлын маш тод илрэл байлаа.

47. **Мөн Засгийн газар шавхагддаг нөөцөөс төсөвт орох орлогыг одоо ба ирээдүй үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах зорилгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 2015 оны 2 дугаар сард баталсан байдаг.** Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрийг зөвхөн хөгжлийн гол хэрэгцээ шаардлага бүхий хөрөнгө оруулалтад зарцуулна гэж заасан байдаг. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө ДНБ-ний 10 хувиас давсан тохиолдолд энэ дүнгээс давсан хэмжээний санхүүгийн хуримтлалыг дотоод болон гадаад зах зээлд хөрөнгө оруулалт хийх, мөн Хөгжлийн Банкаар дамжуулан төмөр замын сүлжээ, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчим хүчний цахилгаан станц барьж байгуулах, олон улсын стандартын шаардлага хангасан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хөрөнгө оруулна гэж заасан байна (Хүснэгт 1).

48. **Төрийн санхүүгийн бодлого нь эдийн засгийн тогтворгүй байдал, улс төрийн шийдвэрээс шалтгаалсан сорилтуудтай тулгарсаар байна.** Орлогын төсөөлөл болон түүний

бодит гүйцэтгэл нэлээд хол зөрсөөр байгаа нь түүхий эдийн үнэ болон ашигт малтмалын орлогын төсөөлөл их эмзэг өөрчлөлт ихтэй тооцдог, мөн хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх гэсэн улс төрийн сонирхлоос ихээхэн шалтгаалсан байдаг. Түүнчлэн орлого, зарлагын гүйцэтгэл анхны батлагдсан төсөвтэй (Хүснэгт 2) уялдаа холбоо сул. Мөнгөн хөрөнгийн таамаглалын бодитой байдал нь сул, идэвхитэй байх боломжтой санхүүгийн хөрөнгийг сул тооцдог нь төсвийн үйл ажиллагааны үр дүнг сулруулж улмаар ЗГ-аас өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтад тэргүүлэх ач холбогдол өгөх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад саад тотгор болж байна. Энэ байдал нь зарлагын хэлбэлзэлийг нэмэгдүүлсэн ба тухайлбал, 2013-аас 2016 оны хооронд 12 хувийн хэлбэлзэлтэй байв. Боловсрол, нийгмийн халамж, зам тээвэр, эрүүл мэнд, шүүх гэх зэрэг ЗГ-ын 20 томоохон төсвийн ерөнхийлөн захирагчдын үйлчилгээг урьдчилан таамаглах байдлыг бууруулж, үйлчилгээний хүртээмж, чанар муу байхад нөлөөлсөн байдаг.

49. **Зарим агентлагуудын дутуу мэдээллээс хамаарч орлогын төсөөлөлийн чанар муу байна (ялангуяа Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал газрын тосны газар). Дээрх агентлагуудын салбар нэгжүүд нэлээд алслагдсан учир авч нэгтгэхэд хүндрэл үүсдэг.** Төсвийн зарлагын таамаглалыг сар бүрийн батлагдсан төсвийн хуваарийн түүхэн өгөгдлийг ашиглан хийдэг учраас мөн л чанар төдийлөн сангүй байна. Учир нь төсвийн зарлагын хуваарийг бэлэн мөнгөний хэмжээнээс шалтгаалж, салбарын яамдаас гаргасан хүсэлтийг үндэслэн байнга өөрчилдөг. Хөрөнгийн зарлага мөн ихээхэн хэлбэлздэг нь зардлын таналтыг хөрөнгийн зардлаас эхэлж хийдэгтэй холбоотой. Тиймээс хэрэгжүүлэгч агентлагуудын бэлэн мөнгөний хэрэгцээг түүхэн өгөгдөлд тулгуурлан нарийн тооцоолох боломжгүй байна. Энэ нь үр дүнтэй, үр ашигтай үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулсаар байна.

50. **Монгол Улсын худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалт хэдий сайн боловч институцийн түвшинд зарим сул талууд байсаар байна.**¹⁴ Ялангуяа хуулийн хэрэгжилт тэр дундаа худалдан авалтын сонгон шалгаруулах хорооны чадвар сул, худалдан авалтын шийдвэрт улс төрийн нөлөө орж шаардлага хангаагүй оролцогчдод ашигтай байдал үүсэх тохиолдлууд гарч байна. Төсвийн хөрөнгө оруулалтын шийдвэрийн ихэнх нь худалдан авах хуулиас гадуур хийгдэж байгаа бөгөөд ил тод байдал болон хяналт туйлын хязгаарлагдмал байна. Түүнээс гадна Засгийн газар хүртээмжтэй, бүрэн ажиллагаатай, сайн зохион байгуулагдсан цахим-худалдан авалтын системийг хөгжүүлэхэд ихээхэн нөөц боломж, хүчин чармайлт гаргаж байгаа ч хэрэгжилт нь төдийлөн сайнгүй байна.

51. **Эдгээр хэд хэдэн хууль тогтоомжууд нь тууштай, идэвх санаачилгатай төрийн албан хаагчид, өрсөлдөх чадвартай хувийн салбараар дамжин хэрэгжих боловч зарим сорилтууд байсаар байна.** Монголын төрийн алба одоо тулгараад байгаа сорилтуудаа шийдвэрлэж чадахгүй бол төрийн үйлчилгээнд итгэх итгэл, техникийн үр чадвар, үр дүнтэй байдлаа алдах эрсдэлтэй юм. Улс төрийн хүрээнд төрийн албан тушаалтныг эрх мэдэл, танил талаараа зуучлан томилж, мэргэжил, үр чадамжид суурилсан төрийн залгамж халаа

¹⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль 2000 оны 4 дүгээр сард батлагдсан. Хэрэгжилтийн удирдамж, худалдан авалтын өргөн хүрээний баримт бичгүүдээс бүрдэнэ.

алдагдсан байна. Төрийн албанаас халагдах байдал 2007 онд жилийн 6 хувь байсан бол 2014 онд 13 хувь болж илт нэмэгджээ. Энэхүү нөхцөл байдал нь мэргэжлийн үр чадвартай, чадавхитай боловсон хүчний тоо буурахын зэрэгцээ үр чадвартай боловсон хүчний эрэлтийг улам нэмэгдүүлж, төрийн албаны чанар, чадавхыг бууруулж, иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлөх маш бодит эрсдэлийг дагуулж байна. Танил талаараа төрийн албанд орох асуудал нь иргэдийн хууль дээдлэх ёс, төрийн албаны үр нөлөөнд итгэх итгэлийг сулруулж байна. 2011 онд хийсэн судалгаанаас үзэхэд хүн амын бараг 100 хувь нь төрийн албыг гэр бүл, танил талаар явуулахаас урьдчилан сэргийлэх тухай хууль, түүнчлэн төрийн алба нь төвийг сахисан, бие даасан, шударга, хариуцлагатай байх явдлыг хангах хууль эрх зүйн орчин хангалттай гэж үзжээ. Гэвч 50 хүрэхгүй хувь нь одоогийн төрийн албаны тухай хуулийг үр дүнтэй гэж үзсэн байна. Үүнээс харахад, төрийн албанд ажилд томилох сүүлийн үеийн чиг хандлага, зохион байгуулалт зэрэг нь аюулын дохио ойрхон байгааг илтгэж байна. Монгол Улсыг бусад орны 1-ээс 5 сая хүн амтай бусад орнуудтай харьцуулахад төсвийн зарлагын хувьд 5 хувиар илүү зардлыг цалин хөлс, түүнтэй адилтгах зардалд зарцуулж байна. Цаашилбал улсын салбарын хэмжээ 2005-аас 2014 оны хооронд огцом өссөн байна. Зарим өсөлт нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн шинэ албан тушаал бий болгох (Жишээлбэл: нийгмийн ажилтан), дүүргийн иргэдэд үйлчлэх ажилтны тоог нэмснээс үүдэлтэй. Мөн ахлах мэргэжилтний албан тушаалын тоо (2-р ангиллын орон тоонууд) энэ хугацаанд хоёр дахин илүү нэмэгдэж, жилийн өсөлт нь 8.6 хувь байна. Төрийн салбар ийнхүү өргөжин тэлж буйг тайлбарлах үндэслэл хомс байхгүй бөгөөд ерөнхийдөө танил талаараа төрийн албанд орж байгаа нь их хэмжээний өсөлтийн шалтгаан болжээ гэж хэлж болохоор байна.

Хөрөнгийн эх үүсвэр: ГШХО ба дотоод санхүүгийн салбар

52. Хөрөнгийн хуримтлал нь ихэнхдээ гадаадын шууд хөрөнгө оруулалт болон улсын өрөөс бүрдэж байгаа бол дотоодын үр бүтээмжтэй үйл ажиллагаанд дотоод хуримтлалыг ашиглах асуудал чухал сорилт хэвээр байна. ГШХО нь цаашид эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх төлөвтэй байгаа ч олон улсын санхүүжилтийн харилцан итгэлцэл, ойлголцлын динамикуыг Засгийн газар болон гадаадын хөрөнгө оруулагчдын хооронд үр ашигтай хадгалах хэрэгтэй. Цаашлаад Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх нь орон нутагт шинэ бизнесийг эхлүүлэхэд чиглэсэн дотоод, гадаад санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах гол суваг нь болсон илүү боловсронгуй, чадварлаг санхүүгийн салбараас ихээхэн хамаарна.

53. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь Монголын эдийн засгийн өсөлтийн санхүүгийн гол эх үүсвэрүүдийн нэг болоод зогсохгүй төсвийн орлого, гадаад валютын гол эх үүсвэр болж байна. Эдийн засаг нь ГШХО-аас хамаарал өндөртэй хэдий ч хөрөнгө оруулалтыг зохицуулж буй хууль тогтоомж нь тогтворгүй байсан нь эдийн засгийн хөгжилд саад тотгор болсоор байна. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай 2012 оны хуулиар үүл уурхай, харилцаа холбоо, банк, санхүү зэрэг гол гол салбаруудад Засгийн газар, УИХ-аас зөвшөөрөл авах болон хөрөнгө оруулалтын зарим хатуу нөхцөлүүд нэвтрүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтын нэлээд хүнд сорилттой тулгарсан. Гадаадын хөрөнгө оруулалт 2013 оноос буурч, Рио Тинтогийн хэдэн тэрбумын Оюу Толгой (ОТ) зэсийн уурхай зэрэг төслүүдийн асуудлаарх олон улсын яриа хэлэлцээнд хүндрэл учирснаар бизнес эрхлэгчдэд болгоомжлол үүссэн. 2010 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох үрсгал 1.7 тэрбум

ам. доллар (ДНБ-ий 24%) хүрч, 2011 онд 4.6 тэрбум ам. доллар (ДНБ-ний 44%) хүрч байв. Энэхүү огцом өсөлтийн шалтгаан нь уул уурхайн салбар, ялангуяа Рио Тинтогийн Оюу Толгой төслийн 1-р үе шатны бүтээн байгуулалт байв. Зөвхөн энэ төсөл ГШХО-д хүчтэй нөлөөлсөн юм. 2012 онд төслийн нэгдүгээр үе шат зогсонги байдалд орсноор хөрөнгө оруулалт буурч, цаашид хөрөнгө оруулалтын огцом уналтанд хүргэсэн. ГШХО-ын урсгал 2015 онд 94 сая ам.доллар болж буурсан байдаг (ДНБ-ий 0.8%). Оюу Толгой төслөөс гадна, гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгал 2014-15 онд буурсан нь дотоодын макро эдийн засгийн нөхцөл байдал, бизнесийн орчны доройтсон, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад ЗГ удаан хандсан, олон улсын зах зээлийн идэвхжил саарч, түүхий эдийн үнэ буурсан зэрэг хүчин зүйлстэй холбоотой байв. Оюу Толгой төслийн 2-р үе шат эхэлсэн, хөгжлийн түншүүдтэй хамтарсан хөтөлбөр буюу өрийн хямрал (sovereign default)-ын эрсдлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн хөтөлбөрийн нөлөөгөөр гадаадын хөрөнгө оруулалт 2017 оноос нэмэгдэж эхэлсэн.

54. Уул, уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтууд төвлөрч, бусад салбарт хөрөнгө оруулалт хомс байна. Бүртгэгдсэн ГШХО -ын мэдээнээс үзэхэд уул, уурхайн салбарт нийт ГШХО-ын 82 хувь нь орсон бөгөөд бөгөөд энэ дүнд Оюу Толгойн хөрөнгө оруулалт багтсан болно. Дараагийн гурван салбар буюу маш бага хувийг бүрдүүлж буй салбаруудаас дурьдвал: эрчим хүч 3.8 хувь, хадгалалт, агуулах 3.4 хувь, санхүүгийн үйлчилгээ 2.7 хувийг тус тус бүрдүүлж байна. Нөөц болон металлдууруулсан “Lumpy” хөрөнгө оруулалтаас гадна хөрөнгө оруулалтын үнэ цэнэ, төслийн тоо сүүлийн жилүүдэд буурч макро эдийн засгийн болон бизнесийн орчинд муугаар нөлөөлсөн. Монголын хөрөнгө оруулалтын хамгийн том түншүүд нь Их Британи, Канад, Япон, Сингапур, Хятад, Орос улсууд байна. (Зураг 8).

55. Санхүүгийн систем нь банкны салбараас ихээхэн хамаарсан ба арилжааны банкны зээл нь хувь хүн, бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн гол эх үүсвэр болсон хэвээр байна. Банкны салбарын эрсдэл өндөр байгаа нь банкуудын зээл гаргах сонирхлыг бага зэрэг бууруулж, найдвартай активт хошуурах хандлагыг бий болгож байна (жишээлбэл, ЗГҮЦ) Энэ нь санхүүжилтийн хүртээмж саарч буйг илтгэнэ. Нөгөөтэйгүүр, хувийн хэвшлийн зээл нь ипотекийн зээлд төвлөрч байсан бөгөөд сүүлийн үед хэрэглээний зээл нэлээд өсч, бизнесийн зээлийн нийт зээлд эзлэх хувь буураад байна. Өрхийн зээл (оронц сууцны зээл, хэрэглээ, цалингийн зээл) нь нийт зээлийн бараг 50 орчим хувийг эзэлж байгаа юм. ЖДҮ-д бизнесээ өргөжүүлэх санхүүгийн хэрэгцээ дутагдалтай хэвээр байна. Гол шалтгаан нь: (i) банкууд барьцаа хөрөнгийн баталгаа ихээр шаарддаг; (ii) өндөр хүүтэй; ба (iii) зээлийн хугацаа богино.¹⁵ 2012 оны дунд үеэс хойш зээлийн хүү нь аажмаар нэмэгдэж, 2017 онд 20 хувьд хүрсэн байдаг. Үүний зэрэгцээ банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ өсч, 2014 оноос өмнө чанаргүй зээлийн эзлэх хувь 3-аас бага байсан бол 2016 онд 9 хувь (Зураг 9, зүүн хэсэг) хүрсэн байна. Дээрх үзүүлэлтүүд нь Монгол Улсыг бүс нутагтаа эрсдэл өндөртэй банкны системтэй улсын тоонд оруулж байна. (Зураг 9, баруун тал). Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа саарч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар суларсан, хадгаламжийн хүүний түвшин өсч, активын чанар муудах, зах зээлийн эрсдэл өндөр, банкуудын үр ашиггүй

¹⁵ Монгол улсын аж ахуйн нэгжийн судалгаа 2013-т Санхүү□□□□ хү□□□□□□ нь бизнесийн хө□□□□□□ хамгийн их саад тотгор учруулдаг гэжээ(Судалгаанд хамрагдсан пүү□□□□ 31.7 хувь нь Зүү□ Ази, Номхон далайн орнуудад дунджаар 11.3 хувь байснаас ө□□□□ байгаа).

зардал, төсвийн алдагдлыг дотоодыоос ихээр санхүүжүүлсэн зэргээс үүдэлтэй байж болох юм.

56. Монгол Улс нь банкны салбарын хүртээмж бусад оронтой харьцуулбал нэлээд өндөрт ордог. 100,000 насанд хүрэгчдэд 72 арилжааны банкны салбар ногдож (дунд болон өндөр орлоготой орнуудад ойролцоогоор 26-33 салбар ногддог), 1,000 хүн тутамд ногдох 1'298 данс, энэ харьцаа нь Монгол Улс дунд орлоготой улсуудтай ижил түвшинд байгааг харуулж байна. Дэлхийн Банкны Global Findex мэдээллийн сангаас харахад 15-аас дээш насны нийт хүн амын 92% нь банкны данстай байдаг. Эсрэгээрээ, хөрөнгийн зах зээл нь маш сул, хөгжил нь удаашралтай, ойрын хугацаанд ахиц гарахааргүй байгаа нь хууль эрх зүйн орчин болон институцийн чадавх сул байгаатай холбоотой юм. Банк бус санхүүгийн салбарын хөгжлийн хурдац удаан байгаа нь зохистой бодлого, байгууллагын бүтэц, хяналтын зохицуулалтыг цаашид үргэлжлүүлэн сайжруулах шаадлагатайг харуулж байна. Банк бус санхүүгийн салбар нь эдийн засагт бага хувийг эзлэх боловч байнгын хяналт шаардлагатай бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны чадавхыг нэлээд сайжруулах шаардлага байна. Нэг талаас, санхүүгийн цөөхөн байгууллагад ихэнх хөрөнгө төвлөрч, ЖДҮ-ийн зээлд хамрагдах боломж хязгаарлагдмал хэвээр байгаа нь ижил түвшний улс орнууд болон дэлхийн түвшинтэй харьцуулахад санхүүгийн хүртээмжээрээ жагсаалтын сүүл үрүү эрэмблэгдэж байна. Гэхдээ нэг хүнд ногдох банкны үйлчилгээгээр (харилцах данс эсвэл зээлийг авч үзвэл) Монгол Улс ижил түвшний улс орнууд болон дэлхийн улс орнуудтай харьцуулахад жагсаалтын эхний хэсэгт эрэмлэгдэж байна. (Зураг А1 5-ыг харна уу).

57. Бодлого боловсруулагчид санхүүгийн тогтвортой салбар нь тогтвортой өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, 2025 он хүртэлх Санхүүгийн салбарын дунд хугацааны хөгжлийн стратеги боловсруулаад байна. Энэхүү стратеги нь олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай, үр ашигтай, хүртээмжтэй, тэнцвэртэй байдлыг хангасан санхүүгийн тогтолцоог бий болгохыг зорьсон. Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, гүнзгийрүүлэх, мөн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэд хэдэн хүчин чармайлт гаргасан; Базель II болон III-ийг хэрэгжүүлж, банкуудад эрсдэлд суурилсан хяналт хийдэг практикийг Монголбанкнаас баталж нэвтрүүлсэн. Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл нь 2012 онд байгуулагдаж, 2013 онд Банкны хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдсан бөгөөд хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах эрхтэй Монгол Улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци (МУХДК) байгуулах эрх зүйн үндсийг тавьсан. 2016 оноос эхлэн бүх банкууд СТОУС-ыг санхүүгийн тайландаа ашиглах бөгөөд үнэ цэнийн бууралтын тооцоонд НББОУС 39-ийг ашиглах шаардлагатай болсон. Хөдлөх ба биет бус хөрөнгийн барьцааны тухай хууль нь 2017 оны 3-р сард цахим бүртгэлийг эхлүүлснээр хүчин төгөлдөр болсон; Түүнээс хойш 100,000 хөдлөх хөрөнгө барьцаалсан барьцаа бүртгэгдэж, Засгийн газарт 1 сая ам.долларын хураамж хуримтлагдаж, шинээр холбогдох зээлийг ихэвчлэн ЖДҮ-д олгосон. Төлбөрийн системийн шинэ стратегийг 2016 онд нэвтрүүлсэн бөгөөд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2017 оны 5-р сард батлагдсан. Саяхан Банкны тухай хууль, Төвбанкны тухай хууль, Хадгаламжийн Даатгалын тухай хуулийг ОУВС-ийн багцын хүрээнд олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх зорилгоор боловсруулан батлуулсан.

58. **Хэдий дээрх олон амжилт байгаа ч “Зохистой харьцааны шалгуур”-аас чөлөөлсөн байдал байсаар байгаа бөгөөд санхүүгийн салбарт хүндрэлтэй асуудлуудтай тулгарсаар байна.** Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих гол хүчин зүйл нь банкууд мөн бөгөөд банкны системийг бэхжүүлэх асуудал нь ОУВС-ийн хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. ОУВС, Монголбанктай хамтран ЕСВ удирдамжийн¹⁶ дагуу активын чанарын хяналт (AQR) -ийг PwC-ээр гүйцэтгүүлсэн. Банкны системийг сэргээн босгох, Монголбанкийг бэхжүүлэхийн тулд Хадгаламжийн даатгалын корпорацийг бэхжүүлэх, банкны хадгаламжийн даатгалын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнчлэн үр ашигтай хадгаламжийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох IADI-ийн гол зарчимд нийцүүлэх шаардлагатай. Эцэст нь, Монголбанк нь банкуудын чанаргүй зээлийн багцыг банкуудаас худалдаж авах, шийдвэрлэхэд зориулж улсын төсвийн санхүүжилт, менежменттэй, хөрөнгийн удирдлагын компани (АМС) байгуулахаар судалж байна. Түүнчлэн, удирдлага, үйл ажиллагааны хувьд төрийн салбараас илүү байж болох чанаргүй зээлийн зах зээлд илүү мэргэшсэн хувийн хэвшлийн удирдлага, менежментийн тогтолцоо, платформыг мөн анхааран үзэж байна.

59. **Хэдийгээр дампуурлын тухай хууль батлагдаад бараг 20 жил хэрэгжиж байгаа ч дампуурлын үйл ажиллагаа бараг байгаагүй бөгөөд цаашид энэ чиглэлийг өргөн хүрээнд сайжруулах шаардлагатай байна.** Дампуурлыг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалт сайн байх нь амьдрах чадвартай бизнесээ хамгаалж үлдэх, төлбөрийн чадваргүй зээлдэгчдэд шат дараатай гарц олох боломжийг бий болгодог үр дүнтэй механизм юм. Цаашлаад өрийн дарамтанд орсон байгууллагуудын үнэ цэнийг боломжит хамгийн их хэмжээнд хадгалах, хэт их хэмжээний өрийн дарамтанд орсон хувь хүмүүст шинэ боломжийг бий болгодог. Энэ тогтолцоогүйгээр хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгч нар нь санхүүжилт олгох боломжтой хэдий ч удаан хугацааны турш үргэлжилж болохуйц маргааны асуудлаас үүдэн зайлсхийж байна. Чанаргүй зээлийн харьцаа харьцангуй өсөх хандлагатай байгаа үед санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд хэрэглэгчийн болон компаниудын муу өр төлбөрийг түргэн шуурхай шийдвэрлэх хэрэгтэй. Эдгээр нь бизнес эрхлэх, ЖДҮ-ийн хөгжил, санхүүгийн салбарын үр ашгийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг дэмжихэд тусалдаг.

60. **Удирдлагын чадавхын сул байдал нь зөвхөн улсын секторт хамаарахгүй юм.** ОУСК-ийн 2013 онд гаргасан компаний засаглалын үнэлгээг Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нийт хөрөнгийн 90%-ийг эзэлж буй хөрөнгийн биржид бүртгэлтэй 20 томоохон компаниудын дадлага туршлагад тулгуурлан гаргасан бөгөөд дундаж үнэлгээ 27.5% (100% - иас) байсан нь тухайн үед судалгаанд оролцсон компаниудын засаглал сул байгааг харуулсан. Компанийн засаглалын үнэлгээний Үндэсний зөвлөлөөс 2014 оны мэдээлэл ашиглан нийт 22 компанид хийсэн "Монголын үндэсний компаниудын засаглал 2015" тайланд компаний засаглал 53.4% гэж гарсан. Азийн ижил түвшний бусад орнуудад сүүлийн үед хийсэн судалгааны дүнтэй харьцуулбал, энэ сайн үр дүн байв. Хэдий ахиц дэвшил

¹⁶ Банкны системийн нийт зээлийн 91 хувьтай тэнцэх AQR нь ДНБ-ний 2 хувьтай тэнцэх (543 тэрбум төгрөг) хөрөнгө дутагдалтай байгааг тогтоосон. Энэ нь төлбөрийн орлогын 6.9 хувь, банкны системийн нийт хадгаламжийн 3.5 хувийг эзэлж байна. Монголбанк банкуудад 9 сарын хугацаа олгохоор шийдвэрлэсэн бөмбөг 2018 оны эцэс гэхэд энэ ажлыг хийхээр төлбөрийн байна. 2017 оны эцсээр банкуудын өмчлөх хөрөнгөний хувьцаа 13.7 хувь, 45 хувь байх төлбөрийн байгаа нь банкны тогтолцоо тогтворгүй хэвээр үргэлж, дахин санхүүгийн байгааг харуулж байна (Монголын макро эдийн засгийн 7 хоногийн тойм, No.31, 2 сарын 23, 2018).

байгаа ч хувийн хэвшлийн чадавх сул байгааг мартаж өсгүй. Үнэн хэрэгтээ хувийн хэвшил нь эдийн засгийн дорвитой өсөлтийг үр дүнтэй бий болгоход тэдэнд дэмжлэг хэрэгтэй юм.

Худалдааны гол асуудлууд: Бизнесийн орчин, Дэд бүтэц, Ложистик

61. **Монгол Улс нь далайд гарцгүй орны хувьд экспортын зах зээлтэй холбогдоход саад бэрхшээлтэй юм.** Гэвч байршлын хувьд Хятад, Оростой хил залгаа оршиж байгаа тул хөрөнгө оруулалт, экспортыг хөгжүүлэх боломж асар их юм. Монголын компаниудын өрсөлдөх чадварт олон хүчин зүйлс нөлөөлж байгаа ч Монгол руу орж буй орцыг нэмэгдүүлж эцсийн бүтээгдэхүүнийг зорилтот зах зээлд хүргэж чадвал далайд гарцгүй сул талаа бууруулах гол зам юм.

62. **Монгол Улс нь өргөн уудам газартай, газар зүйн хувьд Евразийн бүс нутагт стратегийн төв байршилтай ч тээврийн дэд бүтэц (төмөр зам, хатуу хучилттай зам, гааль, ложистикийн төвүүд) сул байгаагаас олон улсын зах зээлд бүс нутгийн төв болоход хүндрэлтэй байна.** Өргөн уудам газар нутагтай далайд гарцгүй, хүн амын нягтаршил бага, түүхий эдийн экспортоос хамааралтай эдийн засгийн хувьд газрын тээврийн дэд бүтэц нь эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварт чухал нөлөөтэй төдийгүй зах зээлд нэвтрэх, тээвэрлэлтийн зардлыг бууруулахад чухал билээ. Бүс нутгийн тээврийн дэд бүтэц нь хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт ажлын байр бий болгох болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл юм. Бизнес эрхлэхүй, Аж ахуйн нэгжийн судалгаа, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Ложистикийн гүйцэтгэлийн индекс (LPI) зэрэг судалгаагаар тээврийн дэд бүтцийн сүлжээ хангалтгүй байгаа нь Монголын бизнесийн орчинд гол садаа болж буйг онцолсон байна. Жишээлбэл, Монгол Улс дэлхийн өрсөлдөх чадварын индексээр 2016 онд 102-т жагсаж, Ложистикийн индекс буюу LPI-д 108-р байрт оржээ. Худалдаа, тээвэртэй холбоотой дэд бүтцийн чанарын хувьд 160 улсаас 140-д жагссан байна (Зураг 10, зүүн тал).

63. **Засгийн газраас гаргасан "Мянганы зам" зэрэг санаачилгуудын үр дүнд үндэсний авто замын сүлжээний урт сүүлийн 20 жилд гурав дахин нэмэгдсэн боловч бүс нутгийн тээврийн сүлжээг өргөтгөх ажил хангалтгүй хэвээр байна.** 2016 он гэхэд Монголын нийт авто замын сүлжээ 49'606 км, үүнээс зөвхөн тавны нэг нь хатуу хучилттай, хайрга, сайжруулсан шороон зам байна. Нийт 21 аймгаас төмөр замын сүлжээ зөвхөн 7 аймгийг хамарсан ба зөвхөн 16 аймаг хатуу хучилттай замаар нийслэлтэй холбогдсон байна. 2015 онд Монгол Улсын замын чанар ижил түвшний орлоготой орнуудаас харьцангуй доогуур буюу 118 дугаарт жагссан байна. Хүн амын нягтаршил бага, цаг уурын хатуу ширүүн нөхцөл байдлаас шалтгаалж Монголд авто зам шинээр барих, арчилгаа хийхэд маш өртөг өндөртэй байдгаас гадна Монгол Улсын бүс нутгийн дэд бүтэц мүү хөгжсөн, тээврийн дэд бүтэц чанар муу байгаад доорх үндсэн гурван хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд: Санхүүжилт хүрэлцээгүй, ялангуяа засвар, арчилгааны санхүүжилт бага, үйл ажиллагааны ил тод байдал сул бөгөөд хөрөнгө оруулалтын төлөвлөлт, дэд бүтцийн хөрөнгийн удирдлагын техникийн чадвар сул байна.

64. **Хөрш орнуудтай холбогдох тээврийн сүлжээг өргөжүүлэх шаардлагатай байна.** Монгол Улс нь энэ чиглэлээр хэд хэдэн хүчин чармайлтыг гаргаад байна. 2013 онд өмнөд хилээр БНХАУ-тай, хойд хилээр ОХУ-тай холбосон зам барих, түүнчлэн 1,100 км

цахилгаанжуулсан төмөр зам, газрын тос, хий дамжуулах хоолойн зам барих шинэ санаачилгыг гаргасан бөгөөд нийтдээ 50 тэрбум ам.долларын өртгөөр барина гэж тооцжээ. Гурван орны засгийн газар тус тусын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор эдийн засгийн корридор байгуулах, тээврийн дэд бүтцийн холболт, боомтын барилга байгууламж, үйлдвэрлэлийн хүчин чадал, хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засаг, соёлын солилцоо, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэхээр тохиролцсон байна. 2015 онд гурван орны засгийн газар төмөр зам барих талаар зөвшилцөлд хүрч Монгол-Орос-Хятадын хамтарсан төмөр замын тээвэр, ложистикийн компанийг байгуулахаар тохиролцов.¹⁷

65. Бүс ба Зам санаачилга (BRI) нь Монголын холболтыг сайжруулах болон худалдааг сайжруулахад эерэгээр нөлөөлөх төлөвтэй байна. “Бүс ба зам” санаачилгыг анх БНХАУ-ын Ерөнхийлөгч 2013 оны 3-р сард санаачилж, Хятадыг Төв болон Өмнөд Азитай холбох, цаашлаад Европ руу авто замаар холбох, түүнчлэн Зүүн Өмнөд Ази, Персийн булангийн орнууд, Хойд Африкийн орнууд болон далайгаар дамжин Европ руу холбохоор санаачилсан байна. Бүс ба зам санаачилгыг хамарсан орнуудын худалдааны статистикаас харахад тухайн нутаг дэвсгэр аажмаар худалдааны эрчимтэй бүс нутаг болж байна. Бүс ба зам санаачилгад холбогдсон орнууд хоорондын худалдааны олон улсын нийт худалдаанд эзлэх хувь 1995 оноос 2015 оны хооронд 31.6 хувиас 44.3 хувь болж өссөн байна. Энэхүү худалдаа болон бүс нутаг доторх худалдааны ихэнх хувийг завсрын бараа эзэлж байна (бүс нутаг доторх нэмүү өртгийн ач холбогдол улам бүр нэмэгдэж байна). Урьдчилсан тооцоогоор уг санаачилга нь худалдааны зардлыг бууруулах замаар худалдааны хэмжээ болон нэмүү өртгийг нэмэгдүүлж чадна гэдгийг харуулж байна.¹⁸

66. Бүс ба зам санаачилга нь Монгол Улсад түс дэм болохуйц худалдааг хөнгөвчлөх механизмийг бүрдүүлэх боломжтой. Одоогоор тодорхойлогдоод байгаа зургаан эдийн засгийн коридор дундаас Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь Монголд илүү хамааралтай юм. Бүс ба зам санаачилга орчмын экспортын нэмүү өртгийн үндсэн эх үүсвэр нь БНХАУ болон ОХУ юм. Монгол Улсын хувьд эдгээр хоёр улстай өргөн уудам газар нутгаар хил залгаа оршиж байдгийн хувьд энэхүү санаачилгаас ашиг хүртэх боломж их байна. Бүс ба зам санаачилга нь мэдээлэл солилцох, хууль журмын зохицуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх, хууль сахиулах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх зэрэг гаалийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийг зорьж байна. Түүнчлэн хяналт шалгалт, хорио цээр, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, стандарт хэмжилзүй, статистикийн мэдээллээр хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч байна. Төлөвлөгөөнд Бүс ба зам санаачилгад оролцогч улсууд хилийн боомтууд дээр гаалийн бүрдүүлэлтийн байгууламжуудыг сайжруулах, нэг цонхны систем бий болгох, гаалийн бүрдүүлэлтийн зардлыг бууруулах, бүрдүүлэлт хийх чадавхыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахыг санал болгож байгаа. Монгол Улсын хувьд худалдааг хөнгөвчлөх дэглэм улам муудсаар

¹⁷ □ Дэлхийн Банкны бодлогын баримт бичгээс мэдээлэл авсан болно: (Derudder, Liu, & Kunaka, forthcoming)

¹⁸ Урьдчилсан тооцоогоор худалдааны зардал 1 хувиар буурахад тухайн бүсийн хоёр талт худалдаа 1.3 хувиар, дотоодын нэмүү өртөг 1.7 хувиар өсөхөөр байна. Худалдааны статистик ба эдийн засгийн дүн шинжилгээг (Boffa, 2018) хийсэн болно

байгаа тул Бүс ба зам санаачилгын хүрээнд хэрэгжүүлэх дээр дурдсан асуудлууд Монгол Улсад ашигтай байх боломжтой. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гаалийн болон хилийн агентлагийн гүйцэтгэл алгуур муудсаар байна (энэ талаар доор дэлгэрэнгүй дурьдсан байгаа).¹⁹

67. Бүс ба зам санаачилга нь өрийн тогтвортой байдлын ач холбогдлыг харгалзаж үзэх боломж олгож байна. Бүс ба зам санаачилгад шаардлагатай хөрөнгө оруулалтын бодит хэмжээ болон санхүүжүүлэх арга механизм бүрэн ил тод бүс бөгөөд хэд хэдэн Хятадын банкны зээл болон бусад дотоод, гадаадын санхүүгийн эх үүсвэрээс бүрдэж байгаа юм. Энэ нь аль хэдийнээ өрийн хэмжээ өндөр байгаа Монгол Улсын хувьд төдийгүй зарим орнуудад өрийн тогтвортой байдлын асуудлыг үүсгэх магадлалтай. Хэрвээ Монгол Улс газрын тосны хий дамжуулах хоолойн хөрөнгө оруулалтыг татах шийдвэр гаргавал өрийн тогтворгүй түвшинд хүрэх боломжтой найман орны нэг болж болзошгүй юм.²⁰

68. Монгол шиг өргөн уудам нутагтай улс орнуудад тээврийн дэд бүтцийн асуудлаас гадна орчин үеийн харилцаа холбоо нь уламжлалт тээвэрлэлтийн үйлчилгээг орлох гол түлхүүр болж байгаа хэдий ч “цахим зааг” гэсэн чухал асуудал урган гарч ирч байна. Өргөн зурвасын цахим сүлжээний хүртээмж хотын хүн амд хязгаарлагдмал байна. Ялангуяа нийт хүн амын ойролцоогоор 50 хувь нь оршин суудаг Улаанбаатар хотод дээрх асуудал тулгараад байна. Одоо хэрэгжүүлж буй бодлого хөдөө, орон нутгийн хүн амын цахим сүлжээний хүртээмжийг хангахгүйгээр зогсохгүй өртөг өндөртэй байна. Мэдээлэл Холбооны Сүлжээ төрийн өмчит компани дангаараа ихэнх хөдөө, орон нутгийн шилэн кабелийн сүлжээг эзэмшдэг бөгөөд (түүнчлэн хувийн операторуудыг өөрсдийн харилцаа холбооны сүлжээг өргөтгөхийг хориглосон байдаг) эдгээр сүлжээг ашиглахын тулд бусад операторууд өндөр төлбөр төлж байна. Операторууд энэхүү өндөр зардлыг хэрэглэгчдэд тэр бүр шилжүүлэх боломж байдаггүй тул операторуудад хөдөө, орон нутагт өргөн зурвасын сүлжээ нэвтрүүлэх сонирхол багатай байна. Энэхүү тайлангийн хүрээнд хийгдсэн судалгаагаар Монголын интернет хэрэглэгчийн эзлэх хувь бусад ижил төстэй орнууд болон дэлхийн бүх улс оронтой харьцуулахад жагсаалтын сүүл үрүү эрэмблэгдэж, интернетэд холбогдсон хамгийн бага хүн амтай орны тоонд багтаад байна (Зураг А1-5 -аас харна уу).

69. Тээврийн дэд бүтэц сул байгаагаас гадна худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа тааруу байна. Энэ нь цаашлаад худалдааны өрсөлдөх чадвар болоод экспортын төрөлжилтийн түвшин маш бага байхад нөлөөлж байна. Дэлхийн банкны 2016 оны Ложистикийн гүйцэтгэлийн индекс буюу LPI-д 160 орноос 108-р байр, мөн чухал үзүүлэлт болох Хил, Гаалийн удирдлагаар 100-р байрт оржээ (Зураг 10, баруун тал). Мөн Бизнес эрхлэхүй, Хилийн чанад дахь худалдаа зэрэг судалгаагаар импорт, экспорт хийх хугацаа Зүүн Ази, Номхон далайн орнуудаас харьцангуй их байгааг харуулсан. Хэт олон баримт бичиг шаарддаг, дүрэм, журам ойлгомжгүй байдаг, хил дээрх биет үзлэг их (хэд хэдэн шалгалт болон лабораторийн шинжилгээ) байдаг, ялангуяа Хятадтай хиллэдэг ачаалал ихтэй Замын-Үүд дэх хилийн боомтын талаар худалдаа эрхлэгчид голлон гомдол ирүүлдэг

¹⁹ Энэхүү мэдээллийг Жулиан Латимерын дараагийн судалгааны үү дүгээр хийсэн: Дэлхийн Банк, 2018 "Бүс ба зам санаачилга: өрийн тогтвортой байдлын асуудал" хамгийн их байлгах худалдааг хөгжүүлэх тулгарч буй сорилтууд, шинэчлэлийн тэргүүн чиглэлүүд"

²⁰ Үүнийг Хурли, Моррис и Портеланс (Hurley, Morris and Portelance 2018)-ээс авав.

байна. Мөн түүнчлэн худалдаачдад тавигдах импорт, экспортын шаардлага байнга өөрчлөгддөг, хоёр хилийн дүрэм журам нийцдэггүй талаар гомдол мөн ирдэг байна. Зураг 10, баруун тал). Мөн Бизнес эрхлэхүй, Хилийн чанад дахь худалдаа зэрэг судалгаагаар импорт, экспорт хийх хугацаа Зүүн Ази, Номхон далайн орнуудаас харьцангуй их байгааг харуулсан. Хэт олон баримт бичиг шаарддаг, дүрэм, журам ойлгомжгүй байдаг, хил дээрх биет үзлэг их (хэд хэдэн шалгалт болон лабораторийн шинжилгээ) байдаг, ялангуяа Хятадтай хиллэдэг ачаалал ихтэй Замын-Үүд дэх хилийн боомтын талаар худалдаа эрхлэгчид голлон гомдол ирүүлдэг байна. Мөн түүнчлэн худалдаачдад тавигдах импорт, экспортын шаардлага байнга өөрчлөгддөг, хоёр хилийн дүрэм журам нийцдэггүй талаар гомдол мөн ирдэг байна. Зураг 10, баруун тал). Мөн Бизнес эрхлэхүй, Хилийн чанад дахь худалдаа зэрэг судалгаагаар импорт, экспорт хийх хугацаа Зүүн Ази, Номхон далайн орнуудаас харьцангуй их байгааг харуулсан. Хэт олон баримт бичиг шаарддаг, дүрэм, журам ойлгомжгүй байдаг, хил дээрх биет үзлэг их (хэд хэдэн шалгалт болон лабораторийн шинжилгээ) байдаг, ялангуяа Хятадтай хиллэдэг ачаалал ихтэй Замын-Үүд дэх хилийн боомтын талаар худалдаа эрхлэгчид голлон гомдол ирүүлдэг байна. Мөн түүнчлэн худалдаачдад тавигдах импорт, экспортын шаардлага байнга өөрчлөгддөг, хоёр хилийн дүрэм журам нийцдэггүй талаар гомдол мөн ирдэг байна. Зураг 10, баруун тал). Мөн Бизнес эрхлэхүй, Хилийн чанад дахь худалдаа зэрэг судалгаагаар импорт, экспорт хийх хугацаа Зүүн Ази, Номхон далайн орнуудаас харьцангуй их байгааг харуулсан. Хэт олон баримт бичиг шаарддаг, дүрэм, журам ойлгомжгүй байдаг, хил дээрх биет үзлэг их (хэд хэдэн шалгалт болон лабораторийн шинжилгээ) байдаг, ялангуяа Хятадтай хиллэдэг ачаалал ихтэй Замын-Үүд дэх хилийн боомтын талаар худалдаа эрхлэгчид голлон гомдол ирүүлдэг байна. Мөн түүнчлэн худалдаачдад тавигдах импорт, экспортын шаардлага байнга өөрчлөгддөг, хоёр хилийн дүрэм журам нийцдэггүй талаар гомдол мөн ирдэг байна.

70. Одоогийн болон ирээдүйн оруулагчдын хувьд тулгамдаж буй чухал асуудлын нэг нь Монгол Улсын үр ашиггүй тээвэр болон ложистикийн тогтолцоо бөгөөд угтаа энэ нь, ялангуяа далайд гарцгүй орны хувьд эерэгээр нөлөөлөх гол сүвгүүд байх ёстой юм. 2010 онтой харьцуулахад Монгол Улсын Ложистикийн гүйцэтгэлийн индекс сайжирч нийт 2.46 оноо (2016) авсан нь дэлхийн 160 эдийн засгаас 108-р байрт жагсжээ. Гэвч Монголын нийт Ложистикийн гүйцэтгэлийн индексийн оноо нь Папуа Шинэ Гвиней, Мьянмар зэрэг улсуудтай ойрхон боловч Камбож, Филиппин, Вьетнам, Индонез зэрэг Зүүн өмнөд Азийн орнуудаас доогуур үзүүлэлттэй байна. Монгол Улс нь худалдаа болон тээвэртэй холбоотой дэд бүтцээр 140-р байр, олон улсын илгээмжээр 129-р байр, ложистикийн чанар болон өрсөлдөх чадвараар 129-р байр, гаалийн бүрдүүлэлтээр 100-р байр тус тус эзэлсэн нь энэ чиглэлээр нилээд их сайжруулалт хэрэгтэй байгааг харуулж байна. Үүнтэй адилаар худалдааны зардал өндөр байгаа нь худалдааны үр ашиг, нийлүүлэлтийн сүлжээнд сөргөөр нөлөөлж байна. Үүнд: импорт, экспортын чингэлгийн дундаж зардал хөгжиж буй Зүүн өмнөд Азийн орнуудын дундаж зардлаас даруй 3 дахин өндөр байна.²¹

71. Эдгээр дэд бүтэц болон ложистикийн асуудлууд худалдааны өртгийг нэмэгдүүлж, улмаар өрсөлдөх чадварыг сулруулж байна. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын худалдааны өртгийн мэдээллийн сангийн дагуу Монгол болон

²¹ Бизнес эрхлэхүй □ 2018 (<http://www.doingbusiness.org/reports/global-reports/doing-business-2018>)

худалдааны голлох түнш улсуудын хоорондын худалдааны өртөг нь эдгээр орон болоод АНУ хоорондын худалдааны өртөгтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

72. Хүснэгт 3-ын эхний хоёр эгнээнд тариф тооцсон худалдааны нийт зардлыг харуулав. Дараагийн хоёр эгнээнд тариф тооцоогүй нийт зардлын дэлгэрэнгүй тооцоог харуулав. Эдгээр тооцоо нь тээврийн зардлыг төдийгүй дүрэм журмын шаардлагуудтай холбоотой зардлыг багтаасан бөгөөд ингэснээр худалдааны түнш орон хоорондын зай болон дүрэм журмаас үүсэлтэй саад бэрхшээлүүдийг илүү тодорхой ялгаж харах боломжтой юм. Монгол Улс нь АНУ-тай харьцуулахад сонгогдсон зах зээлүүдтэй илүү ойрхон бөгөөд экспортлогч орнууд зорилтот зах зээл рүү нэвтрэхэд ижил бэрхшээлтэй тулгарч буйгаас харахад, ажиглалтын зөрүү нь Монгол дахь дүрэм журмын зохицуулалтын асуудлуудаас үүдэлтэй байж магадгүй юм. Зөвхөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг авч үзэхэд үйлдвэрлэлийн дамжлагатай худалдаа илүү үр дүнтэй нөлөө үзүүлж байна. Эдгээр тооцоогоор Монгол Улсын зарим түнш орнуудтай хийх худалдаанд тарифын сул тал ажиглагдаж байгаа хэдий ч тариф нь Монголын экспортын өрсөлдөх чадварыг тодорхойлох үндсэн хүчин зүйл биш юм. Худалдааны ложистик, худалдааг хөнгөвчлөх талын асуудлууд Монголын экспортлогчдод сөрөг нөлөө үзүүлж байгаа учир тэдгээрийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай. Ложистикийн өндөр өртөг нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай импортын түүхий эд болон орцын үнийг өсгөхөд хүргэж байгаа бөгөөд Монголын экспортлогчдод хоёр дахин илүү сөргөөр нөлөөлж байна. Хүснэгт 3-ын эхний хоёр эгнээнд тариф тооцсон худалдааны нийт зардлыг харуулав. Дараагийн хоёр эгнээнд тариф тооцоогүй нийт зардлын дэлгэрэнгүй тооцоог харуулав. Эдгээр тооцоо нь тээврийн зардлыг төдийгүй дүрэм журмын шаардлагуудтай холбоотой зардлыг багтаасан бөгөөд ингэснээр худалдааны түнш орон хоорондын зай болон дүрэм журмаас үүсэлтэй саад бэрхшээлүүдийг илүү тодорхой ялгаж харах боломжтой юм. Монгол Улс нь АНУ-тай харьцуулахад сонгогдсон зах зээлүүдтэй илүү ойрхон бөгөөд экспортлогч орнууд зорилтот зах зээл рүү нэвтрэхэд ижил бэрхшээлтэй тулгарч буйгаас харахад, ажиглалтын зөрүү нь Монгол дахь дүрэм журмын зохицуулалтын асуудлуудаас үүдэлтэй байж магадгүй юм. Зөвхөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг авч үзэхэд үйлдвэрлэлийн дамжлагатай худалдаа илүү үр дүнтэй нөлөө үзүүлж байна. Эдгээр тооцоогоор Монгол Улсын зарим түнш орнуудтай хийх худалдаанд тарифын сул тал ажиглагдаж байгаа хэдий ч тариф нь

Монголын экспортын өрсөлдөх чадварыг тодорхойлох үндсэн хүчин зүйл биш юм. Худалдааны ложистик, худалдааг хөнгөвчлөх талын асуудлууд Монголын экспортлогчдод сөрөг нөлөө үзүүлж байгаа учир тэдгээрийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай. Ложистикийн өндөр өртөг нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай импортын түүхий эд болон орцын үнийг өсгөхөд хүргэж байгаа бөгөөд Монголын экспортлогчдод хоёр дахин илүү сөргөөр нөлөөлж байна. Хүснэгт 3-ын эхний хоёр эгнээнд тариф тооцсон худалдааны нийт зардлыг харуулав. Дараагийн хоёр эгнээнд тариф тооцоогүй нийт зардлын дэлгэрэнгүй тооцоог харуулав. Эдгээр тооцоо нь тээврийн зардлыг төдийгүй дүрэм журмын шаардлагуудтай холбоотой зардлыг багтаасан бөгөөд ингэснээр худалдааны түнш орон хоорондын зай болон дүрэм журмаас үүсэлтэй саад бэрхшээлүүдийг илүү тодорхой ялгаж харах боломжтой юм. Монгол Улс нь АНУ-тай харьцуулахад сонгогдсон зах зээлүүдтэй илүү ойрхон бөгөөд экспортлогч орнууд зорилтот зах зээл рүү нэвтрэхэд ижил бэрхшээлтэй тулгарч буйгаас харахад, ажиглалтын зөрүү нь Монгол дахь дүрэм журмын зохицуулалтын асуудлуудаас үүдэлтэй байж магадгүй юм. Зөвхөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг авч үзэхэд үйлдвэрлэлийн дамжлагатай худалдаа илүү үр дүнтэй нөлөө үзүүлж байна. Эдгээр тооцоогоор Монгол Улсын зарим түнш орнуудтай хийх худалдаанд тарифын сул тал ажиглагдаж байгаа хэдий ч тариф нь Монголын экспортын өрсөлдөх чадварыг тодорхойлох үндсэн хүчин зүйл биш юм. Худалдааны ложистик, худалдааг хөнгөвчлөх талын асуудлууд Монголын экспортлогчдод сөрөг нөлөө үзүүлж байгаа учир тэдгээрийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай. Ложистикийн өндөр өртөг нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай импортын түүхий эд болон орцын үнийг өсгөхөд хүргэж байгаа бөгөөд Монголын экспортлогчдод хоёр дахин илүү сөргөөр нөлөөлж байна.

73. Шинэ хөрөнгө оруулалтын боломжийг нээхийн тулд бодлого боловсруулагчид бизнесийн орчинг сайжруулахад илүү анхаарлаа хандуулах хэрэгтэй. Ингэснээр өсөлтийн гол саад тотгорыг бууруулах боломжтой. Түүхий эдээс гадна Монголын малын тоо толгой асар их, мөн хүнсний боловсруулах үйлдвэр, харилцаа холбоо, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч зэрэг бусад салбарууд цаашид хөгжих бүрэн боломжтой. Хамгийн чухал нь эдийн засгийн бодлого, зохицуулалтын тогтвортой, бат бөх байдлыг хангах, авилгатай тэмцэх асуудлуудыг шийдвэрлэснээр хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах гол алхмуудын нэгээхэн хэсэг байж болох юм. Дэлхийн Банкны 2017 оны Бизнес эрхлэхүй тайланд (www.doingbusiness.org) Монгол Улс 190 орноос 64-р байрыг эзэлж байна. Монгол Улс “Distance to Frontier” үзүүлэлтээр 2010 онд 58.73 хувьтай байсан бол 2017 онд 68.15 хувь болж сайжирсан байна. (0 нь гүйцэтгэл хамгийн доогуур, 100 нь “frontier” буюу шаардлага хангах түвшинг илтгэнэ.) Гэвч сайжруулах шаардлагатай ажлууд нэлээд байна (Зураг 11). Ялангуяа хил дамнасан худалдаа (Монгол 103-р байр; 2016 онд 102-р байр), цахилгааны хангамж (137-р байр, 2016 онд 136-р байр), гэрээний хэрэгжилт (85-р байр, 2016 онд 83-р байр), болон төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх (91-р байр, 2016 онд 87-р байр) зэрэг нь Монгол Улсын бизнесийн орчны жил ирэх тутам суалрч буй асуудлууд юм. Зураг 11). Ялангуяа хил дамнасан худалдаа (Монгол 103-р байр; 2016 онд 102-р байр), цахилгааны хангамж (137-р байр, 2016 онд 136-р байр), гэрээний хэрэгжилт (85-р байр, 2016 онд 83-р байр), болон төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх (91-р байр, 2016 онд 87-р байр) зэрэг нь Монгол Улсын бизнесийн орчны жил ирэх тутам суалрч буй асуудлууд юм. Зураг 11). Ялангуяа хил дамнасан худалдаа (Монгол 103-р байр; 2016 онд 102-р байр), цахилгааны

хангамж (137-р байр, 2016 онд 136-р байр), гэрээний хэрэгжилт (85-р байр, 2016 онд 83-р байр), болон төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх (91-р байр, 2016 онд 87-р байр) зэрэг нь Монгол Улсын бизнесийн орчны жил ирэх тутам суалрч буй асуудлууд юм. Зураг 11). Ялангуяа хил дамнасан худалдаа (Монгол 103-р байр; 2016 онд 102-р байр), цахилгааны хангамж (137-р байр, 2016 онд 136-р байр), гэрээний хэрэгжилт (85-р байр, 2016 онд 83-р байр), болон төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх (91-р байр, 2016 онд 87-р байр) зэрэг нь Монгол Улсын бизнесийн орчны жил ирэх тутам суалрч буй асуудлууд юм.

74. **Дэд бүтцийн асуудлуудаас гадна оруулагчид Монгол Улсыг микро болон макро асуудлуудаас шалтгаалж хөрөнгө оруулахад өндөр эрсдэлтэй гэж үзсэн хэвээр байна. Микро асуудлуудад хууль, эрх зүйн зохицуулалт, лиценз, санхүүжилтийн талаарх мэдээллийн тэнцвэргүй байдал, макро асуудалд хууль журмын байнгын өөрчлөлтийг дурджээ.** Газар өмчлөлийн асуудал хөрөнгө оруулалтыг улам төвөгтэй болгож байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчид зөвхөн хамтарсан үйлдвэрт хөрөнгө оруулах замаар томоохон хэмжээний хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалт хийх боломжтой. Дэлхийн эдийн засгийн форумын Засаглалын үзүүлэлтийн дагуу хууль, эрх зүйн зохицуулалтын чанар харьцангуй бага хэвээр (бусад ижил төстэй орнуудтай харьцуулсан ч гэсэн) байгаа бөгөөд зарим тохиолдолд 2010 оны эхэн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Зураг 12-оос Монгол Улс нь бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад шүүхийн бие даасан байдал, төсвийн сангуудын төвлөрлийг саармагжуулах, шийдвэр гаргах нөлөөлөл зэрэг үзүүлэлтээр харьцангуй сул байгааг харж болно.²² Эдгээр салбарыг сайжруулснаар Монголд өрсөлдөөн бий болгох, технологийн дэвшлийг авчрах өндөр чанартай оруулагчдыг татахад чухал ач холбогдолтой. Зураг 12-оос Монгол Улс нь бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад шүүхийн бие даасан байдал, төсвийн сангуудын төвлөрлийг саармагжуулах, шийдвэр гаргах нөлөөлөл зэрэг үзүүлэлтээр харьцангуй сул байгааг харж болно.²³ Эдгээр салбарыг сайжруулснаар Монголд өрсөлдөөн бий болгох, технологийн дэвшлийг авчрах өндөр чанартай оруулагчдыг татахад чухал ач холбогдолтой. Зураг 12-оос Монгол Улс нь бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад шүүхийн бие даасан байдал, төсвийн сангуудын төвлөрлийг саармагжуулах, шийдвэр гаргах нөлөөлөл зэрэг үзүүлэлтээр харьцангуй сул байгааг харж болно.²⁴ Эдгээр салбарыг сайжруулснаар Монголд

²⁴ Засаглалын хэд хэдэн үзүүлэлтүүд. Энэхүү үзүүлэлтүүд нь Монголын улсын засаглалын ерөнхий үзүүлэлтүүдэд багтдаг. Индексийн эмхтгэлийг Дэлхийн Банкны цахим хуудаснаас үзүүлэх <https://govdata360.worldbank.org/>

өрсөлдөөн бий болгох, технологийн дэвшлийг авчрах өндөр чанартай оруулагчдыг татахад чухал ач холбогдолтой.

75. Гаалийн ерөнхий газар олон улсын стандартад нийцсэн нэлээд олон тооны шинэчлэлийг эхэлсэн боловч ялангуяа том оврын ачаа тээвэр, галт тэрэгний ложистикийн салбарт хууль, эрх зүйн зохицуулалтын хүндрэл байсаар байна. Том оврын ачаа тээврийн үйлчилгээний хувьд хил дамнасан худалдааны хэлэлцээр сул байгаа нь Монгол Улсын бараа бүтээгдэхүүн Хятадын хилээр нэвтрэх үрсгалд хүндрэл болж байгаагаас гадна зарим үед хилийн боомт дээр бараа ачилтыг хоёр дахин хийх тохиолдол гарч байна. Зохицуулалтын стандартын ялгаа нь ложистикийн үйлчилгээ эрхлэх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэхэд сөрөг нөлөөтэй. Төмөр замын хувьд, төмөр замын салбарын зохицуулалт болон тарифын бүтэц нь хувийн хэвшлээс төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн хэсэгт оруулах сэдлийг дэмжих хэмжээний зохицуулалт алга байна. Төмөр замын сүлжээ эзэмшигч (гол удирдагч) Улаанбаатар Төмөр Зам (УБТЗ) операторууд өөрсдийн вагоныг ашигласан тохиолдолд хөнгөлөлт олгодог учир хөдлөх бүрэлдэхүүнд их хэмжээний хөрөнгө оруулалт татахад маш ихээр сөргөөр нөлөөлж байна. Дэд бүтцийн асуудлууд нь хил дамнасан ачаа тээврийн зогсолтгүй хөдөлгөөнд саад бэрхшээл учруулсаар байна. Тухайлбал, Хятадын боомт руу бараа бүтээгдэхүүн зөөвөрлөх төмөр замын царигийн стандарт өөр байгаа нь төмөр замын нэгдсэн цариг ашигласнаар үүсэх үр ашгийг авч чадахгүйд хүрч байна. Энэ асуудлыг Засгийн газраас Таван толгой-Хятадын төмөр замын холбоосоор дамжуулан хийхээр шийдвэрлэсэн ч энэ холбоосыг хийхэд шаардлагатай санхүүжилт шийдэгдээгүй хэвээр байна.

Монголын өвөрмөц хөрөнгө: Мал сүрэг

76. Эцэст нь, ихэнх монголчуудын хувьд хадгаламж, хуримтлуулах үндсэн хэлбэрийн нэг нь мал сүрэг бөгөөд мал сүргийн эрсдэл байнга нэмэгдэж байдаг. Малын тэжээл муу, мал төллөлтийн түвшин бага, хөгшин мал нядалгаанд оруулдаг зэрэг нь махны гарц болоод чанарт сөргөөр нөлөөлж байна. Хоол тэжээлийн нөөц хангалтгүй байгаа нь хүрээлэн буй орчны цочролоос сэргийлж чадахгүйд хүрч, өвлийн гамшгийг улам хүндрүүлж байна. Малын тоо толгойн өсөлт нь бэлчээр, усны нөөцийг ихээхэн доройтолд оруулж байгаагаас гадна төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хөгжсөн хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийн системүүд устан үгүй болжээ. Тэжээлийн олдоцын хувьд 1989 онд нэг малын толгойд ногдох тэжээлийн хэмжээ 40 нэгж/тэжээл байсан бол 2016 онд 11.3 нэгж/тэжээл болжээ. Экологийн чадамжийн (харьцуулалт хийх нөхцөл) хувьд бэлчээрийн талбайн ойролцоогоор 65 хувь нь доройтсон бөгөөд урт хугацааны хяналт, шинжилгээний үр дүнгээр бараг 7 хувь нь цөлжилтөд нэрвэгджээ. Мал сүргийн бүтцийн хувьд хонь, ямааны тоо толгойн харьцаа 3:1 байсан бол одоо бараг 1:1 болж өөрчлөгдсөн байна. Мал аж ахуйгаас орох орлого буурч байгаагаас малчид үндсэн хэрэгцээгээ хангахын тулд өндөр үнэтэй ноолуур борлуулах зорилгоор ямаан сүргийг давамгайлан маллах болжээ. Цаашилбал, 2016 оны байдлаар Монголд үржлийн хонь нийт хонин сүргийн тоонд эзлэх хувь 45.2 хувь байсан бол Австралид 55 хувь орчим байжээ. Нийт сүргийн зөвхөн 3.8 хувь нь цэвэр цусны сайжруулсан үүлдэр ба цөм сүрэг хангалттай биш байна. Мал сүргийн тоо толгойн тэгш бус байдал нь малчдын бүтээмжэд ноцтой нөлөөлж улмаар санхүүгийн болоод экспортоо өсгөн нэмэгдүүлэх чадварт сөрөг нөлөө үзүүлсээр байна (Хүснэгт 4). Хүснэгт .

77. **Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн харьцангуй давуу тал болон малын гаралтай бүтээгдэхүүн урт хугацааны түршид экспортлох боломж бүхий томоохон зах зээлтэй ойрхон байгаа нь Монголын эдийн засаг, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах тал дээр шинэ боломжийг бий болгож байна.** Мал сүргийн давуу талаараа ижил төстэй Шинэ Зеланд гэх мэт улстай харьцуулахад Монгол Улсын махны экспортын боломжит хэмжээ жилдээ 650'000 тонн байна. Боломж байгаа хэдий ч 2016 онд зөвхөн 8,900 тонн түүхий мах экспортолсон байна. ОХУ, БНХАУ, Япон, Солонгос, Төв Азийн орнууд уруу урт хугацаандаа мах экспортлох боломж байсаар байна. 2015 онд БНХАУ дангаараа 1,9 сая тонн мах хэд хэдэн орноос импортолсон бөгөөд Монголоос 150,000 тонн мах импортлох хүсэлт гаргасан байдаг. Экспортыг дэмжихэд эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн (ЭАУХЦ) арга хэмжээ; хил дамнасан ложистик; гаалийн хяналт шалгалт зэрэг нь гол саад бэрхшээл болж байна. Орчин үеийн нядалгааны газруудаас гадна нийт махны 97%-ийг малчид нядалж байгаа ч Монгол Улс нь фермерүүд, малчид, худалдаачид, боловсруулагчид болон тэргүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй үр ашигтай түншлэл тогтоож, нийлүүлэлтийн сүлжээнд бага зэрэг өөрчлөлт хийснээр хүнсний аюулгүй байдлыг хангасан үйлдвэрлэл, экспорт хийх боломжтой. Саяхан батлагдсан Малын генетик нөөцийн тухай хуулийн дагуу Монголын мал аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор генетик нөөцийг бүртгэх, бүс нутгийн онцлогт дасан зохицсон малын шинэ үүлдэр, омог бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад тохируулан сүргийн бүтцийг өөрчлөх зэрэг ферм дээр суурилсан туршилтаар үүлдрийг сайжруулах судалгаа хийж байна.

78. **Хөдөө аж ахуйн экспортыг өргөжүүлэхэд хууль, эрх зүйн зохицуулалтын арга хэмжээ онцгой чухал ач холбогдолтой холбогдолтой юм.** Малын халдварт өвчин төдийгүй хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн асуудал нь малчдын зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулахад саад бэрхшээл болж байна. Сүүлийн 10 гаруй жилийн турш гар, хөл, амны өвчний тархац нь Монголын үйлдвэрлэгчдийг зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүн экспортлоход ихээхэн хохирол учруулж байна. Засгийн газрын зүгээс сүүлийн хоёр жилд малын халдварт өвчний эсрэг вакцинжуулалтыг эрчимжүүлээ. Вакцинжуулалтад хамрагдсан малын тоо толгой 2015 онд 6.5 сая толгой байсан бол 2016 он гэхэд 26.8 сая толгой болж өсчээ. Гэвч мал эмнэлгийн хөтөлбөрүүд нь малын халдварт өвчнийг бүрэн хянаж, мал сүргийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн асуудал, биет болон санхүүгийн хөрөнгийг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна. Шинээр батлагдсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хувийн салбарын үүрэг, ороцоог дахин тодорхойлох, мал эмнэлгийн үйлчилгээ, малын өвчний тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй. Монгол Улсын экспортын зах зээлд нэвтрэх чадавхид саад учруулж буй хил дамнасан малын өвчинтэй тэмцэх арга хэмжээнд хөрөнгө оруулалтаа түлхүү чиглүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэл ("Ариун Цэврийн" гэх мэт) нь тандалтын тогтолцоог бэхжүүлэхэд чухал юм.

Хайрцаг 2: Засаглал: Гэрээний заалт

Байгалийн баялгаас хамааралтай орнуудад гэрээний заалтуудыг тохиролцоо асуудал гардаг. Үүнийг ихэвчлэн нийлүүлэлтийн гэрээ гэж нэрлэдэг бөгөөд төвлөрсөн байдлаар түрээсийг зохицуулдаг, албан тушаалаар ивээн тэтгэх, үлс төрийн дэмжлэгтэйгээр

бүтээгдэхүүн нийлүүлэх (клиентелизм) зэрэг асуудлуудыг хамруулдаг. Ардчилсан болон сонгуулийн тогтолцоотой орнуудад **нийлүүлэлтийн гэрээ** нь түрээсийн дараах нөхцөлд үүснэ. Үүнд: (i) олон нийтийг хамарсан кампанит үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр солилцох (ii) улс төрчид нэр хүнд олж авах ба итгэл үнэмшилтэй харагдахаар төлөвлөх, болон (iii) зөвхөн сонгогчид улс төрчдийг (жишээлбэл: амлалт) дахин сонгосон тохиолдолд харьцангуй тогтвортой байх боломжоос үүсэн гардаг.

Байгалийн баялгаас хамааралтай улс орнуудтай холбоотой нийлүүлэлтийн гэрээ нь улс төр, эдийн засгийн гурван хандлагыг бий болгодог байна. Үүнд: Голланд өвчин буюу Dutch Disease (бодит валютын ханшийн чангаралт), хэлбэлзэл (Өсөлт-ба-Уналтын мөчлөг), сул засаглал (хяналт болон тэнцвэр алдагдсанаас үүсэлтэй) юм. Гэхдээ тусгайлсан зохицуулалттай нийлүүлэлтийн гэрээ нь байгууллагын болоод улс төрийн ихээхэн ялгаатай байдлуудыг бий болгодог болно. Товчилбол, засгийн газрын бүрэлдэхүүний зарим нь үйл ажиллагаагаа бусдаасаа илүү сайн хийдэг бөгөөд авилга, клиентелизм зэрэг улс төрийн хамгийн сөрөг нөлөө бүхий шинж чанаруудтай зэрэгцэн оршдог. Дэлхийн Банкны судалгаагаар (Varma, et al, 2012) байгалийн баялаг ихтэй орнууд "Талууд хоорондын харилцан хүлээх үүрэг, итгэл даах чанар" ба "Улс төрийн оролцооны хэмжээ"-ний хувьд хэрхэн ялгаатай байж болохыг харуулсан байдаг. Энэ судалгаанаас ургуулан Монгол болон Чили хоёулаа олборлох салбараас орсон орлогын хуваарилалтын зохицуулалт хийх зорилгоор адилхан бүтэцтэй хамгийн шилдэг туршлагыг авч хэрэгжүүлсэн боловч маш ялгаатай үр дүнгүүд бий болсныг харах боломжтой. Ижил төстэй "Бүтцийн өөрчлөлтийн бодлого авч хэрэгжүүлэх" нь засаглалын ялгаатай байдал болоод эрс тэс ялгаатай хөгжлийн үр дүнг бий болгож болох юм (World Bank, 2017).

Монгол дахь төсвийн бодлогын удирдлага

Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагаа сул байгаагаас хэд хэдэн хууль тогтоомжийг бий болгосон байна. 2009 онд байгуулагдсан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ) (2012 оны сонгуулийн дараа Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ) болж өөрчлөгдсөн), 2011 онд байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн Банк (МУХБ) нь хоёулаа Хятадын хүчирхэг төрийн оролцоотой хөгжлийн стратегийн загвар дээр суурилж байгуулагдсан. 2011 оны 7 сард Улсын Их Хурал Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нэгдсэн төсвийн тухай хуулийг баталсан. Түүнээс гадна 2014 онд ЭЗХЯ-ыг татан буулгаж, чиг үүргийг шинээр байгуулагдсан Аж үйлдвэрийн яам болон Ерөнхий сайдын харьяа дахь Үндэсний хөгжлийн газарт шилжүүлсэн байдаг. 2016 оны сонгуулийн дараа улсын төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг Сангийн яаманд Төсвийн хөрөнгө оруулалтын газрыг шинээр байгуулж шилжүүлсэн. Хэдийгээр хууль эрх зүйн хувьд эдгээр тохиргоо болон бүтцийн өөрчлөлт нь Монголын олон намын ардчиллын тусгал (Монгол Улс сонгуулийн тойргийн системээс үүдэн хэдийгээр ихэвчлэн хоёр нам эвсэн нийлж эсвэл дангаараа засгийн эрхийг барьдаг боловч) боловч өөрчлөлтийн хэв маяг (ихэнхдээ тогтворгүй, хурдацтай) сонгуулийн мөчлөгөөс үүдэлтэй бөгөөд эдийн засаг, гадаад орчны сөрөг нөлөө, нам хооронд болоод намын дотоод бүлэглэлийн хөдөлгөөнөөс шалтгаалж байна. Хууль тогтоомжийн түүштай хэрэгжилт байхгүйн улмаас амлалтууд биеллээ олж чадалгүй хамтын ажиллагаа нуран унасаар байна.

Төсвийн удирдлага сүүлийн жилүүдэд суларсаар байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсан ч төсвийн тодотгол хийх асуудал хэвээр байгаа бөгөөд өнгөрсөн хоёр жилд төсвийн тэнцвэргүй байдал гүнзгийрсэн. Түүнчлэн, МУХБ байгуулагдаж Сангийн яамны эрх мэдлээс гадуур буюу төсвөөс гадуур их хэмжээний зарцуулалт хийгдэх болсоноор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг тойрох боломж үүссэн төдийгүй улс төрийн сэдэлтэй төсвийн орлогын өөдрөг тооцоолол энэ явдлыг улам дэвэргэсэн. Дэлхийн банкнаас үнэлгээнүүд болох Монголын төсвийн зарлага, санхүүжилтийн дүн шинжилгээний (PEFA analysis) үзүүлэлтүүд 2015 онд хамгийн сайн дундажид байсан бол 2011 оноос хойш CPIA төсвийн болон санхүүгийн удирдлагын үнэлгээний чанар буурсан байна.

Монголд төсвийн хөрөнгө оруулалт хоёр төрлийн системийн алдаанаас шалтгаалан хүнд нөхцөлд орсон байдаг. Нэгдүгээрт, их засвар, арчилгааны ажлыг үл тоомсорлосноос шалтгаалан хуваарилалтын үр ашиг бага бөгөөд энэ нь цаашлаад “Барих-Үл хайхрах-Дахин барих” хувилбарт хүргэсэн байдаг. Мөн сахилга бат дутмаг, хөрөнгийн төсөвлөлтөд ач холбогдол өгөх ямар нэгэн урамшуулах тогтолцоо яамдад байхгүй байна. Хоёрдугаарт, үйл ажиллагааны үр ашиг бага, ялангуяа төсөл хугацаандаа дуусдаггүй хойшлогдох явдал их, төлөвлөлт болоод зардлын тооцоолол муу тэр дундаа барилгын салбарын тооцоолол сул байна. Дэлхийн банкны судалгаагаар (Hasnain 2014) хэрхэн институцийн зохион байгуулалт Монголын улс төрөөс үүсэлтэй эрх мэдлийн шат дарааллын дагуу бий болдгийг харуулсан байдаг. Тухайлбал, УИХ-ын (мөн УИХ-ын гишүүдийн) төвлөрсөн ба стратегийн үүрэг болон олон намын системийн намууд хоорондын эвлэлдэн нэгдэх явдал юм. УИХ-ын төсвийн зарцуулалтад оролцох эрх мэдэл өндөр, уул, уурхайгаас орж их хэмжээний орлого, УИХ-ын гишүүд ямар нэг тойргийг төлөөлдөг сонгуулийн тойргийн систем, дахин сонгогдох зорилгоор тойргийн тодорхой зардлыг зарцуулах хэрэгцээ зэрэг нь хууль тогтоогчдийг хэт их зарцуулалт хийхэд түлхэц болдог нийтлэг бэрхшээл байна. Төсвийн худалдан авах ажиллагааны гажуудлыг мөн үүнтэй адилаар тайлбарлаж болох юм. УИХ-ын гишүүд улс төрийн дэмжлэг авахын тулд тухайлсан барилгын гэрээг дэмжин клиентелизмын дарамт шахалт үзүүлж байна. Хувийн санхүүжилтээр уул уурхайтай холбоотой дэд бүтэц рүү орох нь маш их хэмжээний дарамт, шахалттай тулгардаг байтал эсрэгээрээ УИХ-ын гишүүдийн сонгуулийн мөчлөгийн өрсөлдөх чадвар болон хүч чадал (мөн сонгуулийн сурталчилгааны зардал) нь богино хугацаат хөрөнгө оруулалт, улс төрийн үр ашгийг хөхүүлэн дэмжиж байна (жишээ нь, хөрөнгийг арчлах, засварлах хандлага сул).

Төрийн албаны засаглалын бүтцээс шалтгаалан төрийн албаны удирдлага сул байгаа төдийгүй улс төржсөн байна. Энэ нь улс төрийн томилгоо, гадуурхал, клиентелизм гэсэн гурван шинж чанар байгааг харуулж байна. Төрийн албаны бүтэц зохион байгуулалт 1995 онд батлагдсан бөгөөд 2002, 2008, хамгийн сүүлд 2017 (2019 оноос хэрэгжиж эхэлнэ) онуудад нэмэлт өөрчлөлт орсон байдаг. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдэд эерэг чиг хандлага ажиглагдаж байгаа ч ерөнхий чиг үүргийн яамдын зохион байгуулалтыг байнга өөрчлөх, одоогийн ажиллаж буй албан хаагчдыг албан тушаалаас нь огцруулах, тэднийг улс төрийн хамааралтай томилогдсон хүмүүсээр солих асуудлууд байсаар байна. Энэхүү улс төрийн томилгоо нь зарим тохиолдолд түр зуурынх байдаг хэдий ч төрийн үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон ерөнхий чиг үүргийн яамдын газар,

хэлтсийн дарга нарыг солих асуудал даамжирсаар байна. Төрийн албаны зөвлөлийн мэдээллээр төрийн албан хаагчдын бүрэлдэхүүний хөдөлгөөн 2000-аад оны сүүл үед дунджаар жилийн 5 хувь байсан бол энэ үзүүлэлт илт өсөн нэмэгдэж жилийн 10-12 хувьд хүрчээ. Сүүлд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт төрийн албан дахь улс төрийн томилгоог хязгаарлах зорилготой баталсан байна.

Эдийн засгийн бодлогын үр ашгийн мөчлөг

Эдийн засгийн бодлогын үр ашгийн мөчлөгийн дүн шинжилгээгээр ерөнхийдөө төсөв болон улсын секторын байгууллагад байгаа парламентын нөлөөнөөс үүдэн төсвийн бодлого, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, гүйцэтгэлд ноцтой бэрхшээл учирч байгааг тодотгосон байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашгийг богино хугацаатай болгох, улсын-секторын байгууллагуудын үйл ажиллагааг сүлрүүлэхэд хүргэжээ.

<p>Чиг үүрэг, үйл ажиллагааны бэрхшээлүүд</p>	<p>Төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт болон үйл ажиллагааны үр ашиг муу. Хээл хахуультай холбоотойгоор төслийн нэгжийн зардал маш их. Стандартын бус худалдан авах ажиллагаа болон тендерийн үйл явц. Бага хэмжээний, хэд хэдэн, хэсэгчилсэн төсвийн хөрөнгө оруулалтууд. “Барих-Үл хайхрах-Дахин барих” мөчлөг. Төсвөөс гадуурх их хэмжээний зардлууд. Төсвийн зарлага, санхүүжилтийн хариуцлагын стандартын гүйцэтгэл сул. Төсвийн хязгаарлалтууд нь зөөлөн.</p>
<p>Эрх мэдлийн тэгш бус байдал, улс төрийн эвслүүд</p>	<p>Төрийн албаны гол албан тушаал дахь улс төрийн томилгоо. Парламентын нөлөө илт тодорхой. УИХ-ын гишүүд сонгууль өрсөлдөөнтэй үед тойрогтоо зориулан тусгай зардал тавьдаг. Намын бодлогын дутагдлаас үүдэн хөрөнгийн оруулалтын төсвийг олон хэсэгт хуваагдахад хүргэдэг. Том хэмжээний төсвийн гэрээг өөрт ашигтай байдлаар байгуулахын тулд намын бүлгүүд хооронд сүлжээ бий болсон. Сонгуулийн өрсөлдөөн нь богино хугацаатай хөрөнгө оруулалтыг илүүд үзэх, хөрөнгийн засвар, арчилгаа сул байхад нөлөөлж байна.</p>
<p>Шинэчлэлийн хүчин зүйлүүд</p>	<p>Элитүүд мега төслүүдэд хамтын хязгаарлалт тавих хандлагатай байна. Хомсдож буй болон бүүрч буй орлого нь улс төрчдийн хувийн ашиг сонирхол, дарамт шахалтыг бий болгохоор байна. Үндсэн хуулийн шинэчлэлүүдэд (Сонгуулийн санал авах тухай хууль 2017) төрийн хариуцлагын тогтолцоог санал болгосон. Авилга, төрд итгэх итгэл, төрийн хариуцлагатай байдалд иргэний нийгмийн оролцоо нэмэгдэж байна. Донор орнуудын олон улсын дарамт шахалтууд.</p>

Эх үүсвэр: Эшлэл (Watts 2017)

III ХҮН АМЫН САЙН САЙХАН БАЙДЛЫГ ХАНГАХ

78. Саяханы эдийн засгийн хямралыг үл харгалзан Монгол Улс ядуурлыг ихээхэн бууруулж чадсан боловч ядуурлыг устгах, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх чиглэлээр нилээд зүйлийг хийх шаардлагатай хэвээр байна. Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлснээр орлого өссөн, иймд ажлын байрыг тогтвортой бий болгох, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах тогтвортой эдийн засгийн өсөлтийг үргэжлүүлэн хангах нь цаашид ядуурлыг бууруулахад чухал юм. Түүнчлэн нийгмийн хамгааллын тогтолцоо нь эмзэг бүлгийнхний даван туулах, дасан зохицох чадварыг хангахын тулд дараах гурван гол хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд: (i) Нийгмийн тусламжийн хөтөлбөрийн хамрагдалтыг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах, (ii) Нийгмийн тусламжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд өөрчлөлт хийх, ингэснээр эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтөд энэ нь хамгаалалтыг бий болгох, шилжүүлгийг хүн амын ерөнхий шинж чанарт бус, хүн амын бүлгүүдийн хөрөнгө мөнгөний чадал чинээ, хэрэгцээнд тулгуурлан олгох боломжтой болох ба, (iii) төсөв, санхүүгийн хувьд нийгмийн хамгааллын тогтолцоог тогтвортой болгох.

79. Монгол Улс нь эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээний хүртээмжийг хангах чиглэлээр бодитой ололтонд хүрсэн ч цаашинд энэ ололтоо үйлчилгээний чанарыг сайжруулах замаар баталгаажуулах шаардлагатай байна. Түүнчлэн ихээхэн орхигдсоор байгаа нийтийн аж ахуйн суурь үйлчилгээ ба орон байрны хүртээмжийн асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Эрүүл мэнд, боловсрол ба орон сууцны чанартай дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Халдварт бус өвчний тархалт нэмэгдэж байгаад анхаарлаа хандуулж боловсролын чанар/хамруулалтыг сайжруулах, ариун цэврийн байгууламжийн дэд бүтэц, төвлөрсөн дулаан хагамжийн систем болон хотын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зэрэгт нэн тэргүүнд илүү хөрөнгө капитал хуваарилах буюу эдгээр хөрөнгө оруулалтанд төвлөрч ажиллах, удирдах сайн институци байгууллагууд шаардлагатай байна.

80. Цаашид нийгмийн хамгааллыг сайжруулж чанартай эрүүл мэнд, боловсрол ба орон сууцны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд улс төрийн дэмжлэг авсны хариуд нийгмийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах үзэгдлийн тэнцвэрт байдлаас (cliientelistic equilibrium) гадна санхүүгийн болон институцийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. (i) Төсөв санхүүжилтийн хувьд тогтвортой тэтгэвэр ба нийгмийн хамгаалал, (ii) халдварт бус өвчний дэгдэлт ба орчин үеийн үр чадварын бүтцээс шалтгаалан эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний өртөг өндөр, ба (iii) газар, нийтийн ах ахуйн үйлчилгээ, санхүүжилтийн илүү сайн бодлого шаарддаг орон сууцжуулалтыг сайжруулах зэрэг сорилтууд нь байгууллагын бүтцийн өөрчлөлт ба хариуцлагатай санхүүжилтын аль алиныг шаардаж байна. Үйлчилгээг өргөжүүлэхийн тулд зохих байгууллага, төсөв санхүүгийн дэмжлэггүйгээр зөвхөн улс төрийн маневр хийх нь хүн амын сайн сайхан байдлыг хангахад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд хямрал давтагдсанаар өнөөгийн хүрсэн ололтуудыг нураахад хүргэх эрсдэлтэй.

81. Урт хугацааны сайн сайхан байдлыг хангах чиглэлээр Монгол Улс мэдэгдэхүйц ахиц дэвшилд хүрсэн. Хүний Хөгжлийн Индекс (эрүүл мэнд, боловсрол, нэг хүнд ногдох орлого зэрэг хэмжигдэхүүнийг нэгтгэсэн цогц үзүүлэлт) 1990 ба 2015 оны хооронд 27 хувиар өссөн (харьцуулсан улс орнууд дотроо хамгийн өндөр өсөлттэй байсан орнуудын нэг) бөгөөд эдүгээ хүний хөгжлийн түвшин өндөр ангилалд багтаж байна. Хүн амын наслалт 9 гаруй жилээр (мөн хугацаанд 60.3-аас 69.8) уртассан, сургуульд суралцах дундаж хугацаа 1.4 жилээр (7.7-оос 9.1), нэг хүнд ногдох үндэсний орлого (2011 оны Худалдан авах чадварын паритетаар) жилд 3.3 хувиар тус тус өсч, хуримтлагдсан өсөлт 124 хувьд хүрчээ. (харьцуулсан улс орнууд дунд хамгийн хурдан өсөлттэй орнуудын нэг). Сайн сайхан байдлын бүсэд үзүүлэлтүүд ч сайжирсан байна. Нярайн эндэгдэл 1990-2012 оны хооронд 76.9-өөс 19 болж буурсан ба сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 37-оос 86 хувьд хүрч өсчээ. Эхийн эндэгдлийн түвшин 1995-2015 оны хооронд 186-аас 44, өсвөр насны охидын жирэмслэлтийн түвшин 33.9-өөс 15.7 болж тус тус буурсан бол Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 7.9-өөс 14.5 хувь болж өсчээ. Дээд сургуульд элсэгчдийн хувь 1990-2014 оны хооронд дээд сургуульд суралцах насны хүн амын 18 хувиас 64 хувьд хүрсэн байна. Гар утас хэрэглэгч хүн амын эзлэх хувь 2000-2015 оны хооронд 6.4 хувиас 105.0 хувь болж өсчээ.²⁵

82. Монгол Улсад орлогын ядуурал 2010-2016 онд хооронд огцом буурсан ч ядуурлын хамралтын хүрээ зарим талаар өссөн. Ядуурлын албан ёсны тооцооллоор Монгол Улсын ядуурлын түвшин 2010 оны 38.7 хувиас 2014 онд 21.6 хувь болж буурсан ба 2016 онд 29.6 хувь болж эргэн өссөн.²⁶ Ядуурлын бууралтын хандлага энэ арван жилийн эхний хагаст ажиглагдсан ба 90-ээд оны сүүлчээс мөн ажиглагдаж байсан боловч аргагүйн асуудлуудаас шалтгаалан шууд харьцуулалт хийх боломжгүй. Дэлхийн банкны тооцооллоор ядуурлын түвшин 1998 оноос 2002 оны хооронд 43.1 хувиас 36.1 хувь болж буурсан. Өөр аргачлалаар хийсэн судалгаагаар ядуурлын түвшин 2002 оноос 2008 оны хооронд 65.1 хувиас 35.2 хувь болж буурсан гэсэн байна.²⁷

83. Сүүлийн жилүүдэд ядуурлын түвшинд гарсан огцом өөрчлөлтүүд нь ядууралд өртөх эмзэг байдал өндөр байгааг харуулж байна. 2016 оны байдлаар нийт хүн амын 12.6 хувь нь ядуурлын шугамаас зөвхөн 20 хувиар дээш давсан хэрэглээтэй байжээ. Хүн амын

²⁵ Тоо баримтыг НҮБХХ-ийн Хүний Хөгжлийн Тайлангаас авч ашиглав. (<http://hdr.undp.org/en/data#>, 2018 оны 4-р сарын 15-нд хандсан).

²⁶ Хамгийн сүүлийн ядуурлын албан ёсны тайлан (Монгол Улс, Үндэсний Статистикийн Хороо, 2017 он). Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос ядуурлын түвшинг албан ёсоор хоёр жилд нэг удаа гаргадаг. Суурь хэрэглээний өртгийн аргыг ашигладаг ба 2016 онд ядуурлын албан ёсны шугам нэг хүний сарын хэрэглээний хэмжээ 146,145 төгрөг (ойролцоогоор нэг өдөрт 2.28 ам.доллар албан ёсны валютын ханшаар тооцсон). Харин 2011 оны худалдан авах чадварын паритетын ханшаар тооцсон олон улсын ядуурлын шугамаар (1,90 ам.доллар) тооцвол 2014 онд ядуурлын шугамаас доошоо амьдарч буй иргэд 0.2 хувь байгаа нь ядуурлын албан ёсны үзүүлэлтээс доогуур, ижил түвшний улс орнуудын ядуурлын түвшнээс нилээн доогуур байна. Монгол Улсын Худалдан авах чадварын паритет үзүүлэлтийн чанар эргэлзээтэй байсан учраас Дэлхийн Банкны ажилтнууд энэ тоо баримтыг ашиглаагүй юм. Худалдан авах чадварын паритет үзүүлэлтийн чанарт эргэлзэх болсон гол шалтгаан нь үнийн далд хэлбэлзэл, түүнчлэн бараа, үйлчилгээний ангилал нь Монгол улсын Хэрэглээний Үнийн Индексстэй тохирдоггүй явдал ажээ: Үнийн хэлбэлзэл эсрэг чигт хэлбэлзэж байхад тухайн бүтээгдэхүүний төрөл, хэмжээ ялгаатай байдаг. Энэ талаар цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай (Хавсралт 3: Монгол улсад дутагдалтай байгаа судалгаа, өгөгдөл мэдээлэл -ийг үзнэ үү).

²⁷ Судалгааны асуулга, халамжийн нэгтгэл, ядуурлын шугам зэрэг нь аргачлалын хувьд өөр учраас өмнөх тоон мэдээллүүдийг харьцуулах боломжгүй юм. (Дэлхийн банк 2006), (Дэлхийн банк 2008) тайлангуудыг үзнэ үү.

12.5 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна. Энэ нь эдийн засгийн өсөлт болон өрхийн хэрэглээнээс үүссэн багахан өөрчлөлтүүд ядуурлын түвшинд огцом нөлөөлдөг болохыг харуулж байна. Ядуурлын зөрүү 7.7 байгаа нь нэг хүний хэрэглээний дундаж хомсдол ядуурлын шугамын 7.7 хувьтай тэнцүү илтгэнэ. Зөвхөн ядуучуудын хувьд авч үзвэл хэрэглээний хомсдол уг шугамын 26 хувьтай тэнцүү байна.²⁸

84. Хөдөө, орон нутгийн ядуурлын түвшин хотынхоос өндөр боловч зөрүү нь жил ирэх тусам багасч байна. 2010 онд хөдөө ба хотын ядуурлын түвшин тус бүр 49 ба 33.1 хувь байсан бол 2016 онд 34.9 болон 27.1 хувь болж буурсан нь дээрх хугацаанд хөдөө-хотын ядуурлын зөрүү ойролцоогоор 16 нэгж хувиас бараг 8 нэгж хувь болж буурсныг илтгэнэ. Ядуурлын зөрүүг бүс нутгийн байрлал болон хотын хүн амын өсөлттэй хамтад нь авч үзвэл ядуурал хөдөөд зонхилдог байснаа одоо ихэвчлэн хотын асуудал болж байна. 2016 оны байдлаар Монгол улсын ядуу иргэдийн гуравны хоёр нь ойролцоогоор хотын бүсэд амьдардгаас 40 шахам хувь нь Улаанбаатар хотод байна. (13 дугаар хүснэгтийн зүүн дээд хэсгээс харна уу.)

85. Ядуурлын түвшин аймаг болон бүс нутгуудад ядуурал өргөн тархсаныг харуулж байна. Ядуурлын хамрах хүрээ Өмнөговь аймагт хамгийн бага буюу 15.4 хувь, Говьсүмбэр аймагт хамгийн их буюу 52.4 хувь байна. Гэсэн хэдий ч, бүс нутгийн хүн амын ялгаатай байдлаас хамаарч, ядуу иргэдийн олонх нь Улаанбаатар хотод (нийт ядуу иргэдийн 38,7 хувь) төвлөрч, үлдсэн хувь нь аймгуудад 1-ээс 5 хувийн хэлбэлзэлтэй хамаарч байна. Бүс нутгаар авч үзвэл ядуурлын тархалт Баруун бүсэд 15.6 хувь, Хангайн бүсэд 21.2 хувь, Төвийн бүсэд (Улаанбаатар хот орохгүйгээр) 14.5 хувь ба Зүүн бүсэд 10.1 хувьтай байна.

86. Өрх гэр, хувь хүний онцлог, шинж чанарууд ядууралд орох магадлалд ихээхэн нөлөөг үзүүлдэг. Өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас доогуур боловсролтой, ажилгүй, эсвэл хөдөө аж ахуйн салбарт ажилладаг, ялангуяа малчин бол ядуурлын түвшин хамгийн өндөр харагдаж байна. Ядуурлын түвшин өрхийн тэргүүний жендерийн ялгаанаас хамааралгүй. Харин гэрт амьдарч буй өрхүүд хамгийн их ядууралтай ба (44.5 хувь) нийт ядуу иргэдийн 60 хувийг эзэлж байна (Хүснэгт 5-аас харна уу).

87. Эдийн засгийн өсөлт, уналтын мөчлөгийн аль алинд орлогын тэгш бус байдал хэвээр хадгалагддаг. Хамтын хөгжил буюу халамжийн өсөлт (нэг хүнд ногдох хэрэглээний зарцуулалтаар тооцсон) нийт хүн ам ба хамгийн бага орлоготой 40 хувьд адилхан байсаар байна. 2010 оноос 2016 оны хооронд хүн амын хамгийн ядуу 40 хувийнх нь өрхийн бодит хэрэглээний зарцуулалт жилд 2 хувиар өссөн нь тэдгээрээс дээгүүр орлоготой 60 хувьд гарсан 1.4 хувийн өсөлтөөс өндөр байна. Энэхүү дүр зураг 2012- 2014 онд доод түвшинд байгаа 40 хувийн хэрэглээний тааламжтай өсөлтөөс үүдэлтэй байсан бол бусад хоёр үечлэлд дээрх 40 хувийн хэрэглээний өсөлт бага зэрэг буурсан. Энэхүү хамтын хөгжлийн зэрэгцээ орлогын тэгш бус байдал тогтвортой байсаар байсан. Тэгш бус байдлын коэффициент 2010 оны 0.331-ээс 2016 онд 0.323 руу шилжсэн (Зураг 13-ийн баруун дээд

²⁸ Ядуурлын зөрүү нь хэрэглээний дундаж хомсдлыг тооцдог (тухайлбал, нэг өрхийн хэрэглээний зарцуулалт болон ядуурлын шугамын зөрүү) ба ядуу бус ангилалд хомсдол, алдагдлыг тэг гэж таамагладаг. Зөвхөн ядуу хүн амыг тооцсон тохиолдолд дундаж зөрүү мэдээж илүү өндөр байдаг. Тоон мэдээлэл (Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны 2017 оны тайлан), Хуудас 10 ба 11.

хэсгийг харна уу).²⁹ Монголын ядуурал, орлогын хуваарилалтын тэгш бус байдал нь сонгосон ижил түвшний улс орнууд болон дэлхийн нийт улсуудтай харьцуулахад 2010-2012 оны хооронд дээрээсээ эхний хагаст, 2012-2016 оны хооронд дээрээсээ дөрөвний нэгт багтсан байна.

88. Судалгаа хийгдсэн хугацаанд цалин хөлс өндөр байх нь ядуурлыг бууруулах гол хүчин зүйл болох нь харагдсан. Өрхийн орлогын өөрчлөлтийг 2010 оноос 2016 оны хооронд эх үүсвэрээр нь шинжилж үзэхэд өрхийн орлогын өсөлтийн хамгийн өндөр хэсгийг цалин (нийт 3.9 хувийн өсөлтөөс 3.3 пункт), дараа нь нийгмийн халамжийн орлого (1.2 пункт), орлогын бусад эх үүсвэр (судалгааны хугацаанд 0.06 пунктаар буурсан гэж тэмдэглэгдсэн) тус тус эзэлж байна.³⁰ Өрхийн орлогын өсөлтийн эх үүсвэрийг хоёр жил тутамд үзэхэд 2010 болон 2014 онд цалин хөлсний өсөлт эерэг байсан бөгөөд, хөдөө, аж ахуйн орлого зөвхөн 2012-2014 онд өсчээ. Тэтгэвэр болон халамжийн шилжүүлэг 2010 -2012 оны хооронд өрхийн орлогыг ихээхэн нэмэгдүүлсэн бол 2012-2014 онд төдийлөн нөлөөлөөгүй байв. Гэвч хамгийн чухал нь 2014-2016 оны хооронд өрхийн бүхий л эх үүсвэрийн орлого буурахад тэтгэвэр болон халамжийн шилжүүлэг орлогын тухайн бууралтыг нөхөж чадаагүй нь эдгээр нийгмийн бодлогын шилжүүлэг Монгол улсын айл өрхүүдийг эдийн засгийн цочролоос хамгаалахад үзүүлэх нөлөө хязгаарлагдмал байгааг харуулсан төдийгүй энэ хоёр жилийн хугацаанд ядуурал нэмэгдэхэд зарим талаараа нөлөөлжээ (Зураг 13-ын зүүн доод хэсгээс харна уу). Зарим талаараа нөлөөлсөн гэж дурдсаны учир нь эдгээр нийгмийн хамгааллын халамж, орлогогүйгээр ядуурлын түвшин бараг 15 пунктаар өсч болох байжээ.³¹ Өрхийн орлогын эдгээр тоон үзүүлэлт нь нийгмийн халамжийн орлого нь эдийн засгийн цочролын улмаас үүссэн алдагдлыг нөхөн төлөх механизм байдлаар хэлбэлздэггүй учраас түр зуурын буюу шилжилтийн ядууралд үзүүлэх нөлөө хязгаарлагдмал (тухайлбал хямралын улмаас амьдралын сайн сайхан байдал буурах гэх мэт) боловч удаан хугацааны гүн ядууралтай хамааралтай болохыг харуулж байна.

89. Өрхийн орлогын эх үүсвэрт бүс нутгийн ялгаа бий. Нийслэл хот, аймаг, сумдын төвд цалин хөлс нь өрхийн орлогын өсөлтийн голлох хувийг бүрдүүлдэг бол хөдөө, аж ахуйн орлого нь хөдөө орон нутагт амьдарч буй айл өрхийн орлогын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна (Зураг 13-ын зүүн доод хэсгийг харна уу). Иймд ядуурлыг бууруулах арга зам нь тухайн бүс нутгаас хамааралтай болохыг харуулж байна. Хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах гол арга нь хөдөө аж ахуйн орлогын өсөлтийг дэмжих, харин хот суурин газарт цалинтай ажлын байр бий болгох явдал юм. Нөгөө талаас тэтгэвэр болон халамжийн орлого нь бүх бүс нутагт өрхийн бодит орлогод ижил нөлөө үзүүлж байна. (2010-2016 оны хооронд жилд ойролцоогоор 1 пункт). Энэ нь Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь

²⁹ Өрхийн хэрэглээ нь Монгол Улсын тэгш бус байдал, ядуурлыг тооцоход ашигладаг хөрөнгийн нэгдсэн дүн юм. Орлогын тэгш бус байдлын тооцоолол өндөр ба хэлбэлзэл ихтэй ба Дэлхийн банкны тооцоогоор 2014 оны Жини коэффициент 0.45. Энэ талаар цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай (Хавсралт 3: Монгол улсад дутагдалтай байгаа судалгаа, өгөгдөл мэдээлэл -ийг үзнэ үү).

³⁰ Хөдөө аж ахуйн орлого нь (i) мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон орлого, тариалангийн бүтээгдэхүүнээс олсон орлого, өөрийн хувийн аж ахуй, аж ахуйн нэгжээс авсан хүнсний бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Орлогын бусад эх үүсвэрүүд: (i) Хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого, (ii) бусад орлого ба (iii) бусдаас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан.

³¹ Монгол Улсын ҮСХ-ны тооцоолоор 2016 онд 26.9 хувь байсан ядуурлын хэмжээ нийгмийн хамгааллын шилжүүлэг, халамжийн орлогогүйгээр 47.1 хувь болж өсөх байсныг харуулжээ. 2014 онд мөн үүнтэй ижил нөлөөлөл үзүүлэх тооцоолол гарсан байна. (21.6 хувь 36.7 хувь болж өсөх магадлал).

үндсэндээ дундаж үзүүлэлтэнд бус ангилалд тулгуурласан байдгийн үр дагавар бөгөөд хүн амын илүү ядуу сегментэд чиглэгдээгүй болохыг илтгэж байна.

90. Эдийн засгийн тэлэлтийн жилүүдэд хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэн, ажлын байр бий болгох хэв маягт гарсан чухал өөрчлөлттэй холбоотой орлого өсчээ. Нэг хүнд ногдох нэмүү өртөг урт хугацааны туршид огцом өссөн: 2010-2016 онд жилийн бодит өсөлт 7.0 хувь, 2000-2010 онд 4,1 хувь байжээ. Энэхүү өсөлт нь уул уурхайн салбараас үүдэлтэй боловч эдийн засгийн бусад салбарын бүтээмжийн орлого ч мөн нэмэгдсэн байна (2010-2016 оны хооронд уул уурхайн салбарын жилийн дундаж бүтээмжийн өсөлт 9 хувь, эдийн засгийн бусад салбарын өсөлт 5.4 хувь байв). Ийнхүү өссөн бүтээмжийн орлогыг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч ажилчдын бодит орлогын өсөлт болгосон бөгөөд санхүү, боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлагын салбарт жилийн өсөлт нь 7-аас доошгүй хувь, нийтийн аж ахуйн үйлчилгээ, хөдөө, аж ахуй болон уул уурхайн салбарт 15-аас их хувийн өсөлтийг үзүүлжээ (Зураг 14-ийн зүүн тал). Өнгөрсөн арван таван жилийн хугацаанд ажлын байр бий болгох үйл явц хүчтэй өрнөж, хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцооны түвшин 60 хувиас дээгүүр үзүүлэлттэй байна. 2000-2016 онд хөдөө аж ахуйн салбараас үйлчилгээний салбар луу чиглэсэн бүтцийн шилжилт эрчимжиж 49 хувиас 30 хувь болсон ба нийт хөдөлмөр эрхлэлтийн 35 хувиас 51 хувь болон өөрчлөгджээ (Зураг 14, баруун тал). Энэ нь ялангуяа хөдөө аж ахуй болон барилгын салбарт бодит орлогын ерөнхий өсөлтийг бий болгож, бага орлоготой салбараас (жишээ нь, хөдөө аж ахуйн салбар) бусад салбар луу шилжих ажилчдын хөдөлгөөн нэмэгдсэн нь 2010- 2016 оны хооронд ядуурал эрчимтэй буурсны гол шалтгаан юм.³²

91. Гэвч, Монгол Улсад ажлын байр хангалтгүй, хөдөлмөрийн зах зээлийн үр дүн сул ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл ба/эсвэл эдийн засгийн идэвхигүй байдлын түвшин өндөр байгаа зэрэг хүндрэлтэй асуудлууд хэвээр байна. Тухайлбал, 2014 оноос хойш эдийн засгийн хүндрэлийн улмаас ажиллах хүчний оролцооны түвшин буурч, ажилгүйдлийн түвшин огцом нэмэгдсэн байна. Насанд хүрсэн ажиллах хүчний оролцооны түвшин 2014 оны 3 дугаар улиралд 63.7 хувь байснаа 2017 оны 3 дугаар улиралд 61.1 хувь болж буурчээ. Ажилгүйдлийн түвшин 2014 оны 3 дугаар улиралд 6.4 хувь байснаа 2016 оны эхний улиралд 11.6 хувь болж өссөн бол 2017 оны 3 дугаар улиралд мөн 9.1 хувьтай байв. Бүтцийн талаасаа эдийн засгийн өсөлт тэлэлтийн үе болох 2010 ба 2014 оны хооронд ч ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байсан ба 7 хувиас доош бараг буураагүй юм. Түүнчлэн албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт болон бусад харьцангуй бүтээмж багатай хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд өргөн тархсан хэвээр байна.

92. Улирлын чанартай хөдөлмөр эрхлэгчид, хөдөөгөөс хотруу шилжин ирэгсэд, ялангуяа залуучууд гэх мэт тодорхой бүлгүүдийн ажилгүйдэл, албан бус хөдөлмөр эрхлэлт ба/эсвэл эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин өссөн байна. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн дийлэнх хувийг үйл ажиллагаа нь улирлын чанартай байдаг малчид болон барилгын ажилчид бүрдүүлдэг бөгөөд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн

³² Уул уурхайн салбараас бусад салбарт 2014 оноос хойш бодит цалин буурсан нь, 2014 ба 2016 онд ядуурлын албан ёсны түвшин эргэж өссөнтэй давхцан тохиосныг анхаарах нь зүйтэй.

даатгалын хамрагдалт хязгаарлагдмал байдаг.³³ Монгол, Индонез болон Филиппин Улс нь Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутагт залуучуудын ажилгүйдлийн түвшингээр хамгийн өндөр гурван орон юм. Залуучуудын харьцангуй өндөр хувь нь хөдөлмөр эрхлээгүй, ажил сургуульгүй байна. 2013 онд 15-29 насны залуучуудын 21.1 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, ажил сургуульгүй байжээ. Залуучуудын урт хугацааны ажилгүйдлийн түвшин мөн өссөн бөгөөд сургууль төгссөний дараа бүтээмжтэй, найдвартай ажлын байранд шилжих тодорхой чиглэл байхгүй байна.

93. Хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн нөхцөл байдал холимог үзүүлэлттэй байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд эмэгтэй ажиллах хүчний оролцоо 2007 онд бараг 60 хувь байснаа 2016 онд 55 хувь болж аажмаар буурчээ. Хүйсийн ялгаа энэ хугацаанд 10-аас 12 пункт хүрч өссөн байна. Ажилгүйдлийн түвшин дэх хүйсийн ялгаа эмэгтэйчүүдийн хувьд эерэг буюу 2013 оноос хойш эрэгтэйчүүдээс бага байв (Зураг 15). Монгол Улсын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны үзүүлэлтийг зарим жишиг улсуудтай харьцуулахад (Казакстан, Перу, Замбиа зэрэг улсуудад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин 65 хувиас дээш) доогуур эрэмбэлэгдэж байгаа боловч дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад өндөр (Монгол Улс нь эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшингээрээ дэлхийд эхний 25 хувьд багтах орнуудын нэг) байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин болон ажилгүйдлийн түвшингээрээ дэлхийн болон жишиг орнуудтай харьцуулахад Монгол улс жагсаалтын сүүлийн хагаст жагсаж байна (Зураг А15-аас харна уу). Түүнчлэн эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн зөрүү 12 хувь байгаа нь харьцуулсан улс орнуудын дунд өндөр үзүүлэлт биш байлаа (Азербайжан 46.1%, Киргиз 24.5%, Перу 22.8%, Казакстан 20.6%, Колумба 10.1%).³⁴ Үүнээс гадна тус чанарын судалгаанд эмэгтэйчүүд найдвартай ажлын байр, ажлын аюулгүй байдал дутмаг, цалин хөлсийг олгох аюулгүй тогтолцооцоо байхгүй, нийгмийн даатгалд хамрагддаггүй зэрэг эрсдэлтэй, найдваргүй ажлын байранд ажиллахадаа урхинд орсон мэт санагддаг тухай тайлагнажээ.³⁵

94. Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтэнд ЖДҮ эрхлэгчдэд нийтлэг тулгардаг бэрхшээл сөргөөр нөлөөлдөг - барьцаа хөрөнгө байхгүй, хүйсийн онцлог хүчин зүйл гэх мэт асуудал бий. Өндөр настан болон үр хүүхдээ асрах гэх мэт ар гэрийн үйл ажиллагаа, үүрэг хариуцлагад илүү их цаг зарцуулахыг эмэгтэйчүүдээс шаардсан хэвээр байна. Энэ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин бага байгааг тайлбарлах гол хүчин зүйл юм (Зураг 16-ийн дээд хэсэг). Түүнчлэн эмэгтэй ажиллах хүчний оролцоонд нийгмийн халамжийн хөтөлбөрүүд сөргөөр нөлөөлж байгаа зарим баримт нотолгоо

³³ Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх тооцоолол судалгаа цөөн байдаг. 2015 онд хийгдсэн судалгаанд (Gasmann, Francois and Fardo Trinidad 2015), Shatz et al. (2015) нарын судалгаанд дурдсан мал аж ахуйн салбарыг оролцуулан тооцвол албан бус хөдөлмөр эрхлэлт 57.4 хувь гэсэн үзүүлэлтийг иш татсан байдаг. Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн шинж чанар, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаар нэмэлт судалгаа хийгдэх шаардлагатай. Энэ талаар цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай (Хавсралт 3: Монгол улсад дутагдалтай байгаа судалгаа, өгөгдөл мэдээлэл -ийг үзнэ үү).

³⁴ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан "Хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлтүүд" тайлангийн 9 дэх хэвлэл, (2018 оны 5 сарын 17 нд ILOSTAT-аас татаж авав).

³⁵ (Schmillen and Sandig 2017)

байна.³⁶ Ерөнхийдөө эмэгтэй удирдлагатай ЖДҮ эрхлэгчдийн хувьд зээл авах өргөдөл хүсэлтээ шийдүүлэхэд бусад ЖДҮ эрхлэгчидтэй харьцуулахад төдий л ноцтой асуудал тулгардаггүй ч тэд санхүүгийн байгууллагыг илүү хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхийг шаардсаар байна.³⁷ (Зураг 16-ийн доод хэсэг).

95. Монгол улсын ядуурлыг бууруулах өөр нэгэн хүчин зүйл бол үйлчилгээг сайн зохион байгуулж хэрэглэгчдэд хүргэх бүтэц бүхий нийгмийн хамгааллын тогтолцоо юм. Бенчмарк буюу харьцуулсан судалгаа хийж үзэхэд нийт хүн амд эзлэх нийгмийн хамгааллын хамрагдалтын хувь хэмжээгээр Монгол Улс нь дэлхийн болон сонгосон жишиг орнуудтай харьцуулахад эхний 25 хувьд жагсаж байна (Зураг А1 5). Хүнсний Талон Хөтөлбөрөөс (ХТХ) бусад бүх хөтөлбөрүүд уламжлалын дагуу хүн амын хамгийн эмзэг гэж тооцогдох өөр өөр ангиллын бүлгүүдэд (жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, өрх толгойлсон эмэгтэй гэх мэт) чиглэсэн байна. Ихэнх хөтөлбөрүүд нь ангилалд тулгуурласан байдаг бөгөөд дундаж үзүүлэлтэнд суурилдаггүй эсвэл эдийн засгийн цочролтой уялдаагүй байдаг нь нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн хамрах хүрээ, хэмжээг тэлснээр 2010-2014 онд эдгээр хөтөлбөрүүд ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлсэн ч 2014-2016 онд эдийн засгийн хүндрэлийн улмаас үүссэн ядуурлын нөлөөллөөс урьдчилан сэргийлж чадаагүйн шалтгааны тайлбар мөн.

96. 2008/2009 оны эдийн засгийн хямралын дараа нийгмийн халамжийн хөтөлбөрийг нэн ялангуяа ядуу иргэд рүү чиглүүлэх зорилтот хэрэгцээ байгааг илүү сайн ойлгосон. Энэ үеэс эхлэн төр, засгийн газар нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг зорилтот бүлэгт илүү чиглүүлэх дэд бүтцийг бий болгох зарим алхмуудыг хэрэгжүүлсэн юм. Халамжийн тэтгэмжийн бүртгэл, төлбөр, нягтлан бодох бүртгэл, тайлагнал гэх мэт цогц модуль бүхий Нийгмийн Халамж, Үйлчилгээний Нэгдсэн Мэдээллийн онлайн Системийг шинээр боловсруулсан байна. Ядуурлыг тогтооход чиглэсэн аргачлал болох Орлогыг Орлуулан Тооцох Аргачлалыг (ООТА) нэвтрүүлсэн бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмжийг зорилтот бүлэгт чиглүүлэх зорилгоор ООТА-д суурилсан Өрхийн Мэдээллийн Нэгдсэн Санг шинээр байгуулсан. Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын шийдвэрээр энэхүү өгөгдлийн санг зөвхөн нийгмийн хамгааллын салбар төдийгүй салбар хоорондын өгөгдөл мэдээллийн сан байдлаар ашиглахаар болж ядуу иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн үнэгүй даатгал, хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авах гэх мэт төрийн бусад тусламж, хөнгөлөлт, татаас олгоход ашиглахаар болжээ. Гэвч нийгмийн халамжийн тэтгэмжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд тус өгөгдлийн санг ашиглах зорилт зөвхөн Хүнсний Талон Хөтөлбөрт хэрэгжиж байгаа буюу хэрэглээ хязгаарлагдмал байна. Гэтэл Хүнсний Талон Хөтөлбөр нь асуудлыг шийдэх түр зуурын шинжтэй хөтөлбөр бөгөөд хамрах хүрээ болон тусламж тэтгэмжийн хувьд маш жижиг хөтөлбөр юм.

³⁶ (Gasmann, Francois and Fardo Trinidad 2015) нарын судалгаанд ажиллах хүчний оролцооны түвшинд эконометрикийн дүн шинжилгээ хийж “нийгмийн халамж хүртдэг гишүүнтэй өрхийн иргэдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцооны түвшин харьцангуй идэвхгүй байгааг тогтоожээ”. Түүнчлэн эдгээр халамжийн хөтөлбөрүүд нь эрэгтэйчүүдэд нөлөө үзүүлдэггүй (эсвэл эерэгээр нөлөөлдөг) бол эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоонд сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэжээ”. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж болон цалинтай эзж хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж, хүүхдийн мөнгө хөтөлбөрийн үзүүлэх нөлөөлөлд хийсэн эконометрикийн дүн шинжилгээ нь 2012 оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд томъёолсон дүгнэлтийг баталсан байна.

³⁷ Монгол Улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцоог нэмэгдүүлж хүүхэд асрах төвүүдийн хүртээмж, боломжийг сайжруулах шаардлагатай байгааг саяхан хийгдсэн судалгаа цохон тэмдэглэсэн байна. (Олон Улсын Санхүүгийн Корпораци 2015) ба (Gasmann, Francois and Fardo Trinidad 2015).

97. Бэлэн мөнгө тараах хөтөлбөр нь амьжиргааны түвшингээр доод 40 хувьд хамаарах сегментэд бага зэрэг чиглэсэн боловч ядуу иргэдэд чиглээгүй байна. Дэлхийн банкны 2015 оны судалгаанаас зарим хөтөлбөрүүд нь бусдаасаа илүү прогрессив байгааг харж болно. Амьжиргааны түвшингээр доод 40 хувьд хамаарах бүлэг нийгмийн хамгааллын тэтгэвэр тэтгэмжийн нийт төсвийн 56 хувийг хүртсэн бол дээд 40 хувь нь нийт нийгмийн хамгааллын 28 хувийг хүртжээ. Амьжиргааны түвшингээр сүүлийн 25 хувьд багтсан өрхүүд ихэвчлэн нийгмийн халамжийн тэтгэмж авсан байгаа бол Хүүхдийн Мөнгө Хөтөлбөр (ХМХ) болон бусад ангиллын хөтөлбөрүүд нийтлэг шинж чанартай учраас нийт айл өрхүүдэд жигд хуваарилагджээ.³⁸ Татвар ба халамжийн орлогын тогтолцооны прогрессив шинж чанарын талаарх Дэлхийн Банкны одоо хийж буй судалгаагаар нийгмийн хамгааллаар хуваарилж буй ихэнх мөнгөн тусламж, тэтгэмж нь тэдгээрийн үр өгөөжийг хүртэгчдийн орлогын хувь хэмжээнээс хамаарсан прогрессив шинж чанартай бол (харьцангуй үзүүлэлтээс хамаарсан прогрессив шинж чанартай), тэтгэвэр болон бусад нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь хүн амын илүү ядуу иргэдэд хуваарилагдах төсвийн хувь хэмжээнээс хамаарсан -нэмэлт-прогрессив шинж чанартай (үнэмлэхүй үзүүлэлтээс хамаарсан прогрессив шинж чанартай) болохыг ажиглажээ. Гэвч Хүүхдийн Мөнгө Хөтөлбөр гэх мэт төсвөөс санхүүждэг томоохон хөтөлбөрүүд, суурь боловсрол, хүн амын эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн мөнгөн бус хэлбэрийн тусламж үйлчилгээ нь үнэмлэхүй үзүүлэлтийн хувьд саармаг байна. (жишээ нь, орлогын бараг бүх бүлэг төсвөөс ижил хуваарилалт хүртдэг).³⁹ Энэ нь Монгол Улсад нийгмийн хамгааллын бодлогын хөтөлбөрийн ихэнх нь ангиллын/хавтгайруулах хандлагад суурилсныг баталж байна. Харин цахилгаан, эрчим хүч, төвлөрсөн халаалтын үнэ, төдийгүй орон сууцны зээлийн хүү зэргийг төрөөс зохицуулах замаар шууд бус тусламж, шилжүүлэг үзүүлэх нь амьжиргааны түвшингээр дээд хэсэгт хамаарах бүлэгт илүү таатай нөлөөлөх боломжтой байна (Зураг 17).

98. Төсөвт үзүүлэх нөлөөллийн улмаас тэтгэвэрт онцгойлон анхаарах шаардлагатай байна. 2017 оны төсвөөс тэтгэврийн тогтолцоонд үзүүлж буй татаас ДНБ-ний 2.2 хувийг эзэлж байгаа бөгөөд шинэчлэл хийхгүй бол энэ татаас цаашид 2030 онд 6 хувь, 2050 онд 11 хувь болох тооцоолол бий. Эдгээр тооцоолол нь 2017 болон 2018 оны эхээр батлагдсан хуулийн өөрчлөлтийн улмаас бодитой нэмэгдэж болзошгүй байна. Өртөг зардлын ийм тогтворгүй байдлыг бий болгох шалтгаан нь шимтгэл төлсөн жил тутамд ноогдох тэтгэвэр бодох хувь хэмжээг хангаж хүрэлцэхээргүй шимтгэлийн хувь хэмжээ хэтэрхий бага, хүн амын насжилт, тэтгэврийн насыг харьцангуй багаар тогтоосон (ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд), ажилчдын төлдөг нэрлэсэн зардалтай харьцуулахад тэтгэвэрт гараад авах тэтгэмжийг бодитой нэмэгдүүлэх өөрөөр хэлбэл тэтгэмжийн либералчлал, үйлчилгээг буцаан худалдаж авах зохицуулалт бүхий хуулийг боловсруулсан зэрэг болно. Энэхүү туйлын тогтворгүй байдал нь параметрын томоохон өөрчлөлт хийхийг шаардаж байна.⁴⁰

³⁸ (Onishi and Chuluun 2015)-аас харна уу

³⁹ (Freije ба Yang 2018) -ийг үзнэ үү. Энэхүү судалгаагаар татвар ба халамжийн шилжүүлэг нь орлогын тэгш бус байдлыг (Жини индексээр хэмжсэн) 2016 оны байдлаар 0.418-аас 0.383, орлогын ядуурлын түвшинг 47.3-аас 42.8 хувьд хүргэн бууруулна гэж тооцоолжээ.

⁴⁰ Бүлэг 13-ыг харна уу (Дэлхийн банк 2017), (Дэлхийн банк 2011).

Тэгш байдлын сорилтууд: сайн сайхан байдлыг хангах үндэс нь болсон эрүүл мэнд, боловсрол, орон сууцны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

99. Хүн амын сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд тулгарч буй эмзэг байдал нь Монгол улсын эдийн засгийн гол сорилтуудын нэг юм. Өмнөх хэсэгт хот суурин газарт цалин хөлс, хөдөө, орон нутагт хөдөө аж ахуйн орлого нэмэгдэх байдлаар хөдөлмөрийн хөлс сайжирсан нь Монгол Улсын ядуурлын түвшин буурахад ихээхэн холбоотой байсан талаар дурдсан. II бүлэгт өнгөрсөн жилүүдэд эдийн засгийн өсөлт хэрхэн хөдөлмөрийн эрэлтийг нэмэгдүүлж улмаар хөдөлмөрийн бүтээмжийг өсгөсөн болоод тогтвортой өсөлтөд нөлөөлж буй хязгаарлалтууд бүтээмжийн орлого, хөдөлмөрийн эрэлтэд хэрхэн саад учруулж болохыг тайлбарласан. Энэ хэсэгт хүний капитал, орон сууцны хангамжийн зохисгүй хөрөнгө оруулалттай холбоотой хөдөлмөрийн нийлүүлэлтийн хомсдлын улмаас хүн амын сайн сайхан байдлыг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг судална.

100. Хүн амын сайн сайхан байдлыг сайжруулахын тулд эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Бидний хийсэн Төрөлжсөн хөгжлийн дүн шинжилгээнээс үзэхэд эмзэг байдлыг бууруулахын тулд эдийн засаг талаасаа хүний капиталд бодит хуримтлал бий болгох хэрэгтэй ба ингэснээр хүний хөдөлмөрийн зах зээлийн потенциал нь эрүүл мэндийн сул байдал болон ур чадварын дутагдалд өртөхгүй юм. Түүнчлэн, хүн амд тохиромжтой орон сууц хэрэгтэй ба ингэснээр хүнийн капиталын хуримтлал үүсч, амьдрах нөхцөл нь (үйлчилгээнүүд болон харилцаа холбооны хүртээмжийн хувьд) эдийн засгийн боломжуудыг хэрэгжүүлэх бололцоо олгодог. Дунд зэргийн орлоготой Монгол улсын хувьд хүний капиталын хуримтлал болон орчин үеийн хотжилтын асуудлууд нь нарийн мэдрэмжтэй шийдлийг шаардаж байна. Энд жишээ нь халдварт бус өвчин, дунд сургуулийн дараах боловсролын чанар, хотын нийтийн байгууламжууд зэрэгт учирч буй цогц асуудлуудыг удирдах чадавхитай байгууллагууд хэрэгтэй байна. Монголын эдийн засагт энэ чиглэлээр тулгамдаад байгаа асуудлуудыг дараах хэсгүүдэд авч үзнэ.

Эрүүл мэнд: нэгдмэл бус эрүүл мэндийн систем нь халдварт бус өвчний өсөлттэй нүүр тулаад байна

101. Өнгөрсөн 10 жилд Эх, Нялхсын Эрүүл Мэндийг (ЭНЭМ) дэвшилттэйгээр сайжруулсан ч бүс нутгуудын ялгаатай байдал асуудал болсон хэвээр байна. Монгол улсад эхийн эндэгдлийн түвшин 100,000 амьд төрөлт тутамд 1990 онд 186 байснаас 2015 онд 44 болж буурсан. 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлт тутамд 1990 онд 108.5 байсантай харьцуулахад 2016 онд 17.9 болов.⁴¹ Гэвч эдгээр амжилтаас гадна хэд хэдэн тулгамдсан асуудлууд байгаагаас ба ялангуяа хот, хөдөөгийн ялгаа нэлээд их байна.⁴² Эрүүл мэндийн байгууллагаас гадуур амаржих тохиолдол бараг байхгүй байна⁴³. 2014 оны байдлаар сүүлийн хоёр жилд амаржсан 15-49 насны эмэгтэйчүүдийн 90 хувь нь жирэмсний хугацаанд хамгийн багадаа 4 удаа эмчийн хяналтад орсон бөгөөд энэ үзүүлэлт хөдөө, орон

⁴¹ Дэлхийн хөгжлийн үзүүлэлт, <https://data.worldbank.org>

⁴² ДЭМБ: http://www.wpro.who.int/mongolia/topics/maternal_health/en ; ба НҮБ-ын хүүхдийн сан:

http://www.wpro.who.int/mongolia/topics/maternal_health/en/

⁴³ Үндэсний статистикийн хороо (ҮСХ). 2015. Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа – 2013. Олон талт үзүүлэлтийн нэгдсэн судалгаа. Тайлан. Улаанбаатар хот.

нутагт 84 хувь, хотод 92 хувьтай байна. Мөн, 94 хувь нь амаржсаны дараах долоо хоногийн дотор эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас хөдөөд 80 хувь, хотод 98 хувьтай байна.

102. Монголд бага насны хүүхдийн хөгжлийн хувьд бүс нутаг, нийгэм, эдийн засгийн байдлаас хамаарсан тэгш бус байдал өндөр байна. 2005 оноос 2016 оны хооронд нярай болон 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл 100 хүүхэд тутамд тус бүр 33.4-өөс 15.4, 49-өөс 23.5 болж буурсан. Гэвч энэ түвшин хөдөө, орон нутагт (сумын төв орохгүйгээр) УБ-аас 3-4 дахин өндөр төдийгүй орлого ихтэй өрхөөс илүүтэй ядуу өрхийн хүүхдүүдийн дунд 2-3 дахин их байна. Мөн өсөлт зогсох, хоол тэжээлийн аюултай байдал зэрэг асуудлууд бага насны хүүхдийн хөгжилд нөлөөлсөн хэвээр байна.

103. Хүн амын дундаж наслалт мөн л хөрш орнуудтай харьцуулахад бага буюу 2015 оны байдлаар 69.1 байна. Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд 65.1, эмэгтэйчүүд 73.3 байна. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д хүн амын дундаж наслалтыг 8 жилээр нэмэгдүүлэн 2030 он гэхэд 78-д хүргэхийн тулд үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгохоор тусгасан. Нийт эрүүл мэндийн зардал ДНБ-ний 4.7 хувьтай тэнцэж байгаа нь бүс нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур байна.⁴⁴ Засгийн газраас эрүүл мэндэд зарцуулсан зардал нийт эрүүл мэндийн зарцуулалтын 55.4 хувьтай тэнцүү гэж бүртгэгдсэн нь хөрш орнуудтай ойролцоо түвшинд байна.

104. 2015 онд нийт нас баралтын 78 хувь нь халдварт бус өвчнөөс шалтгаалжээ. Дэлхий дахины өвчний судалгаагаар (2016) 10 нас баралт тутмын 7 нь халдварт бус өвчлөлөөс үүдэлтэйг онцолжээ. Тухайлбал, зүрхний архаг дутмагшил нэгдүгээрт, цус харвалт хоёрдугаарт, элэгний хавдар гуравдугаарт, ходоодны хавдар дөрөвдүгээрт, элэгний цирроз наймдугаарт, уушигны хавдар есдүгээрт, спиртны замбараагүй хэрэглээ аравдугаарт тус тус жагсжээ. Хамгийн ихээр үхэл болон хөгжлийн бэрхшээлд хүргэж буй эхний таван эрсдэлийн хүчин зүйлсэд буруу хооллолт, цусны өндөр даралт, архи, тамхины хэрэглээ, хар тамхи, болон жингийн хэт их илүүдэл хамаарч байна. Өнөөгийн эрүүл мэндийн тогтолцоо болон бодит хэрэгцээний хооронд уялдаа холбоо байхгүйгээс халдварт бус өвчлөлийг бууруулж чадахгүй байна. Энэ нь чанартай анхан шатны тусламж, үйлчилгээг дэмжих урамшууллын тогтолцоо байхгүйтэй холбоотой юм. (дэлгэрэнгүйг эрүүл мэндийн байгууллагын хэсгээс харна уу.)

105. Халдварт өвчнүүд сүүлийн жилүүдэд ерөнхийдөө буурсан байна. Гэвч одоог хүртэл хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаанд эзлэх хувь нь өндөр байгаа бөгөөд ялангуяа гепатит вирусын хувьд халдвар дэгдэх боломж, эрүүл мэндийн түргэн тусламж зэргээс шалтгаалан нийгэм, эдийн засгийн чухал асуудал болоод байна. Монгол Улс гепатитаас үүдэлтэй элэгний хавдрын нас баралтаар дэлхийд тэргүүлдэг.⁴⁵ Олон улс болон харьцуулж буй жишиг орнуудтай харьцуулахад Монгол халдварт бус өвчний улмаас нас баралтаараа

⁴⁴ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэлхийн эрүүл мэндийн зарцуулалтын өгөгдлийн сан (2014). Сүүлийн үеийн тоон мэдээлэл олон нийтэд мэдээлэгдээгүй болно. ДНБ-д эзлэх нийт эрүүл мэндийн зардал харьцуулсан улсуудад буюу Казакстан 4.4%, Хятад 5.5%, Узбекистан 5.8%, Киргикстан 6.5%, Тажикстан 6.9%, ОХУ 7.1%. Засгийн газрын эрүүл мэндийн зардал нийт эрүүл мэндийн зарцуулалтад эзлэх хувь харьцуулсан улсуудад Тажикстан 28.8%, ОХУ 52.2%, Узбекистан 53.3%, Казакстан 54.3%, Хятад 55.8%, Киргикстан 56.1%.

⁴⁵ ДЭМБ Монгол дахь салбар хэвлэл (2016). Халдварт өвчнийг шийдвэрлэх нь Засгийн газар болон нийгмийн үүрэг хариуцлага болох нь, <http://www.wpro.who.int/mongolia/mediacentre/releases/20161025-tackling-infectious-diseases/en>.

хамгийн муу 50 хувьд, харин нярайн эндэгдэл болон насанд хүрэгчдийн халдварт өвчний эндэгдлээр хамгийн сайн үзүүлэлттэй 25 хувьд жагсаж байна. (Зураг А1 5 -ыг харна уу).

106. Гэр бүлийн хүчирхийлэл байгаа талаар зарим нэгэн баримт байна. 2004 онд Улаанбаатар хотын хоёр дүүрэгт явуулсан судалгаагаар судалгаанд оролцогчдын 37.7 хувь нь ямар нэг хэлбэрээр гэр бүлийн хүчирхийлэлд (биеийн, сэтгэл санааны, бэлгийн, санхүүгийн) өртсөн гэсэн дүгнэлт гарчээ.⁴⁶ Энэ нь жендерийн хүчирхийллийн түвшнээр Дэлхийн банкнаас гаргасан Дэлхийн хөгжлийн үзүүлэлтээр эхний хэсгийн сүүл хавиар жагсаж байна.⁴⁷ Судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл нь орлого багатай, хамтран амьдрагч нь ажилгүй эсвэл архи хэрэглэдэг зэрэгтэй холбоотой болох нь тогтоогджээ. Хэрэв ийм хамаарал үргэлжилсээр байгаа бол саяхан тохиолдсон эдийн засгийн хямрал гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэхэд нөлөөлсөн байж болохыг судлах шаардлагатай.⁴⁸

107. Монгол Улс эрүүл мэндийн салбарт томоохон зорилтуудыг дэвшүүлээд байна. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д 2030 он гэхэд үр өгөөжтэй, өндөр чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог бий болгохоор дөрвөн зорилтыг тодорхойлон гаргасан. Үүнд: 1) өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог хөгжүүлж эрүүл мэндийн оношилгоо үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ба хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх; 2) нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар эх, нялхсын эндэгдлээс урьдчилан сэргийлэхэд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлсийг бууруулах, мөн эх, нялхсын эндэгдэл ба шим тэжээлийн дутагдлыг багасгах; 3) хувь хүн, гэр бүл, олон нийт, албан байгууллагуудын идэвхтэй, хүртээмжтэй хамтын ажиллагаанд үндэслэн халдварт бус гол өвчнүүдийг бууруулах, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлүүд ба урьдчилан сэргийлж болохуйц нас баралтыг бууруулах; 4) урьдчилан сэргийлэлт, халдварт өвчний эрт илрүүлэлт, тэдгээрийн эмчилгээний бэлэн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээний шуурхай хариу үйлдэл үзүүлэх чадварыг сайжруулах, хүн бүрийг нэн шаардлагатай вакцинд хамруулах зэргээр халдварт өвчний тархалтыг бууруулах.

108. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах нь Монгол Улсын Засгийн газрын нэн тэргүүнд хэрэгжүүлэх зорилтуудын нэг. “Үндэсний хөгжлийн стратеги”, “Эрүүл мэндийн салбарын үндэсний стратеги мастер төлөвлөгөө 2006-2015”, “Эрүүл мэндийн үндэсний бодлого 2017-2026”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги 2010-2020”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний төлөвлөгөө 2012-2016”, “Эх, нярайн эрүүл мэндийн стратеги 2011-2015”, ба “Хүүхдийг эсэн мэнд өсгөх стратеги 2011-2015” нь бүгд “Мянганы хөгжлийн зорилт”-д тавигдсан зорилтуудад хүрэхэд зорьсон. Эх, хүүхдийн эрүүл мэндийн талаар олсон ололтууд нь төрөхөөс өмнөх эмчийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлж, чадвартай эх баригчидтай болсон, хөдөө, орон нутаг болон алслагдсан сумын эрүүл мэндийн төвүүдэд эхчүүдийг

⁴⁶ (Oyunbileg, et al. 2009).

⁴⁷ Энэ хэмжээ 2 хувиас (Итали, Испани зэрэг улсуудад) 50.7 хувь хүртэл (Бангладеш) хэлбэлздэг. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн тоон мэдээллийн зэрэгцүүлэх улс орнуудын хувьд 12 хувиас (Перу) 37 хувьд (Колумба) дээд болон доод утгаа авч байна.

⁴⁸ Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, цагдаагийн болон бусад судалгааны байгууллагуудаас ирүүлсэн мэдээ, мэдээлэл, үндэсний эсэргүүцэгчид олон нийтэд түгээн дэлгэрүүлж байна. Энэ чиглэлээр нэмэлт судалгаа хийх шаардлагатай (Хавсралт 3-ыг үзнэ үү).

төрөх хүртэлх хугацаанд нь төрөхийн өмнөх байранд байрлуулж, эмчийн хяналтад оруулдаг болсонтой холбоотой байна.⁴⁹

109. Монгол Улсын Засгийн газрын 2000 оноос 2013 оны бодлогын баримт бичгийн үнэлгээнд дурдсанаар Засгийн газар нь халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний олон талт бүтцийг бий болгосноор улс төрийн амлалтаа биелүүлсэн гэж үзсэн ба эрүүл мэндийн үндэсний бодлогод халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилтыг нэгтгэж, үндэсний түвшинд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргасан. Түүнчлэн Монголын халдварт бус өвчлөлд зарцуулдаг төсөв нэг хүнд ногдох орлогоороо илүү дээгүүрт ордог бусад улсуудтай адил хэмжээнд байна. Гэвч халдварт бус өвчлөлийн асуудал шийдэгдэхгүй байгаа нь дараах шалтгаантай: 1) халдварт бус өвчнийг эмчлэх сайн чанартай, үр дүнтэй эрүүл мэндийн үйлчилгээг санал болгох ба урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээ авах эсэх нь тодорхойгүй; 2) Монгол Улсын хэмжээнд халдварт бус өвчинд төрөөс зарцуулж буй хөрөнгө нь нийт өвчлөлийн хэмжээтэй харьцуулахад харьцангуй бага; 3) Төрөөс халдварт бус өвчлөлд зарцуулдаг зардлын ихэнх нь хэвтэн эмчлүүлэгсэд болон эмнэлэг дээрх амбулаторийн үйлчилгээнд зарцуулагдаж байгаа нь хөрөнгийн үр дүнгүй ашиглалтад хүргэдэг.⁵⁰ Монгол Улсын Засгийн газар элэгний гепатитээс урьдчилан сэргийлэхийг чухалчлан “Эрүүл мэндийн салбарын стратегийн мастер төлөвлөгөө 2006-2015”, “Гепатит вирусын хяналтын үндэсний стратеги 2010-2015”, болон “Гепатит вирусээс урьдчилан сэргийлэх, элэгний өвчлөлд өртөгсөд, нас барагсдын тоог бууруулах үндэсний дэд хөтөлбөр 2006-2015” зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан бодлого, стратеги хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ирсэн. Энэ дэд хөтөлбөр нь гепатит вирусээс урьдчилан сэргийлэх, халдварыг эрт оношлох, бусдад халдварлах болон архаг гепатит, цирроз, элэгний хавдар зэрэг элэгний өвчлөлийн улмаас нас баралтыг бууруулахад зорьсон болно.⁵¹

110. Үйлчилгээний чанар нь эрүүл мэндийн салбарын нэг гол чиглэл болохыг “Эрүүл мэндийн салбарын стратегийн мастер төлөвлөгөө 2006-2015”-д заасан. “Эмнэлгийн чанарын удирдлагын системийг сайжруулах хөтөлбөр 2008-2013” нь салбарын бүх түвшинд чанарын удирдлагын системийг нэвтрүүлж, хууль эрхзүйн таатай орчинг бий болгох, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн гарын авлага, гүйцэтгэл, чанарын үзүүлэлтүүдийг боловсруулж хэрэгжүүлэх, чанарыг байнга сайжруулахад оролцогч талуудын хамтын ажиллагааг зохицуулахыг зорьсон. Түүнчлэн эмнэлгийн халдварт нөхцлийг хянах, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангахын тулд эрүүл мэндийн байгууллагын халдварыг хянах системийг сайжруулах стратегийг 2010 онд гаргасан. Өнгөрсөн хэдэн жилд ихэнх эмнэлэг, клиникийн стандартууд шинэчлэгдэж, тусгайлсан өвчнүүдийн талаарх гарын авлага, удирдамжууд хэвлэгдэн гарсан.

111. Эдгээр зорилго, төлөвлөгөө нь салангид санхүүжилт зэрэг саад бэрхшээлүүдээр хязгаарлагдсан байна. Эрүүл мэндийн салбарт орлогын гурван гол эх үүсвэр байдаг: улсын

⁴⁹ ДЭМБ-ын хэвлэл. Гепатитын вирусээс урьдчилан сэргийлэх, хянах улсын хөтөлбөр. http://www.wpro.who.int/mongolia/mediacentre/releases/20160318_viral_hep_prevention_control/en

⁵⁰ О.Дүгээ, Э.Мунаа, А.Сахъяа, А.Махал. Монгол Улсын халдварт бус өвчлөл дэх төсвийн зарцуулалт өндөр орлоготой орнуудын зарцуулалттай адил. Эрүүл мэндийн хамтын ажиллагаа. 2017 оны 5 дугаар сар 1;36(5):918-25.

⁵¹ ДЭМБ-ын хэвлэлийн мэдээ. Вируст гепатитыг урьдчилан сэргийлэх, хянах хөтөлбөрийн хөтөлбөр. http://www.wpro.who.int/mongolia/mediacentre/releases/20160318_viral_hep_prevention_control/en

төсөв, нийгмийн эрүүл мэндийн даатгал, үйлчлүүлэгчдээс төлж буй төлбөр. Улсын төсөв, нийгмийн эрүүл мэндийн даатгал нь тус тусын эх үүсвэрээс бүрддэг ба үзүүлэх үйлчилгээний багцууд нь тус тусдаа бөгөөд хамрах хүрээний хувьд байнга зөрүүтэй байна. 2015 оны эрүүл мэндийн даатгалын хуулиар Засгийн газрын төсвийн эх үүсвэрийн сувгийг нийгмийн эрүүл мэндийн даатгал руу аажмаар шилжүүлэх шийдвэр гарсан нь одоог хүртэл хэрэгжиж байна. Үйлчлүүлэгчдээс төлж буй төлбөрийн орлого өнгөрсөн 10 жилд өндөр хэвээр байсан бөгөөд нийт эрүүл мэндийн салбарын зардлын 40-50 орчим хувийг эзэлж байна. Энэхүү орлогын ихэнх хувийг эм, эмийн хэрэгсэл, албан бус төлбөр зэрэг зардлууд эзэлж байна.

112. Өнөөгийн байдлаар Монгол Улс төлбөрийн холимог систем буюу бүх нийтийн нэгдсэн төлбөр болон нийлүүлэгчийн үйл ажиллагааны бодит зардлын хэмжээгээр төлбөр төлөх системүүдийг хэрэгжүүлж байна. Энэ нь бие биенийгээ нөхдөг бөгөөд зарим төлбөрийн аргачлалтай холбогдсон сөрөг үр дүнг бууруулах шинж чанартай дөрвөн төрлийн төлбөрийн аргачлалаас бүрддэг. Гэвч одоогийн төлбөр, хангамжийн систем нь зөвхөн эрүүл мэндийн тогтолцооны нэн тэргүүний зорилтуудыг л бага зэргээр дэмжиж байна. Гол шалтгаануудын нэг нь чанар болон үр ашигтай байдлыг дэмжих урамшууллын тогтолцоо байхгүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээний стратегийн худалдан авалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газар хийхийг хязгаарласан хэвээр байна. Мөн түүнчлэн Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан хоорондын төлбөрийн системийн салангид байдал гол хүндрэл болж байна.

113. *Монголын эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх тогтолцоо эмнэлэг төвтэй хэвээр байгаа нь хүндрэлтэй байна.* Өнгөрсөн арван жилийн хугацаанд Монгол улс эмнэлгийн орны тоог ихээхэн бууруулсан хэдий ч энэ тоо 2015 онд 1000 хүн ам тутамд 7.2 ногдож байгаа нь бүс нутгийн бусад орнуудаас нэлээд өндөр байна (Хятад, Малайз, Филиппин, Вьетнам). Түүнчлэн тогтолцоо нь салангид, үйлчилгээ үзүүлэгчдийн босоо чиглэлд харилцан уялдаа бага зэрэг байгаа ч эрүүл мэндийн үйлчилгээний төрлийн хөндлөн уялдаа холбоо байхгүй байна. Төрөл бүрийн түвшний үйлчилгээ үзүүлэгчдэд хүн амын эрүүл мэндийг харилцан хоорондоо зохицуулалттайгаар удирдахыг урамшуулах хөшүүрэг байхгүй. Зохион байгуулалттайгаар өвчтөн шилжүүлэх тогтолцоо, өвчтөнийг эмнэлгээс гаргах ба дамжуулах механизмууд ба өвчтөнд хүрч үйлчлэх зэрэгт эмнэлэг болон эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэгчдийн уялдаа холбоо ерөнхийдөө байхгүй байна. Тиймээс одоогийн үйлчилгээний тогтолцоо халдварт бус өвчний өсөлтийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна. Халдварт бус өвчин өргөжиж байгаа тул Монгол улс түүний гол шалтгаанууд болох өвчний эрт илрүүлэлт ба архаг өвчний удирдлагын аль алинд анхаарч шийдвэрлэх шаардлагатай байна. Үүний тулд эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог өндөр чанартай анхан шатны үйлчилгээнд чиглүүлэн өөрчлөн зохион байгуулахад ач холбогдол өгөх, эмнэлгүүдийг эрүүл мэндийн тогтолцооны төвд байгаа бие даасан байгууламж хэлбэрээс анхан шатны үйлчилгээ үзүүлэгчдийг өөртөө багтаасан сүлжээний нэг хэсэг болон үйлчилгээ үзүүлдэг байгууллага болгон өөрчлөх ёстой. Хэрвээ ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол одоогийн чимээгүй халдвар урт хугацаандаа эрүүл мэндийн үр дагаварт сөргөөр нөлөөлж эрүүл мэндийн өндөр өртгийг дагуулах болно.

114. Эцэст нь ихэнх судалгаа, үнэлгээнүүдэд Монголын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, ялангуяа хөдөө орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг гол тулгамдаж буй асуудал гэж онцолжээ. Өндөр чанартай анхан шатны үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн тогтолцоонд чухал үүрэгтэй эрүүл мэндийн чадварлаг мэргэжилтнүүдийг хөдөө, орон нутгийн эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад элсүүлэх ба тогтвор суурьшилтай ажиллуулахад хүндрэлтэй байна. Үйлчилгээний чанарын ялгаатай байдал нь өвчтнүүд анхан шатны тусламжийг алгасан хоёр эсвэл гуравдугаар шатлалын чанартай үйлчилгээг сонгоход илүүтэйгээр нөлөөлж байна. Нөгөө талаар үйлчилгээний чанарын мэдээлэл цуглуулах, чанарын сайжруулалтыг дэмжих стандартчилагдсан гүйцэтгэлийн хяналтын систем байхгүй байна. Хамгийн чухал нь үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд урамшууллын тогтолцоо байхгүй байна. Мөн дундаас дээш давхаргын мянга мянган Монголчууд эмчилгээ хийлгэхээр гадаад орнуудыг зорьж байна (голдуу Солонгос, Хятад).

Боловсрол: бүс нутаг, жендер, нийгэм-эдийн засгийн зөрүүтэй байдал нь чанартай боловсролын хүртээмжид саад тотгор болж байна.

115. Бага боловсролын хүртээмж бараг бүх нийтийг хамарч байна. Харин нийгэм-эдийн засгийн ялгаа боловсролын хамрах хүрээнд нөлөөлж, тогтолцооны дээгүүрх түвшинд ялгаа илүү их байна. Бага сургуулийн насны хүүхдүүдийн сургуульд элсэлтийн хувь 98.1 байна⁵². Бүрэн бус дунд болон бүрэн дунд шатны боловсролын сургуульд хамрагдалт 93 ба 85 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд ядуу, эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүд сургуульд суралцахгүй байх эрсдэл өндөр байна. Сум, орон нутагт амьдардаг дунд сургуулийн насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт хот суурин газарт амьдардаг хүүхдүүдээс бага буюу сургууль завсардах өндөр эрсдэлтэй байсан. Хөвгүүдийн боловсролын түвшин охидынхоос хоцрогдолтой байна. Сургууль завсардсан ерөнхий боловсролын сургуулийн насны хөвгүүдийн тоо охидоос бараг гурав дахин их байна. Монголын 18-24 насны залуучуудын 52 хувь нь коллеж, их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн 61 хувь, эрэгтэйчүүдийн 44 хувь байгаа нь жендерийн ялгаа их байгааг харуулж байна. Тэгш бус байдал ялангуяа өндөр: Энэхүү насны ангиллын зөвхөн 10 хувь нь ядуу болон эмзэг бүлгийн өрхийнх бол 88 хувь нь чинээлэг өрхийн залуус байна.

116. Цаашилбал, Монгол Улс бичиг үсэг тайлагдсан байдал, тоо бодох чадвараараа ижил түвшний орнуудаас хоцрогдолтой явж байна. 3-5 насны монгол хүүхдүүдийн зөвхөн 9 хувь нь энгийн үсэг нэрлэж, тоо бодох чадвартай бол Тайланд, Уругвай, Беларусь, Украин, Македон, Аргентин, Серби, Молдав улсуудад 30-аас 69 хувьтай байна. Монгол орны хувьд бага насны хүүхдүүдийн чадварын ялгаа ихээхэн зөрүүтэй байгаа ба хөдөө, орон нутгийн эсвэл амьжиргааны түвшин багатай өрх, эсвэл үндэсний цөөнхийн хүүхдүүд танин мэдэхүй, хэл яриа, нийгэм сэтгэл зүйн чадвараар ихээхэн хоцрогдож байна⁵³. Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсролын хамрах хүрээг өргөжүүлж, 3-5 насны хүүхдүүдийн 70-80 хувь цэцэрлэгт хамрагдаж байна. Гэсэн хэдий ч хөдөө, орон нутгийн хамрагдалтын түвшин дөнгөж 46 хувьтай байгаа бөгөөд хүн амын олонх болох халх үндэстэнтэй харьцуулахад

⁵² (МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО, 2016).

⁵³ Дэлхийн Банк. 2017. Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсрол: үйлчилгээний хүртээмж, чанар ба хүүхдийн хөгжлийн үр дүн – 2017 он 3 сар (Англи). Вашингтон хот.: Дэлхийн банк групп.

Казах хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 24 нэгж хувиар доогуур байна.

117. Боловсролын суурь үйлчилгээний чанарын жигд бус байдал хүртээмжийн ялгааг улам хурцатган бичиг үсэгт суралцах, тоолж сурах зэрэг суурь танин мэдэхүйн үр чадварыг бууруулж байна. Нэгдүгээрт, хамгийн шүүмжлэлтэй нь сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээнд хамрагдах боломж, ялангуяа эмзэг бүлэгт, хязгаарлагдмал байгаа нь хүүхдүүд сургуульд бэлтгэгдэхэд ихээхэн ялгаатай байдалд хүргэж байна.⁵⁴ Эдгээр ялгааны асуудал нь суурь боловсролын чанар муу бөгөөд доогуур байх, танин мэдэхүйн үндсэн суурь чадваруудыг бий болгоход сөргөөр нөлөөлж байна. 2017 онд хийсэн монгол хэлний унших болон тоо бодох чадварын үнэлгээгээр үндэсний цөөнх болон ядуу өрхийн хүүхдүүдийн нэгэн адилаар малчин өрхийн 1 ба 2-р ангийн хүүхдүүд бусад хүүхдүүдээс нэлээд хоцрогдож байгааг харуулсан байна.⁵⁵

118. Тогтолцооны гүйцэтгэлийн харьцуулалт нь боловсролын чанарыг үнэлэх механизм бөгөөд Монгол Улс олон улсын хэмжээний томоохон үнэлгээнд оролцдоггүй тул үүнийг хийх боломжгүй байна. Монгол Улс PISA болон TIMSS зэрэг олон улсын үнэлгээнд оролцдоггүй нь тогтолцооны гүйцэтгэлийн хувьд сурлагын үр дүн, үр дүнгийн сайжралтыг харьцуулах боломжгүй болгож байна. Үндэсний хэмжээнд 5, 9, 12-р ангийн сурагчид төгсөх шалгалт өгч стандартчилагдсан үнэлгээ хийгддэг бол үнэлгээний бичил мэдээллүүд нь хэвлэгддэггүй байна.

119. Боловсролын систем нь сургуульд болон хөдөлмөрийн зах зээлд амжилт гаргахад шаардагдах нийгэм сэтгэлзүйн үр чадварыг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь бага байдаг. Нийгэм сэтгэлзүйн үр чадварын бат бэх үндэс суурь – өөрөөр хэлбэл хүмүүс хоорондын болон нийгмийн нөхцөл байдлыг үр ашигтай болгон чиглүүлэх уян хатан чадварууд нь сурлагын болон хөдөлмөрийн зах зээлийн амжилтуудтай холбоотой байдаг. Боловсролын ололт болон хөдөлмөрийн зах зээлийн амжилтыг урьдчилан таамаглахдаа IQ-г танин мэдэхүйн бус эсвэл хувийн үр чадвартай харьцуулан үздэг. Монголд эдгээр үр чадварууд дутагдалтай байна. Ихэнх ажил олгогчид бүтээлч байх, шинийг эрэлхийлэгчийн чадвар, цагийн зохицуулалт, харилцаа, манлайлал, хувь хүмүүс хоорондын харьцаа, дасан зохицох чадвар, асуудал шийдвэрлэх, шүүмжлэлт сэтгэлгээ, багаар ажиллах зэрэгтэй холбоотой үр чадварууд дутмаг байгааг онцолдог.⁵⁶ Мөн ажил олгогчид техникийн, гадаад хэлний ба мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХТ) үр чадвар хангалтгүй байгааг онцолж байна. Боловсролын систем нь эдгээр чадварыг хөгжүүлэх боломжийг бага олгодог. Хэдийгээр "хүүхдийг бүх талаас хөгжүүлэхийг" онцлон тэмдэглэж байгаа ч үндэсний сургалтын хөтөлбөр, анги танхимын дадлагууд нь академик сургалтанд зөвхөн чиглэсэн хэвээр байна.

120. Боловсролын тогтолцоонд сургууль төгсөөд ажилд орох шилжилтийг хөнгөвчлөх үр дүнтэй механизм байхгүй бөгөөд ихэнхи төгсөгчид өндөр эрэлт хэрэгцээтэй үр

⁵⁴ (Дэлхийн банк, 2017)

⁵⁵ (Дэлхийн Банк)

⁵⁶ (Shatz, et al. 2015) ба (Дэлхийн Банк 2007)

чадварыг хангалттай эзэмшээгүй байна. Үндэсний хэмжээнд залуучуудын тавны нэг нь ажилд ороход хамгийн их саад тотгор болж байгаа хүчин зүйлийг боловсролтой холбоотой хэмээсэн байна.⁵⁷ Монголын ахлах дунд болон дээд боловсролын хөтөлбөрүүд нь оюутнуудыг ажлын байранд бэлтгэхдээ тааруухан болох нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээс харагдаж байгаа ба мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) ба дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт маш бага, дөнгөж 50 орчим хувьтай байна. Энэ нь тогтолцоо болон үйлдвэр, ажил олгогчдын хоорондын уялдаа холбоо сул байгааг харуулж байгаа юм.⁵⁸ Их, дээд сургууль, МСҮТ-ийн бодлого нь хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцээгүйгээс техникийн эсвэл ажлын байрны тусгай үр чадварыг муу хангасан, ач холбогдол багатай, зах зээлд эрэлтэд нийцээгүй боловсон хүчнийг бэлтгэж байна.⁵⁹

121. Сонирхолтой нь, боловсролын бүх түвшин дэх жендерийн ялгаа Монголын эмэгтэйчүүдэд илүү таатай нөхцөлтэй байна. Эрэгтэйчүүдийн 59, эмэгтэйчүүдийн 79 хувь нь их, дээд сургуульд элсэн ордог нь харьцуулж буй орнуудаас хамгийн өндөр бөгөөд дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад маш өндөр үзүүлэлт юм. Үүний нэгэн адилаар ерөнхий боловсролын сургуулийн элсэлт мөн л 82 болон 80 хувьтай байгаа нь олон улсын хэмжээнд өндөрт тооцогдож байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь нь охид, хөвгүүдийн хувьд ижил (86 хувь) байгаа нь дэлхийн хэмжээнд мөн л дээгүүрт орж, Перу улсын дараа бичигдэж байна. Эдгээр үзүүлэлтүүдийн аль нь ч бидний харьцуулалтын аргыг хэрэглэхэд сонгосон жишиг улсуудтай харьцуулахад 1-р шатлалаас доогуур, Дэлхийн эсрэг харьцуулах үед 2-оос доош ороогүй юм (Зураг А1 5-г үзнэ үү).

122. Монголын Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030 нь мөн л боловсролыг чухалчилсан. Энэ нь бүх нийтэд хүртээмжтэй, тэгш, чанартай боловсрол эзэмшүүлэх, насан туршийн суралцах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой зорилгуудыг багтаасан байна. Түүнчлэн Боловсролын чанарын шинэчлэл төсөл 2015 оны сүүлээр хэрэгжиж эхэлсэн ба Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ) эхний ээлжинд бага ангийн хүүхдийн унших ба математикийн чадварын үнэлгээнүүд болон хичээлийн танхимын ажиглалтыг хийх замаар унших ба тоо бодох үр чадварын ялгаатай байдлыг хэмжих тодорхой алхмуудыг 2017 оноос хийж эхэлсэн. Цуглуулсан өгөгдлүүд нь танхимын сургалтыг сайжруулахын тулд багш бэлтгэх сургалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. БСШУСЯ нь Авъяас хөтөлбөрийн хүрээнд сургуулийн буцалтгүй тусламжийг ашиглах замаар сургуулийн түвшний төлөвлөлт, хариуцлагыг бэхжүүлж байна. Үүнээс гадна Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020-т багш нарын мэргэжил дээшлүүлэх, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг сайжруулах, малчдын хүүхдийн дотуур байрны чанарыг сайжруулахад чиглэсэн өмнөх төлөвлөгөөнүүдийг үргэлжлүүлэхээр ажиллаж байна.

123. Сургуулийн бие даасан байдал муу байх нь үр ашгийг хязгаарладаг бөгөөд сайжруулах зүйл нэлээд байсаар байна. Монгол Улсын Засгийн газраас бага, дунд сургуульд олгодог төсөв гурван бүрэлдэхүүнтэй (I) суралцагчдийн анги бүлэг, сургуулийн

⁵⁷ (Shatz, et al. 2015).

⁵⁸ (Азийн Хөгжлийн Банк 2017) ба (Дэлхийн Банк 2017)

⁵⁹ RAND Корпорациас харна уу. 2015. Монголын хөдөлмөрийн зах зээлийг сайжруулах ба залуусын боломжийг нэмэгдүүлэх. Тайлан.; Дэлхийн Банк.2007. Монгол – Шинэ эдийн засагт зориулж үр чадварыг бий болгох нь. Тайлан, ба De Gorpello, E., P. Tandon, ба S. Yousuf. "Өндөр мэдлэгийг ажилд оруулах нь." (2011).

байршлаас хамааран нэг суралцагчид ногдох хувьсах зардал; (ii) ашиглалтын зардлыг нөхөх зорилготой "тогтмол төсөв"; (iii) бага орлоготой өрхийн хүүхдийг дэмжих зорилготой нийгмийн тусламжийн санхүүжилт. Зарчмын хувьд, энэхүү санхүүжилтийн тогтолцоо нь "суралцагчдыг дагасан санхүүжилт" буюу шаардлагатай газар хэрэгцээт санхүүжилт олгоход чиглэдэг. Гэсэн хэдий ч энэхүү тогтолцоо нь сургуулийн удирдлагуудын зүгээс сургуулийнхаа нөхцөл байдалд тохируулан төлөвлөх, төсөвлөх боломжийг байхгүй болгож байна. Монголд байгаа жишээтэй адилаар сургуулийн бие даасан байдал байхгүй нөхцөлд нэг хүнд ногдох санхүүжилт нь дангаараа сургуулийн хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэхэд хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг.

124. Дээд боловсролын салбар хурдацтай өргөжиж байгаа нь сургалтын зарим хөтөлбөрүүдийн чанар болон ач холбогдлыг сүлрүүлэх болсон. Зах зээлийн эдийн засаг дахь үр чадвар, шинэ санаачлагын эрэлт хэрэгцээг хангахын тулд Монголын дээд боловсрол, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн (МСҮТ) тогтолцоонууд хурдацтай өргөжин тэлж байна⁶⁰. Хүртээмж тэгш бус ба их, дээд сургууль төгсөгчдийн хувьд ажил эрхлэлт доогуур байгаа нь үр чадварын нийлүүлэлт (оюутнуудын ихэнх нь нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр суралцан төгсөж байгаа) эрэлт (шинжлэх ухаан, техникийн салбарт, ялангуяа уул уурхайд)-эд нийцэхгүй байгаатай холбоотой. Түүнчлэн Монголын их, дээд сургуулийг төгсөн хувийн хэвшилд ажиллах боломж маш хязгаарлагдмал хэвээр байна. Аж ахуйн нэгжийн судалгаагаар жишээлбэл, их дээд сургуулиуд технологийн шинэчлэлийг олж авахад голлох үүргийг гүйцэтгэдэг гэж компаниудын зөвхөн 1-2 хувь нь үзэж байна.

125. Хөдөлмөрийн зах зээлийн хувьд 2016 оноос ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын хичээлийн нэгэн хэсэг болгон ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжааны талаар мэдээлэл, зөвлөмжийг олгож эхэлсэн боловч сургуулиас ажил руу шилжих шилжилтийг дэмжихэд чиглэсэн практик стратеги байхгүй байна. БСШУСЯ саяхан сургуульд суурилсан бизнесийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд сургуулиудад ахлах ангийн сонгон суралцах боломжтой хичээл болгон сонголтыг олгосон. Гэвч энэхүү хичээлийг нэвтрүүлэхэд хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой үр чадварыг Засгийн газрын зүгээс олж илрүүлэн эртнээс хөхүүлэн дэмжих хэрэгцээ шаардлагатай байгаа бөгөөд нийгмийн онцлогт тохирсон хамаарал сул байдгаас сургалтын хөтөлбөр хязгаарлагдмал төдийгүй хийсвэр бизнесийн ойлголтод үндэслэсэн учир нийгэм-сэтгэл зүйн үр чадварын төлөвшилтийг сургууль, багш нар хэрхэн дэмжих талаар удирдамж маш бага байна.

126. Хотжилтын бодлого ба боловсролын үйлчилгээний нийлүүлэлт хоорондоо уялдаа холбоотой. Дотоод шилжилт хөдөлгөөн, хотжилт хурдацтай явагдаж буй хэрэгцээг хангах урт хугацааны төлөвлөлт дутмаг байгаа нь хот суурин газарт боловсролын үйлчилгээг хүргэх чадавх тэр дундаа нийт хүн амын тэн хагас, үүнээс ихэнх нь гэр хороололд амьдардаг Улаанбаатарт (УБ) дутмаг байна.⁶¹ Цэцэрлэгийн хүртээмж бага хэвээр байгаа, олон сургуулиуд олон ээлжээр хичээллэдэг, анги дүүргэлт хэт их зэрэг нь чанарын асуудлыг улам хүндрүүлж байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхгүй орхих нь ялангуяа ядуучуудын тоо

⁶⁰ (De Gorpello, Tandon and Yousouf 2011)

⁶¹ (Baker, Nguyen and Mason 2016)-аас харна уу.

өссөөр байгаа Улаанбаатар хотод ядуурлыг бууруулах, хүний капиталын хуримтлалыг бий болгоход гарсан ахиц дэвшлүүдэд аюул занал учруулж байна.

Нийтийн хангамж болон орон байрны хүртээмж: Нийт хүн амын 45 хувь гэрт амьдарч байна

127. Цахилгааны хүртээмж хурдацтай өсөж бараг бүх нийтийг хамарч чадсан байна. Үндэсний цахилгаан хангамжийн түвшин 2005 онд 65 хувьтай байсан бол өнөөдөр нийт өрхийн 90 гаруй хувь нь үндэсний сүлжээнд холбогдсон бөгөөд нийт 331 сумын нэг сумаас бусад сумын төвүүд үндэсний сүлжээнд холбогдож, хэрэглэгчид боломжийн үнээр цахилгаан хэрэглэж байна. Мөн түүнчлэн, 2008-2012 оны хооронд Засгийн газраас хэрэгжүүлсэн нарны зайн систем суурилуулах хөнгөлөлттэй хөтөлбөрийн шугамаар бараг бүх малчид цахилгаан гэрэлтүүлэг, зурагт болон гар утас хэрэглэх боломжтой болжээ.⁶²

128. Цахилгаан хүртээмжээс эсрэгээр, цэвэр ус болон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмж нь Монгол улсын хувьд олон улстай харьцуулахад онцгой хоцрогдож байгаа үзүүлэлтийн нэг юм.⁶³ 2015 оны байдлаар баталгаат усны эх үүсвэрийн хүртээмж нийт хүн амын 64%-ийг хамарч байжээ. Энэ нь хот суурин газрын хүн амын 66%, хөдөө орон нутагт амьдарч буй хүн амын 59%-ийг эзэлж байна. Нийт хүн амын 60% нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг гэж мэдээлсэн байна. Хот суурин газрын усан хангамжид тулгарч буй сорилтуудад үйл ажиллагааны зардлыг нөхөхөд хүрэлцэхээргүй усны тариф бага, орлогын бус зориулалттай усны эзлэх хувь их (хэдийгээр энэ асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч), албан бусаар суурьшсан болон гэр хорооллын орчмын ус, ариун цэврийн байгууламжийн хамрах хүрээ бага төдийгүй хэт хүйтэрдэгтэй холбоотой үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний асуудлууд багтаж байна. Гэр хороололд амьдарч буй хүн амын ихэнх нь баталгаат цэвэр усны хангамжгүй байна. Цэвэршүүлсэн усыг ус түгээх цэг эсвэл усны машинаар нэг куб метрийг нь 1000 төгрөгөөр нийлүүлж байна. Зарим нь цэвэршүүлээгүй усны эх үүсвэр болох худаг ашиглаж байна. Гэр хорооллын оршин суугчид ус түгээх цэгээс өдөрт 10-30 литр усыг өөрсдийн гэр хүртэл зөөвөрлөж байна. Энэ нь ялангуяа өвлийн улиралд маш хүнд юм. Гэр хорооллын оршин суугчид өдөрт дунджаар нэг хүний 5-10 литр ус хэрэглэдэг гэсэн тооцоо байгаа нь ДЭМБ-ын стандартаас маш доогуур байна. Хот суурин газрын ариун цэврийн байгууламжийн асуудал улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд УБ хотын ариун цэврийн байгууламж одоогийн бохир усны хэмжээг цэвэрлэх хүчин чадал байхгүй байна. Сүүлийн үеийн тайлангаар төв цэвэрлэх байгууламжаас гарсан ус Туул голтой нийлснээс үүдэн Туул голын усны чанар муудсан талаар харуулсан байна.⁶⁴ Төгсгөлд нь, нэг хүний өдөрт 1.1 кг хог хаягдал үүсгэж байгаа нь Улаанбаатар хотыг “хог хаягдал өндөртэй” хот болгож байна. Гэвч сүүлийн жилүүдэд гаргасан чухал хүчин чармайлтын үр дүнд УБ хот

⁶² (Дэлхийн банк 2014)

⁶³ Энэхүү тайлангийн жишиг тогтоох дасгалаар Монгол Улсын цэвэршүүлсэн ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн индекс хот болон хөдөөгийн аль алинд сонгосон ижил төвшний орнууд болон дэлхийн нийт орнуудтай харьцуулахад тархалтын хамгийн доод төвшний 50 эсвэл 25 хувьд багтаж байна (

Зураг А1 5-харна уу).

⁶⁴ (2030 Water Resources Group 2014)-өөс харна уу.

бага болоод бага дунд орлогын төвшнөөс давсан ба хог хаягдлын удирдлагын системээ сайжруулах, ялангуяа гэр хорооллыг хамруулах (хог хаягдал цуглуулах давтамж ховор), нийгмийн эрүүл мэндийн асуудлыг зохицуулах үе шатандаа явж байна.⁶⁵

129. Түүнчлэн хүн амын дөрөвний нэгээс бага нь Дулааны цахилгаан станцууд болон дүүргийн дулааны шугам сүлжээгээр (ДДШС) дамжуулан халаалтын зуух ба төвийн эрчим хүчний системд холбогдсон байна. Ихэнх өрхүүд төвлөрсөн бус халаалтын эх үүсвэрийг хэрэглэж байгаа бөгөөд хот суурин газрын барилгууд нүүрсээр галладаг уурын зуух, хотын захын хороолол, хөдөө орон нутагт нүүрс түлдэг зуух ашиглаж байна. Засгийн газар эдгээр дулааны шийдлүүдийг тогтвортой бус гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа төдийгүй Улаанбаатар (УБ) хотын захын дүүргүүдэд их хэмжээгээр ашиглаж байгаа нь нийт хотын хэмжээнд агаарын бохирдлыг маш өндөр түвшинд хүргэж байгаа гол шалтгаан болж байна (**Error! Reference source not found.** бүлгийн 168-р зүйлийг харна уу). УБ хот дахь ДДШС-ний х эрэглэгч өрхийн эзлэх хувь 1990-ээд оны үед 50%-иас илүү байсан бол өнөөдрийн байдлаар 40%-иас бага болсон байна. ДДШС-ний хамрах хүрээ хүн амын өсөлттэй зэрэгцэн нэмэгдэж чадахгүй байгаа бөгөөд шалтгаан нь (i) дулааны тарифыг худалдан авах боломжийг харгалзан маш багаар тогтоосон нь ДДШС-ны харьяа компаниуд хөрөнгө оруулалтаа нөхөн сэргээхэд маш хүндрэлтэй байна (ii) барилгын хэв хэмжээний стандартыг хангаагүй өргөн тархсан, хол зайд байрласан зэрэг нь техникийн болон санхүүгийн хувьд дулааны сүлжээг өргөтгөх боломжгүйд хүргэж байна.

130. Хурдацтай явагдаж буй хотжилтыг орон сууцны зохистой нөхцөл байдлаар хангаж чадаагүй байна. 2000 оноос хойш хотын хүн амын тоо бараг хоёр дахин нэмэгдэж, Улаанбаатар хотын хүн амын тоо 1989 оноос хойш 600,000-аас 1.4 сая болж өссөн байна. Хиймэл дагуулын мэдээнд хийсэн дүн шинжилгээгээр хотын барилгажилттай хэсгийн хамрах хүрээ 73 км²-аар нэмэгдсэн ба, үүнээс 87 хувь нь бага нягтралтай гэр хороолол гэж ангилагджээ. Гэр хороолол нь УБ хотын барилгажилттай хэсгийн 83 хувийг, хүн амын тал орчим хувийг эзэлж байна. Гэр хорооллын оршин суугчид дээрх хүн амын өсөлтийн ихэнх хувийг бүрдүүлж байна. Орон сууцны болон хот төлөвлөлтийн бодлогогүйгээр нийтийн хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй юм.

131. Орон сууцны дутагдал, хотын тээврийн хангалтгүй байдалтай хавсран хотын оршин суугчдын амьдрах нөхцөл, эдийн засгийн боломжийг улам дордуулж байна. Улсын хүн амын бараг тал хувь, улсын бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 60 гаруй хувь нь харьяалагддаг Улаанбаатар хотод хурдацтай хотжилт, түүнээс хурдацтай нэмэгдэж буй тээврийн хэрэгслийн хэрэглээ, газар ашиглалт, тээврийн төлөвлөлт муу, замын сүлжээний зохион байгуулалт дутагдалтай буюу цөөн тооны туслах зам болон орон нутгийн замтай, замын хөдөлгөөний зохицуулалт үр ашиггүй, замын хөдөлгөөний удирдлагын бодлого дутмаг, түүний дотор тээврийн хэрэгслийн зогсоол дутагдалтай зэргээс үүдэн замын хөдөлгөөний түгжрэл улам бүр хүндэрч байна. Ажил, үйлчилгээ хотын төвд төвлөрсөн учир захын дүүргүүдэд дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмж дутагдалтай байна. Саяхан хийгдсэн судалгаагаар гэр хорооллын оршин суугчдын 32 хувь

⁶⁵ (Byamba and Ishikawa 2017)-оос харна уу.

нь гэр ба ажил хооронд нэг талдаа 1-ээс 2 цаг зарцуулж байгаа тооцоо гарчээ. Энэ үзүүлэлт нь Бангкок, Манила гэх мэт том хотуудтай дүйцэж байна.⁶⁶ Түгжрэлтэй замд автобус илүү удаан явдаг учир нийтийн тээврийн хэрэглэгчид хувийн тээврийн хэрэгсэлтэй иргэдээс илүү их хугацаа алдаж саатаж байна. Гэр хорооллын оршин суугчдад нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж байхгүй, эсвэл түүлж буй замын ихэнх хэсэг нь хатуу хучилтгүй учраас тээврийн хэрэгсэлд илүү урт хугацааг өнгөрүүлж байна. Энэ нь ноцтой асуудлын нэг болох хотын орчны бохирдлын хэмжээг мөн нэмэгдүүлж байна (**Error! Reference source not found.** бүлгийн 151-р зүйлээс харна уу).

132. Тээврийн дэд бүтцийн дутагдалтай байдал нь мөн хөдөө, орон нутгийн хүн амын тоонд нөлөөлж байна. Дутуу баригдсан замын сүлжээ, замын чанар муу байгаа нь хөдөө, орон нутгийн хүн амын хэрэгцээт эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг хязгаарлаж байна. Хөдөөгийн хүртээмжтэй байдлын индекс (RAI), өөрөөр хэлбэл, Монголын хатуу хучилттай дөрвөн улирлын замаас 2 км-ийн зайд амьдардаг хөдөөгийн хүн амын эзлэх хувь 2003 онд 36% буюу Зүүн Өмнөд Азийн орнууд дундаас хамгийн доогуур байранд жагсаж байна.

133. Монгол Улсад 1991 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас шилжсэн цагаас эхлэн хот байгуулалтын байгууллагууд, түүнтэй холбоотой дүрэм журам жилээс жилд өргөжин хөгжиж ирсэн. 1992 оны Үндсэн хуулиар үл хөдлөх хөрөнгийг шударгаар олж авах, эзэмших, өв залгамжлах эрхийг олгосон байна. Үүнийг 1994, 1996, 2009 оны газрын хууль тогтоомжоор улам нарийн болгож өмчийн эрхийг тодруулж, хөрөнгө оруулалтын аюулгүй байдлыг хангах зорилгоор газар барьцаалах боломжийг олгосон юм. Гэвч 2002 оны Газрын тухай хуулиар хотын оршин суугчдад зориулж оршин суух зориулалтаар (700 м2) газар үнэгүйны Үндсэн хуулиар үл хөдлөх хөрөнгийг шударгаар олж авах, эзэмших, өв залгамжлах эрхийг олгосон байна. Үүын газрыг хувийн зориулалтаар үнэгүй эзэмшүүлэх энэ үйл явдал дэлхийн өөр хаана ч байхгүй бөгөөд энэ нь хот суурин газрыг өргөжин тэлэхэд шүүд нөлөө үзүүлж, оршин суугчдын амьдралын чанар, хүн амын хэрэгцээт үйлчилгээний хүртээмж, үер зэрэг байгалийн гамшигт өртөхөд мөн нөлөө үзүүлдэг байна (**Error! Reference source not found.** бүлгийн 183-р зүйлээс харна уу).

134. УБ хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөний баримт бичиг нь хот суурин газрыг өргөжүүлэхэд чиглэсэн боловч дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжийг дэмжихэд хувь нэмэр бага байна. Энэхүү төлөвлөгөөнд шинэ дагуул хотуудыг хөгжүүлэх замаар хотын хүн амын төвлөрлийг сааруулах, төлөвлөж буй хотын төв, дэд төвүүдийг холбосон бүсийн хурдны замыг цогц байдлаар хөгжүүлэхээр тусгажээ. Үүнээс гадна УБ хотын газар ашиглалтын болон бүсчилсэн стандартаар бүх хот, тосгон суурин газрын тиг гортигийг тогтоож бусад ангиллын газраас хатуу зааглах, хүн амын өндөр нягтаршилтай байхыг зөвшөөрөөгүй байна. Энэ нь хотын бага нягтралтай тэлэлтийг багасгах, эсвэл хотын одоогийн барилгажилттай хэсгийн нарийвчилсан хөгжил, үйлчилгээг дэмжихэд хувь нэмэр бага төдийгүй хотоос гадуурх хөрөнгө оруулалтад анхаарснаар өндөр зардал гарах, болзошгүй эрсдэлийг бий болгох боломжтой.

⁶⁶ (Дэлхийн банк 2016)

135. Дүрэм журам болон төлөвлөгөөний хэрэгжилт нь дараах үндсэн гурван сорилттой тулгарч байна. Нэгдүгээрт, бүртгэл болон албан ёсны кадастр сул талтай байна. Хэд хэдэн Засгийн газрын байруудын байр зүйн зураглал, газрын зураг дээрх тэмдэглэгээ, бүртгэл бүрэн бус байна. Мөн гудамж, явган хүний зам, нийтийн эзэмшлийн газрууд, сургууль, эмнэлэг зэрэг газруудын зориулалтын ялгаа байхгүй байна. Үүний улмаас сургууль, эмнэлэг зэрэг нийтийн байгууламжуудын зарим хэсгийг хувийн зориулалт руу шилжүүлэх, эсвэл хувийн зориулалтаар барих гэх мэт өмчийн “хуваагдал”-д орж байна. Эдгээрээс гадна газрыг зах зээлийн үнээс доогуур буюу нэрлэсэн үнэд тулгуурлан газар шууд олгодог практик мөн хүндрэлтэй асуудлын тоог нэмэгдүүлж байна.⁶⁷

136. Хоёрдугаарт хот суурин газрын зах зээлийн чиг хандлагад үндэслэн нийслэлийн нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэл болон газрын ашиглалтын зориулалтыг хөрөнгө оруулалттай уялдуулахын тулд дахин шинэчлэх шаардлагатай байна. Нийслэлийн нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нэг бүсчлэлд багтаж байгаа нь нийслэл дэх өмчийн хөрөнгө оруулалтын байршилд гажуудал бий болгож байна. Мөн түүнчлэн нийслэлийн нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэл болон газар ашиглалтын зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх, хянах нь тодорхой бус байгаа нь хувийн хөрөнгө оруулагчдад нэмэлт зардал гаргах, хөрөнгө оруулалтаа саатуулахад хүргэж байна. Газар болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын сүүлийн үеийн өөрчлөлтүүд нь олон нийтийн төөрөгдөл, хамгаалалт, үйл ажиллагааны тодорхойгүй байдлыг бий болгосон. Тухайлбал, өөр өөр бүлэг болон хэд хэдэн газар ашиглалтын төрөлд хамааруулж болохуйц газар өмчлөлийн гурван хэлбэр (эзэмших, өмчлөх, ашиглах) байна. Өмчлөлийн гэрчилгээ авахын тулд есөн газарт хандах хэрэгтэй бөгөөд дээд тал нь 113 өдөр шаардагдана. Шаардагдах зүйлс, үйл явц тодорхой бус ба газрын зөвшөөрлийг тогтвортой, ойлгомжтой, ил тод шалгуураар бус засаг дарга олгож байна. Гадаад болон дотоодын хуулийн этгээд өмчлөлийн эрх авахын тулд зөвшөөрлийн тодорхойгүй үйл явцтай нүүр тулж байгаа төдийгүй зөвшөөрлийн гэрчилгээ нь хэтэрхий богино хугацаатай (хамгийн багадаа 5 жил) гарч байгаа нь хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байна.

137. Гуравдугаарт, өнөөгийн татвар, хураамжийн тогтолцоо нь нийслэлд ихээхэн хэмжээний орлоготой болгох боломжийг олгодоггүй бөгөөд энэ нь нийслэлийн хот суурин газрыг хөгжүүлэх чадварыг хязгаарлаж байна. Статистикаас харахад 2012 онд нийслэлийн орлогын зөвхөн 2.8 хувийг хөрөнгийн татвар бүрдүүлж байна (Кейп Таун хотод 25 хувь, Мадридад 12 хувь байсан). Татвар, хураамжийн өнөөгийн бүтэц нь гүйлгээний мөнгөн дүнг татварын бүртгэлтэй үнэн зөв тайлагнах явдлыг бууруулж байна (ихэнх нь бэлэн мөнгөөр хөтлөгдөж байгаа учир). Орон сууцны хашааны хураамжийг ихэвчлэн цуглуулдаггүй бөгөөд жилийн хураамжаас чөлөөлж байна. Эцэст нь, орон сууцны бус үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь 1997 оны Газрын төлбөр тухай хуулийн дагуу тогтмолоор тогтоогдсон бөгөөд зах зээлийн үнэ цэнийг тусгаагүй байна.⁶⁸

⁶⁷ Сүүлийн үеийн тайлангийн тооцооллоор Нийслэл нь 2000 оноос хойш хамгийн багадаа Нийслэлийн 2012 оны төсвийн орлогын 20 дахин их хэмжээний орлого олох боломжоо ашиглаагүй байна. Гэвч 2012 оноос эхлэн ирээдүйн борлуулалтандаа дуудлага худалдааны тогтолцоог ашиглаж эхэлсэн ба борлуулах зориулалттай газрууд бүгд дуудлага худалдаанд оржээ. (Дэлхийн банк 2015) болон (Дэлхийн банк 2016)-аас харна уу.

⁶⁸ (Дэлхийн банк 2016)

138. Хууль, эрхзүйн бодлого зохицуулалт Монгол Улсын цахилгаан, дулаан хангамжийн хүртээмжид ихээхэн нөлөө үзүүлж байна. Засгийн газар цахилгааны тарифыг хянадаг, нарны зайн системд татаас олгодог зэргээс хүн амын нэлээд хэсэг нь боломжийн үнэтэй цахилгаан хэрэглэх боломжтой гэж хэлж болохоор байна. Энэ эрчээрээ 2016 он гэхэд Монголын цахилгааны хүртээмж бараг бүх хүн амд хүрч чадахаар байна. Энэ амжилт нь түгээлтийн компаниудад хөрөнгө хуваарилах, тарифын түвшинг засгийн газрын тогтоолоор бага түвшинд барихын зэрэгцээ цахилгаан эрчим хүчний сүлжээг өргөтгөх засгийн газрын идэвхтэй санаачилгатай холбоотой юм. Халаалтын хувьд, уламжлалт хоол хийх болон халаалтын зориулалттай зүүхнаас ялгарч буй агаарын бохирдлыг бууруулах зорилготой Улаанбаатар хотын гэр хорооллын хэмжээнд 175,000 орчим утаагүй зүүх нэвтрүүлэх, бүрэн шаталттай түлшийг дэмжих зэрэг хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч бага орлоготой айл өрхүүд санхүүгийн хувьд дээрх сонголтуудыг хийх боломжгүй байгаа нь эдгээр хүчин чармайлтыг зарим талаар амжилтгүй болгож байна. Засгийн газраас УБ хотод уламжлалт зүүх үйлдвэрлэх, борлуулахыг хориглох, цахилгаан халаалтын хэрэглээг дэмжих зорилгоор цахилгааны шөнийн хэрэглээг үнэгүй болгох журам гаргасан нь эдгээр хүндрэлтэй асуудлуудын заримыг шийдэх боломжтой байгаа хэдий ч эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хувьд эрчим хүчний секторын зохистой хууль, эрхзүйн зохицуулалт, бодлогын орчинг бүрдүүлэхгүйгээр цахилгаан, эрчим хүчний тогтвортой хүртээмжийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг арилгах боломжгүй юм.

139. Улаанбаатар хотын усан хангамж, ариун цэврийн байгууламжийн бүтэц зохион байгуулалт нэгдмэл биш бөгөөд дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжгүй байна. Улс төрийн эрх ашгаас шалтгаалан өөр өөр байгууллагууд үйлчилгээ эрхэлж байгаа учир бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийхэд хүндрэлтэй бөгөөд амжилт хязгаарлагдмал байна. Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах газар (УСУГ), Орон Сууц, Нийтийн Аж Ахуйн Удирдах Газар (ОСНААУГ) гэсэн үндсэн хоёр байгууллага ажиллаж байна. Аль аль нь УБ хотын харьяа орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм. Эдгээр байгууллагууд Нийслэлийн эзэмшлийн усан хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг хариуцан ажилладаг. УСУГ нь ОСНААУГ-ийг задгай усаар хангадаг бөгөөд ОСНААУГ орон сууц, байгууллагуудад хуваарилдаг. Эдгээр байгууллагууд хоёулаа алдагдалтай ажиллаж байгаа төдийгүй үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардлаа нөхөж чадахгүй байна. Хэдийгээр усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хувьд УСУГ болон ОСНААУГ-ийн үйл ажиллагааг нэгтгэх нь илүү үр дүнтэй боловч амжилттай болоогүй байна. Мөн хотын захын хэсгийн оршин суугчид орон сууцны хэрэглэгчдээс илүү тариф төлдөг хэдий ч УСУГ ус түгээх байрны тарифын орлогоос үйл ажиллагааны зардлаа нөхөж чадахгүй хэвээр байна.

140. Монгол Улсын Засгийн газар болон Улаанбаатар хотын захирагчийн алба нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслийг олон төрлөөр өргөтгөх чиглэлээр судалгаа хийсэн. Үүнд төмөр замын бүтээн байгуулалтын төлөвлөгөө болон BRT систем багтана. Гэвч аль ч төслийг эхлүүлээгүй. Түүнчлэн хотын захиргаанаас төлбөр хураах нэгдсэн систем, зохицуулалтын шинэчлэл зэрэг автобусны үйлчилгээний чанарыг сайжруулах хэсэгчилсэн шинэчлэлийг хэрэгжүүлсэн. Явган зорчигчийн болон дугуйн шинэ зам тавьсан боловч Улаанбаатар хотод явган зорчих, дугуйтай явах нь таатай бус, явган зорчигч, дугуйчдын хувьд замын үүлзвар дээр хамгаалалт, дохиоллын систем дутмаг байдгаас болж явган

болон дугуйтай зорчиход аюултай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар болон Улаанбаатар хотын захирагчийн алба зам тээврийн дэд бүтцэд хөрөнгө оруулснаар шийдвэрлэгдэх зарим асуудлуудыг харгалзан үзсэн. Одоогийн шийдлүүд нь хотын гол замуудыг өргөтгөх, гүүр барих зэрэг замын дэд бүтцийн ажлуудад төвлөрч төлөвлөсөн байдлаар бүтээн байгуулалт хийж байна.

141. Орон сууцжуулах бодлого зээлийн хүү болон мортгэйжийн татаасын хязгаарлагдмал үр нөлөөнөөс хамаарч ахиц муутай байна. Дэлхийн банкны судалгаагаар мортгэйжийн зах зээл Монголд одоог хүртэл хөгжсөөр байгаа ба 2010 оны байдлаар орон сууц эзэмшигчдийн ердөө 10 хувь нь мортгэйжийн зээлтэй гэж гарчээ. Орон сууцанд оршин суугчдын 20-оос багагүй хувь нь мортгэйжийг ашигладаг. Бодлогын гол асуудал нь Улаанбаатар хотын гэр хорооллын ихэнх оршин суугчид Засгийн газраас татаасын хөтөлбөрийн хүрээнд санхүүжилтээр дэмжсэн орон сууцыг худалдан авах чадваргүй.⁶⁹ Энэхүү худалдан авах чадварын асуудалтай холбоотой бага өртөгтэй орон сууц, хямд нийтийн түрээсийн орон сууц зэрэг хувилбаруудыг цаашид судлууштай.⁷⁰

Энэ нь зөвхөн зарцуулалтын асуудал биш юм: эрүүл мэнд, боловсрол болон орон сууцны төсвийн санхүүжилт

142. Монгол улсын эрүүл мэнд болон боловсролын салбарын зарцуулалтын хэмжээ нь жишиж буй бүлгийн улсуудтай харьцуулахад дунд зэрэг байна. Монгол Улсад эрүүл мэндийн салбарын нийт зарлага нь ДНБ -ий 4.4 хувьтай тэнцэж байгаа нь (Тимор Лестед 1.1 Сербид 10.0 хувьтай тэнцэх), жишиж буй бүлгийн улсуудын болон дэлхийн дундаж түвшинд ойр (Тимор Лестэд 1.1 хувь Шведэд 11.9 хувь байна) байна.⁷¹ Хувийн хэвшлийн зардлууд нь нийт 45 хувийг эзэлдэг бөгөөд энэ нь жишиг бүлгийн улсуудын болон (Тиморын хувьд 10 хувьтай, Азербайжанд 79 хувьтай) дэлхийн дундажид ойр хэмжээнд байна. Эрүүл мэндийн зардал нь жишиж буй бүлгийн улс орнуудтай ижил түвшинд байгаа ч Монгол Улсад халдварт бус өвчин илүү их тархалттай байдаг тул үүнээс шалтгаалж зарцуулагдах ёстой хэмжээнээсээ бага санхүүжилтийг зарцуулж байна.⁷²

143. Нийтийн боловсролын салбарт эрүүл мэндийн салбарын зардалтай ижил төстэй төлөв байдал ажиглагдаж байна. Боловсролын салбарын зарцуулалт Монгол Улсад ДНБ ний 4,6 хувьтай тэнцэж, жишиж буй улсуудын бүлэг дунд (Азербайжанд 2.4 хувь, Молдавт 8.1 хувь) болон дэлхийн түвшинд (Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад 1.2 хувь нь Зимбабве улсад 8.4) дундаж түвшинд ойр байна.

144. Дэд бүтцийн салбарт оруулах хөрөнгө оруулалт нь харьцуулалт хийсэн улс орнуудын дундаж түвшингээс доогуур байна. Нийт нэмүү өртөг шингэсэн ажил, үйлчилгээнд барилгын салбарын эзлэх хувь хэмжээ нь Монголд 2.0 хувь байгаа нь жишиг

⁶⁹ Татвар, шилжүүлэх тогтолцооны дэвшилттэй холбоотой Дэлхийн Банкны судалгаагаар 2016 он гэхэд валютын хүүгийн түвшинд татаас олгодог (энэ нь 8 буюу 5 хувь хүртэл хөнгөлөлттэй зээлийн хүүтэй Зах зээлийн хүү 20 орчим байна) нь үнэмлэхүй, харьцангуй нэр томъёог хоёуланг нь шатлан шинжлэх цөөн програмуудын нэг юм (Freije and Yang 2018). Зураг 17 харна уу.

⁷⁰ (Kamata, et al. 2010) Харна уу

⁷¹ 52011-2015 оны 5 жилийн дундажийг АХХБГ-аас авсан тоо баримтыг ашиглан тооцоолсон. Бид гадуурхалыг (жишээ нь, АНУ, Маршаллын арлууд, Микронези, Тувалу нар эрүүл мэндийн зардалд 13 хувиас дээш, Микронезийн боловсролын зардалд 12 хувь).

⁷² (Dugee, et al. 2017) Харна уу.

бүлгийн улсуудаас хамгийн доод түвшинд байгаа бөгөөд хамгийн сайн гүйцэтгэлтэй улсуудын түвшингээс маш хол байна: Армен, Азербайжанд 13 хувь нь, Тимор Лестед 18 хувь нь, Замбид 20 хувь байна. Барилгын салбар дахь нэмүү өртгийн доогуур түвшин нь нийтийн аж ахуйн үйлчилгээ, зохистой орон сууцны хүртээмжийн түвшин доогуур байгаа мөн, дээр дурьдсанчлан тээвэрлэлт, ложистикийн дэд бүтэц хязгаарлагдмал байгаатай холбоотой юм (II-р хэсэгт энэ талаар дурьдсан).⁷³

145. Зөвлөлдөх хэлэлцүүлгийн үеэр ихэнх оролцогч талууд боловсролын ач холбогдлыг онцлон тэмдэглэж байсан. Ур чадварын зөрүүтэй асуудлын талаар (жишээ нь, хөдөлмөрийн зах зээл дээр үр бүтээлтэй ажлын байр олдох чадвартай төгсөгчдийн дутагдалтай байдал) Улаанбаатар, Дархан, Орхон, Хэнтийгээс оролцсон хэд хэдэн бүлгүүд дурдаж байсан. Эдгээр оролцогчдын зарим нь иргэний боловсрол дутагдалтай байгаа талаар дурьдсан нь засаглалын ерөнхий асуудал, авилгын талаархи ойлголттой илүү холбоотой байх шиг байна. Гэвч сонирхолтой нь, эрүүл мэндийн асуудлуудыг оролцогч талуудын зөвлөлдөх хэлэлцүүлгийн үеэр ихэвчлэн дурдаагүй. Харин Ховд аймагт хийсэн уулзалтын үеэр сонирхлын бүлгүүд нь малчид, уурхайчид зэрэг тодорхой ажил мэргэжлүүдтэй холбоотой эрүүл мэндийн асуудал хүндэрч байгааг дурдаж байсан. Эцэст нь, Улаанбаатар хотын захиргааны ажилтнууд хотын дэд бүтцийн ач холбогдол, төрийн үйлчилгээний хүртээмжийг онцлон дурьдаж байсан. (Хавсралт 2: Оролцогч талуудтай зөвлөлдөх хийсэн хээлцүүлэг үзнэ үү). Цаашлаад хэлэлцүүлэгт оролцогчид боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон эрүүл мэндийн асуудлуудыг хөгжлийн гол асуудлуудаар хамгийн ихээр дурдаж байсан. Харин ус, ариун цэврийн байгууламж, зам, тээвэр, хот байгуулалт зэрэг нь хамгийн бага дурдагдсан асуудлууд байсан. (Зураг А2 1-ийг үзнэ үү).

Хайрцаг 3: Монгол дахь засаглалын асуудал: Клиентелизм ба авилгын хямрал

1990-ээд оноос хойш Монголын улс төрийн томилгоо нь нам дамжсан хувийн ашиг сонирхлын сүлжээнд суурилсан клиентелизмын өрсөлдөөн рүү маш ойртож байна. Энэ нь хөгжилд хүчтэй үр дагавар бий болгож байна. Нэгдүгээрт, өрсөлдөөн бүхий улс төрийн популист амлалтуудын хүрээнд мөнгө тараах хөтөлбөрүүд бий болсон. Хоёрдугаарт, нөөцийн баялгийн асуудлаарх үндсэрхэг үзэл өргөжиж, гадаадын уул уурхайн компаний капиталтай холбоотойгоор шинэ гэрээ, хэлэлцээр, түрээсийн хэмжээг өөрчлөх тухай саналаа шууд тулгадаг. Энэ нь мөн тендер болон Чингис, Самурай бонд зэрэг санхүүгийн шинэ хэрэгслээр дамжуулан улсын орлого, бизнесийн боломжийг хадгалах зорилготой байна. Гуравдугаарт, төсвийн санхүүжилтээр хийгддэг хэт их санхүүжилттэй ("гахайн махны баррель") жижиг төслүүдийн дарамт шахалт нэмэгдсэн нь УИХ-ын гишүүдийг орон нутгийн тойргууддаа ашигтай байлгах боломжийг олгож байна. Дөрөвдүгээрт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсан төсвийн хязгаар тогтоож өгсөн хэдий ч төсвөөс гадуурх зардлууд нэмэгдсээр байгаа ба төсвийн мөчлөг дагасан төсвийн бодлогыг хязгаарлаж чадахгүй хэвээр байна. Тавдугаарт, яамнаас их хэмжээний түрээсийн төлбөр тооцоонд хяналт тавьдаг аливаа бүлэглэлтэй холбоотой улс төрийн эрсдлээс үүдэн дэд бүтцийн томоохон төслүүдэд санхүүжилт олгогдоогүй байна. Нөөцийн өсөлт, уналтын мөчлөгтэй холбоотой клиентелистик тохиролцоо болон гэрээний

⁷³ 2011-2015 оны 5 жилийн дундажийг АХХБГ-аас авсан тоо баримтыг ашиглан тооцоолсон.

хэлэлцээрт илэрч харагддаг эрх мэдлийн шат дараалал нь улс төрийн томилгоо, гадуурхал болон клиентелизм гэх мэт ховор бүтцийг бий болгодог байна (Дэлхийн Банк 2017).

Азийн сангаас 2017 онд хийсэн авилгын судалгаагаар Монголын төрийн байгууллагуудад итгэх итгэл дутмаг, ялангуяа улс төрийн институциудад итгэх итгэл маш бага байгааг баримтаар дурдсан байна. Судалгаанд оролцогчдын 86.7% нь авилга бол түгээмэл байдаг гэж үзсэн; ойролцоо хувь нь улс төрчид авилгатай тэмцэх, ашиг хонжоо олохгүй байх хүсэл байхгүй байна гэж үзсэн; эцэст нь их авилгын хамгийн чухал шалтгаан нь улс төр, бизнесийн ашиг сонирхол нэг болсон явдал юм. 2010 оныхоос ялгаатай нь үндэсний засгийн газар, хууль тогтоогчид, улс төрийн намууд (уул уурхайн салбар, газрын асуудалтай холбоотой) хамгийн их авилгад өртдөг байгууллагууд гэж үнэлэгдсэн байна. Бэлчээрийн эдийн засгийн хувьчлал, хот суурингийн хурдацтай өсөлт, газар тариалангийн хувьчлал, томоохон хэмжээний олборлолтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг эдийн засгийн өөрчлөлт хэрэгжихийн зэрэгцээ уул уурхай ба газар хуваарилах үйл явц (гэрээ, лиценз, зөвшөөрөл) нь хувийн ашиг сонирхлыг өдөөх эх сурвалжууд байх нь гайхах зүйл биш юм. Гэвч улс төрийн институциуд авилгын гол эх сурвалжууд болж байгаа нь -нам, засгийн газар, хууль тогтоох байгууллагууд 2006 онд авилгын эх сурвалжид тооцдоггүй байсан, олон нийтийн улс төрийн байгууллагуудад итгэх итгэл сул, төрийн байгууллагуудын чадавх сул байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдагсдын бараг гуравны хоёр нь авилга өмнөх 3 жилийн хугацаанд огцом өссөн гэж үзсэн байна.

Өрсөлдөөнт клиентелизмтай холбоотой зардлууд нь улсын хөрөнгө оруулалт, нийгмийн шилжүүлгүүд, нөөцийн (экологийн) тогтвортой байдлыг хангахтай холбоотой засаглалын гол сорилтуудад тод харагддаг. 2004 оны баялгийн нөөцийн өсөлтийн нэг үр дагавар нь нөөцийн өсөлт ба нийгмийн чигл хандлага, зорилтот бүлгийн асуудлаарх парламентын өргөн хүрээтэй, өргөтгөсөн хэлэлцүүлэг байв. Үнэ өссөн явдал нь 2004 оны сонгуулийн кампанит ажлын үеэр ардчилсан намаас хүүхэд бүрт мөнгө хуваарилах санал санаачлагыг дэвшүүлэн улмаар засгийн мэдэл эвслийн засгийн газарт шилжсэнээр 2005 онд батлагдсан. 2006 онд гэнэтийн ашгийн татвар буюу зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар бий болсноор (зэс мөн алтны үйлдвэрлэл) Засгийн газар бүх хүүхдэд (Хүүхдийн мөнгөний хөтөлбөр, ХМХ) хүүхдийн мөнгө олгох болсон. Нийгмийн баялгийн нөөцийн үр ашгийг бүх иргэддээ хуваарилах зарчим баримталж бэлэн мөнгө тарааж, амлалтаа биелүүлэх болсон. Гэсэн хэдий ч бэлэн мөнгөний шилжүүлэг нь улс төрийн хэд хэдэн зорилгыг биелүүлсэн: нэг талаас улс орны ядуурлын төлөв байдлыг харгалзан ард түмний баялгийг нийтэд түгээх эрэлт хэрэгцээг хангахын зэрэгцээ хөдөө орон нутагт намын нэр дэвшигчид нийгмийн хуваарилалтаар дамжуулан нэр хүндээ дээшлүүлсэн. Нийгмийн амлалт болон бэлэн мөнгөний шилжүүлэг нь өрсөлдөөнт орчинд санал хожиход чиглэгдсэн байдаг боловч бодлогын болон төлбөрийн хувьд ихээхэн эрсдэлтэй байдаг (Фриц 2014). Сонгуулийн эдгээр амлалт, нийгмийн хөтөлбөрүүд нь төсөвт ихээхэн дарамт учруулж байсан. Сонгууль бүрээр шинэ хөтөлбөр, мөнгө амлаж байсан. Төсвийн орлого хэлбэлзэж 2008-2009 оны эдийн засгийн хямралын үеэр нийгмийн амлалтууд буурсан байна.

Нийгмийн амлалтын өсөн нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэхийн тулд улс төрчид уул уурхайн орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байсан нь тогтворгүй бөгөөд

өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл байсан нь нотлогдож байна. Оюу Толгой уурхайн гэрээнд гарын үсэг зурсны дараа 2009 онд ашигт малтмал ашигласны төлбөр авч эхэлсэн нь шинэ Хүний Хөгжлийн Сангийн суурийг тавьсан. ХХС аас 2010-2012 онд нийт иргэн бүрт 0.5 сая төгрөгийн бэлэн мөнгө, 1 сая төгрөгийн тэтгэмжийг оюутнууд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон. 2012 оны 6 дугаар сар хүртэл ХМХ-өөс мөнгөн тэтгэмжийг олгохыг зогсоосон% Нэвч Нийгмийн халамжийн тухай хуульд заасан ядуурлыг бууруулах зорилтот бүлэгт олгохын оронд 2012 оны 10-р сараас эхлэн ХХС аас хишиг хувь болгон хүүхэд бүрт мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн. Энэхүү хууль нь одоог хүртэл хэрэгжихгүй хэвээр байна. Эдгээр нийгмийн хөтөлбөрүүд ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан гэдэгт эргэлзээ байгаа бөгөөд энэхүү хөрөнгийг ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүдэд зарцуулагдсан тохиолдолд ядуурлын түвшинд үзүүлэх нөлөөлөл нь илүү их байж болох юм.

Монголын бэлэн мөнгө тараах хөтөлбөрүүд нь эхнээсээ гүнзгий улс төржсөн байсан бөгөөд хэд хэдэн чиглэлээр нөөцийн баялаг нь бэлэн мөнгө болон дуусдаг. Сонгуулийн амлалтад үндэслэн төлбөрийн хуваарилалт хийж байсан тул санхүүжилтийн хэмжээ болон нөөцийн орлогын уялдаа холбоо сул байсан бөгөөд үр дүнд нь мөнгөн хуваарилалт нь ашигт малтмалын орлогоос давсан; ХХС-ийн хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд зээл авах шаардлагатай болсон. 2010 онд нийт шилжүүлсэн мөнгөн гуйвуулга нь 324 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад гурав дахин нэмэгдэж, ХХС ийн уул уурхайн үйл ажиллагаанаас олсон ногдол ашиг, татвар, ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогоос бараг хоёр дахин их байна. 2011 онд сар тутам хийдэг тогтмол шилжүүлэг хийж эхлэхэд ХХС-ийн жилийн зарлага эргэн хоёр дахин нэмэгдэж 800 сая төгрөгт хүрсэн нь ХХС ийн жилийн ногдол ашиг, татварын орлого буюу 300 сая төгрөгөөс даруй илүү гарсан байсан. Энэ хоёр жилд шаардагдсан санхүүжилтийн зөрүүг зээл авч шийдвэрлэсэн. (Yeung and Howes 2015). 2016 оды Хүний хөгжлийн санг татан буулгаж, шинэ Ирээдүйн өвийн сан (хөрөнгө оруулалтаас хуримтлуулах засгийн газрын баялгийг санхүүжүүлэх сан) байгуулж 2017 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. ХМХ-ийг улсын төсвийн санхүүжилтээр үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Удирдлагын хамтын ажиллагаа, зохицуулалтын доголдол - улс төрийн шалтгаанаар институцийн үндсэн үйл ажиллагаа доголдож байгаагийн илрэл нь Монголын нийгмийн халамжийн хөтөлбөрийн чадавхыг гүйсгэсэн юм.

Нийгмийн бодлогын үр нөлөөтэй мөчлөг

Нийгмийн бодлого дахь бодлогын үр ашгийн мөчлөгийг шинжлэн судлахад функциональ гол асуудал бол төсвийн тогтворгүй байдал, урсгал зардлын алдагдлаас үүдэлтэй бөгөөд нийгмийн өр төлбөрийг нэмэгдүүлж, нийгмийн бодлогод зарцуулж буй зардлууд нь урт хугацааны туршид хүмүүнүн хуримтлал, хүн амын амьжиргааны түвшинг доройтуулж байгааг харуулж байна. Энэхүү зохицуулалт нь энэхүү хайрцагны догол мөрөнд дурдсаны дагуу Монголын улс төрийн шинж чанарыг тодорхойлдог өрсөлдөөний клиентелизмтэй холбоотой юм. Бодлогын санаачлагууд ба шинэчлэл нь үр дүнтэй үйлчилгээ хүргэх, авилгатай тэмцэх, төсвийн хариуцлагыг шаардахад чиглэгдсэн иргэний нийгэм, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг бэхжүүлэхэд чиглэгдэх ёстой.

Үйл ажиллагааны бэрхшээлүүд	Чанартай, тууштай бус бодлого, нөөцийн орлоготой үялдаа холбоогүй, төлбөр хийх зохион байгуулалттай бөгөөд найдваргүй амлалт, зардал, шилжүүлгийн тогтворгүй өсөлт, төсвийн хямрал багатай, дараа нь төсвийн орлогын алдагдлыг их хэмжээний зээлээр нөхөх
Эрх мэдлийн тэгш бус байдал, улс төрийн нэгдлүүд	Улс төрийн элит эвсэл популист стратегийг хэрэгжүүлдэг. УИХ-ын гишүүд, намын нэр дэвшигчид хүн амы ихтэй хөдөөгийн орон нутагт дэмжлэг авах зорилгоор бэлэн мөнгө тараадаг. Нөөцийн баялгийг хуваалцах зорилго бүхий иргэний хүчтэй шахалт. Өрсөлдөөнт клиентелизм ба сонгуулийн мөчлөг нь зардлын тэлэх дарамтыг бий болгодог
Шинэчлэлийн хүчин	Үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. Авилга болон хариуцлагын асуудалд анхаарлаа төвлөрүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих. Эрдэс баялгийн орлогыг удирдахын тулд засгийн газрын баялгийг бүрдүүлэх элит хөшүүргийг ашиглах (Ирээдүйн өвийн сан)

Эх үүсвэр: Эшлэл (Watts 2017)

IV ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ СТРЕССИЙГ БУУРУУЛАХ

146. Монгол улсад сүүлийн жилүүдийн эдийн засгийн гол үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчны стрессийн зарим үзүүлэлттэй холбоотой байж болно. Уул уурхайн салбарын өсөлт нь тус улсад нүүрлэсэн CO₂-ийн ялгаралтыг эрчимтэй нэмэгдүүлж байгаа болон сүүлийн 10 жилд нүүрстөрөгчийн бүтээмж хурдацтай бүүрч байгаагийн гол хүчин зүйл юм. Мал аж ахуйн үйл ажиллагаа, мал сүрэг нь бэлчээрийн доройтлыг үүсгэж байна. Дээрх хоёр үйл ажиллагаа нь ус ашиглалт, улсын зарим хэсэгт усны хэрэглээний стрессийг бий болгож байдаг. Улс орон хурдацтай хотжиж байгаас агаарын бохирдол нэмэгдэж, үерийн гамшиг, хотын зарим хэсэгт газар хөдлөлтийн эрсдэлд өртөх магадлал өсөж, агаарын бохирдолтой холбоотой өвчний өвчлөлийн түвшин нэмэгдэж байна. Иймд улс орны эдийн засгийн өсөлтийг ногоон өсөлт гэж нэрлэж болохгүй юм.

147. Энэхүү өсөлтийн загвар нь нийт баялгийг нэмэгдүүлж, нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийн доройтлыг бий болгосон. Сүүлийн жилүүдэд Монгол улсын нэг хүнд ногдох нийт баялаг өсөн нэмэгдэж байгаа боловч байгалийн баялаг шавхагдаж байна. Гэхдээ энэ өсөлт капиталын бүх хэлбэрт ажиглагдаагүй байна. Хүмүүн капитал, нөхөн сэргээгдэхгүй байгалийн капитал нэмэгдэж байгаа боловч гадаад цэвэр актив, нөхөн сэргээгдэх байгалийн капитал доройтож байна. Энэ доройтол нь хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын үйл ажиллагаатай холбоотой явдал юм. Түүнчлэн, хүрээлэн буй орчны нөхцөлтэй холбоотой үүсч буй эрүүл мэндийн эрсдлээс шалтгаалан хүрээлэн буй орчин болон эрүүл мэндийн нийт зардал 2005 оноос хойш өсч, 1990 оныхоос ч илүү өндөр болсон байна.

148. Хүрээлэн буй орчны стрессийг зогсоох зохицуулалт, институцийг хөгжүүлэхэд улс орны зүгээс ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч олон нийтийн идэвхитэй оролцооноос гадна холыг харсан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нэг талаас байгалийн баялгийг ашиглах, үр шимийг хүртэх асуудалд ашиг сонирхлын зөрчил байнга гардаг тул ил тод хэлэлцэж байх ёстой. Нөгөөтэйгүүр, олон нийт болон бодлого боловсруулагчдын мэдлэг хязгаарлагдмал байгаа нь эдгээр хүндрэл бэрхшээлийг даван туулахад бэрхшээлтэй байгаа бөгөөд хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд зохистой бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн геополитик зан үйлийг харуулж байна.

Тогтвортой байдлын үр дүн: Монгол улсад ногоон өсөлт бий юу?

149. "Ногоон өсөлт" ийг тайлбарласан өвөрмөц тодорхойлолт байдаггүй боловч эдийн засгийн өсөлтөд байгалийн нөөцийг ашиглахад үзүүлэх нөлөө, цаашлаад эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшнийг тогтвортой байлгах гэсэн тайлбарын талаарх нэгдсэн ойлголт өргөжиж байна. Дэлхийн банкны сүүлийн үеийн тайланд дурдагдсан тодорхойлолтоор бол ногоон өсөлт гэдэг нь: "... байгалийн баялгийг ашиглахад үр ашигтай, мөн бохирдол, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг багасгах хэмжээнд цэвэр, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны менежмент, байгалийн капиталын гүйцэтгэх үүрэг зэргээс шалтгаалан бие байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх байгалийн капитал юм" гэж тодорхойлжээ. Эдгээр бүх зорилтуудыг нэг шалгуур болгон хэрхэн нэгтгэх тухай зөвшилцөлд хүрээгүй байгаа тул хэд хэдэн үзүүлэлтийг гарган ирж, ногоон өсөлтийг⁷⁴ хэрхэн хэмжих талаар хэлэлцүүлэг өрнөж байна. Энэхүү дүн шинжилгээ нь дээрх үзэл баримтлалын дагуу ерөнхий дүр зургийг харуулахын тулд хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг ашиглана. Үүнд: нүүрстөрөгчийн үр ашиг, газар ашиглалт, ус, агаарын эх үүсвэрийг ашиглах, хүн амын хүрээлэн буй орчин, гамшгийн эрсдлийг бууруулах зэрэг болно.

150. Монголын эдийн засгийн нүүрстөрөгчийн ялгаруулалтын хэмжээ сүүлийн арван жилд ихээхэн нэмэгдсэн байна. Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий ялгаруулалтын хэмжээ ижил түвшний улсуудтай харьцуулахад 90-ээд оны үе болон 2000-аад оны эхэн үеэс бараг хоёр дахин өсч, 2005 оноос хойш бараг 4 дахин өсч, бусад улс орнуудын дунд хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Зураг 18, дээд зүүн самбар). Үүний зэрэгцээ нүүрстөрөгчийн бүтээмж (жишээ нь, үйлдвэрлэсэн CO₂-ын үйлдвэрлэсэн кг тутмын бодит ДНБ-ний үнэ цэнэ) хурдацтай буурч, бусад ижил түвшний улс оронтой харьцуулахад бага түвшинд байна. (Зураг 18, дээд баруун самбар). Өнгөрсөн 10 жилийн хугацаанд уул уурхайн экспортыг амжилттай дэлгэрүүлсэн нь улс орны нүүрстөрөгчийн ялгаруулалтын хэмжээний өөрчлөлтийг тайлбарлаж буй гол хүчин зүйл бөгөөд энэ нь зарим нэг эрдэс баялаг экспортлогч жишиг орнуудтай адил (жишээ нь, Казахстан) байгаа бол бусад экспортлогчдоос ялгаатай байна (жишээ нь, Азербайжан, Боливи, Колумб).

151. Монгол улс нь газар ашиглалтын хувьд одоог хүртэл өргөн уудам хэвээр байгаа боловч бэлчээр их хэмжээгээр доройтож байгаа нотолгоо байна. Сүүлийн жилүүдэд ой мод сүйтгэх асуудал нэмэгдээгүй байгаа нь бусад улс орнуудаас ялгаатай байна (Зураг 18,

⁷⁴ See for instance the World Bank, OECD, United Nations Environment Program and the Global green growth Institute initiative on data and information: Green Growth Knowledge Platform. (<http://www.greengrowthknowledge.org/>). Another attempt to gauge how economic growth affects the stock of natural resources is in the World Bank's publication, the Changing Wealth of Nations (<https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/29001/9781464810466.pdf>)

дунд зүүн самбар). Гэхдээ энэ дүгнэлт нь төөрөгдөлтэй байж болох юм. Учир нь Монголд ойн асуудал бус харин бэлчээртэй холбоотой асуудал эрсдэлтэй байдалд байна (энэ талаар дэлгэрэнгүйг энэ хэсгийн үлдсэн хэсэгт авч үзэх болно). Үүнээс гадна тусгай хамгаалалттай газар нутаг багагүй хувийг эзэлдэг боловч эдгээр газрын ихэнх хэсэг уул уурхайн үйл ажиллагааны хэтийн өргөжилттэй харшилж байгаа талаар дараа дараагийн хэсэгт авч хэлэлцэх болно (Зураг 18, дунд баруун талын самбар).

152. Усны нөөц ашиглалт ба агаарын бохирдлын үзүүлэлтүүдийг олон улстай харьцуулалахад Монгол Улс онцгойрон муу гүйцэтгэлтэй харагдахгүй байгаа боловч үндэсний дундаж болон улс хоорондын харьцуулалтыг төөрөгдүүлж магадгүй юм. Усны хэрэглээний хувьд үндсэн жишиг улс орнуудтай харьцуулахад Монгол улс нэг хүнд ногдох цэвэр усны нөөц маш бага байна (Зураг 18, доод зүүн самбар). Гэтэл улсын зарим хэсэг, ялангуяа нийслэл, өмнөд говийн бүс нутгийн усны хэрэглээг дотоодын нийлүүлэлттэй харьцуулахад богино хугацаанд нийслэл, дунд хугацаанд өмнөд говийн бүс усны хомсдолд орж болзошгүй байна. Үүний нэгэн адил, амьсгалын замд гүн нэвтэрч, эрүүл мэндэд маш ноцтой хохирол учруулдаг 2.5 микроноос бага хэмжээтэй тоосонцорын агууламжтай агаарын бохирдолд өртсөн хүн амын тоогоор бусад жишиг улс орнуудтай харьцуулахад дунд хавиар жагсаж байна (Зураг 18, доод баруун талын самбар). Гэсэн хэдий ч нягтаршил багатай, нутаг дэвсгэрийн хэмжээ том учир энэ тоо нь мөн төөрөгдөлтэй байж болно. Нийслэл хотын агаарын бохирдол нь Дэлхийн хэмжээнд хамгийн муу үзүүлэлттэй байгаа бөгөөд хүн амын эрүүл мэндэд үзүүлэх ноцтой нөлөөлөл, эдийн засгийн хөгжилд саад тотгор учруулж болзошгүй юм. Энэ талаар сүүлийн хэсэгт илүү дэлгэрүүлэн авч хэлэлцэх болно. 2015 онд Монгол улсын агаарын бохирдлыг DALY-ийн 10 үндсэн шалтгаануудын нэгт багтаасан байна (хөгжлийн бэрхшээлийн улмаас тохируулсан амьдралын жил, өвчний улмаас нас барах, тахир дутуу болох, эрт нас барснаас шалтгаалсан өвчний дарамтыг хэмжих).⁷⁵

153. Сүүлийн жилүүдэд Монгол улсад байгалийн гамшигийн давтамж болон цаг уурын өөрчлөлтийн нэмэгдэж байна. Зүд болох “зүд гэдэг нь өвлийн улирлын гамшиг бөгөөд их хэмжээний цас орох, хүйтэн ширүүн болох болон байгалийн бусад хүнд нөхцлийн улмаас байгалийн гамшиг болж малын тэжээлгүй болох, эсвэл мал тэжээлдээ хүрэх замыг хаах зэргээр мал хорогдох үзэгдлийг нэрлэнэ.”⁷⁶ үзэгдэл давтамж сүүлийн 20 жилийн хугацаанд нэмэгдэж байгаа нотолгоо байдаг. (Хүснэгт 6). Мөн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дундаж температур нэмэгдэж буйг зарим судлаачид нотолсон байдаг. Үүнээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учирж, улмаар хөдөөгийн хүн ам, малчдын амьжиргааны эх үүсвэрт сөргөөр нөлөөлж байна.⁷⁷

Тогтвортой байдлын тулгамдсан асуудлууд: Монгол улс байгалийн баялгийн капиталaa хуримтлуулж байна уу?

154. Монголын эдийн засгийн гурван хүндрэлтэй асуудлын нэг нь өсөн нэмэгдэж буй хүрээлэн буй орчны стресс юм. Өмнөх хэсэгт дурдсанчлан, Монгол улс нүүрсхүчлийн хийн

⁷⁵ Эрүүл мэндийн хэмжүүр ба үнэлгээний хүрээлэн, <http://www.healthdata.org/mongolia> (accessed July 9, 2017).

⁷⁶ (Fernández-Giménez, Batkhisig and Batbuyan 2012)

⁷⁷ (Batima 2006).

хэмжээг бууруулахад амжилт гаргаагүй, бэлчээрээ алдсан, усны асуудалтай тулгарсан зэргээс гадна, дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын нэг болжээ. Үүний зэрэгцээ тус улсад гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа бөгөөд эдгээрийн зарим нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байж магадгүй юм. Дахин хэлэхэд, Diversified Development analytical framework буюу Төрөлжсэн хөгжлийн дүн шинжилгээний үр дүнгээс харахад, тус улс эдийн засгийн бодит хуримтлал бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Монгол улс байгалийн баялагтай улсын хувьд баялгийн капиталаас санхүүгийн, биет болон хүмүүнүн хуримтлал үүсгэх шаардлагатай юм. Цаашлаад эдгээр нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэн зохицуулах чадавх бүхий байгууллага байх шаардлагатай юм.

155. Хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангахад бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагуудаас алсыг харсан бодлого боловсруулах, одоогийн болон шинээр хэрэгжих хууль тогтоомж, зохицуулалтыг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үрт хугацааны хэтийн төлөвийг хангахад чиглэсэн асуудлуудыг хууль ёсны дагуу шийдвэрлэх нь чухал юм. Байгал орчныг хамгаалах, байгалийн нөөцийн менежмент, хууль тогтоомжийн хэрэгжилт Монгол улсад сул байгаа талаар ерөнхий ойлголт байдаг бөгөөд үүнийг нотолсон судалгаанууд байдаг. Усны эх үүсвэрийн хомсдол, өсөн нэмэгдэж буй агаарын бохирдол, бэлчээрийн доройтол болон өмнөх хэсэгт дурдсанчлан гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа нь төлөвлөлтийн бодит нөлөөлөл, хууль тогтоомжийн хэрэгжилт хэр зэрэг байгаа талаар асуудал дагуулж байна. Зарим тохиолдолд асуудлын цар хүрээ, зардал (жишээ нь, УБ хотын агаарын бохирдол) хурдацтай ахиц дэвшилд саад болдог. Бусад тохиолдолд нийгмийн ялгаатай бүлгүүд хоорондын уялдаа холбоо, улс төр, эдийн засгийн зөрчилдөөн (жишээлбэл, Өмнөговь аймаг дахь усны хэрэглээ) зэрэг нь улс орны байгалийн баялгийн үнэ цэнийг иргэд, хөгжлийнхөө төлөө ашиглахад саад болж байна.

156. Монгол улсын СДШ нь дээрх асуудал бүрт дүн шинжилгээ хийж, Монгол улсын эдийн засагт учирч буй саад тотгоруудыг авч үзсэн болно. Агаарын бохирдол, газрын доройтол, ус нөөцийн хомсдол, эрчим хүчний нөөцийн дутагдал зэрэг нь зөвхөн иргэдийн эрүүл мэндэд төдийгүй эдийн засгийн ирээдүйн боломжид сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

Ус: хөдөө аж ахуй, уул уурхай, хотууд, усны эрэлт бүгдэд байна.

157. Монгол Улс нь усны хомсдолтой орон бөгөөд нийт усны хэрэглээ нь нөхөн сэргээгдэх усны хангамжаас давсан буюу ихэнхдээ жилийн дүнгээр хамгийн багадаа 50 хувийн үзүүлэлттэй байна.⁷⁸ Хэрэгцээт усыг газрын доорхи усны нөөцөөр хангаж байгаа боловч тэдгээр нь нөхөн сэргээлт хийгддэггүй тул усны хомсдол цаг хугацаа өнгөрөх тусам нэмэгдэх болно. Уурхайн олборлолт, хүнд үйлдвэрлэлийн зөвшөөрлүүд нэмэгдэхийн хирээр усны эрэлт хэрэгцээ өсөх хандлагатай байна. Энэ зууны эхээр 3000 усны эх үүсвэр, үүнээс 680 гол горхи, 760 нуур ширгэсэн гэж бүртгэгджээ. Говь цөлийн хээрийн бүс жил бүр хойд зүг рүү өргөжин шилжиж байна. Эрдэмтэд илүү их газар нутаг говь цөлийн бүсэд хамаарагдах болж, ялангуяа зүүн бүс болон хээрийн бүс, хойд зүгт тархаж магадгүй гэж таамаглаж байна (АХБ, 2014).

⁷⁸ Харна уу http://www.fao.org/nr/water/aquastat/countries_regions/MNG/

158. Эдийн засгийн үйл ажиллагаа, хотжилтын улмаас усны нөөцөд сөргөөр нөлөөлж буйг зарим судалгаагаар анхааруулж байна. Монгол улсын усны нөөцийн хүртээмжийг 2030 Усны Нөөцийн Бүлэг тоймлон гаргасан бөгөөд энэ нь усны нөөц, эрэлт хэрэгцээний хувьсал өөрчлөлт нь маш ноцтой усны нөөцийн алдагдалтай газар нутгийг бий болох магадлалтайг харуулсан юм. Уг судалгаагаар Улаанбаатар хотын усны нөөцийн хүртээмжийг судалж үзэхэд тус хот нь боломжит нөөцөө ашиглаж, бага эрэлтийн хувилбараар 2024 он гэхэд усны эх үүсвэрийн хомсдолд орох үзүүлэлттэй байхаар тооцоолжээ. Өмнийн Говийн бүсэд хийсэн судалгаагаар ижил төстэй байдал ажиглагдаж, усны эрэлт нийлүүлэлт нь бага эрэлтийн хувилбараар 2030 он гэхэд дөнгөж хангагдах бөгөөд 2025 он гэхэд эрэлт нийлүүлэлтийн зөрүүтэй байдал үүснэ. (Зураг 19 ийг харна уу, зүүн дээд ба баруун панел) Мөн Говийн бүсэд Дэлхийн банкны Уул бурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын туслалцаа (MINIs) төсөл нь тус улсын 3 сав газарт усны нөөцийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн, гүний усны нөөц, ашиглалтын талаарх мэдээллийг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. Энэхүү төлөвлөгөө нь хараахан олон нийтэд зарлагдаагүй байгаа хэдий ч говийн бүсийн зарим дэд сав газрын ус ашиглалтын зөвшөөрөл бүхий үйлдвэрлэл явуулж буй газруудад усны нөөцийн хомсдол үүсэх магадлалтай байна. 2030 усны нөөцийн бүлгийн судалгаагаар газрын доорх усны талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул 29 сав газрын 22-д газрын доорх усны судалгаа хийх шаардлагатай гэж үзсэн байна.

159. Уул уурхайн салбар нь усны нөөцөд онцгой нөлөө үзүүлж байна. 2006 оны 5 дугаар сард Дэлхийн банк уул уурхайн салбарын хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг судалсан ба ус зүйн горим өөрчлөх нь ноцтой асуудал гэж үзсэн бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа нь гадаргын болон газар доорхи усыг үр ашиггүй хэт ихээр ашигладаг бөгөөд хэт их бохирдол үүсгэж байгааг дурджээ.⁷⁹ Жижиг хэмжээний уурхайн олборлолтын үйл ажиллагаа усны чанарт муугаар нөлөөлж, томоохон болон дунд хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй уурхайн хаягдал чулуулгийн овоолго, хаягдлууд нь ноцтой асуудал болж байсан байна. 2016 оны дөрөвдүгээр сард хэвлэл мэдээллийнхэн уул уурхайн салбар усны нөөцийг хэтрүүлэн хэрэглэж байгаа талаар мэдээлж байсан бөгөөд зарим уул уурхайн компаниуд давсархаг, гүний ус буюу "чулуужсан ус" -ыг хэрэглэдэг гэсэн боловч бодит байдал дээр өөр байна⁸⁰.

100	03	Ажил эрхлэлт,	Хөдөлмөрийн орлогын хувь. (үндэсний орлогын хувь)	Ажилтнуудын цалингийн ДНБ-д эзлэх хувь. Ажилчдын нөхөн олговрыг Үндэсний дансны систем (ҮТС) D.1-аар ДНБ-ийг В.1 дансаар хэмжинэ. Ажилтны цалин хөлс нь бэлэн мөнгө болон мөнгөн бус хэлбэрээр хийгддэг. Түүнчлэн ажилчдад үзүүлэх үр өгөөжийг бий болгох нийгмийн даатгалын тогтолцоонд төрөөс оруулсан хувь нэмрийг оруулна.	Дэлхийн Банк, Дэлхийн хөгжлийн тайлан 2013UNDATA, http://data.un.org .	http://data.worldbank.org/data-catalog/wdr-2013-jobs

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
10	04	Ажил эрхлэлт, Нийгмийн хамгаалал	Ажилчдын бодит орлогын бодит дундаж, жилийн өсөлт. (%)	Ажиллагсдын бодит сарын дундаж өсөлт гэдэг нь бодит дундаж цалингийн жилийн өсөлт (эсвэл буурсан) жилээр тодорхойлогддог. Ажилчдын цалин нь тухайн улс орны хэрэглээний үнийн индексээр тодорхойлогдсон ажилтнуудад төлсөн нийт цалин хөлс, ажилласан хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсгүй ажилласан цаг, цалин хөлстэй ажилласан хугацааны цалин хөлстэй, жилийн амралт гэх мэт, бусад төрлийн цалин хөлс, амралтын өдөр. Орлого нь нийгмийн даатгалын шимтгэл, тэтгэврийн тогтолцоонд төлсөн ажилчдын хувьд ажил олгогчийн оруулсан хувь нэмэр, эдгээр схемийн хүрээнд ажилчдын хүлээн авсан тэтгэмжийг хасч тооцдог. Орлого нь мөн ажлаас чөлөөлөх, цуцлах зардлыг хасч тооцдог. Орлогын статистик нь ажилтнуудын нийт цалин хөлстэй холбоотой, өөрөөр хэлбэл ажил олгогчид ямар нэгэн хасалт хийхээс өмнө нийт дүнг хэлнэ.	Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас 2014-2015 оны дэлхийн цалингийн тайлан	http://www.ilo.org/ilostat/GWR? afrL oop=133895 5075782656 & adf.ctrl- state=k1d4c5 2do 4#%40 %3F afrLoop %3D1338955 075782656% 26 adf.ctrl- state%3Dp6t 8y7cns 4
10	05	Labor and	Нийгмийн даатгалын хамрах хүрээ (2010). (ажил эрхэлж буй хүн амын%)	Ахмад настны тэтгэврийн тогтолцоонд идэвхитэй хувь нэмэр оруулж буй ажиллах хүчний хувь.	Дэлхийн хөгжлийн тайлан 2013	http://data.worldbank.org/data-catalog/wdr-2013-jobs

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
10	06	Ажил эрхлэлт, Нийгмийн хамгаалал	Хамгийн ядуу бүлэгт хамаарах тусламж хүртэгчид - Нийгмийн хамгаалал ба хөдөлмөр эрхлэлтийн бүх хөтөлбөрүүд. (нийт тусламж хүртэгсдийн хувь)	Хөтөлбөрт хамрагдагсдын тоог нийт хүн амд эзлэх тусламж хүртэгчдийн тоотой харьцуулахад эзлэх хувь. Энэ шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн төрлөөр, шилжүүлгийн дараах ба урьдчилан шилжүүлэх халамжийн хуваарилалтын аль алинаар нь тооцоолно. Хөтөлбөрүүдийг ASPIRE ангиллын дагуу нийгмийн тусламж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зах зээлд нэгтгэдэг. SPL хөтөлбөрийн бүх үзүүлэлтүүд нь нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зах зээлийн тоон үзүүлэлтүүдийн нийлбэрийг үзүүлэв. Тухайлбал, хүртэгсэдийн тоо нь (Тухайн хэсэгт амьдарч буй өрхийн дор хаяж 1 гишүүн нь SPL хөтөлбөрт хамрагддаг өрхүүдийн тоогоор) / (Хүн амын дундах SPL хөтөлбөрт оролцож буй хүмүүсийн тоо). Үзүүлэлт нь шууд болон шууд бус тусламж хүртэгчдийг хамарна.	Дэлхийн Банк, "Эрсдэл ба тэгш байдлын төлөө нийгмийн хамгааллын шалгуур үзүүлэлтүүдийн атлас" (ASPIRE)	http://datatopics.worldbank.org/aspiration

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
100	07	Ажил эрхлэлт, Нийгмийн хамгаалал	Хамрах хүрээ - Бүх нийгмийн хамгаалал ба хөдөлмөр. (%)	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хөтөлбөрт хамрагдсан хүн амын хувь (шүүд ба шүүд бус ашиг хүртэгсэд орно). Энэ шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн төрөл, нийт хүн амын хувьд, шилжүүлгийн дараах болон урьдчилан шилжүүлэх халамжийн хуваарилалтын аль алианаар нь тооцдог. Хөтөлбөрүүдийг ASPIRE ангиллын дагуу нийгмийн тусламж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зах зээлд нэгтгэдэг. SLP-ийн бүх үзүүлэлтүүд нь нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зах зээлийн тоон үзүүлэлтүүдийн нийлбэрийг үзүүлэв. Тухайлбал, хамрах хүрээ нь (хамгийн багадаа нэг гишүүн шилжүүлэг хүлээн авдаг өрхөд амьдарч буй өрхийн тоогоор). (Тухайн түвшний хүмүүсийн хувь тоо).	Дэлхийн Банк, "Эрсдэл ба тэгш байдлын төлөө нийгмийн хамгааллын шалгуур үзүүлэлтүүдийн атлас" (ASPIRE)	http://datatopics.worldbank.org/aspire/documentation
111	01	Нийгэм, Хот,	Цахилгааны хүртээмж, хот суурин газар. (хүн амын%)	Хот суурин газрын цахилгаан эрчим хочний хортээмж нь хот суурин газрын хүн амын эрчим хүчний хүртээмж юм	Дэлхийн Банк, Дэлхийн Банкнаас Бүх Тогтвортой Эрчим хүч (SE4ALL) мэдээллийн сан, Global Electrification мэдээллийн сан.	http://data.worldbank.org/indicator/EG.ELC.ACCS.UR.ZS

Дадлага	Үзүүлэлт	дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 1	0 2	Нийгэм, Хот,	Цахилгааны хүртээмж, хөдөө орон нутаг. (хүн амын%)	Хөдөөгийн хүн амын эрчим хүчний хангамжид эзлэх хувь.	Дэлхийн Банк, Дэлхийн Банкнаас хэрэгжүүлж буй Тогтвортой Эрчим хүчний (SE4ALL) мэдээллийн сан, Global Electrification мэдээллийн сан.	http://data.worldbank.org/indicator/EG.ELC.ACCS.RU.ZS
1 1	0 3	Нийгэм, Хот,	Шингэн түлшний хөдөө орон нутгийн хүртээмж (хөдөөгийн хүн амын%)	Хөдөөгийн хүн амын шингэн түлшний хэрэглээ.	Дэлхийн Банк, ДЭМБ-ын Дэлхийн Өрхийн Эрчим хүчний мэдээллийн сангаас бүх хүн бүхэнд зориулсан Тогтвортой Эрчим хүч (SE4ALL) мэдээллийн сан.	http://data.worldbank.org/indicator/EG.NSF.ACCS.RU.ZS
1 1	0 4	Нийгэм,	Шингэн түлшний хүртээмж, хот суурин газар (шингэн түлшний хэрэглээтэй хотын хүн амын%)	Шингэн түлшний хэрэглээтэй хотын хүн амын хувь.	World Bank, Sustainable Energy for all (SE4ALL) database from WHO Global Household Energy database.	http://data.worldbank.org/indicator/EG.NSF.ACCS.UR.ZS
1 1	0 5	Нийгэм,	Хотын хатуу хог хаягдлын хэмжээ (MSW) цуглуулсан. (Нийт MSW-ийн хувь)	Хотын хатуу хог хаягдлын хэмжээ (MSW) нийт MSW-ийн хувь хэмжээгээр цуглуулсан	Хаягдал атлас: 2013 оны тайлан, доорх хаягаар орж үзнэ үү: http://www.atlas.d-waste.com/	http://www.atlas.d-waste.com/

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 2	0 1	Худалдаа болон	Мэргэшсэн удирдлагын чадвар.	2005 оноос хойш Дэлхийн Эдийн Засгийн Форум нь Дэлхийн Өрсөлдөх чадварын индекс (GCI) -д өрсөлдөх чадварын шинжилгээнүүдээ үндэслэсэн бөгөөд үндэсний өрсөлдөх чадварыг микро эдийн засаг, макро эдийн засгийн суурийг хэмждэг цогц арга хэрэгсэл юм. Гүйцэтгэх санал асуулгын судалгаа (Судалгаа) нь энэ төрлийн хамгийн урт бөгөөд өргөн хүрээтэй судалгаа юм. Судалгаагаар дэлхийн өнцөг булан бүрт бизнес эрхлэгчдийн мэдээллийн эх сурвалжууд нь ховор буюу олон улсын түвшинд хүрч чаддаггүй өргөн хүрээний сэдвээр дэлхийн өнцөг булан бүрт бизнесийн удирдагчдын санал бодлыг тусгадаг. Судалгааны үр дүнг ГЕО болон бусад Форумын индекс тооцоонд ашиглана. Судалгааны 2014 оны 2-р сараас сараас 6-р сарын хооронд 148 орны 14,000 бизнесийн удирдагчдын саналыг авчээ. Судалгаанд хамрагдагсдаас дараах асуултыг 1-7 оноогоор үнэлэхийг хүссэн: "Танай улсад удирдах албан тушаалд хэн томилогддог вэ?" [1 = ихэвчлэн хамаатан садан, хамаатан садан, чадавхид суурилагагүй 7 = гол төлөв ач холбогдол бүхий мэргэжлийн менежерүүд, чадавхид суурилсан]	The Global Competitiveness Index is based on the result of the work of Sala-i-Martin and Artadi 2004. World Economic Forum, Executive Opinion Survey (2014)	http://report.s.weforum.org/global-competitiveness-report-2014-2015/introduction-2/

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 2	0 2	Худалдаа болон	ЭМ-ийн зах зээлийн төвлөрлийн индекс.	Hirschman Herfindahl индекс нь экспортлогч түншүүдийн хоорондох худалдааны үнийн тархалтын хэмжүүр юм. Маш цөөхөн зах зээл дээр төвлөрдөг худалдаатай (экспортын эсвэл импорт) орон нь индексийн утга 1-тэй ойролцоо байх болно. Үүнтэй адилаар, худалдаа нь төрөлжсөн, олон төрлийн худалдааны багцтай орон нь 0 индекстэй ойролцоо байна. Өгөгдлийн тэмдэглэл: 1) Экспортын өгөгдөлд Mirror экспортыг авч үзнэ. 2) Дэлхийн болон EUN-ээс бусад бүх улсуудыг түншлэлийн бүлэг гэж үздэг. 3) Энэхүү тооцоололд Бүтээгдэхүүний "Нийт" ашиглагддаг. 4) Энэ шалгуур үзүүлэлтийг тайлагнагч-түншлэлийн түвшинд тооцоолж, тайлагнагчийн түвшинд нэгтгэдэг.	Дэлхийн худалдааны нэгдсэн шийдэл (WITS) - НҮБ-ын Статистикийн хэлтэс (UNSD) Хамтран ажиллагч	http://wits.worldbank.org/CountryProfile/country/ALL/startyear/2009/endyear/2013/indicator/HH-MKT-CNCNTRTN-NDX

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 2	0 3	Худалдаа болон	Инноваци. (Индекс)	<p>Өрсөлдөх чадварыг өөр өөр өнцгөөс харахад дэлхийн өрсөлдөх чадварын индексийг бүрдүүлдэг 12 тулгуурт багтана. Инноваци нь технологийн болон технологийн бус шинэ мэдлэгээс үүсэлтэй. Технологийн бус шинэчлэл нь байгууллагад ноогдож буй ноу-хау, үр чадвар, ажлын нөхцлүүдтэй нягт уялдаатай байдаг тул GCI-ийн 11-р баганад хамардаг. Өрсөлдөх чадварын эцсийн тулгуур нь технологийн шинэчлэлд гол анхаарлаа хандуулдаг. Хэдийгээр институцийг сайжруулах, дэд бүтцийг бий болгох, макро эдийн засгийн тогтворгүй байдлыг бууруулах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах замаар олж авч чадсан хэдий ч эдгээр хүчин зүйлүүд нь эцэстээ буурч буй орлого болж байна. Хөдөлмөр, санхүүгийн, бараа бүтээгдэхүүний үр ашгийн хувьд мөн ижил байна. Урт хугацаанд амьдралын стандартыг технологийн шинэчлэлээр өргөжүүлж болно.</p>	<p>Дэлхийн өрсөлдөх чадварын индекс нь Сала-и-Мартин, Артада 2004 оны ажлын үр дүнд тулгуурласан болно. Дэлхийн эдийн засгийн форум, 2014-2015 дэлхийн өрсөлдөх чадварын индекс</p>	<p>http://report.s.weforum.org/global-competitiveness-report-2014-2015/methodology/</p>

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 2	0 4	Худалдаа болон	Экспортын зардал. (Контейнер, ам. доллар)	Зардлыг 20 тн контейнерт ногдох ам.долларын төлбөр, хураамжаар тооцоолно. Бүтээгдэхүүнийг экспортлох буюу импортлох горимтой холбоотой бүх төлбөр, хураамж багтсан болно. Эдгээрт бичиг баримт, гаалийн бүрдүүлэлт, техникийн хяналтын зардал, гаалийн зуучлагчийн хураамж, терминал барих төлбөр, дотоодын тээвэр зэрэг захиргааны зардал орно. Зардлын арга хэмжээ нь тариф болон худалдааны татварыг агуулдаггүй. Зөвхөн албан ёсны зардал бүртгэгдэнэ. Бизнес хэд хэдэн таамаглал дэвшүүлжээ: 60-аас дээш ажилтантай; Хамгийн олон хүн амтай хотод байрладаг; Хувийн, хязгаарлагдмал хариуцлагатай компани байна. Экспортыг боловсруулах бүс нутагт эсвэл экспортын тусгай зөвшөөрлөөр үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаггүй; Гадаадын өмчлөлгүй дотоодын; Борлуулалтын 10-аас дээш хувийг экспортлодог. Борлуулсан барааны талаархи таамаглал: Борлуулсан бүтээгдэхүүн бүрэн нь хуурай замаар, 20 фут, контейнерын ачаалалтай. Бүтээгдхүүн: Аюултай биш, цэргийн зүйлүүдийг оруулдаггүй; Хөргөх болон бусад тусгай орчин шаарддаггүй; Олон улсын стандартаас бусад ургамлын хорио цээрийн буюу хүрээлэн буй орчны аюулгүй байдлын стандартыг шаарддаггүй.	WITS - Дэлхийн Банк, Бизнес эрхлэх төсөл (http://www.doingbusiness.org/).	http://wits.worldbank.org/CountryProfile/country/ALL/startyear/2009/endyear/2013/indicator/IC-EXP-COST-CD

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 2	0 5	Худалдаа болон	Бараа, үйлчилгээний экспорт, импорт, (ДНБ-д эзлэх хувь)	Бараа, үйлчилгээний импорт (экспорт) нь дэлхийн бусад улсаас (борлуулсан) бүх бараа, зах зээлийн бусад үйлчилгээний үнэлэмжийг илэрхийлнэ. Үүнд бараа, ачаа, даатгал, тээвэр, аялал жуулчлал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр, харилцаа холбоо, барилга байгууламж, санхүү, мэдээлэл, бизнес, хувийн болон төрийн үйлчилгээ гэх мэт бусад үйлчилгээнд багтана. Тэд ажилчдын нөхөн олговор, хөрөнгө оруулалтын орлого (хуучин хүчин зүйл үйлчилгээ гэж нэрлэдэг), шилжүүлгийн төлбөрийг хасч тооцдог.	WDI. Экспортод ДНБ-д эзлэх хувиар, импортоор ДНБ-д эзлэх хувь.	http://data.worldbank.org/indicator/NE.EXP.GNFS.ZS http://data.worldbank.org/indicator/NE.IMP.GNFS.ZS
1 2	0 6	Худалдаа болон	Импортын зардал. (Контейнер, ам. доллар)	Зардлыг 20 футын контейнерт ногдох төлбөр, хураамжийг АНУ доллараар хэмждэг. Бүтээгдэхүүнийг экспортлох буюу импортлох горимтой холбоотой бүх төлбөр, хураамж багтсан болно. Үүнд баримт бичиг, гаалийн бүрдүүлэлт, техникийн хяналтын зардал, гаалийн зуучлагчийн хураамж, терминал боловсруулах зардал, дотоодын тээврийн зардал орно. Зардалд тариф болон худалдааны татварыг оруулахгүй. Зөвхөн албан ёсны зардал бүртгэгдэнэ.	Дэлхийн Банк, Бизнес эрхлэх төсөл (http://www.doingbusiness.org/).	http://wits.worldbank.org/CountryProfile/country/ALL/startyear/2009/endyear/2013/indicator/IC-IMP-COST-CD

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 3	0 1	Тээвэр ба МХТ	Гар утасны үүрэн захиалга. (100 хүнд ногдох)	Гар утасны үүрэн телефоны захиалга нь олон нийтэд ашиглагдсан утасны сүлжээнд хандах боломжийг олгодог үүрэн холбооны технологийг ашиглан нийтийн гар утасны үйлчилгээнд захиалга өгөх юм. Дараа төлбөртэй болон урьдчилсан төлбөрт захиалгыг багтаасан.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд Олон улсын цахилгаан холбоо, Дэлхийн цахилгаан холбоо / МХХТ-ийн хөгжлийн тайлан, мэдээллийн сан, Дэлхийн банкны тооцоо.	http://data.worldbank.org/indicator/IT.CEL.SETS.P2
1 3	0 2	Тээвэр ба МХТ	Нэг хүнд ногдох замын салбарын эрчим хүчний хэрэглээ. (Газрын тос тэнцүү)	Авто замын салбарын эрчим хүчний хэрэглээ гэдэг нь газрын тосны бүтээгдэхүүн, байгалийн хийн, цахилгаан эрчим хүч, шатамхай, сэргээгдэх эрчим хүч, хаягдал зэрэг замын салбарт ашиглагддаг нийт эрчим хүч юм.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд Олон улсын авто замын холбоо, Дэлхийн замын Статистик ба тэмдэглэсэн электрон файлууд, мөн Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA Статистик © ЭЗХАХБ / IEA, http://www.iea.org/stats/index.asp).	http://data.worldbank.org/indicator/IS.ROD.ENGY.PC
1 3	0 3	Тээвэр	Замын нягтрал. (100 км2 нутаг дэвсгэрт зам тавих km)		Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, wbopendata ашиглана	-

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 3	0 4	Тээвэр ба МХТ	Интернет хэрэглэгчид (100 хүнд ногдох)	Интернет хэрэглэгчид нь дэлхий даяарх сүлжээнд нэвтрэх эрхтэй хүмүүс юм.	Дэлхийн хөгжлийн индикаторууд Олон улсын холбооны холбоо, Дэлхийн цахилгаан холбоо / МХХТ-ийн хөгжлийн тайлан, мэдээллийн сан, Дэлхийн банкны тооцоо.	http://data.worldbank.org/indicator/IT.NET.USER.P2
1 4	0 1	Ус	Жилийн цэнгэг усны гарц, жилийн нийт дүн. (дотоодын нийт усны нөөцийн хувь)	Жил бүрийн цэнгэг усны гарц нь нийт усны гарцыг илэрхийлэх бөгөөд энэ нь ус нөөцлөх савнаас гарч буй ууршилтын алдагдлыг тооцохгүй. Зарим улс орнуудад ус цэвэршүүлэх үйлдвэрээс үйлдвэрлэсэн усыг их хэмжээгээр хэрэглэдэг тул үүнийг мөн багтаав. Нийт сэргээгдэх эх үүсвэрийн усны гарцын хэмжээ нь 100% -иас хэтрэх боломжтой. Учир нь сэргээгдэхгүй эх үүсвэрийн усны гарц эсвэл ус цэвэршүүлэх үйлдвэрийн усны гарц их хэмжээтэй байвал эсвэл усны хэрэглээ их хэмжээтэй байвал дээрх үр дүн гарах боломжтой. Хамгийн сүүлийн үеийн ашиглаж болох мэдээлэл 1987-2002 оных байна.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд. Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, AQUASTAT мэдээлэл, Дэлхийн Банк болон ЭЗХАХБ-ын ДНБ-ий тооцоо.	http://data.worldbank.org/indicator/er.h2o.fwtl.zs

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 4	0 2	Ус	Нэг хүнд ноогдох цэвэр усны жил бүрийн хэмжээ. 1000 хүн ам тутамд (тэрбум куб метр)	Жилийн цэнгэг усны гарц нь нийт усны гарцыг илэрхийлэх бөгөөд энэ нь ус нөөцлөх савнаас гарч буй ууршилтын алдагдлыг тооцохгүй. Зарим улс орнуудад ус цэвэршүүлэх үйлдвэрээс үйлдвэрлэсэн усыг их хэмжээгээр хэрэглэдэг тул үүнийг мөн багтаав. Нийт сэргээгдэх эх үүсвэрийн усны гарцын хэмжээ нь 100% -иас хэтрэх боломжтой. Учир нь сэргээгдэхгүй эх үүсвэрийн усны гарц эсвэл ус цэвэршүүлэх үйлдвэрийн усны гарц их хэмжээтэй байвал эсвэл усны хэрэглээ их хэмжээтэй байвал дээрх үр дүн гарах боломжтой. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны гарц гэж нийт усалгааны систем, мал аж ахуйн үйлдвэрлэл, үйлдвэрлэлд шууд ашиглахыг (дулааны цахилгаан станцыг хөргөхөд ашигласан усыг багтаана) хэлнэ. Дотоодын хэрэглээнд ашиглах нь ундны ус, орон нутгийн хэрэгцээ, нийлүүлэлт, нийтийн үйлчилгээ, аж ахуйн нэгж, өрх гэрт ашиглах усыг хэлнэ. Хүн амын өгөгдлийг Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдээс авав.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд. Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, AQUASTAT мэдээлэл, Дэлхийн Банк болон ЭЗХАХБ-ын ДНБ-ий тооцоо.	http://data.worldbank.org/indicator/ER.H2O.FWTL.K3
1 4	0 3	Ус	Усны бүтээмж, нийт. (Тогтмол 2010 оны цэвэр усны нийт куб метрээр, ам.доллар)	Усны бүтээмжийг жилийн нийт усны эргэлтээр хувааж, ДНБ-ний тогтмол үнээр тооцно.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд. Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, AQUASTAT мэдээлэл, Дэлхийн Банк болон ЭЗХАХБ-ын ДНБ-ий тооцоо.	http://data.worldbank.org/indicator/ER.GDP.FWTL.M3.KD

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
14	04	Ус	Усны дарамттай сав газарт амьдардаг хүн амын эзлэх хувь, 2010. (хүн амын%)	Суурь усны дарамтыг хэмжихэд жилийн нийт урсацын хувиар илэрхийлэгддэг жил бүрийн усны зарцуулалт (хот, аж үйлдвэр, хөдөө аж ахуй). Илүү үнэ цэнэ нь хэрэглэгчдийн дунд өрсөлдөөнийг илтгэнэ. Ус багатай хуурай газар нутгийг саарлаар харуулсан боловч нэгтгэсэн оноог тооцохдоо өндөр дарамтаар үнэлсэн. (Gassert ба бусад 2013: 8).	CIESIN-ийн Дэлхийн хүн амд зориулсан хүн амын тоо, 2010 он: 2010 Олон улсын газарзүйн шинжлэх ухааны мэдээллийн төв - CIESIN - Колумбийн их сургууль. 2014. Дэлхийн хүн ам, 4-р хувилбар (GPWv4), урьдчилсан хувилбарын 2 (2010). NY Палисадес. http://www.ciesin.columbia.edu/data/gpw-v4 WRI-ийн гол сав газрын гол сөрөг хүчин зүйл, с2010: Gassert, F., M. Landis, M. Luck, P. Reig, T. Shiao. 2013. "Aqueduct Global Maps 2.0". Ажлын баримт бичиг. Вашингтон, ДС: Дэлхийн нөөцийн институт.	http://www.wri.org/publication/aqueduct-metadata-global

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 4	0 5	Ус	Хаягдал усыг цэвэршүүлэх. (нийт усны%)	Бохир ус цэвэрлэх байгууламж (WASTECXN) –Хүний үйл ажиллагаанаас бохирдсон цэвэршүүлэх шаардлагатай усны бохирдлын хувь	Эх сурвалж: Malik, O. (2013). Үндэсний хэмжээнд бохир ус цэвэрлэх эмчилгээний олон улсын мэдээллийн сан. New Haven, CT: Байгаль орчны хууль ба бодлогын Yale төв.	http://epi.yale.edu/content/water-resources-raw-data-file
1 4	0 6	Ус	Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж. (хөдөөгийн хүн амд эзлэх хувь)	Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж нь (хот, хөдөө) нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хүн амын эзлэх хувь юм. Сайжруулсан ариун цэврийн байгууламжууд нь ариутгах татуурга / бохир ус зайлуулах суваг, (бохирын систем, жорлон), агааржуулалттай сайжруулсан нүхэн (VIP) жорлон, нүхэн хавтан жорлон, бордоо жорлон зэрэг багтана.	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх ДЭМБ / ЮНИСЕФ-ийн хамтарсан хяналтын хөтөлбөр (JMP) (http://www.wssinfo.org/ / "}).	http://data.worldbank.org/indicator/SH.STA.ACSN.RU
1 4	0 7	Ус	Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж, хот суурин газар. (хот суурин газрын хүн амд эзлэх хувь)	Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж нь (хот, хөдөө) нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хүн амын эзлэх хувь юм. Сайжруулсан ариун цэврийн байгууламжууд нь ариутгах татуурга / бохир ус зайлуулах суваг, (бохирын систем, жорлон), агааржуулалттай сайжруулсан нүхэн (VIP) жорлон, нүхэн хавтан жорлон, бордоо жорлон зэрэг багтана.	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх ДЭМБ / ЮНИСЕФ-ийн Хамтарсан хяналт шинжилгээний хөтөлбөр (JMP) (http://www.wssinfo.org/ / "}).	http://data.worldbank.org/indicator/SH.STA.ACSN.UR

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 4	0 8	Ус	Сайжруулсан усны эх үүсвэр, хөдөө орон нутаг. (хөдөөгийн хүн амд эзлэх хувь)	Сайжруулсан усны эх үүсвэрийн хүртээмж нь (хот, хөдөөгийн аль нь ч) ундны усны эх үүсвэрийг хэрэглэж буй хүн амын эзлэх хувь. Сайжруулсан ундны усны эх үүсвэр нь ундны усны эх үүсвэрээс ус дамжуулах шугам хоолой (хэрэглэгчийн орон сууц, хашаа, талбайд байрлуулсан ахуйн ус дамжуулах шугам хоолой) болон бусад сайжруулсан ундны усны эх үүсвэр (нийтийн цорго, хоолой, цооног, цооног, хамгаалагдсан булаг, хамгаалагдсан булаг, мөн борооны ус цуглуулах).	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх ДЭМБ / НІБ-ын Хүүхдийн хөдөлгөөний хяналт шинжилгээний хамтарсан хөтөлбөр (JMP): http://www.wssinfo.org	http://data.worldbank.org/indicator/SH.H2O.SAFE.RU.ZS
1 4	0 9	Ус	Сайжруулсан усны эх үүсвэр, хот суурин газар. (хот суурин газрын хүн амд эзлэх хувь)	Сайжруулсан усны эх үүсвэрийн хүртээмж нь (хот, хөдөөгийн аль нь ч) ундны усны эх үүсвэрийг хэрэглэж буй хүн амын эзлэх хувь. Сайжруулсан ундны усны эх үүсвэр нь ундны усны эх үүсвэрээс ус дамжуулах шугам хоолой (хэрэглэгчийн орон сууц, хашаа, талбайд байрлуулсан ахуйн ус дамжуулах шугам хоолой) болон бусад сайжруулсан ундны усны эх үүсвэр (нийтийн цорго, хоолой, цооног, цооног, хамгаалагдсан булаг, хамгаалагдсан булаг, мөн борооны ус цуглуулах).	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх ДЭМБ / НІБ-ын Хүүхдийн хөдөлгөөний хяналт шинжилгээний хамтарсан хөтөлбөр (JMP): http://www.wssinfo.org	http://data.worldbank.org/indicator/SH.H2O.SAFE.UR.ZS

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 5	0 1	Жендэр	Ажиллах хүчний оролцооны түвшин, нийт (нийт хүн амын 15+ хувь)	Ажиллах хүчний оролцооны түвшин нь эдийн засгийн идэвхтэй 15 ба түүнээс дээш насны хүн амын хувь хэмжээ юм. Тухайн хугацаанд бараа, үйлчилгээг үйлдвэрлэхэд хөдөлмөр эрхэлдэг бүх хүмүүс.	Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ILOSTAT мэдээллийн сан. 2017 оны 11-р сард авсан ОУХБ-ын Ажиллах хүчний тооцоо, тооцоо 2017 оны эхээр гарсан.	http://data.worldbank.org/indicator/SL.TLF.CACT.ZS
1 5	0 2		Ажиллах хүчний оролцооны түвшин, эмэгтэй (нийт хүн амын 15+ хувь)	Ажиллах хүчний оролцооны түвшин нь эдийн засгийн идэвхтэй 15 ба түүнээс дээш насны эмэгтэй эмхүн амын хувь хэмжээ юм. Тухайн хугацаанд бараа, үйлчилгээг үйлдвэрлэхэд хөдөлмөр эрхэлдэг бүх хүмүүс.	Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ILOSTAT мэдээллийн сан. 2017 оны 11-р сард авсан мэдээлэл.	http://data.worldbank.org/indicator/SL.TLF.CACT.FE.NE.ZS
1 5	0 3		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох хувь,	Тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын түвшин гэдэг нь тухайн жилд шинэ төрсөн хүүхэд 5 нас хүрэхээс өмнөх нас баралтын 1000-д ногдох магадлал юм.	Тооцоолол НҮБ-ын Хүүхдийн эндэгдлийн үнэлгээний бүлэг (НҮБ-ын ХС, ДЭМБ, Дэлхийн Банк, НҮБ-ын ХЭТ-ийн хүн амын хэлтэс) -аас гаргасан www.childmortality.org вэбсайтаас боловсруулсан.	http://data.worldbank.org/indicator/SH.DYN.MORT.FE

Дадлага	Үзүүлэлт	Дадлага	Үзүүлэлт	Үзүүлэлтийн тодорхойлолт (Тайлбар & Аргачлал)	Мэдээллийн эх сурвалж	Холбоос
1 5	0 4		Төрөх үеийн хүйсийн харьцаа (нэг эмэгтэйд ногдох эрэгтэй төрөлт)	Төрөх үеийн хүйсийн харьцаа нь нэг эмэгтэй төрөлтөд ногдох эрэгтэй төрөлт юм Өгөгдөл нь 5 жилийн дундаж үзүүлэлт юм.	НҮБ-ын Хүн амын хэлтэс Дэлхийн хүн амын хэтийн төлөв.	http://data.worldbank.org/indicator/SP.POP.BRTH.MF
1 5	0 5		Ажил олгогч, эмэгтэй (эмэгтэй ажил эрхлэлтийн хувь)			
1 5	0 6		Эмэгтэй удирдлагатай байгууллага (компаний%)			
1 5	0 7		Цалин, хөлстэй ажилчин, эмэгтэй (эмэгтэй ажил эрхлэлтийн хувь)			
1 5	0 8		ЖСАХ-ийн дутагдалтай хэрэгцээ (15-49 насны гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь)			

Хавсралт 2: Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт

i. Оршил

Монгол Улстай түншлэх стратеги болон Монгол Улс: цогц дүн шинжилгээг боловсруулахад нэг чухал алхам болох оролцогч талуудтай хийх зөвлөлдөх уулзалтуудыг 2017 оны 8 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 6 хүртэл Улаанбаатар хот болон 5 аймагт зохион байгууллаа. Эдгээр уулзалтын үеэр Монгол Улсын хөгжил, тулгамдсан асуудлууд, тэргүүлэх чиглэлүүд, мөн Дэлхийн Банкны дэмжлэг нь ядуурлыг тогтвортой бууруулж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахад хамгийн том нөлөө үзүүлэх чиглэлүүдийн талаар санал солилцов.

Нийтдээ ойролцоогоор 400 оролцогчтой хорин таван уулзалт зохион байгуулав. Улаанбаатар хотод Засгийн газар, Улсын Их Хурал, хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ), эрдэм шинжилгээний байгууллагууд, үндэсний болон олон улсын хувийн хэвшлийнхэнтэй уулзалтуудыг тус тус зохион байгуулсан. Монголын дөрвөн бүс нутаг дахь олон талуудын үзэл бодлыг судлахын тулд Ховд, Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Хэнтий аймгуудад орон нутгийн засаг захиргаа, ИНБ-үүд, хувийн хэвшлийнхэнтэй уулзалтуудыг зохион байгууллаа. Санал авах үйл ажиллагаанд олон талын өргөн цар хүрээтэй оролцогч талуудыг хамруулахын тулд уулзалтууд болон цахим хуудсыг аль алиныг ашигласан болно.

Нүүр тулсан уулзалтыг нэгдсэн хуралдаан, хэлэлцүүлэг, шаардлагатай тохиолдолд бүлгийн ярилцлага хийж улмаар хөндлөнгийн төвийг сахисан чиглүүлэгчтэйгээр нэгтгэн тайлагнах замаар (жишээ нь, Улаанбаатар дахь ИНБ-үүдийн өргөн хүрээтэй уулзалт гэх мэт) зохион байгуулав. Бүх ярилцлага "Чатхам Хаус Дүрэм" –ийн дагуу буюу "... оролцогчид хүлээн авсан мэдээлээ чөлөөтэй ашиглах боломжтой, гэхдээ ингэхдээ илтгэгч болон бусад оролцогчийн нэр, харьяаллыг ил гаргахгүй" гэсэн зарчмыг дагав. Ингэснээр оролцогчдын дунд нээлттэй байдал, мэдээлэл солилцох явцыг дэмждэг. Түүнчлэн уулзалтад оролцогчид тэдний санал бодлыг тоон үзүүлэлтээр дүгнэх богино хугацааны судалгаанд оролцсон.

Бусад сонирхогч талуудын оролцоог хангахын тулд англи, монгол хэл дээрх онлайн судалгааг цахим хуудсанд байршуулж, түгээсэн. Үүний зэрэгцээ иргэд ил захидал бөглөх байдлаар Монголын ирээдүйн алсын харааны талаарх санал бодлоо хуваалцах боломжийг бүрдүүлж, Дүжингарав дахь олон нийтэд үйлчлэх төв болон уулзалтын газруудад байрлуулсан.

Энэхүү хавсралт нь хоёр хэсэгтэй. Үүнд: эхнийх нь уулзалтын үеэр оролцогчдын санал, бодлын чанарын тойм; Хоёрдугаарт, уулзалтын үеэр оролцогч талуудаас авсан судалгааны статистик тойм болон цахим хуудсанд байршуулсан нээлттэй судалгааны тойм орж байна. Зохиогчид Монголын хөгжлийн талаархи санал бодлоо хуваалцсан оролцогч бүх талуудад талархаснаа илэрхийлж байна. Энэхүү хавсралтыг боловсруулсан зохиогчид, уг эхийг Монгол Улсын хөгжлийн гол сорилтуудын талаарх оролцогч талуудын бүх үзэл бодлыг бүрэн дүүрэн эсвэл төгс илэрхийлсэн гэж үзээгүй болно. Энэхүү эх нь оролцогч талуудын

үзэл бодлын хязгаарлагдмал товч хураангуй бөгөөд бид тухайн үед өрнөсөн хэлэлцүүлэг, яриаг аль болох үнэн зөв, бүрэн дүүрэн буулгахыг зорьсон болно. Энэ текстэнд алдаатай тайлбар эсвэл буруу тайлбар хийсэн бол энэ нь зөвхөн зохиогчдын буруу юм.

ii. Зөвлөлдөх уулзалтаар илэрхийлсэн гол саналын хураангуй

Улаанбаатар дахь судлаач, эрдэм шинжилгээний байгууллагууд, 2017 он 8-р сарын 30

Улаанбаатар дахь эрдэм шинжилгээний ажилтан, судлаач нар Монгол Улсад урт хугацааны хөгжлийг хангахын тулд засаглал, төрийн албаны тулгамдсан асуудлуудыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. Засаглалын одоогийн тулгамдсан асуудлуудын үндэс нь улс төрийн явцуу ашиг сонирхол болон улс төрийн бүлгүүд өөрсдийн хувийн ашиг сонирхлын төлөө ажилладаг оршиж байгаа бөгөөд энэ нь цаашлаад төрийн албаны халаа сэлгээ, институцийн ой санамж доройтох, урт хугацааны хөгжлийн бодлого алдагдахад хүргэж байна. Тиймээс төрийн албаг улс төрөөс хараат бус бөгөөд үр чадварт суурилсан болгох чиглэлээр шинэтгэл хийх, түүнчлэн улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох замаар засаглалын асуудлуудыг шийдэж болно гэсэн саналууд гарав.

Нөгөөтэйгүүр удаа дараа гарч буй алдаатай бодлого шийдвэрүүд, улс төрийн үймээн самуун нь олон нийтийн дунд иргэний боловсрол бага байгаатай холбоотой. Иргэдийн сэтгэлгээ, ёс суртахууны доройтол нь урт хугацааны тогтвортой ажлын байраас илүүтэйгээр богино хугацаанд хууль бус замаар орлого олох боломж болон бэлэн мөнгөний халамжийг эрэлхийлж байгаагаар илэрч байна. Оролцогчид мөн төрийн байгууллагууд, ИНБ, хөгжлийн түншүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд нь олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, нөлөөллийн кампанит ажил явуулах, мэдээллийн үнэн зөв байдлыг хянах/үнэлэх мэргэжлийн институцуудыг бий болгох болон эрдэм шинжилгээний байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээрийг бусад талуудтай илүү уялдаа холбоотой ажилладаг болгох тал дээр урт хугацааны хүчин чармайлт гарган ажиллах хэрэгтэйг онцлов.

Эрдэм шинжилгээний байгууллагуудын онцлон тэмдэглэсэн бас нэг сэдэв бол Монголын хөдөө аж ахуйн салбарт өдгөө тулгамдаж буй сорилт бэрхшээл болон цаашдын хөгжлийн боломж юм. Салбарын хөгжилд асар их боломж байгаа хэдий ч хүнсний аюулгүй байдлын зохих стандарт байхгүй (эсвэл түүний хэрэгжилт хангалтгүй) байгаагаас эрсдэл үүсч байна. Салбарын хөгжилд тулгарч буй бэрхшээлүүд нь технологи, экспортын зах зээл, дэд бүтэц, малын эрүүл мэндийн асуудал дутагдалтай байна. Хөдөө аж ахуйн экспортыг дэмжих бодлогын зөв арга хэмжээ нь экспортын зах зээлийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаархи олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, малын бэлчээрийг хамгаалах зорилгоор татвар ногдуулах шаардлагатай байна. Зарим эрдэм шинжилгээний байгууллагууд мөн дундаж давхаргыг бэхжүүлэх, бизнесийн хөгжлийг дэмжих үүднээс мега компаний үйл

ажиллагааг сонгосон салбаруудад хязгаарлах, зээлийн хүүг бууруулах боломжийг судлах санал гаргав.

Дэлхийн Банкны дэмжлэгтэй хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь иргэний боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, инновацийг дэмжих, хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих (шинэ технологи, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох / эрсдлийг бууруулах) зэргийг санал болгож байна. Уул уурхайн салбарт хувийн хэвшлийн санхүүжилт хүрэлцээтэй байдгийг харгалзан, тус салбарт Дэлхийн Банкны оролцоо хязгаарлагдмал байх ёстой гэж зарим оролцогчид үзсэн. Гэвч зарим нь уул уурхайн салбарын засаглалын асуудлуудад Дэлхийн Банк анхаарлаа хандуулахыг санал болгосон байна.

Засгийн газартай хийсэн үүлзалт, 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Засгийн газрын агентлагууд, салбарын яамдын төлөөлөл эдийн засгийн төрөлжилт, хүртээмжтэй өсөлтөд тулгарч буй сорилтуудыг онцолсон. Уул уурхайгаас хамааралтай байгаа байдал нь сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг тогтворгүй, байнгын хэлбэлзэлд оруулж, улмаар засаглалыг сулруулсан байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд уул уурхайн бус салбарын хөдөлмөрийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүч, мэдлэгт суурилсан экспортын баримжаатай үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийг төрөлжүүлэх бодлого боловсруулах нь зүйтэй.

Засгийн газрын төлөөлөгчид засгийн газрын бүх түвшний зохицуулалт, менежментэд хамааралтай асуудлуудыг онцолсон. Институтын асуудлуудад Засгийн газрын нэгдсэн мэдээллийн сан, мэдээллийн төвийн үйл ажиллагаа сул байгаа, мөн байгууллага хоорондын үялдаа холбоо сул байгааг жишээ болгож, төрийн албан хаагчдын халаа сэлгээ их, авилга, эгэх хариуцлагын тогтолцоо сул байгаа нь улс төртэй холбоотой байна гэж үзжээ. Бодлого төлөвлөлтийн чадавх дутагдалтай байгаагаас шалтгаалан нотолгоонд суурилсан урт хугацааны бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг дэмжих хэрэгцээ шаардлага байгааг дурьдсан.

Ядуурлыг бууруулах, хамтын хөгжил цэцэглэлийг нэмэгдүүлэхэд хөдөөгийн хөгжил, хүний хөгжлийн цогц стратегийн ач холбогдлыг мөн хэлэлцэв. Хөдөө аж ахуйн бизнес, түүний экспортыг хөгжүүлэх, улмаар бэлчээр, усны менежмент, малын эрүүл мэнд, гамшгийн эрсдэлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл гэх мэт хүрээлэн буй орчны асуудлуудыг судалж үзэх замаар хөдөөгийн амьжиргааг дэмжих зорилго бүхий хөдөөгийн хөгжлийн стратеги хэрэгтэй. Эрүүл мэнд, боловсролын салбарын хөрөнгө оруулалт, тэр дундаа сургуулийн өмнөх боловсрол, хоол тэжээл, эрүүл мэнд зэрэг нь дараагийн үеийг

ядуурлаас гаргахад шийдвэрлэх ач холбогдолтой юм. Зарим оролцогчид хүн амын насжилт, нийгмийн халамжийг ядууст чиглүүлэх хэрэгцээ шаардлагыг тэмдэглэж байсан.

Дээр дурьдсан бүх чиглэлүүдэд Дэлхийн Банкнаас үзүүлэх тусламж дэмжлэгийг чиглүүлэх боломжтой хэмээн санал болгож байсан. Үүний зэрэгцээ бүх салбарт олон төрлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхийн оронд сонгогдсон гол чиглэлүүдэд төвлөрч, илүү тодорхой, хэмжигдэхүйц үр дүн гаргахад анхаарах нь зүйтэй гэв. Дэлхийн Банкны зүгээс Засгийн газар, хувийн хэвшлийнхэн, хөгжлийн түншүүдийг нэгтгэж илүү их хөшүүрэг болж өгөхийг мөн санал болгов.

Иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн үүлзалт, Улаанбаатах хот, 8 дугаар сарын 31

Тус үүлзалтын эхний хэсэгт Монголын хөгжлийн зам өнгөрсөн хугацаанд зөв явсан эсэх талаар хэлэлцүүлэг өрнөсөн. Оролцогчид тэгш бус байдал, улс төрийн тогтворгүй байдал нэмэгдэж, нийгэм дэх шударга бус байдал өсөж буйг тэмдэглэв. Зарим ИНБ-үүд ардчилал нийгэмд ашиг тусаа өгөөгүй, ядуурлыг бууруулсангүй гэж үзэж байсан. Харин зарим ИНБ - үүд ардчилал, зах зээлийн эдийн засагт тайван замаар шилжин орсноос хойш Монголын хөгжилд олсон ололт амжилтыг сайшаан тэмдэглэж, хүмүүсийн амьжиргааны түвшин дээшилсэнг дурьдаад, зарим хүмүүсийн амьжиргааны түвшин шилжилтийн үеийн түвшнээс дээшлээгүйгээс ядуурал нэмэгдэж байгаа гэсэн ойлголттой байна. Авилга, шударга бус байдал, засаглалын асуудлууд улс төрөөс үүдэлтэй тул улс төрийн намын санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Иргэний нийгмийн сул дорой байдал, иргэдийн боловсрол муу байгаа нь тулгамдсан асуудал болохыг байнга дурьдаж байв. Санхүүжилт, чадавх дутмаг байдгаас иргэний нийгмийн байгууллагууд нийгмийг төлөөлж чаддаггүй буюу ард түмэн, Засгийн газар хоорондын гүүр болон ажилладгийн улмаас Засгийн газрын үйл ажиллагаанд төдийлөн хяналт тавиж чадаггүй байна. ИНБ-үүд нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүдийг бэхжүүлэх, иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх мөн олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх кампанит ажил зохион байгуулах зэрэг зарим олон нийтэд чиглэсэн төрийн үйлчилгээг хүргэх ажлыг ИНБ-үүдээр хийлгэх боломжтойг хэлж байв. Боловсролын салбарын хувьд, Монгол Улс дахь академик сургалтын чанар ерөнхийдөө сайн байгаа хэдий ч ёс зүйн боловсрол, иргэний боловсрол, нийгмийн эрүүл мэндийн талаарх боловсрол гэх мэт бусад чухал асуудлууд орхигдсоноос өнөөгийн нийгэмд үүсээд буй олон асуудлуудыг үүсгэж байгааг тэмдэглэв. Санхүү, хөрөнгө оруулалтын хувьд боловсролын үйлчилгээний шинэ дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ихээхэн хувийг эзэлж байгаа бөгөөд цаашид багшийн боловсролын тогтолцоонд хөрөнгө оруулах, уг тогтолцоог шинэчлэхэд анхаарах шаардлагатай байна гэв.

Уулзалтын үеэр онцолсон бусад асуудлууд нь эдийн засгийн төрөлжилт, хүрээлэн буй орчны хамгаалал, хувийн хэвшлийн хөгжил юм. Байгаль орчны салбарын ИНБ-үүд уул уурхайн үйл ажиллагаанаас болж хүрээлэн буй орчны доройтолд орж, уламжлалт нүүдэлчин аж амьдралын хэв маяг алдагдаж байгаад санаа зовниж байлаа. Бусад ИНБ-үүд хувийн хэвшлийг хөгжүүлэх болон банкны салбарын хөгжилд чухал ач холбогдол өгч байсан. ТХХТ-ийн үйл ажиллагаа нь Монголд авилгын томоохон эх сурвалж болж байна гэж үзэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байгааг дурдсан.

Дэлхийн Банкны түншлэлийн хүрээнд цаашид засаглал, нийгмийн эгэх хариуцлагыг сайжруулах, иргэний боловсролыг дээшлүүлэх, эдийн засгийн төрөлжүүлэх, хүний капиталыг бий болгох, хувийн хэвшлийг хөгжүүлэх зэргийг санал болгож байв. Оролцогчид нь Дэлхийн Банкны дэмжлэгтэй төслүүдийн хэрэгжилтийн талаар хэд хэдэн саналуудыг хэлсэн. Үүнд: (i) төслүүдийг байгаль орчны хамгийн сайн стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх, (ii) төслийг хэрэгжүүлэхээс өмнө өргөн хүрээнд зөвлөлдөх, байгаль орчны үнэлгээ хийх, (iii) хэрэгжүүлсэн төслүүдийн тогтвортой байдлыг хангах, салбарын тогтвортой байдлыг хангах шинжилгээний ажлыг үргэлжлүүлэх, (iv) Монголд хэрэгжиж буй Дэлхийн Банкны төслүүдийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.

[Үндэсний хувийн хэвшлийнхэнтэй хийсэн уулзалт, Улаанбаатар хот, 2017 оны 8 дугаар сарын 31](#)

Уулзалтын үеэр институцийн үр ашиггүй зохицуулалтууд, үялдаа холбоогүй бодлогууд, авилга, хүнд суртлын асуудлуудтай холбоотой засаглалын асуудлууд нь хувийн хэвшлийг хөгжүүлэхэд саад болж буй гол бэрхшээлүүд болж байна хэмээн оролцогчид тэмдэглэв. Төрийн бодлого богино хугацаатай байхаас гадна хэрэгжүүлэх зохистой механизм, хяналтын тогтолцоо дутмаг байдаг. Төрийн албан хаагчдын чадавхыг хөгжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эгэх хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн Банктай хамтран ажиллах боломжтой юм.

Дэд бүтэц дутмагаас гадна урт хугацааны санхүүжилтийн хүртээмж нь хувийн хэвшлийнхний өөр нэг санаа зовоосон асуудал болж байна. Зарим оролцогчид төрийн хөрөнгө оруулалт хязгаарлагдмал учраас дэд бүтэц болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд ТХХТ-ийг ашиглахыг санал болгосон. ЖДҮ-үүд, бизнесээ тэлэх үр чадвар, чадавх муутай байдаг.

Ажлын байр бий болгох, ажил эрхлэх нь улс орны нийтлэг хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой хэдий ч төрөөс бэлэн мөнгө тараах нь хувийн хэвшил дэх хөдөлмөр эрхлэлтэнд саад болж байна. Ядуу/ нэн ядууст чиглэсэн үйл ажиллагаанд санхүүгийн технологи гэх мэт илүү шинэлэг үйлчилгээг ашиглахыг санал болгож байна. Уул уурхайн салбар бусад салбарт эрэлт бий болгож, шууд бус ажлын байрыг бий болгож байна. Гэхдээ эдийн засгийн төрөлжилт сул, уул уурхайгаас хэт хамааралтай байгааг шийдвэрлэх шаардлагатай. Эрүүл мэнд нь ядууралд нөлөөлөх гол хүчин зүйл болохын хувьд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Дэлхийн Банк Группын хувьд Монгол Улсад олон талуудын оролцоог хангах чиглэлээр өөрийн давуу талыг түлхүү ашиглах, хувийн хэвшил болон бусад талуудтай олон улсын шилдэг туршлага болон мэдлэгийг хуваалцах нь зүйтэй гэсэн саналууд дэвшүүлэв.

Олон улсын хувийн хэвшлийн байгууллагуудтай хийсэн үүлзалт, 2017 оны 9 дүгээр сарын 1

Бүх оролцогчид Монгол Улсын хөгжилд уул уурхайн салбар чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ бусад салбарыг хөгжүүлэх хэрэгцээ боломж байгааг дурдсан. Засгийн газарт бусад олон зорилт, хүсэлтэй байгаа хэдий ч, уул уурхайн салбар нь Монголыг хөгжүүлэх боломж бололцоотой юм. Тиймээс Засгийн газар нь дэлхийн түвшний компаниудыг Монголд хөрөнгө оруулалт хийх итгэлийг өсгөх, шударга хууль, дүрмийг бий болгох замаар энэ салбарыг бүрэн дэмжих хэрэгтэй байна. Хөдөө аж ахуй, аялал жуулчлал нь мөн Монгол Улсад хөгжүүлэх боломжтой гол салбарууд бөгөөд эдгээр нь ажлын байр илүү ихийг бий болгох давуу талтай.

Хөрөнгө оруулагчдад тулгардаг хамгийн том сорилтуудын нэг бол хууль эрх зүйн орчины тогтвортой байдал, улс төрийн эрсдэл болон бодлого, хууль тогтоомжийн талаар үнэн зөв, тодорхой мэдээлэл ил тод хүртээмжтэй бус байдаг зэрэг багтаж байна. Өөрийн явцуу сонирхлын үүднээс аливаа асуудалд хандах улс төрчдийн эгэх хариуцлагын асуудал, богино хугацааны бодлого, төрийн албан хаагчдын чадавх сул байгаа нь улс орны хөгжилд саад болж байна. Төрөөс баримталж ирсэн арга барил, төрийн оролцоотой төслүүд амжилттай хэрэгжихгүй гэдэг нь сүүлийн жилүүдэд нотлогдож байгааг оролцогчид дурдав. Засгийн газар хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, ТХХТ-ийн талаархи хууль тогтоомжийг тодорхой болгон боловсруулах хэрэгтэй.

Улс төрчид олон нийтийн үзэл бодолд мэдрэмжтэй, соргог байдаг тул улс төр, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд мөн сонгогчдын иргэний боловсрол дутмаг байдал хувь нэмрээ оруулж байгаа гэдгийг олон улсын хувийн хэвшлийн төлөөлөгчид тэмдэглэв. Тиймээс олон нийтийн ойлголт, боловсрол, дуу хоолойг нэмэгдүүлэх нь зөв бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Холбоод, ТББ-ууд, олон улсын санхүүгийн байгууллагууд нь хэвлэл мэдээллээр дамжуулан зөв мэдээллийг олон нийтэд сурталчлах,

сошиал медиа зэрэг үр дүнтэй шинэ арга хэрэгслийг ашиглан олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллах ёстой гэв.

Оролцогчдоос ирүүлсэн бусад асуудлууд дотор бүс нутгийн харилцаа холбоо, хил дамнасан хамтын ажиллагааны санаачлагыг дэмжих, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг ялангуяа усны менежментийн асуудалд онцгой анхаарах зэрэг орж байна.

Дэлхийн Банкнаас цаашид үзүүлэх тусламж дэмжлэгийн хувьд оролцогчдын хамгийн түгээмэл хүсэлт бол Засгийн газарт техникийн туслалцаа, бодлогын зөвлөмж өгөх асуудал байв. Хувийн хэвшил, Засгийн газар болон иргэний нийгмийг холбогч гүүр болж ажиллах нь Дэлхийн Банкны гүйцэтгэж болох бас нэг үүрэг юм. Зарим оролцогчид Дэлхийн Банкны зүгээс талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, төслийн зохион байгуулалтыг оновчтой болгох, бизнесийн үйл ажиллагааны өртгийг нөхөхөд туслах зорилгоор томоохон төслүүдэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзсэн.

[Дархан хотын засаг захиргаа, хувийн хэвшил, ИНБ-үүдтай хийсэн уулзалт, 7 дугаар сарын 7-ны өдөр](#)

Дархан хотын оролцогч талууд нь ядуурлыг бууруулах, хамтын хөгжил цэцэглэлийг бий болгоход Монголд эко хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ашигт малтмалын нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцүүлгийн үеэр онцлон тэмдэглэсэн. Хоёр томоохон эдийн засгийн дунд орших улсын хувьд Монгол Улс нь олон улсын харилцаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэх ёстой. Гэсэн хэдий ч бүх оролцогч талууд уул уурхайн орлогын тэгш хуваарилалт хангалтгүй байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж байгааг тэмдэглэсэн.

Монгол Улс даяар ажлын байр бий болгохын тулд хөдөө аж ахуйн бизнес, ЖДҮ-ийг хөгжүүлэхэд илүү анхаарлаа хандуулах ёстой. Дархан хотын хувьд хувийн хэвшлийн салбар болон ЖДҮ эрхлэгчдэд бодит дэмжлэг байхгүй байна. ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр нь өндөр хүүтэй, богино хугацаатай байхаас гадна хувийн хэвшлийн салбарт Засгийн газрын оролцоо хэтэрхий их байгаа тул зах зээлийн шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байна. Стандарт, баримт бичиг бүрдүүлэлттэй холбоотой асуудлууд, зах зээлийн мэдээлэл хомсдолтой байгаа нь экспортын зах зээлд нэвтрэхэд садаа болж байна. Түүнчлэн, үйлдвэрлэлийн боловсруулалт бага хийгдэж, "кластер" байхгүй байгаа нь түгээмэл бэрхшээл юм.

Улс төрийн тогтворгүй байдал болон үүнээс үүссэн макро эдийн засаг, засаглалын асуудлуудыг Дарханд хийсэн бүх уулзалтын үеэр онцолж байв. Алсын хараагүй, богино настай бодлогууд нь улс орны хөгжилд садаа болж байна. Ил тод байдал дутмаг байдгаас

авилга өргөн тархсан. Төрийн албан хаагчид улс төрийн намууд бүрэн боловсорч, бодлогын мэтгэлцээн, хэлэлцүүлэг хийх шаардлагатайг зарим оролцогчид дурдаж, нөгөө хэсэг нь ардчиллын илүү өвөрмөц хэлбэрийг Монгол Улсад нэвтрүүлэх ёстой гэв. Мөн бүс нутгийн онцлог шинж, харьцангуй давуу талд үндэслэн бүс нутгийн хөгжлийн стратегийг бий болгох, орон нутгийн хөгжлийг дэмжих орон нутгийн засаг захиргааны бие даасан байдлыг сайжруулахад анхаарах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. Төр, хувийн хэвшлийн яриа хэлэлцээ, зөвлөлдөх уулзалт дутмаг, Засгийн газрын олон нийтийн харилцаа сул байгааг хэд хэдэн уулзалтын үеэр тэмдэглэсэн.

Дархан хотын бүх оролцогч талууд боловсролын чанар, багшийн хөгжил, иргэний боловсрол, хувийн хөгжилд чиглэсэн боловсролын салбарын шинэчлэлийг хийх хэрэгцээ шаардлага байгаатай санал нэгдсэн. Оролцогчид ёс зүй, гэр бүлийн хүмүүжил, үнэ цэнэ, Монголын уламжлалт үнэ цэнэ, соёл, ёс заншилд илүү анхаарал хандуулах хэрэгцээ шаардлага байгааг онцлохын зэрэгцээ хувийн хөгжил, насан туршийн боловсрол зэрэг асуудлуудыг дурдаж байлаа. Үнэ төлбөргүй, бүх нийтийг хамарсан хавтгайрсан халамжийн үйлчилгээнд найдах хандлага олон нийтийн дунд өргөжиж байгаа тул нийгмийн бодол санааг өөрчлөх, иргэний боловсролыг дээшлүүлэх нь тэргүүлэх чиглэлийн асуудал байх ёстойг мөн онцолж байв. Хэдийгээр Дархан нь залуучуудын хот боловч залуучуудын ажилгүйдэл их, тэдгээрийн хүчийг ашиглахгүй байна. Хөдөлмөрийн зах зээлийн хувьд зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаагүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор цалингийн жишиг тогтоох, ажил эрхлэгчдийн чадвар зэрэг хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой асуудлууд байна.

Дархан хотод хүрээлэн буй орчны доройтол, ИНБ-ууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудад дэмжлэг үзүүлдэггүй зэрэг бусад асуудлуудыг мөн онцлов. ИНБ, эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар бэлчээрийн даац хэтэрч байгаагаас бэлчээрийн талхагдал үүсч байгааг тэмдэглэсэн. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар доройтож байгаа нь хөдөө аж ахуйн салбарт системчилсэн үнэлгээ хийх, цогц стратеги боловсруулж хэрэгжүүлэхийн чухлыг харуулж байна.

Оролцогчид боловсролын болон хөдөө аж ахуйн салбарт Дэлхийн Банк тусламж дэмжлэгээ үргэлжлүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглээд, төсөл хэрэгжсэний дараа хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг хангахад анхаарал хандуулахыг зөвлөсөн. Үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж буй бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх нь ажлын байр бий болгох, ЖДҮ-ийг дэмжихэд илүү үр дүнтэй байж болох юм. Зорилтод бүлэгтээ хүрч чадаагүй төслийн санхүүжилтийн хувьд зарим оролцогчид төслийн оролцогчид илүү үр дүнтэй хяналт шинжилгээ, үр дүнг гаргахын тулд төслийн үр дүн, үйл ажиллагааны талаар илүү ил тод мэдээлэхийг санал болгосон.

Орхон хотын засаг захиргаа, хувийн хэвшил, ИНБ-үүдтай хийсэн уулзалт, 9 дүгээр сарын 8-ны өдөр

Улс орны хөгжлийн боломжуудад ашигт малтмалын баялаг багтдаг. Эрдэнэт хот нь үүний тодорхой үр шим хүртэгч юм. Эрдэнэт нь бүсийн төв болох боломжтой бөгөөд хүн амын нягтрал, хүний нөөц, дэд бүтэц зэргээс шалтгаалан бизнес хөгжүүлэхэд ихээхэн боломжтой юм. Мөн эко бизнесийн үйл ажиллагаа явуулж, түүний экспортыг өргөжүүлэх боломж бий. Мал нь 'сэргээгдэх' нөөц бөгөөд үүнийг илүү ихээр ашиглах хэрэгтэй.

Орхон аймаг дахь уулзалтуудаар хэлэлцсэн асуудлуудын дийлэнх нь засаглал, төрийн салбарын шинэчлэлийн асуудлууд байсан. Төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжилд түлхэц үзүүлэх, мөн засаг захиргааны хуваарилалтыг сайжруулах замаар төрийн үйлчилгээг сайжруулахын тулд шинэчлэл хийх шаардлагатайг санал болгов. Бүс нутгуудын ялгаатай байдлаас шалтгаалж зарим засаг захиргааны нэгж илүү татаас шаардаж, бага орлого төвлөрүүлдэг. Хувийн хэвшилд төрийн оролцоо ихсэж, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын нөөцийг зохистой удирдахад авилгын асуудал өсөж, хувийн хэвшлийн оролцоо ихээхэн нэмэгдэж байна. Улс төрийн тогтворгүй байдал нь тогтворгүй бодлогыг бий болгодог.

Нөгөө талаар засаглалыг бэхжүүлэхийн тулд ИНБ-уудын чадавх сул, олон нийтийн оролцоо, иргэний боловсрол муу байгаа зэрэг асуудлуудыг бодолцох хэрэгтэй. ИНБ, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны механизмыг бий болгох хэрэгтэй. ИНБ-үүд нь гүүр болж, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн кампанит ажил явуулах чадвартай байх ёстой.

Өнөөгийн тулгамдсан олон сорилтуудын дотор хүний хөгжил, боловсрол нь хамгийн тулгамдсан асуудал боллоо. Их сургууль, МБСБ-ыг төгсөгчдийн тоо олон боловч тэдэнд зах зээл дээр шаардлагатай мэдлэг, үр чадвар дутмаг байна. Боловсролын систем нь хүмүүст академик мэдлэг олгохоос гадна үр чадвар, амьдрах чадварыг дээшлүүлэхэд зориулагдсан платформ болох хэрэгтэй юм.

Монгол дахь олон улсын төрийн бус байгууллагуудтай хийсэн уулзалт, 9 дүгээр сарын 11

Уулзалтын үеэр уул уурхай, хөрөнгө оруулалт, дэлхийн томоохон зах зээлүүдтэй хөрш зэргэлдээ байршил, залуучуудын хөгжил, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар, идэвхтэй иргэний нийгэм гэх мэт хөгжилд хүрэх олон боломжууд Монголд байна гэж олон улсын ТББ-ууд онцлон тэмдэглэв. Гэсэн хэдий ч улс орны бэрхшээлийг ерөнхийдөө цогцоор нь тэнцвэртэй харж, авч үздэггүй. Бодлогын гажуудал нь эдийн засгийг төрөлжүүлэхэд саад болдог. Тус улс хүн ам цөөтэй тул том үйлдвэрлэлийн хувьд тохиромжтой биш юм.

Үүний оронд боловсролд анхаарах, ялангуяа хөдөө орон нутгийн сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын ач холбогдлыг дурдаж, энэ салбарт хөрөнгө оруулалт хийх нь илүү их боломжийг бий болгож болохыг онцолж байв. Хүүхдийн ядуурал Монголд өндөр байна. Боловсролын салбарт оюутнууд дадлагын хийх хөтөлбөр дутагдаж байгаа нь суралцагсад сурч мэдсэн мэдлэг, үр чадварын дагуу хөдөлмөрийн зах зээл дэх өндөр шалгуурыг ханган ажиллах боломжийг бүрдүүлдэггүй.

Ил тод, хариуцлагатай байдлаас гадна засаглалын асуудлууд болох төсвийн засаглал, төрийн худалдан авалт зэргийг олон улсын ТББ хүндрэлтэй асуудлаар нэрлэж байна. Одоогийн байдлаар төрийн удирдлага, улс төр хоёрын хооронд багахан ялгаа байна. Түүнчлэн хот, хөдөөгийн ажилгүйдлийн түвшин, төлөвлөгөөгүй хот суурин газрын хоорондох том ялгаа нь төвлөрлийг сааруулах бодлогыг улам боловсронгуй болгохыг шаардаж байна. Эмзэг бүлгийнхэнд тогтвортой, урт хугацааны ажлын байр бий болгох нь бас нэгэн том сорилт юм. Олон улсын ТББ-уудаас үүдэлтэй бусад асуудлууд нь цаг уурын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтол, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ байв.

Олон улсын ТББ-ууд Дэлхийн Банкны үйл ажиллагаа нь засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байх шаардлагатай гэж үзсэн. Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа хийх, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг бэхжүүлэхэд Дэлхийн Банкны дэмжлэг үзүүлж болох салбарууд юм. Түүнчлэн, Дэлхийн Банк төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, ногоон санхүүжилтийн санаачлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Арга барилын хувьд томоохон зээлийн төслийг хэрэгжүүлэхэд ИНБ-уудыг оруулах, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн, дүүргийн түвшинд төслүүдийг хэрэгжүүлэхийг оролцогчдын зүгээс санал болгосон.

Улаанбаатар хотын удирдлагуудтай хийсэн уулзалт, 9 дүгээр сарын 11

Нийслэл хотын албан хаагчид нийт хүн 60% нь амьдардаг хотын хувьд Улаанбаатарын давуу талыг онцлохоос гадна хотын хэт төвлөрөл, дэд бүтэц муугаас үүдэн хүрээлэн буй орчин,

хотын тогтвортой байдалд сорилтууд байгааг дурьдав. Эдгээрийн дотор Улаанбаатар хотын усны хомсдол нэмэгдэж байгаа нь хамгийн тулгамдсан асуудлын нэг байв. Орон сууцны оршин суугчдын тоог өсөхийн хэрээр усны хэрэглээ нэмэгдэх төлөвтэй. Агаар, хөрсний бохирдол нь оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Ус цэвэршүүлэх хуучирсан байгууламж нь хүрээлэн буй орчны асуудал, бохирдол үүсгэдэг. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар хандивлагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах бодлогын арга хэмжээг бэхжүүлэх шаардлагатайг албан тушаалтнууд онцлон тэмдэглэв. Жишээлбэл, яаралтай тусламжийн үеэр улсын сургуулиуд болон иргэдийн танхим ашигладаг Япон улсын туршлагыг судлах талаар санал болгосон.

Хотын хэт төвлөрлийн гол шалтгаан нь улсын өмчит их сургуулиуд болон Улаанбаатар хотод байрладаг том захууд хэмээн нэрлэв. Эдгээрийг шийдэх зарим арга зам бол Улаанбаатараас их дээд сургуулиудыг гаргах, бизнесийн шинэ санаа санаачлагыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авах явдал юм. Нийслэлийн хотын статус нь 20,000 хүн амтай аймгийн төвтэй адил бөгөөд үйлчилгээ үзүүлж, удирдахад бэрхшээл учруулдаг. Хэт төвлөрлийг шийдвэрлэхэд хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хувийн хэвшлийн өсөлтийг дэмжих, ажилгүйдэл, ЖДҮ-ийн бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж хотын мэргэжилтнүүд үзсэн. Аялал жуулчлал нь улс орны хөгжил, мөнгөн орлогын урсгалын өөр нэг боломж юм.

Боловсролын салбарт төрийн албан хаагчдын зохицуулалтыг сайжруулах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүртээмжтэй болгох, бүх сургуулиудад нийтийн боловсролын чанарыг сайжруулах хэрэгцээ байгааг онцлон тэмдэглэв. Боловсролын яам шинэ сургуулийн байршлыг шийдэж, барилгын ажилд хяналт тавьдаг бол эдгээр төслүүдийн чанар, үр ашгийн хяналтыг Улаанбаатар хотын захиргаа хянах боломжгүй байгаа нь боловсролын салбар дахь зохицуулалт муу байгааг харуулж байна. Төвийн зарим сургуулиудад үзүүлж буй боловсролын чанар нь хотын захын сургуулиудаас ялгаатай байдаг. Нийтийн боловсролын талаар янз бүрийн сонирхогч талуудаас санаа зовж буй нэгэн адил хотын удирдлагууд хот суурингийн иргэдийн боловсролыг дээшлүүлэх, "хот суурин газрын соёл, амьдралын хэв маягийг дэмжих" шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв.

Улаанбаатар хотыг уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй, үян хатан болгох, хот төлөвлөлтөд техникийн туслалцаа үзүүлэх, ногоон санхүүжилтийг олоход Дэлхийн Банк тусламж дэмжлэг үзүүлж болохыг Улаанбаатар хотын удирдлагууд санал болгожээ. Ажилгүйдлийг бууруулах, хотын бизнес хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах талаар Дэлхийн Банктай хамтарч ажиллаж болох талаар хэд хэдэн санал зөвлөмж өгсөн. Зарим албан тушаалтнууд мөн одоогийн УБ цэвэр агаар төслийн үйл ажиллагааг өргөжүүлэн

агаарын бохирдлоос гадна хөрс, усны бохирдолтой холбоотой асуудлуудыг шийдвэрлэж болох санал дэвшүүлсэн.

Өмнөговь аймгийн засаг захиргаа, хувийн хэвшил, ИНБ-уудтай хийсэн уулзалт, 9 дүгээр сарын 14

Уулзалтын үеэр оролцогчид улс орны хөгжилд уул уурхайн салбарын оруулсан ач холбогдлыг онцолсон. Гэсэн хэдий ч бэлчээрт нөлөөлж байгаа учраас Монголын уул уурхайг хөгжүүлэхэд малчдаас ихээхэн эсэргүүцэлтэй тулгардаг. Тиймээс уул уурхайн төслүүдийн ашиг тусын талаар олон нийтийг тэнцвэртэй мэдээллээр хангахын тулд илүү их хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Түүнчлэн Өмнөговь аймгийн уурхайн орлого, татвар нь улсын төсөвт шүүд орж, орон нутгийн хүмүүст бага ашиг тусаа өгч байгааг тэмдэглэсэн. Энэ нь уул уурхайн төслүүдэд орон нутгийн эсэргүүцлийг бий болгож, уул уурхайн компаниуд болон орон нутгийн иргэдийн хооронд хурцадмал байдлыг бий болгож байна. ИНБ-ууд уул уурхайн лиценз олгоход орон нутгийн түвшинд зөвлөлдөх, урьдчилан мэдээлэх үйлчилгээ дутмаг байгааг дурдаад газар болон лицензийн менежментийг сайжруулах шаардлагатай байгааг онцлов. Засаг захиргааны оролцогчид хууль бус олборлолтыг зохицуулах хэрэгцээ шаардлагыг дурьдаж - хууль бус олборлогчид ажилгүй гэж бүртгэгдсэн тул өөрсдийн орлогоо тайлагнадаггүй, төсвөөс халамж дэмжлэг авдгийг хэлж байв.

Цаашид аялал жуулчлал, мал аж ахуйд тулгуурласан эдийн засгийг төрөлжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй гэдгийг нотлов. Говийн бүсэд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлэх асар их хүчин чадалтай байна. Ажилгүйдэл ядуурлын нэг шалтгаан болж байгаагийн хувьд эдийн засгийг төрөлжүүлэх бодлогыг ажлын байр бий болгох бодлоготой уялдуулах нь зүйтэй. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхийн тулд малын эрүүл мэндтэй холбоотой асуудлууд, ЖДҮ-ийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тулгуурласан боловсруулах үйлдвэрүүдийг бий болгоход анхаарах шаардлагатай. Малчид малын гаралтай бүтээгдэхүүнээ эцсийн хэрэглэгчдэд шүүд борлуулах боломж хязгаарлагдмал учраас тэдэнд орлогоо нэмэгдүүлэх боломж тун бага байдаг. Орон нутгийн бизнесийн боломжийг нэмэгдүүлэхийн тулд хоршоод, өргөтгөлүүдийг цаашид хөгжүүлэх хэрэгтэй. Энэ нь хоршоодыг эсэргүүцдэг зарим бодлого боловсруулагчдыг мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх ажлаас эхлэх хэрэгтэй болно. Салбарын тусгай асуудлаас гадна бүх салбарт бодлого, судалгаа дутагдалтай байна. Орон нутгийн ЖДҮ нь чадавх бэхжүүлэх, зохистой бодлого боловсруулахад илүү их дэмжлэг авах хэрэгтэй бөгөөд ингэснээрээ тэд Оюу толгой уурхайд бүтээгдэхүүнээ нийлүүлэх илүү боломжтой болж, орон нутгийн иргэдэд томоохон төслүүдээс нэмэлт ашиг хүртээх боломжийг бүрдүүлэх ёстой. Тодорхой саналууд нь дотоодын ханган нийлүүлэгчдийн дундах өрсөлдөөд улс төрийн хөндлөнгийн оролцоог арилгаж, уул уурхайн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаанд орон

нутгийн ЖДҮ, компаниуд оролцох, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх боломжийг олгох байв.

Өмнөговь аймаг дахь бүх уулзалтын үеэр хүрээлэн буй орчныг хамгаалах, тогтвортой байдлыг хангах асуудлыг онцлон дурдсан. Монголын ард түмэн байгаль хамгаалах чиглэлээрх боловсрол дутагдалтай. Хур тунадас дутагдах, цаг агаарын температурын өсөлт, цөлжилт нэмэгдэх, бэлчээрт нөлөөлөх зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл Монгол Улсад түгээмэл байна. Энэ бүс нутагт усны нөөц багасч байна. Оролцогчид мөн агаарын болон хөрсний бохирдол зөвхөн Улаанбаатарт төдийгүй аймаг, сумын төвүүдэд улам бүр ихээр тулгамдсан асуудлууд болоод байгааг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Монгол Улс дахь томоохон арилжааны банкууд мөн Монгол Улсын нэгдэн орсон Парисын гэрээнд хүлээсэн үүргийн дагуу нүүрстөрөгчийн өндөр агууламжтай төслүүдийг санхүүжүүлэхээ зогсоохыг ИНБ-ууд зөвлөж байна.

Төрийн албанд тогтворгүй байдал, чадавх сул, урт хугацааны бодлогын төлөвлөлт дутагдалтай байгаа нь засаглалын гол асуудлууд юм. Оролцогчид төрийн албанд зориулсан мониторингийн чадавх сул байгааг онцлон тэмдэглэж байсан бол ИНБ-ууд хөгжилд саад учруулж буй Засгийн газрын эгэх хариуцлагын механизм дутмаг байгааг онцлон тэмдэглэсэн. Аймаг, сум бүрийн онцлог боломжоос хамаарч бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг Засгийн газрын оролцогчид онцлон тэмдэглэв.

Оролцогчид засаглалын болон бусад асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хүний хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгөх хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэв. Иргэд хөгжин боловсрохын хэрээр засаглал, хүрээлэн буй орчин болон бусад асуудлуудыг шийдвэрлэнэ. Ялангуяа сургуулийн өмнөх боловсрол, хөгжил нь хүний хөгжлийн үндэс суурь болох тул санхүүжилтийн ихээхэн хэсгийг энэ салбарт оруулж, стратегийн анхаарал хандуулах ёстой. Гэсэн хэдий ч энэ салбарт өнгөрсөн хугацаанд нийт санхүүжилтийн бага хувийг эзэлж байгааг Дэлхийн Банкны санхүүжилтээр Монголд хийгдэж байсан ажлуудаас хүртэл харагдана.

Оролцогчдын дийлэнх нь Дэлхийн Банк нь хөдөө аж ахуй, хүний хөгжил, аж үйлдвэрийг хөгжүүлэх, засаглалыг дэмжихэд үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой гэж санал болгосон. Хувийн хэвшлийн оролцогчид хүрээлэн буй орчныг хамгаалах, усны менежмент, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн дэмжлэгт анхаарах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. Ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчинг сайжруулах, ИНБ-ын чадавхыг бэхжүүлэх, томоохон хөрөнгө оруулалтын гэрээний гадны хяналтыг хэрэгжүүлэх, уул уурхайн нөөцийн менежментийг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх зэрэг бусад саналууд багтаж байна. ИНБ-ын оролцогчид Дэлхийн Банкныг ИНБ, хувийн хэвшлийнхэнтэй шууд хамтран ажиллаж, үр дүн, үнэлгээний хүрээг сайжруулах талаар санал дэвшүүлсэн.

Ховдод болсон зөвлөлдөх уулзалтад оролцсон хүмүүс бүгд өнгөрсөн хугацааны хөгжлийн янз бүрийн боломжуудыг нэрлэж байсан ч олон хүн уул уурхайн салбар болон орон нутгийн хөгжлийн сан нь эдийн засгийн өсөлтөд гол хувь нэмэр оруулсанд санал нийлсэн. Үүнээс гадна бусад боломжууд гэвэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өндөр үнэ, хандивлагч байгууллагуудын дэмжлэг, 8 хувийн хүүтэй ипотекийн зээлийн улмаас барилгын салбарын өсөлт, аялал жуулчлал, ардчилал зэргийг дурдаж байв.

Ховдын оролцогчид бас л засаглалын асуудал нь Монгол Улсад тулгарч буй хамгийн тулгамдсан асуудлуудын нэг болж байгааг онцолсон. Иргэний боловсрол, оролцоо дутмаг байгаагаас төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй. Төр засгийн бүтэц хэт томорч, бусад бүх салбарт оролцох оролцоо нь нэмэгдэж байна. Үүнээс гадна Засгийн газрын бодлого тогтворгүй байснаас хөгжлийн замыг тогтворгүй болгож байна. Хэдийгээр урт хугацааны хөгжлийн алсын хараа байгаа боловч үүнийг хэрэгжүүлэх механизм байхгүй байна. Засгийн газрын байнгын өөрчлөлт, улс төрийн нөлөө орон нутгийн түвшинд хүртэл илэрч байгаа ба энэ нь төрийн албаны сулрахад хүргэж байна. Энэ бүхэн нь Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг бууруулж, иргэд Засгийн газарт итгэдэггүй учраас дуу хоолойгоо хүргэж чадахгүй байна. Гэсэн хэдий ч засаглалын олон асуудлаас үл хамааран зарим хувийн хэвшлийн оролцогчид засаглалын асуудлуудыг дахин тодруулах хэрэгцээ гарч, засаглалыг бэхжүүлэхэд зориулж илүү их нөөц, хөгжлийн санхүүжилт хийхэд хүргэж байгаа нь үр дүнд хүрэхгүй байгаа юм. Ховд аймгийн алслагдсан байршилтай холбоотойгоор махны экспортын зах зээлд гарах, нийслэлээс алслагдсан байдал зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байна. Бүсийн хөгжлийн стратеги нь эдгээр бүс нутгийн хэрэгцээ, давуу талыг харгалзан үзэх ёстой.

Энэ бүс нутагт урьд нь уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны асуудалд анхаарал сул тавьж байсантай холбоотойгоор цаашид эдгээр асуудалд анхаарах хэрэгцээ шаардлага бий болсныг олон оролцогчид онцлон тэмдэглэсэн. Баруун бүсэд өвөл хатуу хүйтэн болж, элсэн шүүрга, цөлжилт эрчимтэй нэмэгдэж байна. Агаарын бохирдол нь баруун нутгийн оршин суугчдын хувьд ихээхэн санаа зовоосон асуудал болсон. Эдгээр асуудлуудаас шалтгаалан бүс нутгийн хэмжээнд ногооруулах төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Уул уурхайн төслүүд үйл ажиллагаагаа эхлэхээс нь өмнө тухайн төслийн хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг үнэлэх шаардлагатайг хувийн хэвшил дурьдсан.

Ховдын хэлэлцүүлгүүд мөн хүний хөгжлийн асуудлууд, ялангуяа эрүүл мэндэд чиглэсэн. Зарим сонирхогч талуудын тэмдэглэснээр Ховд аймагт төрөл бүрийн өвчлөл ерөнхийдөө өндөр байдаг. Малчдын эрүүл мэнд онцгойлон мүү байгаа боловч энэ асуудлыг орхигдуулсан. Иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг тул хүнсний аюулгүй байдалд анхаарах шаардлагатайг оролцогчид онцлон тэмдэглэсэн.

Салбарын хэмжээнд ажиллагсдын тоог өндөр байгаагаас шалтгаалан уурхайчдын эрүүл мэндэд богино болон урт хугацаанд үзүүлэх ажлын нөлөөллийг судалж үзэх нь чухал юм. Боловсролын салбарт мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, ерөнхий боловсролын чанар муу, нийслэл рүү шилжих хөдөлгөөн, багш нарын хөгжилд анхаарал хандуулах хэрэгцээ зэрэг бэрхшээлүүдийг хэлэлцсэн.

Оролцогчид мөн хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын боломжийг ашиглан эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатайг онцлов. Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүнд тулгуурласан экспортын баримжаатай ЖДҮ-ийг хөгжүүлэх нь илүү олон ажлын байр бий болгож, ядуурлыг бууруулахад туслах болно. Банкуудын зээлийн хүү өндөр, барьцаа хөрөнгийн үнэлгээ бага байгааг дурьдсан. Мал аж ахуйн салбарт малын эрүүл мэнд гол асуудал болж байгаа бол орон нутгийн фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд хүнсний ногооны агуулах дутагдалтай байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Эрчим хүчний тогтвортой хангамж дутагдалтай байгааг олон уулзалтуудаар орон нутгийн хөгжилд садаа болж буй гол асуудлаар дурдсан болно.

Хэнтий аймгийн засаг захиргаа, хувийн хэвшил, ИНБ-үүдтай хийсэн уулзалт, 10 дугаар сарын 5

Хэнтий аймаг баялаг түүх, байгалийн баялаг ихтэй тул аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх нөөц бололцоо ихтэй гэдэгтэй Хэнтий аймаг дахь бүх оролцогч талууд санал нийлэв. Мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих нь залууст тулгуурлан цаашид улс орныг хөгжүүлэх өөр нэг боломж юм. Хөдөө аж ахуйн салбарын хувьд экспортын баримжаатай бизнес, ЖДҮ-ийг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, малын эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх зэрэг нь тэргүүлэх ач холбогдолтой асуудлууд болж байна. Харин аялал жуулчлалын салбарт хүрээлэн буй орчныг хамгаалах, бизнесийн хөгжлийг тэнцвэржүүлэх зорилгоор аялал жуулчлалын салбарт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ байгааг оролцогч талууд дурдсан байна. Бүх оролцогч талууд байгалийн нөөцийн илүү тэгш менежментийн бодлого боловсруулахын ач холбогдлыг онцолсон бол ИНБ-үүд уул уурхайн салбарт цаашдаа хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээг онцлон тэмдэглэсэн. Уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт хүрээлэн буй орчны нөлөөлөл болон засаглалын үнэлгээ хийх шаардлагатай.

Хэнтий аймагт ядуурлын түвшин өндөр байгаа нь шийдвэрлэвэл зохих гол асуудал болж байгаа бөгөөд ядуурлын түвшин өндөр байгаа нь ажилгүйдэл газар авсан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого дутмаг байгаагаар холбоотойг ихэнх оролцогч онцолсон юм. Тухайлбал, ядуурлыг бууруулахын тулд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, бизнес эрхлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх томоохон үйлдвэрүүдийг хөгжүүлэх, хөдөлмөрийн хөлсний үнэлэмж доогуур байгааг шийдвэрлэх болон Инновацийн тухай хуулийг батлах

хэрэгцээ байгааг онцолсон. Хувийн хэвшлийн оролцогчдын зүгээс нийгмийн халамжийн бодлогыг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг хөндөж, бүх нийтийг хамарсан нийгмийн халамж, бэлэн мөнгө тарааж байгаагаас шалтгаалан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол бага байгааг дурдав. Тэд мөн их дээд сургуулиудын тоо хэт их байгааг харгалзах, ажлын байран дээр ажиллах чадварлаг ажилчид дутагдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсролын бодлогыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг хэлэлцсэн. Бараг бүх айл өрхүүд хүүхдүүдээ их сургуульд сургаж, сургалтын төлбөрийг өндөр хүүтэй зээлээр төлдөг бөгөөд энэ нь Монголд ядуурлыг нэмэгдүүлэх гол шалтгаан болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тодорхой үр чадвартай боловч ажил олоход хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдаг тул тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь зүйтэй гэдгийг ИНБ-ууд онцлов.

Хэнтий аймгийн оролцогчид боловсролын чанарыг дээшлүүлэх, Монголын боловсролын салбарт хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэв. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй үр чадвар дутмаг байгааг харгалзан, ТМБС-ын хөтөлбөрүүд нь ажлын байрны зах зээл, бодлоготой илүү уялдаатай болж бэхжих шаардлагатай. Эдийн засаг, санхүү, иргэний болон эрүүл мэндийн салбарт олон нийтийн боловсрол, мэдээлэл бага боловч гадаадад суралцахад санхүүгийн ихээхэн хэмжээний эх үүсвэр зарцуулагдаж байна.

Хэнтий аймгийн бүх уулзалтуудад хувийн хэвшлийг хөгжүүлэхэд тулгарч буй томоохон сорилтууд нь зах зээлийн судалгаа дутмаг, Засгийн газрын зохицуулалт хангалтгүй байгаагаас зарим бүтээгдэхүүний нийлүүлэлт хэт ихэссэн, зээлийн хүү өндөр байгааг хөндөв. Жижиг хэмжээний тогтворгүй бизнесүүдийг дэмжихэд голлон чиглэсэн өмнөх бодлогоос том, дунд хэмжээний үйлдвэрүүдийг экспортын чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бодлогод шилжих шаардлагатай байгааг мөн бүх уулзалт дээр хөндөж байв. Засгийн газрын төлөөлөгчид хөдөө орон нутагт бизнес эрхлэх, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах нь чухал байгааг онцлов. Хувийн хэвшлийн төлөөлөгчид лиценз, зөвшөөрөл авахад Засгийн газрын хүнд суртал хамгийн их саад тотгор болгож байгааг онцолсон.

Засаглалын асуудал нь бүх уулзалтуудад гол сэдэв болж, урт хугацааны хөгжлийн төлөвлөлт, төрийн албаны шинэтгэлийг яаралтай хийх шаардлагатайг дурдаж байв. Засгийн газрын байгууллагуудын залгамж чанар, төрийн албаны чадавх, чанар маш ихээр буурсан. Улс төрийн тогтворгүй байдал нь урт хугацааны хөгжлийн төлөвлөлт, төрийн алба, бизнесүүдэд нөлөөлдөг. Орон нутгийн төсвийн төсөвлөлтийн үйл явцад улс төрийн оролцоо байдгаас шалтгаалан орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлсний үр өгөөж хангалтгүй байна гэж дурдсан байна. Мөн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дагалдах дүрэм журам, бодлогуудыг амьдрал дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг гэв.

Төрийн албан тушаалтнууд нэг талдаа Засгийн газрын ил тод байдлыг сайжруулж, нөгөө талдаа иргэдийн боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ байгааг дурдав. Үүнийг мэргэжлийн мэдээллийн институтууд болон рейтингийн агентлагуудыг байгуулснаар хийж болно. ИНБ-ын оролцогчид ИНБ-уудын чадавхыг бэхжүүлэх, Засгийн газартай түншлэх, илүү сайн яриа хэлэлцээ хийх чадварыг нь хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь зүйтэйг онцолсон. Түүнчлэн төр засгийн анхан шатны түвшний үйлчилгээ буюу багийн түвшинд хүрч ажиллах хэрэгцээ шаардлага маш их байдаг боловч чадавх маш сул байна байдаг гэв.

Дэлхийн Банкны хамтын ажиллагааны боломжит салбарууд нь засаглал, бодлогын шинжилгээ, төрийн албыг бэхжүүлэх явдал юм. Дэлхийн Банк мөн бүх сонирхогч талуудын оролцоог хангасан салбарын түвшний зөвлөлгөөн, хэлэлцүүлгийн хүрээг нэвтрүүлэх, хувийн хэвшлийн салбарын төлөвлөлтийн чадавхыг сайжруулахад зөвлөлдөх тогтолцоог нэвтрүүлж болно. Санхүүжилтийг олон жижиг салбар, ЖДҮ-д хуваарилахаас илүүтэйгээр ажлын байр бий болгоход зориулж аж үйлдвэр, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэх, санхүүжүүлэх хүний хөгжлийг дэмжих санааг олон оролцогч талууд санал болгосон. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тул Дэлхийн Банкны уул уурхайн салбар дахь оролцоо хязгаарлагдмал байх нь зүйтэй гэж үзсэн. Үүний оронд Дэлхийн Банк нь ИНБ-ууд болон иргэний оролцоог дэмжихэд үйл ажиллагаагаа чиглүүлж, ингэснээр уул уурхайн салбарыг илүү ил тод, эгэх хариуцлагатай бөгөөд тогтвортой болгоно гэдгийг дурьдаж байв.

Улаанбаатарт ИНБ-тай хийсэн үүлзалт, 10 дугаар сарын 3

Улаанбаатар хот дахь өргөн хүрээний ИНБ-ууд нь ядуурал, хүний эрх ба жендэр, хүрээлэн буй орчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, боловсрол, засаглал гэсэн зургаан асуудлын хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн. Хэлэлцүүлгийн эхний хэсэгт тэгш бус байдал, ядуурал нэмэгдэж буйг голлон хөндөж ярилцав. ИНБ-уудын зүгээс Монгол Улсад ардчилал, чөлөөт зах зээлийн хөгжлийн зам зөв байсан эсэхэд эргэлзэн эрэгцүүлж байв. Ихэнх оролцогчид Монгол Улс ашигт малтмалд суурилсан хөгжлийн загварыг бус, мэдлэгт суурилсан төлөвлөлт, хөгжилд хүрэх ёстой гэж үзсэн. Баян ядуугийн ялгааг багасгахын тулд татварын дэвшилтэт тогтолцоог нэвтрүүлэх, татварын бусад шинэчлэлийг нэвтрүүлэхийг ИНБ-ууд дэмжсэн. Татварын өршөөл үзүүлэх, татвараас чөлөөлөх нь ихэвчлэн хязгаарлагдмал хүрээний компаниуд, бизнес эрхлэгчдэд ашигтай байдаг тул үүнийг зогсоох шаардлагатай. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль, Төрийн өмчийн тухай хууль / Хөрөнгө оруулалтын тухай хуулийг батласнаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна. Түүнчлэн үүнийг иргэний эрх, үүрэг хариуцлага, жендэр ба хүйс, соёл зэрэг асуудлыг боловсролын хөтөлбөрт оруулах замаар стратегийн хувьд дэмжих нь зүйтэй.

Эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн оролцоо бага байгаа ба жендэрийн тэгш байдлыг хангахад олон сорилтууд тулгарч байна. Олон хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд ядууралд орох эрсдэл нь нэмэгддэг тул эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн ядуурал, эмзэг байдлыг арилгах нь чухал юм. Нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад жендерээр ангилсан статистик мэдээлэл байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд мөн институцийн болон эрх зүйн хүрээ сул байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боловсролын хүртээмж, ажил эрхлэлтийн боломж хязгаарлагдмал байгаагаас гадна одоо байгаа нийгмийн халамжийн үйлчилгээнүүд нь хэрэгцээтэй хүмүүст чиглээгүй байдаг.

Боловсролын ач холбогдлыг Монголын ард түмэн ихээхэн үнэлдэг тул боловсролын салбарыг хөгжүүлэх боломж их байна. Гэтэл сүүлийн үеийн бодлого, үйл ажиллагаа нь боловсролын чанарт бус боловсролын барилга байгууламжийг барих ажилд голлон төвлөрсөн. ИНБ-үүд боловсролын чанарыг сайжруулахад тэгш бус байдал улам өргөжиж байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тусгай бүлэг болон өөр хэл яриатай хэсэгт тохирсон боловсролын бодлогыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн. Бага сургуульд 6 наснаас элсэн орох нь хөдөөгийн хүүхдүүдэд тохиромжгүй, учир нь ихэнх хүүхэд сургуулиас өмнөх боловсролд хамрагдаж чаддаггүй тул сургуульд сурч боловсроход бэлтгэгдээгүй байна.

Хүрээлэн буй орчны асуудал, уур амьсгалын өөрчлөлт орон нутгийн түвшинд амьдралын хэв маягт нөлөөлдөг. Гэсэн хэдий ч хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг ихэнхдээ орхигдуулдаг. Хүрээлэн буй орчны асуудлууд нэмэгдэж байгааг харгалзан аливаа төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө байгаль орчин, хүрээлэн буй орчны үнэлгээг илүү өргөн хүрээнд хийх хэрэгтэй гэж үзсэн. Түүнчлэн сайн боловсон хүчин уул уурхайн салбар луу шилжиснээр бусад салбарын хөгжих боломжийг хязгаарлаж байгаа нь анхаарал татаж байна. ИНБ-үүд хэлэлцүүлэгт засаглалын асуудлууд, тэр дундаа эгэх хариуцлага хөгжөөгүй гэдгийг дахин давтан хэлж байсан.

iii. Зөвлөлдөх хэлэлцүүлгийн үер явуулсан санал асуулгын статистик хураангуй

Зөвлөлдөх уулзалтанд оролцсон ойролцоогоор 400 оролцогчдоос Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл болон Дэлхийн Банкны дэмжлэгийн талаарх санал бодлоо товчхон бөглөж өгөхийг хүссэн юм. Энэхүү санал асуулга нь хурлын үеэр нээлттэй хэлэлцүүлгээс авсан чанарын мэдээлэлээс гадна тоон нотолгоог олж авахад чиглэсэн. Хагас хаалттай хариулт бүхий зөвхөн хоёр асуултын хүрээнд асуулгыг явуулав:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

<i>Төрийн удирдлага, шинэтгэл</i>	<i>Эрүүл мэнд</i>	<i>Зам тээвэр</i>
<i>Боловсрол</i>	<i>Эдийн засгийн өсөлт</i>	<i>Худалдаа ба экспорт</i>
<i>Авилгатай тэмцэх</i>	<i>Хүрээлэн буй орчныг хамгаалах ба бохирдлыг хянах</i>	<i>Хотын хөгжил</i>
<i>Хувийн хэвшлийн хөгжил</i>	<i>Эрсдэлийн удирдлагын менежмент</i>	<i>Нийгмийн хамгаалал</i>
<i>Байгалийн нөөцийн удирдлага</i>	<i>Хүнсний аюулгүй байдал</i>	<i>Эрчим хүч</i>
<i>Ажлын байр бий болгох /хөдөлмөр эрхлэлт</i>	<i>Эрх тэгш боломжоор хангах</i>	<i>Ус, ариун цэврийн байгууламж</i>
<i>Хөдөө аж ахуй, мал аж ахуй ба ой</i>	<i>Санхүүгийн зах зээл</i>	<i>Уур амьсгалын өөрчлөлт</i>
<i>Хөдөөгийн хөгжил</i>	<i>Гадаадын хөрөнгө оруулалт</i>	<i>Бусад (дээд тал нь 5 үг)</i>

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

<i>Хүний хөгжлийг дэмжих</i>	<i>Бизнес орчныг сайжруулах чиглэлээр дэмжих</i>	<i>Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих</i>
<i>Байгалийн нөөцийн удирдлага, хүрээлэн буй орчныг хамгаалах</i>	<i>Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих</i>	<i>Бүгд чухал</i>

Эдгээр хуралд оролцсон хүмүүс ихэнхдээ засаглалын чиглэлд шинэтгэл хийх хэрэгцээ шаардлага байгааг дурдсан (161 удаа, 1536 хариултын 10.5 хувь). Үүний дараа боловсрол (135), ажлын байр (129), хувийн хэвшлийн хөгжил (112), авилгатай тэмцэх (103) зэрэг хариултууд орсон байна. Хамгийн бага дурдсан бэрхшээлүүд гэвэл: нийгмийн хамгаалал (29), хот байгуулалт (28), эрчим хүч (24), уур амьсгалын өөрчлөлт (20), гамшгийн эрсдэлийн менежмент (13) зэрэг байна. Дэлхийн Банк Группын туслалцаатай хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүний хөгжлийг дэмжих чиглэлд хамгийн их санал ирсэн (нийт 707- оос 186, энэ нь 26 хувь), дараа нь бизнесийн орчинд дэмжлэг үзүүлэх (131), төрийн удирдлага, засаглалын чиглэлээрх дэмжлэг оров (130).

Дээрх судалгаанаас өргөн хүрээний цахим судалгааг Дэлхийн Банкны вэб хуудсанд байршуулж, уулзалтад оролцогчдоос илүү өргөн хүрээний хүмүүсээс санал авах зорилгоор


2017 оны 8 дугаар сарын 21-ээс 10 дугаар сарын 20-ны хооронд сошиал хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав. Энэхүү өргөн хүрээний судалгааг 600 орчим хүн бөглөсөн бөгөөд судалгаанд оролцсон нийт иргэдийн 91% нь монгол хэл дээр бөглөв. Энэ цахим судалгаанд хариулагчийн хувийн мэдээлэл (нас, хүйс, аймаг, байгууллагын төрөл)-ийг асууснаас гадна оролцогч талуудтай хийсэн уулзалтын үеэр авсан судалгааны 2 асуулт, мөн уулзалтын үеэрх хэлэлцүүлгийн агуулгатай ижил 3 нээлттэй асуултыг тавьсан болно:

1. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад өсөлт, ядуурлыг бууруулахад чиглэсэн гол хүчин зүйлс юу байсан гэж та бодож байна вэ? (НЭЭЛТТЭЙ АСУУЛТ)
2. Монгол Улсад ядуурлыг бууруулах, хөгжил цэцэглэлд хүрэхэд тулгарч буй хамгийн том сорилт юу вэ? (НЭЭЛТТЭЙ АСУУЛТ)
5. Бусад санал, зөвлөмжүүд (НЭЭЛТТЭЙ АСУУЛТ)

Уулзалтын үеэр тавьсан асуулттай ижил асуултыг вэб хуудсаар дамжуулан авахад хариулт нь ижил дүр зургийг харуулсан буюу хөгжилд садаа болж буй асуудлыг шийдвэрлэхэд засаглалын шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага байгааг ихэнх нь дурдсан байна. (336 удаа, 2739 хариултын 12.3 хувь). Үүний дараа авилгатай тэмцэх (298), боловсрол (321), ажлын байр (279), хувийн хэвшлийн хөгжил (256) зэрэг хариулт байв. Сонирхолтой нь хамгийн бага дурдагдсан таван бэрхшээл нь өмнөхтэй ижил байсан бөгөөд дарааллын хувьд бага зэрэг өөрчлөгдсөн байна. Үүнд: нийгмийн хамгаалал (28), уур амьсгалын өөрчлөлт (19), хот байгуулалт (15), эрчим хүч (15), гамшгийн эрсдэлийн менежмент (7) гэсэн байна. Дэлхийн Банк Группын туслалцаатай хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг веб сайтын санал асуулгаар авахад хүний хөгжлийг дэмжих үйл жиллагаа нь хамгийн их саналыг авсан (1379-с 364 нь 26.4 хувь нь), дараа нь бизнесийн орчинд дэмжлэг үзүүлэх (279) болон дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх (2009) зэрэг байв. Дахин хэлэхэд, сонирхогч талуудтай хийсэн уулзалтуудын оролцогчдын саналтай бараг ижил.

Ерөнхийдөө, хөгжлийн сорилтуудыг эрэмбэлсэн хариултууд нь уулзалтад оролцогчид болон нээлттэй цахим судалгаанд оролцогчдынх төстэй байна. Эдгээр хоёр бүлэг хамгийн их сорилтод ижил таван сорилтыг сонгожээ. Ганц ялгаа нь цахим судалгаанд оролцогчид эдгээр таван асуудалд илүү их ач холбогдол өгч хариултын нилээд их хувийг эзэлж байна. (Зураг А2 1). Ганц ялгаа нь *тэгш байдлын* үзүүлэлт цахим судалгаараар ирсэн хариултанд уулзалтад оролцогчдоос авсан хариултаас илүү өндөр хувийг эзэлж байгаа нь магадгүй цахим судалгаа нь Монголын нийгмийн ядуу бүлгийн гишүүдэд илүү хүрч саналыг нь авч чадсанг харуулж байна.


Зураг А2 1: Хурлын санал асуулга болон онлайн судалгаанаас авсан гол хариултууд



Эх сурвалж: 2017 оны 8 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 5 хүртэл оролцогч талуудтай хийсэн үүлзалтаас цуглуулсан санал асуулгын дүн болон онлайн судалгаагаар 2017 оны 8 дугаар сарын 21-ээс 10 душаар сарын 20 хүртэл авсан хариултууд

Дэлхийн Банк Группын тусламжтай хэрэгжүүлж болох үйл ажиллагаанд өгсөн саналууд эдгээр бүлгийн хувьд бараг ижил байна. Зураг А2 2 нь үүлзалтад оролцогчдын хариулт төрийн салбарын засаглалыг дэмжихийг илүүд үзсэн бол цахим хариулт нь дэд бүтэц хөрөнгө оруулалтыг дэмжих болон төрийн салбарын засаглалыг дэмжихэд бараг тэнцүү ач холбогдол өгсөн байна.

Зураг А2 2: Цахим судалгааны гол хариултууд




Эх сурвалж: 2017 оны 8-р сарын 30-наас 10-р сарын 5 хүртэл оролцогч талуудтай хийсэн уулзалтаас цуглуулсан санал асуулгын дүн; ба 2017 оны 8-р сарын 21-өөс 10-р сарын 20 хүртэл авсан цахим судалгааны дүн

Сонирхолтой нь, хариултуудын эрэмбэ нь судалгаанд хамрагдсан оролцогч бүлгийн байршлаас хамааран ялгаатай байна. Улаанбаатарт болсон уулзалтаас цуглуулсан мэдээллүүдийг хөдөө орон нутагт хийсэн уулзалтаар цуглуулсан мэдээлэлтэй харьцуулахад хоёр гол ялгаа ажиглагдаж байна. Нэг талаас хөдөө орон нутагт бизнес эрхлэгчид бизнес хөгжүүлэхтэй холбоотой асуудлуудад илүү их санаа зовж байна. *Ажлын байр, хувийн хэвшлийн хөгжил, хүнсний аюулгүй байдал, санхүүгийн зах зээл, худалдаа, экспорт* зэрэг асуудалд хөдөө орон нутгаас оролцогчид илүү ач холбогдол өгч, Улаанбаатар хотынхоос дор хаяж 2 нэгж хувиар илүү байна. Нөгөөтэйгүүр, *засаглал, боловсрол, байгалийн нөөцийн менежментийн асуудалд* Улаанбаатар хотын оролцогчид илүү ач холбогдол өгсөн (Зураг А2 3).


Бүх насны бүлгүүд хөгжлийн сорилтуудаар 5 асуудлыг сонгосон боловч залуучууд (30-аас доош насны хүмүүс) боловсролд илүү их ач холбогдол өгч, бусад насны бүлгүүд авилгалын эсрэг болон ажлын байр бий болгоход чухал ач холбогдол өгсөн. Өсвөр үеийнхэн бусад насны бүлгээ бодвол *худалдаа, экспортыг* илүү чухал ач холбогдол өгч *эрх тэгш боломж* болон *хүнсний аюулгүй байдлын* асуудалд бага ач холбогдол өгчээ (Зураг А2 4-ийг үз). Хариултуудыг хүйсээр ангилан авч үзвэл үнэлгээ нь ерөнхийдөө маш төстэй боловч хэд хэдэн ялгаа байна. Эмэгтэйчүүд ажлын байр, байгаль орчны хамгаалал, эрүүл мэндийн асуудалд илүү ач холбогдол өгсөн бол эрэгтэйчүүд гадаадын хөрөнгө оруулалт, зам, тээвэр, эрчим хүчний ач холбогдлыг онцолжээ. Аль аль бүлэг нь боловсролд тэргүүлэх ач холбогдол өгч, авилгад санаа зовниж байв (Зураг А2 5).

Зураг А2 3: Уулзалтуудын гол хариултыг байршлаар нь авч үзвэл




Эх сурвалж: 2017 оны 8 дунд сарын 30-наас 10 дугаар сарын 5 хүртэл оролцогч талуудтай хийсэн уулзалтаас цуглуулсан санал асуулгын дүн.

Зураг А2 4: Цахим судалгааны хариултыг оролцогчдоор авч үзвэл, насны ангиллаар.



Эх үүсвэр: Цахим судалгаагаар цуглуулсан мэдээлэл, 8 дугаар сарын 21нээс 10 дугаар сарын 20, 2017.

Зураг А2 5: Цахим судалгааны хариултыг оролцогчдоор авч үзвэл, хүйсээр.



Эх сурвалж: 2017 оны 8 дугаар сарын 21-ээс 10 дугаар сарын 20 хүртэл онлайн судалгаагаар цуглуулсан хариултууд.

iv. Уулзалтанд оролцсон байгууллагуудын жагсаалт (цагаан толгойн дарааллаар)

<ul style="list-style-type: none"> • Удирдлагын академи • Өсвөр үеийн хөгжлийн төв • АДРА • АНТ ТББ • Бүх нийтийн боловсролын төлөө ТББ • Алтай Холдинг ХХК • Алтайн нүүдэл ХХК • Монгол дахь АмЧам • Амира од ХХК • And Energy ХХК • Анхлан - Аз ХХК • АОЕ нийгэмлэг • АОЕ нийгэмлэг • Казах эмэгтэйчүүдийн Аралур холбоо • Аргалангийн Тэнгис ХХК • Ариун Хэлхээ ТББ • Арслан Бар ХХК • Азийн сан 	<ul style="list-style-type: none"> • Азийн хөгжлийн банк • Хэнтий аймгийн ахмад эмч нарын холбоо • Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо • АUA төв • Баянхуа төгөл ХХК • Бадарххаан ХХК • Хэнтий аймгийн 5-р багийн малчин • БНХАУ-ын банк • Монголбанк • Баялаг Ундарга ХХК • Баян-Уул ХХК • Хөөрхөн зүрхнүүд ТББ • Бэрэн ХХК 	<ul style="list-style-type: none"> • Бишрэлт Групп • Токио-Мицубиши UFJ банк • Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрын хамгаалал ТББ • Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал • Булхамбаяр ХХК • Монгол улсын бизнесийн зөвлөл • Бизнесийн инкубаторын төв • Бутааахай ХХК • Засгийн газрын Хэрэг эрхлэх газар • Иргэний боловсрол олгох төв • Хөгжлийн бэрхшээлтэй 	<ul style="list-style-type: none"> иргэдийн хөгжлийн төв • Хөгжил дэх Хүний Эрхийн Төв • Чоно групп • Иргэдийн холбоо ТББ • Төрийн албаны зөвлөл • Иргэний нийгмийн байгууллагуудын холбоо • Аймгийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо • Дархан-Уулын үйлдвэрлэгчдийн холбоо • Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах төв • Компанийн Засаглалын Төв • Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Дархан хотын салбар
---	---	---	---

<ul style="list-style-type: none"> • Дарханы гэрэл ХХК • Дархан Мөнх ХХК • Дархан ноос ХХК • Дарханы савхи ХХК • Дархан-Уул аймгийн төв номын сан • Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал • Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар • De Facto хүрээлэн • Хөгжлийн банк • Хөгжлийн шийдэл ТББ • Дөрвөл Улирал Хэнтий ХХК • Дүүрэн Од ХХК • E & Y Mongolia Audit LLC • Эко ноос ХХК 	<ul style="list-style-type: none"> • Австралийн Элчин Сайдын Яам • Канадын ЭСЯ • Энэтхэгийн элчин сайдын яам • ОХУ-ын Элчин сайдын яам • Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын ЭСЯ • АНУ-ын ЭСЯ • Энжи ХХК • Байгаль орчны хөдөлгөөнүүдийн нэгдсэн холбоо • Эрчим хурдан хүлэг ХХК • Эрдэнэ Ресурс Хөгжил • Эрдэнэт Мах Маркет ХХК • Эрдэнэтийн шинжлэх ухаан, технологийн парк • Европын Сэргээн Босголт, 	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн Банк • Монголын Боловсрол, Шинжлэх ухааны холбоо • Санхүүгийн зохицуулах хороо • Францын Элчин сайдын яам • Газар Өгөөж ХХК • Женко тур бюро ХК • Гэрэлт Хэрлэн ХХК • Глобал Ногоон Хөгжлийн Хүрээлэн • Глоб Интернэшнл ТББ • GT-ийн Өмгөөлөгчид • Гурван Сайхан цэвэр ус ХХК • Хэнтий аймгийн малчин • HGEI холбоо • Hogan Lovells 	<ul style="list-style-type: none"> • I Volunteer ТББ • Авлигатай тэмцэх газар • Бие даасан судалгааны хүрээлэн • ING банк • Интермэд эмнэлэг • Олон улсын валютын сан • Олон улсын Бүгд найрамдахчуудын хүрээлэн • Жаргалант Ховд ТББ • Жаргалант Луу ХХК • Жаргалант Шанд ХХК • ЖАЙКА • Жимсний баяжмал хоршоолол • Жуулчин корпораци Өмнөговь аймгийн Хаан банк • ХААН Банк Хан Хэнтий Ногоон ТББ • Хангайн бүсийн
---	---	---	---

<p>хөгжлийн төв ТББ</p> <ul style="list-style-type: none"> Хараа голын иргэдийн байгаль орчны холбоо Хатан Түнгэл Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимийн Хэнтий салбар Хэнтий Ногоочид ТББ Хэнтий Өгөөмөр ХХК Хэнтий аймгийн ИНБ-уудын холбоо Хэнтий аймгийн улсын бүртгэлийн газар Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар 	<ul style="list-style-type: none"> Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Хэнтий аймгийн Цагдаагийн хэлтэс Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн хэлтэс Хэнтий аймаг, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар Хонгор ТББ ТББ МҮХАҮТ-ын Ховд салбар Ховд Барилгын Холбоо Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 	<ul style="list-style-type: none"> Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд Сафар Ховд Скай ХХК Ховд Сутай ТББ Ховд их сургууль Хөвчийн Жонон ХХК Хөвсгөл нуур эзэмшигчийн хөдөлгөөн ТББ Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал Konrad Adenauer сан KPMG ЛГБТ Төв Лондон ХХК Дархан хотод үйлдвэрлэв МАЕМ Со ХХК Майдар цаг үе сан Мах Маркет ХХК МАКС бүлэг MCS Холдинг ХХК 	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй хүн - эрүүл гэр бүли төв ТББ Мерси Кор, Ховд салбар Метал хийц ХХК Мянганы сорилтын сан Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Барилга, хот байгуулалтын яам Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Эрчим хүчний яам Байгаль орчин, аялал жуулчлалын яам Сангийн яам Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Гадаад харилцааны яам Эрүүл мэндийн яам
--	---	---	--

<ul style="list-style-type: none"> • Хууль зүйн яам • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам • Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам • Зам, тээврийн хөгжлийн яам • МОНФЕМНЕТ ТББ • Монгол Алтан Тосон ХХК • Монголын Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ • Монгол Микрон Ноолуур (Polaris, IBIS зочид буудал) • Монголын боломж сан • Монголын Залуучуудын Зөвлөл • Байгаль орчны хөдөлгөөний 	<ul style="list-style-type: none"> Монголын холбоо • Монголын Байгаль орчны ТББ-уудын холбоо • Голомт банк • Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв • Монголын гэр бүлийн халамжийн холбоо • Монголын Эх Байгаль Авралын Сан • МУИС, Орхон аймгийн салбар • Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн холбоо • Моннис Групп • Монполимет групп • MSM & TG нийгэмлэг төв • ЭмЭсЭм групп 	<ul style="list-style-type: none"> • Мөнх Шувуут ХХК • Мөнхийн Чансаа ХХК • Харааны бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо • Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим • Үндэсний хөгжлийн агентлаг • Онцгой байдлын ерөнхий газар • Хүний эрхийн үндэсний комисс • Уул уурхайн үндэсний ассоциаци • Үндэсний статистикийн газар • МУИС, Бизнесийн сургууль • Шинэ суурин, эрүүл, аюулгүй газар нутаг ТББ • Ньюком Групп 	<ul style="list-style-type: none"> • NLM байгууллага • Номин Холдинг • NovaTerra • Нүүдэлчин групп • Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар • Дархан хотын Ойн нөхөрлөл холбоо • Нээлттэй Нийгэм Хүрээлэн • Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Орхон салбар • Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн чуулган • Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар • Оюу Толгойн хяналт ТББ
---	---	--	---

<ul style="list-style-type: none"> • Бидний оролцоо - нөлөөлөл ТББ • Хувийн бизнес эрхлэгч • Оюу Толгой • РЕНЕМ LLC • Монгол Улсын Их Хурал • Петровис • Гүнж ТББ • Сэтгэл зүйн хариу үйлдэл ТББ • Дархан-Уул аймгийн Олон нийтийн мэдээллийн төв • Rancho LLC • Улаан загалмайн нийгэмлэг • Хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ • Зам, тээврийн хөгжлийн төв • Хүүхдийг ивээх сан • Скаутын холбоо 	<ul style="list-style-type: none"> • Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар • Дархан-Уул аймгийн Ахмадын Холбоо • Шилмэл Од ХХК • Шуурхай Зөгий ХХК • Сондог ХХК • Сонгино бие даан амьдрах төв • Sorig Ten ТББ • Спортын аялал жуулчлалын холбоо Дархан салбар • Хил хязгааргүй алхам ТББ • Хүчирхэг Хөвгүүд ТББ • Дархан-Уул аймаг дахь оюутны холбоо • Сумитомо корпораци • Супер Матрас ХХК 	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой хөгжлийн судалгааны хүрээлэн • Сүү ХК • ТА-3 төслийн харилцаа холбоо • Тажун ХХК • Тамир Өсөх ХХК • Таван Богд Групп • Тэгш гол ХХК • Тэнгэрийн хишиг ХХК • Тесо групп • Худалдаа хөгжлийн банк • Ховд аймгийн Үйлдвэрчний эвлэл • Ил тод байдлын сан • Транспарэнси Интэрнэшнл ТББ • Цэцэн хан Өлгий ХХК • Төгөлдөр ирээдүйн төлөө ТББ • Төмөр шоо ХХК • Туушин 	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотын захирагчийн алба • Өмнөговь аймгийн МҮХАҮТ салбар • Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал • Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар • Өмнөговь аймгийн МҮХАҮТ салбар • НҮБХХ • Ундрах ХХК • НҮБ-ын Хүүхдийн Сан • Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо • Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо
---	---	---	--

<ul style="list-style-type: none"> • НҮБ-ын Хүн амын сан • Бүх нийтийн хөгжил бие даан амьдрах төв • Хөдөө аж ахуйн их сургууль • Шинжлэх ухаан, технологийн их сургууль • Үр жимс холбоо • Ургал-Энх ХХК • Мэргэжлийн Боловсрол Орхон ТББ • Вагнер Ази • Өөрчлөлтийн төлөөх 	<p>эмэгтэйчүүд ТББ</p> <ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих сан • Эмэгтэйчүүдийн "Ховд аймгийн холбоо" • Дэлхийн эрүүл мэндийн байгууллага • Дэлхийн Зөн • WWF • Хас банк • Бодлогод залуусын хяналт ТББ • Ү-Үе тэнгийн сургагч бэлтгэх 	<p>үндэсний сүлжээ</p> <ul style="list-style-type: none"> • Заамарын Залуучуудын ТББ • Зориг сан
---	---	--

Хавсралт 3: Монголын мэдээлэл, судалгааны ялгаа

Байгууллагын удирдамжийн дагуу Системчилсэн дүн шинжилгээ нь "... улс оронд нотолгоонд суурилсан хөгжлийн бодлогыг баталж, хөгжлийн зорилгод нь хяналт тавихад зайлшгүй шаардлагатай гол асуудлуудын мэдээллийн ялгаатай байдлыг товч шинжилсэн болно. Дүн шинжилгээ нь тухайн орны хувьд хамгийн их хамаарал бүхий Дэлхин банкны зорилго болон тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой хөгжлийн зорилтуудыг хянахад чухал ач холбогдолтой өгөгдөл, мэдээлэлд онцгой анхаарсан. "Энэхүү хавсралт нь энэ шаардлагыг хангаж байна:

Боловсролын чанарын мэдээлэл	117-р зүйлд заасны дагуу Монгол Улсад боловсролын чанарыг үнэлэхүйц хэмжээний мэдээлэл, TIMSS, PISA байхгүй байна. Боловсролын стандартын эдгээр болон бусад мэдээллийн эх сурвалж нь тухайн улсын боловсролын тогтолцооны чанарын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлоход шаардлагатай болно.
Албан бус хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн бусад шинж чанарын талаарх мэдээлэл.	90 ба 91-р зүйлд зааснаар Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн ноцтой, өргөн хүрээтэй асуудал гэж үздэг боловч албан бус хөдөлмөр эрхлэлтийн тогтмол тооцоо байхгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн оношлогоо, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл, динамикийг тогтмол хянаж үзэх шаардлагатай.
Жендэрийн хүчирхийллийн талаарх мэдээлэл.	105-р зүйлд зааснаар жендэрийн хүчирхийллийн талаар цөөхөн судалгаа байдаг боловч энэ талаархи улс орны асуудал улам бүр нэмэгдсээр байна.
Худалдан авах чадварын харьцаа (PPP)-ны ханшийн өөрчлөлтийг шалгах	23-р нэмэлт тайлбарт зааснаар, 2011 оны PPP-ийн түвшинг ашиглан ядуурлын түвшин тооцоход үлэмж бага тооцоолол гарсан. Монгол Улсад PPP-ийг бий болгоход учирч буй бэрхшээлүүдийн талаархи нотолгоо байгаа тул PPP-ийн 2011, 2008 онуудын үнийг албан ёсоор өөрчлөх шаардлагатай.
Усны стрессийн талаарх мэдээлэл	156 ба 157-р зүйлд зааснаар тухайн орон нутгаас шалтгаалан усны стресс болон эдийн засгийн хөгжлийн түвшин янз бүр байгааг олон судалгаа, таамаглалаар харуулсан байдаг. Энэ нь маш чухал ач холбогдолтой, яаралтай асуудал учраас асуудлыг шийдвэрлэхийн тулд илүү их судалгаа хийх шаардлагатай байна.
Орлогын тухай мэдээлэл, мөнгөн шилжүүлэг ба хөрөнгө	26-р нэмэлт тайлбарт зааснаар ядуурал ба тэгш бус байдал нь халамжийн нэгдмэл байдлаар хэрэглээг ашигладаг. Зарим шинжээчдийн үзэж байгаагаар орлогын тоо баримт нь ядуурал, тэгш бус байдал янз бүрийн хандлагатай байгааг харуулж байна. Орлогын

	<p>талаархи мэдээлэл байгаа боловч хөрөнгийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай ба мөнгөн шилжүүлгийн микро-өгөгдөл дутуу байна. Эдгээр асуудлуудын талаархи илүү мэдээлэл нь тухайн улсын нийгмийн халамжийн түвшин, чиг хандлагын талаар илүү нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд хэрэгтэй.</p>
--	--